

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ

*Монгол Улсад хууль зүй, дотоод хэргийн салбар үүсэж хөгжсөний
түүхт 110 жилийн ойд зориулсан тусгай дугаар*



ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2021 №1 (75)
19 дэх жилдээ

СЭТГҮҮЛИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Пүрэвдорж БАТБААТАР
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Батбуян БАТ-ЭРДЭНЭ ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бөхчулуун БАТ-ЭРДЭНЭ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бадам БАТЗОРИГ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жигжидсүрэн БОЛДБААТАР
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

Баатар БОЛДБААТАР
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Галбат ГАНТӨМӨР
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Жамсран ДОЛГОРСҮРЭН
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

Наваанпэрэнлэй ЖАНЦАН
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Очирхуяг ЗОРИГТ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Авирмэд ЛХАГВА
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН
ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Чойжил НЯМСҮРЭН
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Тамжид ОЮУНЧИМЭГ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Заяатхүү ТӨРМАНДАХ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ХВАН И ГАБ
ДОКТОР, ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Улсын бүртгэлийн дугаар 237
ISBN 978-99929-62-31-3

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Сэнгээ ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Батсүх АЛТАНСҮХ
ДОКТОР (Ph.D)

Шаравдорж АРИУНБИЛЭГ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Лувсан БАТ-ОЧИР
ДОКТОР (Ph.D)

Рагчаасүрэн БАЯРМАГНАЙ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жаргалсайхан МӨНХБОЛД
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Намжилдорж МӨНХЗУЛ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Думбурай МЯГМАРЦЭРЭН
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Бадарч НАРМАНДАХ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жутьяа НЯМДУЛАМ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Батхишиг ЛХАГВАСҮРЭН
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Буриад ЛХАГВАРАГЧАА
ДОКТОР (Ph.D)

Шархүү ЧУЛУУНБАТ
ДОКТОР (Ph.D)

Батзэвэг ЭНХБОЛД
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Магмадорж ЭРДЭНЭБАЯР
ДОКТОР (Ph.D)

ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН:

Сэнгээ ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН:

Бэгзсүрэн ЖАМСРАН

ГАРЧИГ

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх асуудал	Б.Энхболд С.Гантулга	5
Криминологийн биологийн онол: Үзэл баримтлал, хөгжлийн хандлага	Б.Энхболд М.Анхбаяр	16
Транснациональная организованная преступность /Незаконный оборот в борьбе против наркотики в Монголии/	Жутъяа Нямдулам	24
Цагдаагийн алба хаагчийн буруутай үйлдэлд шошгололтын онолын нөлөөлөл	Э.Дашгаадан	35
Хүн худалдаалах гэмт хэргийн олон улсын болон дотоодын нөхцөл байдал, чиг хандлага	Ж.Ууганчимэг	40
Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн эрүүгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ	О.Билэгжаргал	45
Албаны нууцлалын эрх зүйн зохицуулалтын зарим асуудал	Д.Золзаяа	54

ХАРЬЦУУЛСАН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Гадаадын орнуудын уучлал үзүүлэх эрх зүйн зохицуулалт, онцлог	Г.Гантөмөр	59
---	------------	----

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж, зүйлчлэлийн асуудал	Д.Энхнасан	66
Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж хүнийг алах гэмт хэргийн түүхэн уламжлал	Ч.Баярхүү	71

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийн асуудалд	Ц.Хонгорзул Т.Мөнхбадрах	74
---	-----------------------------	----

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

“Цагдаагийн хэсгийн байцаагч” албан тушаалын үүсэл, хөгжил, эрх зүйн зохицуулалтын уламжлал	Б.Баянмөнх	78
Организация профилактики преступлений условно осужденных органами полиции Монголии	А.Баасанцэрэн	91
Цагдаагийн алба хаагч резинэн болон хуванцар сумтай буу хэрэглэх аргачлал, анхаарах зарим асуудал	Ш.Чулуун	96

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Бичих хэрэгслийн мөрийг дүрс өсгөх аргаар судалсан нь	М.Түмэннаст	105
---	-------------	-----

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Sustainable development and the loan contract in Mongolia	Otgongerel Jantsan	123
---	--------------------	-----

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ АЛАХ БОЛОН ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ¹

Б.Энхболд

Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн, доктор (Ph.D), дэд профессор

С.Гантулга,

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга: Энэхүү өгүүллээр бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн нөхцөл байдал, ялын бодлого, түүний өөрчлөлтийн байдалд дүн шинжилгээ хийж, энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх арга замын талаар санал-зөвлөмж боловсруулсан.

Түлхүүр үг: Хүүхэд, бага насны хүүхэд, гэмт хэрэг, шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх ажиллагаа.


Удиртгал

Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын байгууллага болох “Хүүхдийг ивээх сан”-гаас жил бүр эрхлэн гаргадаг “Хүүхдийн эрх чөлөөний төлөв байдал” судалгаагаар 2018 онд Монгол Улс 100,000 хүн амд 1.4 хүүхдийн амь нас хохирсон үзүүлэлтээр 176 орноос 76-д орсон байна.² Уг судалгаагаар гэмт хэргийн улмаас хүүхдийн амь нас хохирч буй нөхцөл байдалд үндэслэн тухайн улс дахь хүүхдийн аюулгүй байдлын түвшнийг тодорхойлдог.

Иймд бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнд шүүхээс оногдуулсан ялын төрөл, хэмжээнд дүн шинжилгээ хийх, энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлж эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулах шаардлагатай байна.

II. Хүнийг алах гэмт хэргийн нөхцөл байдал, ялын бодлогын өөрчлөлт

График №1-Хүнийг алах гэмт хэргийн түвшин (2009-2020), хүний тоогоор



Сүүлийн 10 жилд³ дунджаар 212, сард 18 гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгджээ.⁴ Үүнээс 2018 онд хүнийг алах гэмт хэрэг улсын хэмжээнд 192 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 3 хэргээр буюу 1.6 хувиар өсч, нийслэлийн хэмжээнд 8 хэргээр буюу 6.8 хувиар буурч, орон нутгийн хэмжээнд 11 хэргээр буюу 15.5 хувиар өссөн байна.

Хүнийг алах гэмт хэрэгт холбогдсдын нас, хүйсийн байдал

¹ Энэхүү судалгааг Нээлттэй нийгэм форумын захиалгаар гүйцэтгэсэн болно.

² Global childhood report 2019- Savethechildren.org/us/about-us/resource-library/annual-report

³ 2009-2018 он

⁴ Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2018. ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. УБ., 2019. 169 дэх тал

2019 онд хүнийг алах гэмт хэрэгт 201 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 буюу 2.6 хувиар өссөн байна. Холбогдогчдын 22 буюу 11 хувь нь эмэгтэй, 179 буюу 89 хувь нь эрэгтэй, тэдний 1 буюу 0.5 хувь нь 14-17 насны хүүхэд байна. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс эрэгтэй 4.7 хувиар өсөж, эмэгтэй 12, хүүхэд 85.7 хувиар тус тус буурсан үзүүлэлт юм.




График №2



График №3

Хүнийг алах гэмт хэргийн улмаас хохирогчдын статистик үзүүлэлт

2019 онд хүнийг алах гэмт хэргийн улмаас 196 хүн хохирч, үүнээс 168 нь нас барж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад нас барса хүний тоо 1 буюу 0.6 хувиар буурсан байна. Хүснэгт №1

№	Үзүүлэлт	Он				Өсөлт, бууралт ⁵		Хугацаа		Өсөлт, бууралт	
		2015	2016	2017	2018	Тоо	Хувь	2019 оны эхний 8 сар	2020 оны эхний 8 сар	Тоо	Хувь
1	Хүнийг алах гэмт хэрэг	204	174	189	192	3	1.6	128	135	7	5.4
2	Хүнийг алах гэмт хэргийн хохирогч	214	184	191	196	5	2.6	131	137	6	4.5
3	Хүүхэд хохирсон хүнийг алах гэмт хэрэг	7	2	8	3	-5	-62.5	1	3	2	200
4	Үүнээс хохирогч	9	2	9	3	-6	-66.7	1	3	2	200

⁵ Сүүлийн 2 жилийн байдлаар

	хүүхдийн тоо /0-17 нас/											
5	Үүнээс	0-7 нас	5	1	7	3	-4	-57.1	-	-	-	-
6		8-13 нас	2	-	1	-	-1	-100.0	-	1	1	100
7		14-17 нас	2	1	1	-	-1	-100.0	1	2	1	100

Эх сурвалж: ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба

Сүүлийн 4 жилд хүнийг алах гэмт хэргийн халдлагад 785 хүн өртөж, хохирогчдын 92 хувь нь нас барсан байна. Хүнийг алах гэмт хэрэг болон энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдын тоо сүүлийн 3 жил тогтвортой өсөж, хохирогчдын олонх энэ төрлийн гэмт хэргийн улмаас нас барж, эрүүл мэндэд нь хүнд хохирол учирчээ. Энэ гэмт хэргийн улмаас учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэх боломжгүй буюу хүний амьд явах эрх зөрчигддөг тул нийгмийн хор аюул ихтэй гэмт хэрэгт тооцогддог. Энэ ч үүднээс дэлхийн улс бүр эрүүгийн хууль тогтоомждоо хүнийг алах үйлдлийг гэмт хэрэгт тооцож, энэхүү гэмт үйлдэлтэй ялын хатуу чанга бодлогоор тэмцдэг.

Сүүлийн жилүүдэд хүнийг алах гэмт хэргийн улмаас хүүхэд, тэр дундаа бага насны хүүхэд хохирох явдал буурахгүй байна. Тухайлбал, 2015 онд 7 гэмт хэрэгт 9 хүүхэд, 2016 онд 2 гэмт хэрэгт 2 хүүхэд, 2017 онд 8 гэмт хэрэгт 9 хүүхэд, 2018 онд 3 гэмт хэрэгт 3 хүүхэд, 2019 онд 1 гэмт хэрэгт 1 хүүхэд, 2020 оны 8 сарын байдлаар 3 хэрэгт 3 хүүхэд тус тус хохирсон байна. **Үүнээс 2015 онд 7, 2016 онд 1, 2017 онд 8, 2018 онд 3, 2020 оны 8 сарын байдлаар 1 бага насны хүүхэд хохирч, нас баржээ.**

Гэмт этгээдүүд ихэвчлэн бага насны хүүхдийг биеэ хамгаалж чадахгүй, бага насны хүүхэд гэдгийг мэдсээр байж, өөр гэмт хэргийг нуун далдлах зорилгоор гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж амь насыг нь хөнөөжээ.

Гэмт этгээдүүдийн дийлэнх нь хохирогчтой гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн байгаа бөгөөд удаан хугацаанд гэр бүлийн хүчирхийлэлд байлган, тарчлаасны эцэст амь насыг хөнөөсөн нь анхаарал татаж байна. Мөн хүчиндэх болон бусад төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээд үйлдсэн гэмт хэргээ нуун далдлах, гэмт хэргийн ул мөрөө баллах зорилгоор хохирогч бага насны хүүхдийг алсан тохиолдол цөөнгүй бүртгэгджээ. Тухайлбал, Шүүгдэгч П.Т 2009 оны 8 дугаар сарын 26-27-нд шилжих шөнө Булган аймгийн Тэшиг сумын ... дугаар багийн нутаг ... гэх газар 13 настай Ц.М-ийг биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулан заазуур болон гараараа зодож, толгой, нүүр, гар, хөлд нь олон тооны шарх, цус хуралт үүсгэж, онц харгис хэрцгий аргаар өвтгөн шаналгаж, зовоон тарчлааж хүчиндсэн, хүчиндэх гэмт хэргээ нуун далдлах зорилгоор хохирогчийг нуурын усанд живүүлж алсан.⁶

Учирсан хохирол

Хүнийг алах гэмт хэргийн улмаас иргэнд учирсан 948.1 сая төгрөгийн хохирлын 78.3 хувийг нөхөн төлүүлж, 533.1 сая төгрөгийн хөрөнгийг битүүмжилжээ. Энэ төрлийн гэмт хэргийн улмаас учирсан хохиролд хохирогчийн оршуулга, эмчилгээ, өмгөөллийн зардал, хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн унааны зардал зэрэг материаллаг зардлыг шүүхээс нотлох баримтыг үндэслэн шүүгдэгчээс гаргуулахаар шийдвэрлэж байна.

Шүүхээс хянан шийдвэрлэсэн бүхий л гэмт хэргээс үзэхэд, хохирогчийн хууль ёсны төлөөлөгчид шүүгдэгчээс сэтгэл санааны хохиролд 5-100 сая төгрөгийг нэхэмжилсэн боловч шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг хангалгүйгээр, гэм хорын хохирлыг иргэний журмаар шүүхэд хандан шийдвэрлүүлэх эрхтэй болохыг шийтгэх тогтоолдоо дурдсан байна.

⁶ Булган аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2010 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 84 дүгээр шийтгэх тогтоол

Хүснэгт №2-Хүнийг алах гэмт хэргийн ялын бодлогын өөрчлөлт

2002 оны Эрүүгийн хууль				2015 оны Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/				Ялын бодлогын өөрчлөлт	
Зүйл, хэсэг	Гэмт хэргийн ангилал	Ялын доод хэмжээ	Ялын дээд хэмжээ	Зүйл, хэсэг	Гэмт хэргийн ангилал	Ялын доод хэмжээ	Ялын дээд хэмжээ	Ялын доод хэмжээ	Ялын дээд хэмжээ
91.1	Онц хүнд гэмт хэрэг	10 жил хорих ял	15 жил хорих ял	10.1 (1)	Хүнд гэмт хэрэг	8 жил хорих ял	15 жил хорих ял	-2	Үгүй
91.2	Онц хүнд гэмт хэрэг	15 жил хорих ял	25 жил хорих ял, цаазаар авах ял	10.1 (2)	Хүнд гэмт хэрэг	12 жил хорих ял	20 жил хорих ял, бүх насаар хорих	-3	-5 Цаазаар авах ялыг хасаж, бүх насаар хорих ял нэмсэн.

Хүнийг алах гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах хорих ялын доод хэмжээг 2 жилээр багасгасан, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн тохиолдолд оногдуулах хорих ялын доод хэмжээг 3 жилээр, дээд хэмжээг 5 жилээр тус тус багасгаж, Монгол Улс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколд нэгдэн орсонтой⁷ холбоотойгоор цаазаар авах ялыг халж, энэ онцгой ялын оронд бүх насаар хорих ялыг хуульчилсан. Ингэж хорих ялын хэмжээг урьд байгаагүйгээр зөөлрүүлсэн нь гэмт хэргийг тогтоон барихад ялын хатуу чанга нь бус гарцаагүй байх нь чухал байхтай холбоотой бөгөөд шийтгэлгүй өнгөрөх болов уу гэсэн найдлага дагуулсан хатуу ялаар шийтгэгдэх айдсаас хөнгөн боловч гарцаагүй шийтгүүлнэ гэсэн мэдрэмж илүү нөлөөтэй гэсэн онол, олон улсын хандлагад нийцүүлсэн явдал юм.⁸

Практикт гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талын шинжийг тогтооход ихээхэн бэрхшээл тулгардаг. Гэмт хэрэг үйлдсэн хүний субъектив талд төдийлөн анхаарал хандуулалгүйгээр гэмт үйлдэл, эс үйлдэхүй, түүний улмаас учирсан хор уршигт анхаарах болсон олон улсын жишгийг харгалзан 2002 оны Эрүүгийн хуульд хүнийг танхайн, өс хонзонгийн сэдлээр алсан бол хүндрүүлэх бүрэлдэхүүнд заасан байсныг 2015 оны Эрүүгийн хуульд хассан. Мөн хүнийг алах гэмт хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн үйлдсэн, давтан үйлдсэн бол хүндрүүлж үзэхээр заасныг хассан бол гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, эрүүдэн шүүж, бага насны хүүхдийг алсан; зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүн зохион байгуулалттай гэмт үйл ажиллагааныхаа явцад; үзэл бодол, арьсны өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, бэлгийн болон хүйсийн чиг баримжаагаар нь үзэн ядаж алсан бол тус тус хүндрүүлэх бүрэлдэхүүнд шинээр хуульчилсан.


Судалгаанаас үзэхэд хүүхэд, ялангуяа биеэ хамгаалж чадахгүй бага насны хүүхэд хүнийг алах гэмт хэргийн халдлагад өртөх явдал түгээмэл байна. Хүнийг алах гэмт хэргийн хохирогч хүүхдийг насны байдлаар нь авч үзвэл 1-10 насны хүүхэд дийлэнх хувийг эзэлж байна. Бага насны хүүхдийг алсан тохиолдлыг хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчилсан явдал нь цаг үеэ олсон хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдсэн чухал алхам болсон гэж үзэж болохоор байгаа юм.

⁷ 2012 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар соёрхон баталсан.

⁸ С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн хуулийн эмгэгийг эмчлэх нь. Үндэсний шуудан сонины 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн №008(2705). 14 дэх тал

III. Хүчиндэх гэмт хэргийн нөхцөл байдал, ялын бодлогын өөрчлөлт

График №4-Хүчиндэх гэмт хэргийн түвшин (2009-2020), хүний тоогоор



Сүүлийн 10 жилд дунджаар 345, сард 29, хоногт 1 гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгджээ.⁹ Үүнээс 2019 онд хүчиндэх гэмт хэрэг улсын хэмжээнд 481 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 38 хэргээр буюу 7.3 хувиар буурчээ. Нийслэлийн хэмжээнд 55 хэргээр буюу 20.4 хувиар буурсан, орон нутгийн хэмжээнд 18 хэргээр буюу 7.2 хувиар өссөн байна.

Хүчиндэх гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн нас, хүйсийн байдал

2019 онд 338 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34 буюу 11.2 хувиар өссөн үзүүлэлт юм. Холбогдогчдын 3 буюу 0.9 хувь нь эмэгтэй, 335 буюу 99.1 хувь нь эрэгтэй, тэдний 24 буюу 7.1 хувь нь 14-17 насны хүүхэд байна. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс хэрэгт холбогдсон эрэгтэй 10.9 хувиар, эмэгтэй 50.5 хувиар тус тус өсөж, хүүхэд 20 хувиар буурсан байна.

Хүчиндэх гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал




График №5



График №6

⁹ Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2018. ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. УБ., 2019. 176 дахь тал

Хүчиндэх гэмт хэргийн улмаас хохирогсдын тоон үзүүлэлт

2019 онд энэ төрлийн гэмт хэргийн улмаас 487 хүн хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хохирсон хүн 119 буюу 32.3 хувиар өссөн байна. Үүнээс 2 хүн нас барж, 89 хүний эрүүл мэндэд хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нас барсан хүний тоо 1 буюу 2 дахин өсөж, эрүүл мэндэд хохирол учирсан хүний тоо өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

№	Үзүүлэлт	Хугацаа				Өсөлт, бууралт ¹⁰		Хугацаа		Өсөлт, бууралт	
		2015 он	2016 он	2017 он	2018 он	Тоо	Хувь	2019 оны эхний 8 сар	2020 оны эхний 8 сар	Тоо	Хувь
1	Хүчиндэх гэмт хэрэг	279	290	376	519	143	38.0	385	285	100	-26.4
2	Хүчиндэх гэмт хэргийн хохирогч	287	295	368	487	119	32.3	386	290	96	-24.8
3	Хүүхэд хохирсон хүчиндэх гэмт хэрэг	134	140	183	235	52	28.4	134	153	19	14.1
4	Үүнээс хохирогч хүүхдийн тоо /0-17 нас/	139	143	187	238	51	27.3	137	160	23	16.7
5	Үүнээс	0-7 нас	7	18	20	0	0.0	6	9	3	50.0
6		8-13 нас	47	45	59	32	54.2	26	39	13	50.0
7		14-17 нас	85	80	108	19	17.6	45	64	19	42.2

Хүснэгт №3

Эх сурвалж: ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба

Хүчиндэх гэмт хэрэг нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалд халдаж, улмаар хүний амьд явах эрх, эрүүл амьдрахын халдашгүй байдалд ихээхэн хохирол, хор уршиг учруулдаг нийгэмд хор аюул их учруулдаг гэмт хэрэг юм. Сүүлийн 4 жилд хүчиндэх гэмт хэргийн гаралт нэмэгдэж, энэ төрлийн гэмт хэргийн улмаас 1437 хүн хохирчээ. Ялангуяа хохирогчдын тоо сүүлийн 3 жилд огцом өсжээ. Үүний дотор энэ төрлийн гэмт хэргийн улмаас хүүхэд, тэр дундаа бага насны хүүхэд хохирох явдал буурахгүй байна. Тухайлбал 2015 онд 134 гэмт хэрэгт 139, 2016 онд 140 гэмт хэрэгт 143, 2017 онд 183 гэмт хэрэгт 187, 2018 онд 235 гэмт хэрэгт 238, 2019 онд 134 гэмт хэрэгт 137, 2020 оны эхний 8 сарын байдлаар 153 гэмт хэрэгт 160 хүүхэд тус тус хохирчээ. **Үүнээс 2015 онд 54, 2016 онд 63, 2017 онд 79, 2018 онд 111, 2019 онд 32, 2020 оны эхний 8 сарын байдлаар 48 бага насны хүүхэд хохирсон байна.**

¹⁰ Сүүлийн 2 жилийн байдлаар

Гэмт этгээдүүд ихэвчлэн гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай бага насны хүүхдийг биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй байгааг далимдуулан хүч хэрэглэн заналхийлэх аргаар хүчиндсэн байна. Эцэг, эхдээ болон бусдад хэлбэл ална, эрүүл мэндэд нь хохирол учруулна хэмээн заналхийлж, бага насны хүүхдийг хүчиндсэн байх бөгөөд хохирогч айж эмээсний улмаас гэмт этгээдийн үйлдлийг нууж өнгөрдөг нь дахин хүчиндүүлэх, цаашид удаан хугацаанд энэ гэмт хэргийн халдлагад өртөх нөхцөлийг бүрдүүлж байна.

Бага насны хүүхдийг хүчиндэж, улмаар жирэмсэн болгосон, бэлгийн замын халдварт өвчин халдаасан, хохирогчийг тохуурхан доромжилж үйлдсэн тохиолдол цөөнгүй хувийг эзэлж байна. Тухайлбал, судалсан хэргийн дийлэнх хувийг хохирогч хүчиндүүлсний улмаас жирэмсэн болсноор гэмт хэрэг илэрсэн байх бөгөөд хэрэв хохирогч жирэмсэн болоогүй бол тэр хэрэг илрэхгүй байх магадлал өндөр юм.

Бага насны хүүхдийг хүчиндсэний улмаас хохирогч жирэмсэлсэн тохиолдолд бүгд (100 хувь) үр хөндүүлсэн байгаа нь хохирогчийн цаашдын эрүүл мэнд, бие бялдар, оюун санааны хөгжилд асар хортой талаар мэргэжлийн эмч хэлдэг. Мөн хохирогчийг хүчиндэж, бэлгийн замын халдварт өвчин халдаасан тохиолдолд бага насны хүүхдийн эрүүл мэндэд ихээхэн хохиролтой бөгөөд хохирогч хүчиндүүлсний улмаас сэтгэцийн өвчтэй болсон, амиа хорлосон, амиа хорлохоор завдсан, хүчиндүүлснээс хойш бусадтай замбараагүй бэлгийн харьцаанд орсон явдал түгээмэл байна. Тухайлбал, насанд хүрээгүй хохирогч Ц.Б нь хойд эцэг С.С-д 2016 оны 3 дугаар сарын 7-ны өдрөөс 2016 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийг хүртэлх хугацаанд удаа дараа хүчиндүүлсэн. Хохирогч шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн мэдүүлэгтээ "...Намайг харж хамгаалах ёстой хүн С.С-д хүчиндүүлсэндээ гутарч, сэтгэл санаагаар унасанд асрамжийн газрын галч А.С, харуул К.Х нартай бэлгийн харьцаанд орсон." гэжээ.¹¹

Учирсан хохирол

Хүчиндэх гэмт хэргийн улмаас иргэнд учирсан 482.6 сая төгрөгийн хохирлын 66.1 хувийг нөхөн төлүүлж, 65.9 сая төгрөгийн хөрөнгийг битүүмжилжээ.

Хүснэгт №4-Хүчиндэх гэмт хэргийн ялын бодлогын өөрчлөлт

2002 оны Эрүүгийн хууль				2015 оны Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/				Ялын бодлогын өөрчлөлт	
Зүйл, хэсэг	Гэмт хэргийн ангилал	Ялын доод хэмжээ	Ялын дээд хэмжээ	Зүйл, хэсэг	Гэмт хэргийн ангилал	Ялын доод хэмжээ	Ялын дээд хэмжээ	Ялын доод хэмжээ	Ялын дээд хэмжээ
126.1	Хүндэвтэр гэмт хэрэг	1 жил хорих ял	5 жил хорих ял	12.1 (1)	Хөнгөн гэмт хэрэг	1 жил хорих ял	5 жил хорих ял	Үгүй.	Үгүй.
126.2	Хүнд гэмт хэрэг	5 жил хорих ял	10 жил хорих ял	12.1 (2)	Хүнд гэмт хэрэг	5 жил хорих ял	12 жил хорих ял	Үгүй.	2
				12.1 (3)	Хүнд гэмт хэрэг	8 жил хорих ял	15 жил хорих ял	3	5
126.3	Онц хүнд гэмт хэрэг	15 жил хорих ял	25 жил хорих ял, цаазаар авах	12.1 (4)	Хүнд гэмт хэрэг	12 жил хорих ял	20 жил хорих ял, бүх насаар хорих	-3	-5 Цаазаар авах ялыг хасаж, бүх насаар

¹¹ Увс аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 28 дугаар шийтгэх тогтоол

			ял					хорих ял нэмсэн.
--	--	--	----	--	--	--	--	------------------

Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах хорих ялын доод, дээд хэмжээг өөрчлөөгүй, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн этгээдэд оногдуулах хорих ялын дээд хэмжээг 3 жилээр, дээд хэмжээг 5 жилээр тус тус нэмэгдүүлсэн, хугацаатай хорих ялын хэмжээ багассантай холбоотойгоор онц хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар энэ гэмт хэргийг үйлдсэн хүнд оногдуулах хорих ялын доод хэмжээг 3 жилээр, дээд хэмжээг 5 жилээр тус тус багасгаж, цаазаар авах ялыг халж, харин үүний оронд бүх насаар хорих ялыг хуульчилсан.

Дээрх нэмэлт өөрчлөлтөөс дүгнэхэд хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах хорих ялын дээд хэмжээг бууруулж, цаазаар авах ялыг халсан нь 2002 оны эрүүгийн хуулийн ялын бодлогыг зөөлрүүлэх, нөгөө талаас Монгол Улс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколд нэгдэн орсонтой¹² холбоотой. Олон нийтийн сүлжээгээр 2015 оны Эрүүгийн хуульд хүүхэд хүчиндсэн хүнийг 2 сая төгрөгөөр торгох ял шийтгэхээр хуульчилсан гэсэн мэдээлэл түгээгдсэн. Энэ нь худал мэдээлэл бөгөөд хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах ялын бодлого төдийлөн зөөлрөөгүй, гэмт этгээдэд ял завших боломж огт олгоогүйн зэрэгцээ хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг өргөн хүрээнд хамгаалж, олон улсын жишгийг харгалзан энэ гэмт хэргийн объектив талын шинжийг тодорхойлж, үйлдлийн аргыг дэлгэрэнгүй байдлаар хуульчилсан. Тухайлбал, хүчиндэх гэмт хэргийн объектив талын шинжийг хүчээр бэлгийн харьцаанд орсон, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн гэж тодорхойлж, хохирогчийн хүсэл зоригийн эсрэг, хуульд заасан арга хэрэглэж, хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан; хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн, эсхүл өөр зүйл оруулсан¹³ үйлдлийг хүчиндэх гэмт хэрэгт тооцсон. Бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл нь бэлгийн харьцаанд орох үйлдэлтэй адил хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалд халддаг, нийгмийн хор аюул нь их үйлдэл учраас хүчиндэх гэмт хэрэгт тооцсон нь хүний эрхийг хангахад чухал алхам болсон гэж үзэж байна. Эмэгтэй хүний бэлэг эрхтэнд хуруу, бусад зүйлийг хийсэн, ам, шулуун гэдсэнд бэлэг эрхтнээ оруулсан зэрэг хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалд бүдүүлгээр халддаг үйлдлийг 2002 оны Эрүүгийн хуулиар бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргээр зүйлчилж, хөнгөн ял оногдуулдаг байсан бол шинэ Эрүүгийн хуулиар хүчиндэх гэмт хэрэгт тооцсон.

Мөн 2015 оны Эрүүгийн хуульд хүчиндэх гэмт хэргийн хохирогч нь бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдал зөрчигдсөн аль ч хүйсийн хүн байж болно¹⁴ гэж хүйсийн ялгаваргүйгээр хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг Эрүүгийн хуулиар хамгаалсан нь ихээхэн ач холбогдолтой. Шинэ Эрүүгийн хууль хэрэгжиж эхлэхээс өмнө эрэгтэй хүн (эрэгтэй хүүхэд)-ийг шулуун гэдсээр хүчиндсэн тохиолдолд бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргээр зүйлчилж, гэмт этгээдэд хөнгөн ял оногдуулж, ял завшуулж байсан.

Судалгаанаас үзэхэд хүүхэд, ялангуяа биеэ хамгаалж чадахгүй бага насны хүүхэд хүчиндэх гэмт хэргийн халдлагад өртөх явдал түгээмэл ажиглагдав. Хүчиндэх гэмт хэргийн хохирогч болсон хүүхдийг насны байдлаар нь авч үзвэл 4-10 насныхан дийлэнх хувийг эзэлж байна. Бага насны хүүхэд хүчиндсэн бол Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэрэглэсэн, хохирогчийн хүсэл зоригийн эсрэг үйлдсэн зэрэг субъектив талын шинжийг хангасан байхыг шаардахгүй.¹⁵ Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн хүн бага насны хүүхэдтэй бэлгийн харьцаанд орсон, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн объектив талын шинжээр нь зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь өмнөх хуультай харьцуулахад илүү нарийвчилсан, ялын бодлогын хувьд чангарсан зохицуулалт юм.

Энэ төрлийн гэмт хэргийг хүндрүүлэх нөхцөл байдалгүйгээр үйлдсэн тохиолдолд 2002 оны Эрүүгийн хуулиар хүндэвтэр, 2015 оны Эрүүгийн хуулиар хөнгөн ангиллын гэмт хэрэгт хамаарах тул шүүхээс хуульд заасан болзол, шалгуурыг хангасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх боломжтой. Практикт түгээмэл үйлдэгдэж буй байдлыг харгалзан гэр

¹² 2012 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар соёрхон баталсан.

¹³ Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн тайлбар

¹⁴ Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн тайлбар

¹⁵ Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн тайлбар

бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндсэн, хохирогчийг жирэмсэн болгосон, хохирогчид бэлгийн замын халдварт өвчин халдаасан, хоёр ба түүнээс олон хүнийг хүчиндсэн бол тус тус хүндрүүлэх бүрэлдэхүүнд шинээр хуульчилсан.

2015 оны Эрүүгийн хуульд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгасны нэг илрэл нь урьд нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12 дугаар бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж, гэм буруутайд тооцогдож байсан хүн үйлдсэн бол хүндрүүлэхээр хуульчилсан явдал юм. Хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, бэлгийн мөлжлөг, арван зургаан насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэхээс бусад гэмт хэргийг давтан үйлдсэн тохиолдолд зүйлчлэлээр нь хүндрүүлж, гэмт хэрэг үйлдсэн хүний эрх зүйн байдлыг дордуулахгүй.

IV.Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөл

Судалгааны үр дүнгээс үзэхэд, бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

1. Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн 98.5 хувийг эрэгтэй, бага насны хүүхдийг алах гэмт хэргийн 55 хувийг эрэгтэй, 45 хувийг эмэгтэй хүн үйлдсэн байна. Мөн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүний 50.0 хувь, бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн хүний 62.5 хувийг 19-30 насны хүн эзэлж байгаа бол 51-74 насны хүмүүс бага насны хүүхдийг хүчиндсэн тохиолдол 6 орчим хувь байна. Харин бага насны хүүхдийг 51-ээс дээш насныхан алсан тохиолдол бүртгэгдээгүй байна.
2. Судалгаанаас үзэхэд, бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүний 90 орчим хувь нь бүрэн дундаас доош, 60 хувь нь бүрэн бус дундаас доош боловсролтой, 85 орчим хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй, 70 орчим хувь нь орон нутагт төрж, өссөн, 19 орчим хувь нь урьд нь ял шийтгэгдэж байсан хүн байна.
3. Хорих ял биечлэн эдэлсэн хүн зан байдлын хувьд засарч хүмүүжээгүй байхад хугацаанаас нь өмнө тэнсэн сулласан, шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, өршөөгдсөн үед цагдаагийн байгууллага хяналт сул тавьсан нь энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл болсон тохиолдол цөөнгүй байна.
4. Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн хохирогчдын 90 орчим хувь нь сургууль, цэцэрлэгт хамрагддаг, сэтгэц, бие махбодын хувьд эрүүл, хүчиндэх гэмт хэргийн хувьд 13-14 насны хүүхэд халдлагад өртсөн тохиолдол 47 хувь, хүүхдийг алах гэмт хэргийн хувьд 8-10 насны хүүхэд хохирсон тохиолдол 37.5 хувь, энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдын хамгийн бага нь 1 настай хүүхэд байна. Мөн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн хохирогчдын 97.1 хувь эмэгтэй хүүхэд байхад хүүхдийг алах гэмт хэргийн хувьд 65 хувь мөн эмэгтэй хүүхэд байгаа нь анхаарал татаж байна.
5. Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэг нь гэр бүлийн хүрээнд ялангуяа хохирогч өөрийн амьдардаг гэртээ болон төрөл садангийн хүний гэрт халдлагад өртөж байгаа нь хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хангагдахгүй байгааг илтгэж байна. Тухайлбал, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн 38.2 хувь, хүүхдийг алах гэмт хэргийн 40 хувь нь хүүхэд өөрийн амьдардаг гэртээ халдлагад өртсөн бол бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн 30.9 хувь, бага насны хүүхдийг алах гэмт хэргийн 27.5 хувь нь хамаатан садан, эцэг, эхийн найзын гэрт халдлагад өртжээ.
6. Гэр бүл салалт, гэр бүлийн тогтворгүй байдал, хүүхдэд тавих хараа хяналт сул байдал, гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээний архидалт, гэр бүлээс гадуурх бэлгийн харьцаа зэрэг нь бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдэх үндсэн шалтгаан болж байна. Судалгаанаас үзэхэд, өөрийн төрсөн хүүхдээ хүчиндсэн тохиолдол 2.9 хувь, төрсөн хүүхдээ алсан тохиолдол 42.5 хувийг тус тус эзэлж байна. Харин дагавар хүүхдээ хүчиндсэн тохиолдол 19.1 хувь, төрөл, садангийн хүний хүүхдийг хүчиндсэн тохиолдол 17.6 хувийг эзэлж байгаа бол дагавар хүүхдээ алсан тохиолдол 15 хувь, төрөл, садангийн хүний хүүхдийг алсан тохиолдол 12.5 хувийг тус тус эзэлж байна. Тухайлбал, гэр бүл салж, хоёр дахь амьдрал зохиосонтой холбоотойгоор дагавар хүүхдээ үзэн ядаж удаан хугацаанд зоддог байснаас хүүхдийг алсан тохиолдол 25 хувь, өөрийн төрсөн хүүхэд биш гэсэн шалтгаанаар бага насны хүүхдийг хүчиндсэн тохиолдолд 40.2 хувийг эзэлж байна. Эцэг эх нь салсан, эцэг эхийн аль нэг нь өөр хүнтэй гэр бүл болсон гэсэн шалтгаанаар эмээ, өвөөгийн гэрт байхдаа бусад хүмүүст хүчиндүүлсэн тохиолдол 27.9 хувийг тус тус эзэлж байна.

7. Гэр бүлийн хүрээнд үйлдэгдсэн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг нуугдмал шинжтэй байгаа нь гэмт хэрэг давтан үйлдэгдэх, удаан хугацаанд үргэлжлэх шалтгаан, нөхцөл болж байна. Судалгаанаас үзэхэд, гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн, эсхүл төрөл, садангийн хүний халдлагад өртсөн бага насны хохирогч тэр даруй бусдад мэдэгдсэн тохиолдол 16 буюу 23,5 хувьтай байгаа анхаарал татаж байна. Хохирогч жирэмсэн болсон, эсхүл бэлгийн замын халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн, үйлдэл дээрээ баригдсанаас бусад тохиолдолд хохирогч цагдаагийн байгууллагад мэдэгдээгүй байна. Удаан хугацаанд нуун далдалсан шалтгаан нь 40,4 дарамтад өртсөн, 20,3 хувь хууртагдсан, 17 хувь гэр бүлийн гишүүдээсээ санаа зовсон /ээж, дүү/, 19,1 хувь бэлгийн харьцааны учир холбогдлыг ойлгоогүй зэрэг байна. Харин үл таних хүнд хүчиндүүлсэн тохиолдолд хохирогч ойролцоо байгаа хүн болон өөрийн эцэг, эх ойр дотны хүндээ шууд мэдэгддэг байна.
8. Бага насны хүүхдийг алах гэмт хэргийн хувьд хохирогчийн буруутай үйл ажиллагаа бараг тогтоогдоогүй, харин гэнэн итгэмтгий зангаасаа болж гэмт хэрэгт хохирсон тохиолдол цөөнгүй байна. Тухайлбал, “Ухаан алдахаар гоё мэдрэмж төрдөг” гэсэн үгэнд хууртаж, өөрийгөө боолгуулсан байна. Харин хүчиндэх гэмт хэргийн хувьд хохирогч согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн, мөнгө шаардлагатай болсон, зочид буудал, гэмт хэрэг үйлдсэн хүний ажлын байранд очсон, тээврийн хэрэгслээр зугаалсан, ажил, хөдөлмөр эрхлэх нэрээр садар самуун явдалд орж биеэ үнэлсэн, бусдаас тусламж хүсэх боломж байсаар байтал тусламж аваагүй зэрэг нь хохирогч болоход нөлөөлсөн байх боломжтой байна. Эдгээр нөхцөл байдлын цаана гэр бүлийн таагүй орчин, эцэг, эхийн хараа хяналт сул, гэр бүл салалт, гэр бүлийн хүчирхийлэл байгааг анхаарах нь зүйтэй. Судалгаанаас үзэхэд, 12 настай охин ажил хийж байгаа нэрээр гэртээ нэг сар орчим ирээгүй байхад эцэг, эх нь хайгаагүй байх, хойд эцэгтээ хүчиндүүлсэн охин нэгэнт хүчиндүүлсэн гэсэн шалтгаанаар бусад хүнтэй төлбөртэй бэлгийн харьцаанд орсон тохиолдол байна.
9. Бага насны хүүхдийг биеэ хамгаалж чадахгүй гэдгийг нь мэдсээр байж зодох, боох, шидэх зэрэг аргаар алсан тохиолдол дийлэнх хувийг эзэлж байна. Бага насны хүүхдийг алах гэмт хэргийг үйлдсэн хүн өмнө үйлдсэн гэмт хэргийг бага насны хүүхэд харсан тохиолдолд гэмт хэргээ нуун далдлах, хялбарчлах зорилгоор тухайн бага насны хүүхдийг алсан үйлдсэн тохиолдол 25 хувь, хүүхдийн хийсэн үйлдэлд зэвүүцэх, үзэн ядах, үгэнд орсонгүй гэсэн үл ялих зүйлээр шалтаглаж алсан тохиолдол 35 хувь, тэжээн тэтгэхээс зайлсхийх сэдэлт, зорилготой 20 хувь байгаа нь анхаарал татаж байна. Хүчиндэх гэмт хэргийн хувьд бэлгийн харьцааны учир холбогдлыг ойлгохгүй байгааг далимдуулж, хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, согтууруулах ундааны зүйл хэрэглүүлж, биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулах, хууран мэхлэх зэрэг аргаар ихэвчлэн үйлдэгдсэн байна.
10. Хүчиндэх гэмт хэргийн улмаас бага насны хохирогч болон түүний ойр дотны хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, сэтгэл санаанд ихээхэн хохирол учирч байна. Тухайлбал, хохирогч нас барсан, амиа хорлосон, сэтгэцийн эмгэгтэй болсон, жирэмсэн болсон, ураг хөндүүлсэн, бэлгийн замын халдварт өвчтэй болсон, сургууль завсардсан, гэр бүлээсээ дайжсан, гэр бүл салсан, биеэ үнэлэх болсон, бэлгийн замбараагүй харьцаанд орж эхэлсэн зэрэг сөрөг үр дагавар бий болжээ.
11. Хүчиндэх гэмт хэргийн хохирогч 10-14 насны хүүхдийн хувьд сэтгэл зүйн хувьд бүрэн төлөвшөөгүй, өөрийн гэсэн үзэл бодол тогтоогүй байдаг учир сониуч зан, адал явдалд дурлах, итгэмтгий байх, хөөрч сагсуурах, шинэ нөхцөл байдалд дасах чадавхгүй байх, хайр халамж дутагдах, зарим тохиолдолд биеийн хөгжлийн онцлог зэрэг нь хохирох эрсдэлийг нэмэгдүүлж байна.

V.Зөвлөмж

Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр:

1. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртөх эрсдэлийн судалгааг жил бүр хийж, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх бодлого боловсруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөхдөө судалгааны үр дүнг ашиглах;

2. Хүүхдийн эрхийг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, хэрэгжилтийн байдалд хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх;
3. Хүүхэд гэмт хэрэгт хохирох, ялангуяа хүнийг алах болон хүчиндэх гэмт хэргийн нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жинг бууруулах чиглэлээр эрх зүй, зохион байгуулалтын шинжтэй арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;
4. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, гэр бүлийн харилцаа, гэр бүл төлөвлөлт, эцэг, эхийн хариуцлага, үлгэр дуурайлал, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаарх иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх сургалт, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах;
5. Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгэм, хамгааллын яам, Боловсрол соёл шинжлэх ухааны яам, батлан хамгаалах яам хамтран гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлага, гэр бүл салалтаас үүсэх үр дагаврын талаар сургалтын хөтөлбөр боловсруулж ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, их, дээд сургуулийн оюутан, хугацаат цэргийн алба хаагч нарт сургалт явуулах ажлыг тогтмолжуулах;
6. Хүүхдийн эрхийн хороо, хүүхдийн эрхийн улсын байцаагчийн үйл ажиллагааг хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхдийг илрүүлэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулахад чиглүүлэх, ажлын үр дүнг тооцож, ажиллах;
7. Садар самуун явдал, биеэ үнэлэх, хардалт, эцэг эхээ үл тоомсорлох зэрэг хүүхдийн сэтгэхүй, хүмүүжилд сөргөөр нөлөөлөх агуулга бүхий насанд хүрэгчдэд зориулсан телевизийн нэвтрүүлэг, кино, ярилцлага, цэнгээт үзүүлбэрийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараахгүй байхад анхаарах, бага насны хүүхэд интернет орчинд чөлөөтэй нэвтрэх нь зохистой эсэх, хязгаарлалт тогтоох боломж нөхцөлийн талаар судлах;
8. Бага насны хүүхэд хүчирхийлэлд өртсөн тохиолдолд эрх бүхий байгууллага, сурган хүмүүжүүлэгч, нийгмийн ажилтан, гэр бүлийн гишүүдэд цаг алдалгүй хандах талаар хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон аргаар мэдээлэл хүргэх;
9. Энэ төрлийн гэмт хэргийг түгээмэл үйлдэж буй 19-25 насны бүрэн дундаас доош боловсролтой, эрхэлсэн тодорхой ажилгүй, ял шийтгэл эдэлж байсан, тэнсэгдсэн, ял хойшлогдсон, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж шийтгэгдсэн этгээдүүдэд тавих хяналтыг сайжруулах, гэмт хэргийн хор уршиг, эрүүгийн хариуцлагын талаарх болон зан үйлд нөлөөлөх сургалтыг олон талт хэлбэрээр зохион байгуулах;
10. Энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж, хорих ял эдэлж суллагдсан хүнд тавих хяналтыг сайжруулах, нийгэмд дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх;
11. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг эрүүл мэндийн үзлэг, хүүхдийн хөгжлийн ерөнхий байдлын судалгаанд тогтмол хамруулах;

VI.Ном зүй

- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2017. УБ., 2018
- Global childhood report 2019- Savethechildren.org/us/about-us/resource-library/annual-report
- Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2017. ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. УБ., 2018
- Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2018. ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. УБ., 2019

КРИМИНОЛОГИЙН БИОЛОГИЙН ОНОЛ: ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ХӨГЖЛИЙН ХАНДЛАГА

Б.Энхболд

*Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн,
доктор (Ph.D), дэд профессор*

М.Анхбаяр

*ДХИС-ийн магистрант, Ховд аймгийн Цагдаагийн газрын
Булган сум дахь Цагдаагийн хэлтсийн мөрдөгч, цагдаагийн ахмад*

Удиртгал

Түлхүүр үг: Биологи, генетик, гэмт зан үйл, гэмт хэрэгтэн.

Зорилго: Криминологийн биологийн онолын ойлголт, үзэл баримтлал, шинжлэх ухаан-практикт гүйцэтгэсэн үүрэг, бусад онолоос ялгагдах онцлог, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоход оршино.

Судалгааны арга зүй: Гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг биологийн онолын үүднээс тайлбарласан гадаад, дотоодын эрдэмтэн, судлаачдын бүтээлд харьцуулсан судалгаа хийх, нэгтгэн дүгнэх, задлан тайлбарлах аргуудыг ашигласан.

Судалгааны үр дүн: Биологийн онол нь криминологийн шинжлэх ухааны нэг судлагдахуун бөгөөд Монгол Улсад гэмт зан үйлийн шалтгаан, нөхцөлийг биологийн онолын үүднээс тайлбарласан шинжлэх ухааны судалгаа хараахан хөгжөөгүй, эхлэл төдий байна.

Судалгааны хязгаарлалт: Гэмт явдлын шалтгааныг тайлбарлах биологийн онолын агуулга, мөн чанар, хөгжлийн хандлагыг үзэл баримтлалын хүрээнд судалсан.

Судалгааны ач холбогдол: Гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг тайлбарлах биологийн онолын талаар системчилсэн мэдлэгийн тогтолцоог бий болгох, энэ онолыг шинжлэх ухааны эргэлтэд оруулж, гэмт явдлаас урьдчилан сэргийлэх онол-арга зүйг хөгжүүлэхэд ач холбогдолтой.

Өгүүллийн төрөл: Тодорхойлон тайлбарласан өгүүлэл.

1.Криминологийн биологийн онолын үзэл баримтлал

Криминологийн сонгодог онол XIX зууны эхний хагас хүртэл гэмт явдал судлалын салбарт дангаараа ноёрхсоор байсан. 1870-аад оны криминологийн сонгодог онолын үзэл санаа биологийн “позитивизм”-д байр сууриа алдаж, шүүмжлэлд өртөж эхэлсэн. Криминологийн биологийн чиглэлийн онол нь дараах үзэл санааг дэвшүүлдгээрээ бусад онолоос ялгардаг. Үүнд:

- Гэмт хэрэг нь нийгэм-хууль зүйн ойлголт боловч түүний шалтгаан, нөхцөлийг хүнээс ангид тайлбарлах боломжгүй, өөрөөр хэлбэл, гэмт хэргийг хүн үйлддэг тул хүнийг судлахгүйгээр түүний шалтгаан, нөхцөлийг тодорхойлох боломжгүй;
- Гэмт хэрэгтэн хүн төрдөг, тэдгээр нь хүй нэгдлийн үеийн үлдэгдэл, нийгмийн гишүүдийн дагаж мөрддөг эрх зүйн болон ёс суртахууны хэм хэмжээг ойлгох, сахин биелүүлэх чадваргүй тул хууль зөрчиж гэмт хэрэг үйлддэг;
- Гэмт хэргийн биологийн шалтгааны гол хүчин зүйлс түрэмгий болон нийгмийн хэм хэмжээг зөрчсөн зан үйл бөгөөд түүнийг бүрдүүлэгч эх үүсвэр тархины болон сэтгэцийн эрүүл мэнд байдаг;
- Хүний зан үйлийг тодорхойлогч хүчин зүйлсэд генетикийн болон удамшлын шинжүүд чухал үүрэг гүйцэтгэдэг тул хүнд үе дамжсан гэмт зан төлөв бүрэлдэн тогтдог;
- Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл нь хувь хүний биологийн шинж болох нас, хүйс, арьсны өнгө, биеийн хөгжил, сэтгэн бодох чадвартай салшгүй холбоотой;
- Гэмт хэргийн биологийн шалтгаан нь амьдралын хэв маяг, нийгэм, эдийн засгийн өөрчлөлтөөс хамааран хувьсан өөрчлөгдөж байдаг өргөн хүрээтэй ойлголт-зэрэг болно.

2.Биологийн анхны онолууд, шинжлэх ухаанд үзүүлсэн нөлөө

Биологийн анхны онолуудын хувилбар нь гэмт хэрэгтнүүд нь хуулийг дагаж мөрддөг иргэдээс биологийн хөгжлийн хувьд хамаагүй дор эсхүл зарим талаараа биологийн хувьд дефекттэй, тодорхой бүлэг хүмүүс байдаг гэж үзсэн. Нийгэм тэдгээр хүмүүсийг шийтгэж өөрсдийгөө хамгаалдаг боловч гэмт хэрэг үйлдэх шалтгаан нь биологийн заягдмал, тиймээс ямар ч хууль нөлөө үзүүлж чадахгүй учраас байгалиас заяасан гэмт хэрэгтэн хүмүүст ял шийтгэл, түүний төрөл, хэмжээ нөлөөлдөггүй гэж үздэг. Биологийн анхны онолуудад “Гэмт бие хүний онол”, “биеийн бүтцийн онол”-ууд хамаардаг.”

Гэмт бие хүний онол

Биологийн анхны онолуудын дундаас хамгийн чухал онолыг Италийн Турины их сургуулийн шүүх эмнэлгийн болон нийгмийн эмгэг судлалын профессор Чезаре Ломброзо 1876 онд “Criminal man” буюу “Гэмт бие хүн”¹⁶ гэсэн бүтээлээрээ танилцуулсан.

Ч.Ломброзо гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судалгааны арга зүйд үндэслэн, системтэйгээр судалсан бөгөөд түүний дэвшүүлсэн “Гэмт бие хүний онол” нь онц хүнд гэмт хэрэг үйлдсэн 383 хүний гавалын ясыг 3839 жирийн хүний гавлын ястай, 26886 гэмт хэрэгтнийг, 25447 цэрэгтэй харьцуулан судалсан дүгнэлтэд үндэслэсэн.¹⁷ Тэрээр дараах үзэл санааг дэвшүүлсэн. Үүнд:

- Гэмт хэрэгтэн хүн төрдөг. Төрөлхийн гэмт хэрэгтэн физиологийн хувьд гажиг өгөгдөлтэй төрдөг. Тийм хүмүүс орчин үеийн нийгмийн хууль, дүрмийг зөрчих шалтгаан болдог.
- Төрөлхийн гэмт хэрэгтэн бол хүний хөгжлийн эхний үе шатандаа үйлдэгсэд ба “атавизм” гэж дүгнэсэн. Тийм хэв маягийн хүмүүс хүний бие махбодтой, сэтгэхүйтэй боловч хүй нэгдлийн үеийн хүний зөн совинтой байдаг. Тэднийг тусгайлан хамгаалахгүй бол соёлт нийгмийн амьдралд дасан зохицдоггүй тул хууль ёсыг зайлшгүй зөрчдөг. Төрөлхийн гэмт хэрэгтнүүд нь нүүр, царайны болон толгой буруу стандарт бус хэмжээстэй, сармагчин шиг том чих, том ам, хэт урт эрүү, муруй хамар, хэт ясархаг хацар, урт гар, хэт их үрчлээтэй нүүр, маш урт хөл гарын хуруу гэх мэт харагдах шинж тэмдгүүдээрээ танигддаг. Эдгээр гажгуудын 5 ба түүнээс дээш шинж эрэгтэй хүнд, 3 ба түүнээс дээш нь эмэгтэй хүнд илэрч байвал түүнийг төрөлхийн гэмт хэрэгтэн гэж үзнэ.
- Байгалийн шалгарлын улмаас эмэгтэй төрөлхийн гэмт хэрэгтнүүдээс эрэгтэй төрөлхийн гэмт хэрэгтнүүд олон байдаг. Эрчүүд физиологийн хөгжлийн гажигтай эмэгтэйчүүдтэй үржилд орох нь бага байдаг учраас эмэгтэйчүүдийн генийн өөрчлөлттэй байх магадлал тэдний амьд үлдэхтэй холбоотой учраас эрчүүдийнхээс бага байдаг. Ломброзо эрэгтэй гэмт хэрэгтнүүдэд гол анхаарлаа хандуулдаг байсан ч өөрийн өргөмөл хүү Ульяам Фереро-той хамтран “Эмэгтэй гэмт хэрэгтэн” бүтээлээ 1897 онд туурвисан.
- Хүн нь төрөлхийн гэмт хэрэгтнээс гадна “Хэрэг хариуцах чадваргүй гэмт хэрэгтнүүд”, “Криминалиод” гэсэн 2 төрөлтэй байдгийг тодорхойлсон. Хариуцах чадваргүй гэмт хэрэгтэн нь солиотой, ухаан муутай, эпилепс өвчтэй унадаг татдаг, сэтгэцийн өвчтэй хүмүүс бөгөөд нийгэмдээ зохицдоггүй сэтгэцийн эмгэгтэй хүмүүс гэж дүгнэсэн.
- Тэрээр төрөлхийн гэмт хэрэгтэн нь нийт хүн амын олон хувийг эзэлдэг гэж үзэж байсан бол хожимгоо гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг нийгэм, улс төр, эдийн засгийн нөхцлөөс шалтгаалдаг гэдгийг нэмснээр эрэгтэй гэмт хэрэгтнүүдийн 35 хувь хүртэл, эмэгтэйг 14 хүртэл хувь нь төрөлхийн гэмт хэрэгтэн байдаг гэж үзжээ.

Английн хорих байгууллагын ажилтан Чарльз Горинг “Гэмт бие хүн”-ий талаарх өөрийн судалгааны үр дүнг XX зууны эхээр танилцуулсан.

¹⁶ “L'Uomo delinquente” (Гэмт хүн) нэртэй бүтээл гаргасан нь ихээхэн шуугиан дэгдээж, Итали хэл дээр таван удаа хэвлэгдэхийн зэрэгцээ Европын олон хэлнээ хөрвүүлэгдсэн байдаг.

¹⁷ С.Жанцан, “Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол /Гэмт хэргийн тухай сургааль/. I боть. УБ., 2009. 953 дахь тал

Ч.Горинг судалгааны ажилдаа хүний биед физиологийн хэмжилт хийх, статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх аргыг ашигласан бөгөөд судалгааны хүрээнд шоронгийн хоригдлуудыг их сургуулийн оюутан, цэргүүд, профессор, эмнэлгийн өвчтөнүүдтэй харьцуулан судалсан. Тэрээр хүний толгойн хэмжээс, нүдний өнгө, царайны төрх, биеийн хэлбэр зэргийг багтаасан 37 физиологийн үзүүлэлтээр судалгаа хийсэн нь Ч.Ломборозогийн ажлаас судалгааны объект, арга зүй хувьд илүү шинжлэх ухаанч хэлбэртэй болсон. Судалгааны үр дүнгээр цэвэр физиологиос шалтгаалсан гэмт хэрэгтэн гэсэн ойлголт байхгүй гэж Ч.Ломборозогийн онолыг үгүйсгээд дараах дүгнэлтийг дэвшүүлсэн. Үүнд:

- Шоронгийн хоригдол ба иргэдийн хооронд биеийн өндөр, биеийн жингийн хувьд л ялгаа байдаг бөгөөд бусад физиологийн шинжийн хувьд онцын ялгаа байдаггүй;
- Гэмт хэрэгтнүүд хуулийг дуулгавартайгаар дагаж мөрддөг иргэдээс сэтгэцийн гажигтай байдлаараа ялгагддаг бөгөөд энэ шинж тэмдгээ өвлөж төрдөг;
- Давтан гэмт хэрэгтнүүдийн хувьд "ёс суртахуун"-ы доройтлолтой байдаг гэжээ.

Түүний дараа Америкийн антропологич Е.А.Хутон Ч.Ломборозо болон Ч.Горинг нарын судалгаатай ижилхэн судалгааг 1927-1939 онд АНУ-ын хорих ангиудад ял эдэлж байгаа 17000 орчим хоригдлуудын дунд явуулсан. Е.А.Хутон судалгаа явуулахдаа илүү нарийвчлан арга зүй ашигласан бөгөөд судалгааны объектын хүрээнд коллежийн оюутнууд, эмнэлгийн өвчтөнүүд, галын болон цагдаагийн ажилтнуудыг хамруулж, тэднийг хоригдлуудтай харьцуулахдаа нэг төрлийн арьс өнгө, нэг үндэстэн, насны бүлэг, нийгмийн давхарга, үйлдсэн гэмт хэргийн төрлөөр нь бүлэглэн харьцуулалт хийсэн нь гэмт хэргийг ижилхэн үзүүлэлтээр хэмжих аргачлалыг бий болгожээ. Судалгааны үр дүнгээр Ч.Горингийн дүгнэлтийг үгүйсгээд Ч.Ломборозогийн зарим дүгнэлтийг дэмжиж, шинэ хэмжигдэхүүнийг криминологийн шинжлэх ухаанд оруулсан юм. Үүнд:

- Хүний гэмт хэрэг үйлдэх шалтгаан, нөхцөлд нийгмийн анги, давхаргын байдал тийм ч их нөлөө үзүүлэхгүй, учир нь гэмт хэрэгтнүүд үндсэндээ "төрөлхийн дутуу хөгжилтэй" байдаг;
- Гэмт хэрэг үйлдэхэд хүний биеийн бүтцийн гажгаас гадна хүний амьдарч буй нутаг дэвсгэрийн онцлог чухал үүрэг гүйцэтгэдэг гэсэн санал дэвшүүлсэн.

Горинг болон Хутон нарын дэмжсэн Ломброзын төрөлхийн гэмт зан үйл, биологийн төрөл зүйлийн гажгийн талаарх үзэл баримтлалууд хожмоо XIX зууны төгсгөл, XX зууны эхэн үеэр хөгжин цэцэглэж байсан, төрөлхийн ухаан муутай байдал, удамшлын гэмт зан үйл, дотоод шүүрлийн тэнцвэргүй байдлын талаарх онолуудад тусгалаа олсон.

Биеийн бүтцийн онол

Гэмт хэрэг ба бие махбодын шинжүүдийн хоорондын холбоог хэд хэдэн эрдэмтэн тайлж, XX зууны эхний хагаст биеийн хөгжил, бүтцийн харьцааг харьцуулан судалсан. Эдгээр эрдэмтдийн нэг төлөөлөгч нь Эрнест Кретсчмер бөгөөд тэрээр хүний бие бялдрыг 3 үндсэн хэсэгт хуваасан бөгөөд үүнд, нэгдүгээрт, туранхай, турьхан биетэй хүн, хоёрдугаарт, өндөрдүү биетэй, хүчтэй, чанга ястай хүн, гуравдугаарт, дундаж өндөртэй, бөөрөнхий биетэй, бүдүүн хүзүү, том ам, нүүртэй хүн гэсэн ангилалыг хамруулан авч үзсэн байна.

Туранхай (Cycloid personality) төрлийн биеийн бүтэцтэй хүн нь ихэвчлэн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлддэг бол өндөрдүү биетэй, хүчтэй, чанга ястай хүн (Displastic) биеийн бүтэцтэй хүн ихэвчлэн сэтгэлийн хөөрөл ихтэй, өөрийг хянах удирдан жолоодох чадвар сул хөгжсөн бөгөөд ихэвчлэн бэлгийн хүчирхийллийн шинжтэй гэмт хэрэг үйлддэг, дундаж өндөртэй бөөрөнхий биетэй хүн (Schizoids) ангилалд багтах хүмүүс нь оюун санааны хувьд ямар нэгэн өвчтэй байх нь элбэг бөгөөд хүч хэрэглэсэн гэмт хэрэг үйлдэх магадлал ихтэй байдаг гэжээ.¹⁸

Америкийн нэрт эрдэмтэн В.Шелдон нь Э.Кретсчмерийн ажлыг цаашид хөгжүүлсэн бөгөөд тэрээр 1949 онд Бостонд амьдардаг 200 залууг өөрийн судалгаанд хамруулж, тэдний биеийн хөгжлийг коллежийн оюутнуудын тусламжтайгаар тодорхойлсон. Судалгааны үр дүнд үндэслэн хүний биеийн хөгжлийн 3 хэлбэрийг бас бий болгож чадсан. Үүнд, эндорпи, эстоморп, мезоморп хэлбэр багтдаг. Ихэнх хүмүүст мезоморп шинж, зан төлвийн онцлог байдаг. Мезоморп гэдэг ангилалд бие махбодын хөгжил сайтай, түрэмгий, идэвхтэй хүнийг багтаасан.

Марихуана занимает значительное место среди наркотиков, ввозимых в Россию. Основной поток ее идет через границы с Украиной, Казахстаном и странами Балтии посредством использования железнодорожного транспорта. Почти 30% от всего объема марихуаны, доставляемой в Россию, направляется, из государств Средней Азии. Существует и новый - канал доставки нигерийской ~ марихуаны через Европу в Россию. Вьетнамская марихуана, пакистанский и афганский гашиш и гашишное масло чаще всего попадают сюда морским путем на военных и коммерческих судах.

Оценивая ситуацию в целом, следует заметить, что нередко каннабис играет роль "волка в овечьей шкуре", поскольку многие потребители, начиная регулярно употреблять каннабис, рано или поздно переходят на героин и другие, более сильные наркотики. Каннабис фактически прокладывает им дорогу, вовлекая в круг потребителей все большее количество людей, расширяя и делая более стабильными рынки сбыта сильных наркотиков, приносящих огромные доходы транснациональным преступным организациям, контролирующим их реализацию, и не мешающим более мелким преступным организациям заниматься оборотом "легких" видов наркотиков.

Синтетические наркотики. К синтетическим наркотикам относятся несколько групп препаратов, имеющих различный спектр действия от стимуляторов до барбитуратов, являющихся, по сути снотворными

препаратами. Воздействие наркотических средств этой группы вызывает стойкое привыкание.

За последнее десятилетие в странах Европы значительно возрос спрос на синтетические наркотики, особенно у молодежи. Большим спросом стали пользоваться психотропные вещества, такие как "экстази" и кетамин. При этом резко возросли объемы производства, продажи и потребления "экстази". Соответственно стали возрастать и объемы изъятого из нелегального оборота наркотика. Согласно статистическим данным Интерпола в 1999 году в странах Европы было конфисковано 14 000 000 доз экстази, что почти в три раза превышает аналогичный показатель за 1998 год. Кроме того, в этом же регионе было конфисковано около 1,6 миллиона таблеток, предположительно направляемых - в Северную Америку, еще 1 миллион таблеток предназначался для реализации на других мировых рынках

Метилендиоксиметиламфетамин (МДМА),¹ который и называется "экстази", является сильным стимулятором со слабым галлюциногенным действием. Цена одной дозы в США составляет около 30 долларов, в России — до 60 .

Прибыль на операциях с экстази достигает 2000 процентов, поэтому нелегальный оборот этого средства осуществляется под контролем крупных транснациональных группировок. Распространяется наркотик обычно в местах досуга молодежи, и рекламируется как "легкий" стимулятор. Молодые люди, употребляющие такие таблетки, вскоре, как правило, переходят на более сильные наркотики.

Нидерланды, Польша и Германия являются странами, где налажено мощное нелегальное производство МДМА. Около 80% всех изготавливаемых таблеток экстази приходится на Голландию и Бельгию.

Для международных перевозок главным образом используются курьеры, почтовые экспресс службы; для перевозки крупных партий в страны Южной и Северной Америки - чартерные рейсы авиакомпаний и другие средства транспортировки.

В значительных количествах изготавливаются синтетические наркотики в Соединенных Штатах, особенно амфетамин и его производные. США являются крупнейшим в мире производителем ЛСД - сильнейшего галлюциногена, изобретенного в Америке. Мода на этот наркотик в США привела к тому, что количество наркоманов стало исчисляться десятками тысяч, 90% из которых были студентами колледжей. В 1990 году в США было раскрыто 1200 подпольных лабораторий по изготовлению наркотиков. В настоящее время, в связи с серьезным противодействием правоохранительных органов, производство и употребление ЛСД значительно уменьшилось .

Сегодня серьезную проблему для многих стран представляют другие ; синтетические наркотики, и в частности, метаамфетин, имеющий другое название "лед". Этот наркотик синтезируется на основе эфедрина. В настоящее время Китай является крупнейшим производителем как кристаллического метаамфетина, предназначенного для продажи в Японии, на Тайване, в Южной Корее и на Филиппинах, так и эфедрина, используемого для незаконного производства метаамфетина в Бирме, Таиланде, Тайване и Мексике.

Эти страны-потребители стоят перед серьезной проблемой широкого распространения в настоящее время стимулирующих веществ. Так, например, в Японии, благодаря активным действиям якудза по их распространению, стимулирующие средства на базе амфетаминов употребляются всеми слоями общества, начиная от молодежи и кончая

домохозяйками. За счет широкого круга потребителей, который продолжает увеличиваться, цена на эти вещества падает и сегодня составляет лишь пятую часть их стоимости 20 лет назад (15 \$ за 0,03 гр.). В 1996 году в Японии зафиксировано рекордное количество изъятых в Японии стимулирующих веществ - 650,8 кг.

Аналогичные проблемы испытывают Гонконг, Тайвань и Таиланд, где значительно увеличилось продажа и потребление кристаллического метаамфетина. Правительство этих стран рассматривают сложившуюся ситуацию как угрозу национальной безопасности.

Контроль за производством и реализацией товара осуществляют китайские преступные организации. В последнее десятилетие они наладили сотрудничество с российскими

производителями эфедрина на Дальнем Востоке. Это позволяет им увеличивать объемы поставляемого в Россию эфедрина, где из него изготавливается «лед», который по оценкам, специалистов вышел на первое место в нелегальном обороте наркотических средств в Дальневосточном регионе, угрожая захлестнуть всю страну. Так, в 1997 г. на дальневосточной таможне было изъято около 90 килограммов эфедрина. Это означает, что реально провезено как минимум в 10 раз больше - около 1 тонны.

Цены дозы (0,05 грамма «льда») колеблются от 5 до 20 долларов. Исходя из средней цены этого наркотика, в результате незаконного его оборота в 1996 г. наркодельцы заработали более 120 миллионов долларов. По популярности продажи эфедрин держит на территории России почетное третье место. Впереди только гашиш и наркотики опиоидной группы.

Для транспортировки эфедрина в Россию активно используются российские граждане. Так, при досмотре багажа российских туристов,

прибывших из КНР, только за один раз было обнаружено 82 килограмма эфедрина стоимостью 175 тысяч долларов по ценам «черного» рынка. Кроме того, эти наркотики доставляются в Россию грузовым и пассажирским автомобильным транспортом, следующим через границу с Китаем, или морем в порты Дальнего Востока.

В целом синтетические наркотики занимают доминирующее положение среди других групп наркотических и сильнодействующих веществ. Они не требуют длительного выращивания и связанных с этим возможных потерь (например, в результате засухи, уничтожения плантаций правоохранительными органами и т.п.); минимальный объем вещества (доза может составлять доли миллиграмма) способствует более безопасной транспортировке, а широкий круг потребителей обеспечивает высокие доходы. Кроме того, научно-технический прогресс позволяет синтезировать наркотики нового поколения, более дешевые и более сильные.

Преступления, связанные с наркотическими средствами и психотропными веществами к 2020 году введение в ситуацию в Монголии

1. Преступления, связанные с наркотическими средствами и психотропными веществами:

В 2020 году было зарегистрировано 237 преступлений, связанных с наркотиками и психотропными веществами.

Незаконное употребление наркотических средств и психотропных веществ, указанных в статье 20.7, для незаконных наркотических средств и психотропных веществ в соответствии со статьей 234, а именно 20.7.1 – 202, 20.7.2 – 27, 20.7.3 – 5; 20.8 наркотические средства и психотропные вещества (в том числе наркотические средства и психотропные вещества), указанные в статье - статье 1, а также психотропные средства и психотропные вещества (в том числе наркотические средства и психотропные вещества) не регистрируются.; Незаконный посев растительности растений, указанных в разделе 20.10 ниже - 1 и 236 от общего числа преступлений было зарегистрировано. Он снизился на 88 преступников или на 27,2 процента по сравнению с этим видом преступлений, зафиксированным в 2019 году.³⁹

Уголовное преследование:

Из 311 лиц, совершивших преступления, зарегистрированные в полиции 2020 года, 291- мужчина и 20-женщина.

Жертвами стали участники 2019 года, 77 человек, которые участвовали в опросе в течение 2020 года, и 11,3 процента были в возрасте 13-18 лет, и 334 человека, или 49,2 процента, были в возрасте 19-25 лет, и 209 человек, или 30,7 процента, были в возрасте 26-35 лет, и 60 или 8,8 процента были старше 36 лет.

Ситуация, показанная выше, иллюстрирует, что подростки из целевых групп, как ожидается, перейдут от 19-25 до 19-25 лет в зависимости от классификации проекта «минус 25» с пост 2020 года по 16 марта, и проект осуществляется в рамках проектов,

³⁹ Общие фонды полицейских расследований. Эти данные содержат вышеприведенные показатели преступности как на национальном, так и на местном уровнях полиции.

осуществляемых 211 классами 1079 и 29112 классами учащихся 1079 классов и их родителей на основе наркотических средств и психотропных препаратов, предлагаемых, организуются мероприятия.

2. Наркотические средства и психотропные вещества современное состояние связанной с ними преступности:

Наркотические средства и психотропные вещества поставляются в нашу страну со следующими изменениями. К ним относятся:

1. Принимаются решения о нагрузке на пограничные посты Внутренней Монголии и Китая, такие как въездные ворота диверсии во Внутреннюю Монголию и провинцию Дорногоби

2. Монгольская Народная Республика была вовлечена в это мероприятие, потому что они включают в себя ЛЕД или лед, Гааш, экстази, кокаин и алкоголь.

3. Это относится к числу государственных крупных объектов, используемых для обеспечения лекарствами и другими медицинскими товарами, и монгольские граждане, как ожидается, будут незаконно перевозить их из других стран в связи с безвизовым режимом Монголии.

4. Некоторые европейские страны используют интернет-среду в США, Канаде, Испании, Ирландии, Германии, Нидерландах и Турции для покупки ЛЬДА или льда, гашиша, возвратных веществ и транспортировки Международных почтовых услуг.⁴⁰

К числу следующих мер, принимаемых на границе Монголии, относятся:

- Грузовые услуги;
- Международное почтовое сообщение;
- Грузовые перевозки /скрыть импортные товары/;
- Маркировка контейнеров, упаковка и покрытие камуфляжем;
- Контрабандист внедряется в мир, как и интернет.

Ниже приведены примеры некоторых способов продажи:

- Используйте hide /send to a location после получения оплаты в определенном месте./;
- Использование чужих аккаунтов;
- Из рук в руки;
- Замена бартера /бартер/;
- Город и город для приобретения незаконных наркотических средств и психотропных веществ через грузовые и пассажирские перевозки.

Следующие действия, которые необходимо предпринять:

Законы и нормативные акты; предупреждать молодежь от этого вида преступлений, предупреждать молодежь и молодых людей от совершения злоупотребления наркотиками и психотропными веществами; содействовать нахождению жилых зданий в безопасном убежище и защите; разоблачать преступность и преступления; устанавливать эффективный и закрытый подход с целью всеобъемлющей и частичной финансовой защиты, основанный на фактических данных из источников информации о наркотиках и психотропных веществах., положительные результаты показали снижение продаж.

СМИ, опубликованные в 2020 году на цифровом сайте новостей о наркотиках и психотропных веществах, опубликовали 175 статей о криминальной подоплеке и 64,3 процента официальных и официальных новостей о законах, законодательстве и государственной политике, показывающих официальное мнение исследователей и журналистов о 97 статьях или 35,7 процента соответственно, были опубликованы в месяц в среднем по 23 новости и информации.

/ Дополнительно за последние 5 лет от начала/

Наркотические средства и психотропные вещества

сопутствующие преступления /по состоянию на 2020.12.29/:

За последние 5 лет было зарегистрировано 848 случаев, связанных с наркотическими средствами и психотропными веществами, которые были проверены 1643.

⁴⁰ Х. Доржсурен, "Наркотические средства и психотропные вещества"; "Будущая тенденция преступности, связанной с незаконным оборотом"; "Наркопреступность: причины, условия и методы профилактики" 2019.

В больницах набрали 191 и 328 человек, связанных со злоупотреблением наркотическими средствами и психотропными веществами, количество связанных с наркотиками и психотропными веществами снизилось на 41 или 21,5 процента и 99,2 процента соответственно по сравнению с предыдущим годом.

Из них 23 случая были зарегистрированы в сельской местности: 4 - в Орхонском АЙМАКЕ, 9 - в Дархан-Уульском АЙМАКЕ, 3 - в Селенгинском АЙМАКЕ, 3 - в ТУВИНСКОМ АЙМАКЕ, 3 - в Омноговском АЙМАКЕ и 1-в Дорнодском АЙМАКЕ.

За этот период 6 иностранных граждан /Китай-2, Россия-2, Федеративная Республика Нигерия-2/ 2,0 процента от общего доминирования-прошли тестирование на этот вид государства.

Аудитория по возрасту:

За последние 5 лет по этому делу было расследовано 1367 человек, 83,2% из них были в возрасте от 19 до 35 лет, а 105% - моложе. Следующая картина показывает, что подростки ведут к более молодому возрасту и могут двигаться с 19-25 лет.

Таким образом, тенденции развития мирового наркобизнеса имеют крайне неблагоприятный характер. Мировой наркорынок продолжает оставаться одним из самых стабильных и развивающихся. Наркобизнес является самым высокодоходным видом транснациональной преступной деятельности, влекущим за собой разрушительные социальные последствия, угрозу национальной безопасности стран-потребителей наркотиков, всему мировому сообществу. Производство наркотиков нового поколения позволяет снижать цены и вовлекать в нелегальный их оборот все большее количество людей, что позволяет значительно увеличивать прибыль. Структурная организация ТПО помогает легко уходить от ответственности, жертвуя только низовыми звеньями розничной торговли и курьерами. Транснациональность характера деятельности не позволяет юрисдикциям отдельных стран эффективно бороться с наркобизнесом. При этом наркобизнес активно стимулирует другие виды транснациональной преступной деятельности, а также коррупцию и легализацию преступных доходов.

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН БУРУУТАЙ ҮЙЛДЭЛД ШОШГОЛОЛТЫН ОНОЛЫН НӨЛӨӨЛӨЛ

*Э.Дашгаадан
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн багш,
докторант, цагдаагийн ахлах дэслэгч*

Товч агуулга: Шошгололтын онол, үзэл баримтлалд тулгуурлан нийгмийн дунд сөрөг нөлөө үзүүлдэг гэмт хэрэг, зөрчил, тэр дундаа цагдаагийн алба хаагчдын нийтлэг гаргадаг эрх зүйн зөрчлийн шалтгаан, нөхцлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх арга замын талаар авч үзсэн.

Түлхүүр үгс: Гэм буруу, үйлдэл, цагдаагийн алба хаагч, зөрчил, шошгололтын онол, нэг, хоёрдугаар хазайлт.

Оршил

Шошгололтын онол /labelling theory/ нь Дюркгейм ба Симмелсийн тодорхойлсноор аливаа зүйл, үзэгдлийн шинж чанар, онцлогийн нөлөөнөөс шалтгаалдаг нийгмийн шинжлэх ухааны томоохон асуудал болох аномн үзэгдлийн суурь болж, норм, дүрэм, журмаас хазайх тухай үзэл санааг илэрхийлдэг чухал ойлголт юм.

Дюркгейм нийгмийн харилцаа нягтарших тусам ёс суртахуун багасна гэх таамаар нийгэм, эдийн засгийн ялгаатай байдалд байгаа хүмүүсийн дунд тодорхой нэг хэсгийн зохион бий болгосон дүрэм, журамд нь үл нийцэх үйлдэл, хандлагыг зөрчил гэж тодорхойлж, улмаар нийгмийн ихэнх хэсэгт албадлага хэрэглэх үйл явцыг судалсан байна.

Шошгололтын онолын ерөнхий санаа нь нийгмийн сэтгэл судлал дахь Мидийн үзэл санаатай ижил бөгөөд эго үзэл, бусдыг шүүмжлэх үзэгдэлтэй адил төстэй юм. Хэн нэгнийг доромжлон хочлох нь бусад хүмүүсийн тухайн хүнд хандах хандлагад шууд нөлөөлөх ба тухайн хүний нийгмийн харилцаан дахь байр суурийг өөрчилдөг.

Аль ч оронд ядуу, гэр оронгүй, боловсролгүй, үзэмжгүй хувцастай өөрөөр хэлбэл, нийгэм, эдийн засгийн түвшин доогуур иргэд гэмт хэрэг, зөрчилд холбогдох тохиолдол их байдаг бөгөөд тэдгээрийг ийнхүү шошголдог. Цагдаагийн алба хаагчид ихэвчлэн нийгмийн дундаж бүлгээс гаралтай нь гэмт хэрэг, зөрчил үйлддэг, хүчирхийлэл үйлддэг өөрөөр хэлбэл, цагдаа бүдүүлэг, бусдыг зоддог гэх ойлголтыг төрүүлдэг. Тэдний гаргадаг алдаа, сахилгын шийтгэл зэрэг нь яг юунаас шалтгаалдаг талаар авч үзье.

Үндсэн хэсэг

Нийгмийн шинжлэх ухааны суурь ойлголтуудын нэг болох эрх зүйн зөрчил нь товчхондоо нийгмийн үнэт зүйл, дүрэм, журамд үл нийцэх сөрөг зан үйл гэж тодорхойлогддог. Эрх зүйн зөрчил нийгмийн дэг журамд нийцэх, үл нийцэх эсэхийг ард иргэд буюу тухайн нийгэм өөрөө тодорхойлдог.⁴¹ Эрх зүйн зөрчлийг тодорхойлсон олон төрлийн онол байдаг. Эдгээрээс тун сонирхолтой нь шошгололтын онол юм. Хүн нийгмийн харилцаанд орох явцдаа нийгмийн аль нэг дүрэм, журмыг зөрчсөн бол түүнийг “үл бүтэх этгээд” хэмээн нэр, хоч зүүх бөгөөд ард иргэд тухайн хүнийг тэр өнцгөөс л харна. Тухайн хүн ч үүнд аажим аажмаар дасах бөгөөд тэр нэр, хоч өөрийнх нь салшгүй нэг хэсэг болно. Тухайлбал, дэлгүүрээс авсан барааны мөнгөө төлөхөө мартаад гарсан хүнийг барьж, түүнийг хулгайч гэж дүгнэн дараагийн удаа тухайн хүнийг орж ирэхэд хамгаалагч нар алдалгүй ажигладаг. Бекер бол энэ онолын гол төлөөлөгчдийн нэг юм. Шошгололтын онолын үзэл баримтлалыг дэмжигчид гэмт хэргийг субъектив талаас нь үнэлж, дүгнэдэг.⁴²

Хүнийг шошголоход тухайн хүний гэр бүл, нийгмийн гарал, гадаад төрх, амьдардаг газар, цалин, ажил, мэргэжил, боловсрол зэргийг нэн тэргүүнд авч үздэг. Тухайлбал, хүн ядуу бол хулгай хийнэ, хүчирхийлэл үйлдэнэ гэж шууд дүгнэдэг. Нөгөө талаасаа өөрийг нь нийгэм, ард иргэд шууд сөргөөр дүгнээд байхаар хүн өөрөө нийгмээсээ зайгаа барьдаг.⁴³

⁴¹ Berry, David. 1974. Central Ideas in Sociology, London: Constable

⁴² Bilton T, Bonnet K, Jones P, Stanworth M, Sheard K, 1987. Introductory Sociology 2nd edition, London: Macmillan

⁴³ Berry, David, 1974, Central Ideas in Sociology, London: Constable

Нэгэнт нийгмийн дунд шошго зүүсэн бол тухайн нэрийг арилгах, ижил тодотгол бүхий бүлгээс салах тун бэрх. Санаатай, санаандгүй ямар нэг байдлаар гэмт хэрэг, зөрчилд холбогдсон бол дараагийн удаа гэмт хэрэг үйлдэгдэхэд цагдаа тэр хүнийг хамгийн түрүүнд сэжиглэнэ.


Ямар нэгэн зөрчил үйлдсэн хүнийг бусад хүмүүс байнга гэм буруутай мэт шошго зүүснээр тухайн хүн бусдаас ялгаатай нэгэн болж эхэлдэг. Хэрвээ тухайн хүн өөрийгөө тиймээр нь хүлээн зөвшөөрөөд эхэлбэл дахин өөрчлөгдөх боломжгүй болдог.⁴⁴

Үүний зэрэгцээ ард иргэд хувь хүний үйлдэл, хандлагаас ч үл хамааран нийгэм, эдийн засгийн нөхцлөөр нь дүгнэдэг. Тухайлбал, өнчин, эцэг эх нь архичин зэргээр хүнийг шууд дүгнэдэг.

Лемерт 1951 онд бичсэн “Нийгмийн патологи: Социопатик хандлага руу үе шаттай шилжих нь” /Social pathology: A Systematic Approach to the Theory of Sociopathic Behavior/ бүтээлдээ гэмт хэргийн шалтгаан юу болох талаар юу ч дурдаагүй байлаа. Түүний хувьд хамгийн чухал нь аливаа нэг гэмт хэрэг үйлдэгдэхэд яг юу болдог гэдэг нь л чухал байсан юм. Лемертийн үзсэнээр ямар нэгэн зөрчилд олон нийт сөрөг хандлага үзүүлэхгүй л бол зөрчил болохгүй юм. Зөрчил үйлдсэн зан үйлийг олон нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмын хязгаар дотор багтана гэж тодорхойлбол энэ нь нэгдүгээр хазайлт болж үлддэг байна.

Лемертийн үзсэнээр хувь хүний мөн чанарын гол өөрчлөлт бол олон нийтийн зүгээс түүний буруутай үйлдэлд сөрөг хандлага үзүүлж, түүнийг ерөнхийд нь буруутгахад илэрдэг. Хүний алдаа буюу Лемертийн тодорхойлсноор нэгдүгээр хазайлт нь тухайн хүнийг тийм ч их буруутгаад байдаггүй бөгөөд олон нийтийн зүгээс хүлээн зөвшөөрсөн дүрэм, журмаар шийтгэхээр заагаагүй бол түүнийг гэмт хэрэг үйлдсэн мэт гадуурхдаггүй. Өөрөөр хэлбэл, тухайн хүнд болон нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй гэсэн үг юм. Харин хүн алдаа, буруутай үйлдэл гаргасан үед нийгэм, олон нийтийн зүгээс сөрөг хариу урвал үзүүлэхэд, өөрийгөө өмөөрч хамгаалах тохиолдолд Лемертийн хоёрдугаар хазайлт руу шилждэг байна. Учир нь хоёр дахь хазайлт гэж тодорхойлсон хандлагаар хүн өөрт нь үзүүлсэн сөрөг хандлага, өөрийг нь дүгнэсэн тодорхойлсонтой зохицон өөрийнхөө бүх зүйлийг өөрчилдөг. Ингэснээр өөрийг нь шошголсон онцлогийн дагуу нийгэмд өөрийгөө харуулж эхэлдэг.

Лемертийн гэмт үйлдлийн механизм



Энэ талаасаа Лемерт ганцхан буруу үйлдэл, зөрчил хүнийг гэмт этгээд болгочихдоггүй, харин хүнийг хүүхэд наснаас нь эхлээд сайн эсвэл муу гэж тодорхойлох, тэр байдал нь байнга давтагдах байдлаар тухайн хүн нь өөрөө өөрийгөө түүнтэй нийцүүлэн өөрчилдөг гэж дүгнэжээ. Үүнээс үзвэл, хөнгөн хэлбэрийн албадлагын арга хэмжээ, шийтгэл нь тухайн хүнийг зөрчил үйлдсэн онцлогийг нь улам бэхжүүлэх, мөн чанар өөрчлөгдөх хэмжээнд хүргэхгүй юм. Хувь хүн зөрчил үйлдэх, энэ хандлагаа үргэлжлүүлэхэд эхлээд түүнийг өөр өөр нэр хочоор дуудах, шошголох, тэмдэглэх, шоолох, хэт шүүмжлэх зэргээс эхлээд олон нийт, нийгмийн зүгээс тодорхой гадуурхах нөхцөл байдал нөлөөлдөг байна.⁴⁵

Лемертийн үзсэнээр хоёр дахь хазайлт хүртэл процесс дараах 8 үе шатаас бүрдэнэ.

Үүнд:

1. Нэгдүгээр хазайлт;
2. Олон нийтийн хариу, шийтгэл;
3. Илүү хазайлт;

⁴⁴ Angenent, Huub and de Man, Anton, 1996, Background Factors of Juvenile Delinquency, New York: Peter Lang

⁴⁵ Lemert, Edwin. 1951. Social Pathology: A Systematic Approach to the Theory of Sociopathic Behavior. McGraw-Hill Book Company

4. Илүү чанга шийтгэл, буруутгах;
5. Илүү хазайлт, шийтгэсэн системд өс санах;
6. Хүлээн зөвшөөрсөн хязгаараас хэтрэх ба гэмт этгээд гэж дүгнэгдэнэ;
7. Шошгологдсон этгээд илүү зөрчил, гэмт хэрэг үйлдэж эхэлнэ.
8. Гэмт этгээд гэх статусыг эзэмшинэ.

Эдгээр үе шатуудад тухайн этгээдийг тодорхойлсон гэмт этгээд гэх тодотгол улам бэхждэг. Үүний дараа хүн өөрийгөө гэмт этгээд гэж ойлгодог.

Лемертийн үзсэнээр анх удаа гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд маш олон шалтгаан байж болно. Ийм учраас шошгололтын онол анхны хэрэг, зөрчлийн шалтгааныг авч хэлэлцдэггүй. Хамгийн гол нь хоёр дахь хазайлт юм. Түүнийхээр бол бүх нэгдүгээр хазайлт хоёрдугаар хазайлтыг үүсгэдэггүй. Хоёр дахь хазайлт бол үйлдсэн гэм буруутай үйлдлийн хариуд олон нийтийн үзүүлж байгаа хариу урвалын үр дүн байдаг.

Орчин үеийн гүн ухаантнуудын нэг Личбах "Рациональ сонголтын онол нь тэр чигээрээ нийгмийн шинжлэх ухаан уу?" /Is Rational Choice all of social science/ бүтээлдээ "Нийгмийн бүхий л бодит байдлыг тодорхойлохын тулд хувь хүнийг байгалийн талаас нь дүгнэх боломжгүй, хангалтгүй гэж үзсэн юм. Учир нь хүмүүсийн хандлага нийгмийн орчноосоо шалтгаалан өөрчлөгддөг"⁴⁶ гэжээ.

Ахмет ба Брайтвейт нар Австрал Улсын нийслэлийн 32 сургуулийн 4, 7 дугаар ангийн 1401 сурагч болон тэдний 978 эцэг, эхэд анкет асуулгын аргаар сургуулийн орчинд дээд ангийн сурагчид доод ангийн сурагчдыг дээрэлхэх, сүрдүүлэх, доромжлох, хүч хэрэглэх нөлөөг судалжээ. Үр дүнд нь зэмлэлийг хүлээн зөвшөөрсөн хүүхдүүд өөрөөсөө бага насны хүүхдийг дээрэлхэх хандлага багассан бол зэмлэлийг хүлээн зөвшөөрөөгүй хүүхдүүд өөрөөсөө бага насны хүүхдийг дээрэлхэх хандлага нь улам нэмэгджээ. Ялангуяа хүүхдүүдээ шошголох өнгө аясаар зэмлэдэг айлын хүүхдүүд бусад хүүхдүүдээс илүү өөрөөсөө бага насны хүүхдийг дээрэлхэж, зоддог гэсэн үр дүн гарчээ. Энэ үр дүнгээс сургуулийн удирдлага болон гэр бүлийн зүгээс үр нөлөөтэй холбоо тогтоох нь маш чухал ач холбогдолтой бөгөөд хүүхдийг аль болох зохистой зэмлэл хэрэглэн сөрөг зан үйлийг засах боломжтой гэж дүгнэжээ.

Картер Хэе АНУ-ын өрнөд хэсгийн нэгэн хотын 197 өсвөр насны хүүхдэд хийсэн судалгаагаар Брайтвейтийн нэгтгэгч зэмлэлийн онолыг туршиж үзжээ. Эцэг, эхийн хүүхдүүддээ хэрэгжүүлж байгаа арга хэмжээ дараа нь хүүхдүүдийнх нь хандлагад хэрхэн нөлөөлж байгааг судалсан энэ судалгаагаар онол батлагдсан үр дүнд хүрсэн байна. Эцэг, эх нэгтгэгч зэмлэлийн шинжтэй арга хэмжээ авах нь эцэг, эх, хүүхдийн харилцаа холбоог улам сайжруулж байсан ба хүүхэд гэм буруутай үйлдэл гаргах түвшин багассан байна.

Хэдийгээр эхний үеийн шошгололтын онолын үзэл баримтлалд ял шийтгэл нь сөрөг үр дагавартай гэж үзсэн боловч ял, шийтгэл нь урьдчилан сэргийлэх нөлөөтэй юу, шошголох нөлөөтэй юу гэдгийг тайлбарлах аргагүй юм. Энэ талаар хийсэн маш олон судалгаагаар аль аль талынх нь үр дүн гарах магадлалтай гэж харагддаг.

Цагдаагийн алба хаагчдаас үйлдсэн сахилга, ёс зүйн зөрчил 2015-2019 онд давхардсан тоогоор 10550 цагдаагийн алба хаагч 10451 сахилгын зөрчил гаргаж шалгагдсан байх ба энэ нь, жилд дунджаар 1894, сард 159, өдөрт 6.2 алба хаагч сахилгын зөрчил гаргасан болохыг илтгэж байна.

Цагдаагийн байгууллагын алба хаагчдын гаргасан сахилга, ёс зүйн зөрчлийг сүүлийн 5 жилээр харьцуулан харахад цагдаагийн байгууллагын нийт бие бүрэлдэхүүний 21.7 хувь сахилга, ёс зүйн зөрчил гаргасан байна.⁴⁷

"Цагдаагийн алба хаагч, иргэдийн хоорондын харилцаа" асуулгад иргэд хариулахдаа 50 хувь нь "дунд", 32 хувь нь "сайн", 3 хувь нь "маш сайн", 4 хувь нь "маш муу", 11 хувь нь "муу" үзүүлэлттэй хариулсан байна.⁴⁸

Судалгаанд хамрагдсан иргэдийн 65 хувь нь "Цагдаагийн алба хаагч, иргэдийн хоорондын харилцаа" дунд буюу түүнээс дор түвшинд үнэлж байгаа нь иргэдийн дунд цагдаагийн алба хаагчийн харилцааны соёл дутмаг, соёлгүй гэсэн ойлголттой болсон,

⁴⁶ Lichbach, Mark I. 2003. Is Rational Choice Theory All of Social Science? Ann Harbor: The University of Michigan Press

⁴⁷ Цагдаагийн Ерөнхий газрын Дотоод хяналт, аюулгүй байдлын газрын 2019 оны үйл ажиллагааны тайлан

⁴⁸ Нийслэлийн 9 дүүргийн цагдаагийн алба хаагчдын иргэдтэй харилцах харилцаанд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох 2 хувьсагчийн судалгааны тайлан. УБ. 2015 он

цаашлаад цагдаагийн алба хаагчдад итгэх итгэл суларсантай холбон тайлбарлаж болохоор байна.

Цагдаагийн алба хаагч бол нэг талаасаа иргэн учраас зөрчил, дутагдал гаргах нь тийм байж боломгүй үзэгдэл биш юм. Энэ өгүүлээр цагдаагийн алба хаагчийн ажил мэргэжилтэй холбоотой зөрчлүүд болон шошгоолтын нөлөөг авч үзэхээр зорьсон.

Цагдаагийн алба бол нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэгтэй байдаг тул гэмт хэрэг, зөрчилд холбогдсон этгээдүүдийг олж тогтоох, тэдэнд таслан сэргийлэх арга хэмжээ авах явцдаа ёс зүйн алдаа дутагдал гаргах тохиолдлууд байдаг. Гэвч нөгөө талаараа хэн нэгний буруутай үйлдлээс болж хамгийн их шүүмжлүүлдэг, хамгийн муу нэр зүүж, шошголуулдаг алба бол цагдаагийн алба байдаг.

Цагдаагийн алба хаагчид хүч хэрэглэдэг, зоддог, эрүү шүүлт тулгадаг, зохион байгуулалттай гэмт хэрэг үйлддэг, авлига, хээл хахуульд нэрвэгдсэн, улс төрчдийн талд ажилладаг зэрэг сөрөг нэр, шошго заримдаа алба хаагчдыг дагаж явдаг. Хэдийгээр нийт алба хаагчид тийм тодотголд багтахгүй ч зарим нэг хэсэг нь үүнтэй эвлэрэх тухайлбал, цагдаагийн алба хаагч хатуу ширүүн харьцахгүй бол иргэд шаардлага хүлээж авдаггүй, архины хамааралтай иргэдийг залхаан цээрлүүлэхгүй бол өөрөөр хэлээд “нэмэргүй”, гэмшдэггүй зэрэг ойлголтыг авсан байдаг. Энэ нь шинээр ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчдад ч сөрөг үлгэр дуурайлал болох магадлалтай байдаг.

Дүгнэлт

Шошгоолтын онолын гол хоёр санаа бол олон нийтийн хариу хандлага, хоёр дахь хазайлт юм. Шошгоолтын онолоор нийгэмд нэг бүхэл үнэт зүйлийн тогтолцоо гэж байхгүй. Харин эсрэгээрээ заримдаа нэг нэгэнтэйгээ зохицдог, заримдаа зөрчилддөг нэгээс олон үнэт зүйлийн тогтолцоо байдаг. Иймээс ямарваа нэг үйлдэл, хандлага аль өнцгөөс харахаасаа шалтгаалан өөрөөр үнэлэгддэг. Гэмт хэрэг, зөрчил ч мөн адил.

Мөн шошголуулах хүний нийгэм, эдийн засгийн байдал, улс төрийн хүч нөлөө зэрэг нь түүнд хандах хандлага, тухайн шошго, түүнд хадгалагдаж үлдэх эсэхэд нөлөөлдөг хүчтэй хүчин зүйл юм.

Нийгэмд хамгийн их муу нэр зүүдэг албадын нэг нь цагдаагийн алба байдаг. Энэ нь тухайн албаны хийж гүйцэтгэж байгаа ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалдаг ч нөгөөтэйгүүр ингэж нэр шошго зүүх нь алба хаагчдын ёс зүй, нэр хүнд, соёл, иргэдтэй харилцах харилцаа, цаашлаад хандлагад сөрөг нөлөө үзүүлэх боломжтой.

Санал

1. Цагдаагийн алба хаагчдын гэмт хэрэг, зөрчил үйлдэх, сахилгын шийтгэл хүлээх болсон шалтгаан, нөхцлийг бодитоор тогтоож, тэдний албаны ёс зүйн үр нөлөөг дээшлүүлэх;
2. Иргэд олон нийтийн хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээнд цагдаагийн алба хаагчийн нэр төрд халдах, тэдний хууль ёсны ажил үүргээ биелүүлэхтэй холбоотой шүүмж, доромжлол зэрэгт хяналт тавих;
3. Цагдаагийн алба хаагчдыг гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэхэд засаг захиргааны анхан шатны нэгжийн хүрээнд иргэд, байгууллагууд оролцсон олон нийтийн бүлгүүдийг үүсгэж, хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих, сурталчлах, нийтийн хэв журам, аюулгүй байдлын эсрэг зөрчил, ёс суртахууны эсрэг зөрчлүүдийг цаг алдалгүй шуурхай мэдээлэх, мэдээлэл солилцох, түгээх ажилд хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх;
4. Улс орон өөр өөрийн үндэсний онцлог шинж, практик туршлагатай хэдий ч цагдаагийн мэргэжлийн ёс зүйг бий болгох, нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх, бодитойгоор хэрэгжүүлэх асуудал бүх улсад адил төстэй байна. Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрт заасан сайн удирдлага зохион байгуулалт зорилтын хүрээнд гадаад орны цагдаагийн байгууллагын сайн туршлагаас ямагт суралцаж үйл ажиллагаандаа нэвтрүүлэх.

Ашигласан материал

1. Angenent, Huub and de Man, Anton, 1996, Backround Factors of Juvenile Delinquency, New York: Peter Lang
2. Berry, David, 1974, Central Ideas in Sociology, London: Constable

3. Bilton T, Bonnet K, Jones P, Stanworth M, Sheard K, 1987. Introductory Sociology 2nd edition, London:Macmillan
4. Lemert, Edwin. 1951. Social Pathology: A Systematic Approach to the Theory of Sociopathic Behavior. McGraw-Hill Book Company
5. Lichbach, Mark I. 2003. Is Rational Choice Theory All of Social Science? Ann Harbor: The University of Michigan Press
6. Цагдаагийн Ерөнхий газрын Дотоод хяналт, аюулгүй байдлын газрын 2019 оны үйл ажиллагааны тайлан
7. Нийслэлийн 9 дүүргийн цагдаагийн алба хаагчдын иргэдтэй харилцах харилцаанд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох 2 хувьсагчийн судалгааны тайлан. УБ., 2015 он

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ОЛОН УЛСЫН БОЛОН ДОТООДЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

Ж.Ууганчимэг
ДХИС-ийн ЭЗНУС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн
дэд профессор, ахмад

Товч агуулга: Хүн худалдаалах гэмт хэргийн олон улсын болон дотоодын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, чиг хандлага, урьдчилан сэргийлэх арга замын талаар санал-зөвлөмж боловсруулсан.

Түлхүүр үг: Хүн худалдаалах гэмт хэрэг, хүнийг хууль бусаар хил давуулах гэмт хэрэг, хүний эрх, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, бэлгийн мөлжлөг, хөдөлмөрийн мөлжлөг, боолчлол, хүний цус, эд, эрхтнийг хууль бусаар авах, хохирогч.

Хүн худалдаалах гэмт хэрэг гэж юу вэ?

НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх конвенцийн Хүн, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай нэмэлт протокол ("Палермо протокол" гэж нэрлэдэг)-д "Хүн худалдаалах гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, хууран мэхлэх, залилах, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл бусдыг хяналтандаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ. Хүнийг мөлжих гэдэгт биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөгт оруулах, албадан хөдөлмөрлүүлэх, боолчлох буюу түүнтэй төстэй нөхцөлд байлгах, эд эрхтнийг авах үйлдлийг ойлгоно" гэж тодорхойлсон.

Олон улс хүн худалдаалах гэмт хэргээс гадна хүнийг хууль бусаар хил давуулах үйлдэлтэй хамтран тэмцэж ирсэн.

Хүн худалдаалах болон хүнийг хууль бусаар хил давуулах гэсэн хоёр ойлголтын ялгааг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- Хүн худалдаалах гэмт хэрэг нь заавал үндэстэн дамнасан байх албагүй харин хүнийг хууль бусаар хил давуулах нь зайлшгүй шаардлагатай.
- Хүнийг хууль бусаар хил давуулах хууль бус байдаг бол хүн худалдаалахыг заримдаа хуулиар хориглоогүй байдаг.
- Хүн худалдаалахад ихэнхдээ хохирогчдыг хүчирхийлж, мөлжлөг оруулдаг бол хүнийг хууль бусаар хил давуулахад бол үгүй.
- Хүн худалдаалахад ихэнхдээ тэгш бус харилцаа өрнөдөг.
- Хүн худалдаалахад зорилгодоо хүрмэгцээ өөр эсвэл шинэ харилцаа үүсдэг бол хууль бусаар хил давуулахад бол үгүй.
- Хүмүүс, ялангуяа эх үүсвэр болсон орнуудын иргэд хүн худалдаалагч болон хил давуулагчдад өөрөөр ханддаг, хил давуулагчдыг эерэгээр буюу өөрсдийг нь зовлонгоос гэтэлгэгч гэж хардаг бол хүн худалдаалагчдыг хууран мэхлэгч, хүчирхийлэл үйлдэгч гэмт хэрэгтэн гэж хардаг.

Эдгээр ойлголт нь зарчмын хувьд ялгаатай ч сүүлийн үеийн баримтад суурилсан судалгаанаас үзэхэд, хууль бусаар хил давуулалт нь явцдаа хүн худалдаалах гэмт хэрэг болсон байна. Ихэнх тохиолдолд өндөр хөгжилтэй улсад ирэх хүсэлтэй хүмүүс хил давуулагч нарт мөнгө төлөн ирдэг, гэхдээ ирсний дараагаар тэдэнд төлбөр нэрийдлээр нэмэлт өртгийг төлж дийлэхгүй, хууль бусаар орж ирсэн учир хууль сахиулах байгууллагад хандаж чадахгүй иргэдийг эрхшээлдээ оруулдаг байна.

Интерполын мэдээлж байгаагаар хүн худалдаалах гэмт хэрэг нь хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хөдөлмөрийн мөлжлөгт ашиглах, цус, эд, эрхтнийг авах мөлжлөгийн хэлбэрээр түгээмэл үйлдэгдэж байна. Гэвч зарим тохиолдолд эрэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгөд ашиглах, хүүхдүүдийг гуйланчлуулах, хүчээр цэрэгт элсүүлэх хэлбэрээр үйлдэгддэг.

НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх конвенцийн 34.2 дугаар зүйлд хүн худалдаалах гэмт хэрэг болон уг конвенцид заасан бусад гэмт хэргүүд заавал үндэстэн дамнасан эсвэл зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн шинжтэй байх

шаардлагагүй хэмээн заажээ. Өөрөөр хэлбэл, хохирогчдыг элсүүлэх, ашиглах үйл ажиллагаа нь тухайн нэг улсын дотор өрнөж болох юм. Мөн энэ нь тухайн гэмт хэрэг нь хувь хүн, гэр бүлийн гишүүд зохион байгуулалт шаардахгүйгээр үйлдэх боломжтой гэсэн үг юм.

Хүн худалдаалах гэмт хэрэг нь хүний үндсэн эрхийг ноцтой зөрчдөг, өндөр зохион байгуулалттай үйлдэгддэг гэмт хэрэг ба Монгол Улс хүнийг албадан хөдөлмөрлүүлдэг, бэлгийн мөлжлөгт ашиглах зэргээс шалтгаалан эх үүсвэрийн болон хүлээн авагч орон болоод байна. Түүнээс гадна хүн худалдаалах гэмт хэрэг нь Европ болон Ази тивд маш ашигтай бизнес болтлоо газар авсаар байгаа нь тун харамсалтай.

Хүн худалдаалах гэмт хэрэгт зохион байгуулалттай гэмт бүлэглэл чухал үүрэг гүйцэтгэдэг. Зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд нь олон төрөлтэй байдаг. Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэж буй гэмт бүлэглэлүүдийн оролцоог баримтжуулах нь төвөгтэй ба судлаачид гэмт бүлэглэлүүдийн сүлжээний мөн чанар, хамрах хүрээний талаарх бидний ойлголтыг гүнзгийрүүлэх тал дээр хийх зүйлс их байна.

Сүүлийн 10 жилийн хугацаанд энэ асуудлыг шийдвэрлэхэд анхаарал хандуулсан хэдий ч хүн худалдаалагчдад ял эдлүүлэх нь бага хэвээр байгаа нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд зөвхөн нэг хэмжээст хандлага хангалтгүй байгааг харуулж байна. Хүн худалдаалах гэмт хэргийг дан ганц гэмт бүлэглэлүүдтэй хамааралтай гэж ойлгох нь хүн худалдаалах үйл ажиллагаа болон оролцоог хэт энгийнээр дүрслэх, шаарлага хангаагүй хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад хүргэж байна хэмээн мэргэжилтнүүд шүүмжлэлтэй ханддаг.

Олон улсад энэ төрлийн гэмт хэрэг нь бэлгийн мөлжлөг, боолчлох, албадан хөдөлмөрлүүлэх, цус, эд, эрхтнийг хууль бусаар авах гэсэн мөлжлөгийн хэлбэрээр ихэвчлэн үйлдэгддэг ба энэхүү гэмт хэргийн хохирогчид нь эмзэг давхрагийн хүмүүс байдаг бөгөөд ихэвчлэн гэмт этгээдүүд тэднийг хууран мэхлэх, эрхшээлдээ оруулахын тулд гэр бүлийнхэнд нь хүч хэрэглэхээр заналхийлдэг байна. Нөгөө талаар хохирогчдын очсон улсад нь цагдаагийн байгууллага авлигад автсан, ямар нэгэн байдлаар холбогдсон байдаг зэрэг шалтгаанаар эрхээ хамгаалуулах боломж хомс байдаг.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн хангалттай хамгаалалт авч чаддаггүйгээс гадна бусдын эрхшээлд үйлдсэн үйлдлийнхээ төлөө гэмт хэрэгтнүүдтэй адил ял шийтгүүлэх тохиолдол цөөнгүй байна. Энэ нь тэдний цагдаагийн байгууллагад итгэх итгэлийг алдагдуулж, хууль сахиулах байгууллагатай хамтарч ажиллахаас зайсхийх нэг нөхцөл болдог байна. Үүний үр дүнд гэмт хэрэгтнүүдийн өширхөлтөөс айсан хохирогчид мэдүүлэг өгөхөөс татгалздаг. Хэдий тэд мөрдөн байцаах ажиллагаанд оролцохоор зөвшөөрдөг ч, цагдаа болон шүүхийн өмнө мэдүүлэг өгөх давхар бэрхшээлтэй тулгардаг. Ингэснээрээ хохирогчид өөрсдөд нь тохиолдсон зүйлсээ дахин санах, дурсах шаардлагатай болдог. Эцэст нь ихэнх хохирогчид өөсдийгөө хохирогч гэж үздэггүй учир цагдаагийн байгууллагад ханддаггүй байна. Тэвчишгүй нөхцөлд амьдардаг хэдий ч тэд эх орондоо үлдсэн хүмүүстэй харьцуулахад хамаагүй дээр нөхцөл байдалд байна гэсэн хандлагатай байдаг байна. Иймээс хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үр дүнтэй арга хэмжээ авахын тулд эх үүсвэр болж байгаа оронд дотоодын зохицуулалт хийх шаардлагатай.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, гэрчийг хамгаалах эрх зүйн орчин өнөөдөр байхгүйтай адил байна. Хохирогчийг хамгаалахаас гадна, туслалцаа үзүүлэх, нөхөн төлбөр олгох, нэр хүндийг нь сэргээх, эргэн нийгэмшихэд зориулж төрийн зүгээс бодитой ажил өнөөг хүртэл хийгээгүй байна. Тухайлбал, Монголд хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогч нь хэргийг хянан шалгах ажиллагаанд эхлээд хохирогч байж байгаад гэмт хэрэгтний ятгалаг, айлган сүрдүүлэлтэд орсноос болж мэдүүлгээсээ буцаж, улмаар өөрсдөө хуурамч мэдүүлэг өгөх явдал гардаг. Мөн энэхүү гэмт хэргийн хохирогч сэтгэл санааны асар их хохирол амссан байдаг бөгөөд энэ хохирлыг тооцох тогтолцоо, эрх зүйн орчин бүрдээгүй гэж хэлж болно.

2019 оны хүн худалдаалах гэмт хэргийн төлөв байдлын тайлангаас үзэхэд, Монгол Улсын Засгийн газар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах хүчин чармайлтаа нэмэгдүүлж, төрөөс 3 жил дараалан хохирогч хамгаалах ажилд санхүүжилт олгоогүй байсан бол хохирогч хамгаалах үйлчилгээний дийлэнхийг үзүүлдэг хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагуудад 95 сая төгрөгийн санхүүжилт өгсөн байна. Монгол Улс ард иргэдээ хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлж, хохирогчийг хамгаалах хүчин чармайлтаа сайжруулах зорилгоор “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний

хөтөлбөр” (2017-2021) болон үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан.⁴⁹ Тухайлбал, 2018 онд төрөөс тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд 709 сая төгрөг төсөвлөсөн байна. Энэхүү төсвөөр хил хамгаалах байгууллагууд эцэг эх, хууль ёсны асран хамгаалагчгүйгээр хилийн дээс алхаж буй 167 монгол хүүхдийг хүн худалдаалахын шалгуур, үзүүлэлтийн дагуу шалгахуйц цагаачлал, харьяатын албаны шинэ програм хангамжийг суурилуулж, хэрэглээнд оруулсан байна. Хэдийгээр эдгээр хүүхдүүд дунд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч илрээгүй ч, хил, гаалийн ажилтнууд тэдний паспортанд яаралтай тусламж шаардлагатай үед хэрэглэх консулын холбоо барих мэдээлэл бүхий хуудсыг хавчуулж, үргэлжлүүлэн хянах зорилгоор биометрийн хувийн өгөгдлийг хууль сахиулах байгууллагад илгээжээ.

Гэмт этгээдүүд хүн худалдаалахын хохирогч болсон гадаад иргэдийг Монгол Улсаар дамжуулан Орос, Хятад зэрэг улс руу нэвтрүүлдэг байж болзошгүй байна. Монгол Улсын иргэдийг албадан хөдөлмөрлүүлэхээр Хятад, Казакстан, Норвеги, Швед, Турк улсад, харин бэлгийн мөлжлөгт ашиглахаар Бельги, Камбож, Хятад, Герман, Хонконг, Япон, Макао, Малайз, БНСУ, Швед, Турк, АНУ болон Монгол Улс дотроо худалддаг байна. Гэмт этгээдүүд зарим үед хар тамхи, олон нийтийн хуурамч сүлжээ, ажлын байрны цахим зар, англи хэлний хөтөлбөрүүд зэргийг ашиглан хохирогчдыг хууран мэхлэх замаар бэлгийн мөлжлөгт татан оруулдаг ажээ.⁵⁰ Иргэний нийгмийн байгууллагын сүүлийн үеийн судалгаагаар гэр бүлийн хүчирхийлэл нь ихэнх монголчуудыг хөдөлмөр эрхлэлтийн аюултай сонголт хийхэд хүргэж, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болгож, гэмт этгээдүүдэд элсүүлэгдэхэд нөлөөлж байна гэжээ.⁵¹

Охид, эмэгтэйчүүд массажны газар, хууль бус эмсийн хүрээлэн, зочид буудал, баар цэнгээний газар, караоке, клубүүдэд бэлгийн мөлжлөгт дотооддоо өртөж байна. Трансжендэр эмэгтэйчүүдийг хөдөлмөр эрхлүүлэхээс гадуурхдаг нийгмийн жигшил зэвүүцэл өргөн тархсан учраас тэд бэлгийн мөлжлөгт өртөх өндөр эрсдэлтэй.

Япон, Өмнөд Солонгос улсын жуулчид хүүхэдтэй бэлгийн харьцаанд орох сонирхлоор Монголд ирдэг гэж өмнөх жилүүдэд тайлагнаж байсан бол иргэний нийгмийн зарим бүлгүүдийн мэдээлж байгаагаар энэ явдал улам газар авсан байж болзошгүй байна. Монгол Улсын өмнөд хэсэгт өрнөж буй уул уурхайн салбарын хөгжил дотоодын болон олон улсын шилжилт хөдөлгөөнийг эрчимжүүлсэн нь ялангуяа Хятад-Монголын хилийн эргэн тойронд хүн худалдаалах гэмт хэргийн эрсдлийг нэмэгдүүлж байна. Өмнөговь аймагт Хятадын хилээр нүүрс тээвэрлэж буй ачааны машины жолооч нарын паспортыг ажил олгогчид нь тээврийн хэрэгслийн барьцаа болгон хураан авч байгаа нь тэднийг хөдөлмөрийн мөлжлөгт өртөх хүчин зүйл болж байна. Эдгээр жолооч нар улсын хил нэвтрэх зөвшөөрөл авч, Хятадад нүүрсээ хүргэж өгөх хүртэл хэдэн долоо хоног, хэдэн сарын туршид хагас нойртойгоор ачааны машины цуваанд байнгын хүлээлгэнд зогсдог байна. Хүргэлт хоцроход үйлчлүүлэгчид цалин хөлсийг нь бууруулдаг учир ийм алдагдал нь тэднийг хөдөлмөрийн мөлжлөгт өртөх эрсдэлд оруулдаг байна. Залуу охид, эмэгтэйчүүд уул уурхайн компаниудыг Хятадын хилтэй холбодог нүүрс тээвэрлэх зам дагуу хил нэвтрэхээр хүлээж буй жолооч нарт болон уул уурхайн жижиг тосгон, хотууд, Өвөр Монголын хил дагуух шөнийн цэнгээний газруудад биеэ үнэлж ашиглуулах эрсдэл өндөр байна. Уул уурхайд ажиллаж буй ажилчид урт хугацааны ээлжийн гарааны үеэр үр хүүхдээ гэртээ орхисноор тэд бэлгийн мөлжлөгт өртөх өндөр эрсдэлд орж байна. Түүнчлэн, бага насны хүүхдүүд бичил уурхайтай холбоотойгоор албадан хөдөлмөр эрхлэлтийн мөлжлөгт өртөж байна.⁵²

Зарим тохиолдолд хүүхдийг хүчээр гуйлга гуйх, хулгай хийх болон хурдан морь унах, мал маллах, эсвэл хогийн цэг дээр хог түүх, барилга зэрэг эдийн засгийн албан бус салбарт хөдөлмөр эрхлүүлж байна. Гэр бүлийн гишүүдийн зүгээс хүүхдийг хүчээр хөдөлмөр эрхлүүлж бэлгийн мөлжлөгт оруулахад хамсаатан болж байна. Эцэг, эхийнх нь гарын үсэг зурж байгуулсан гэрээний дагуу ажиллаж буй уран нугараач Монгол охидыг гол төлөв Монгол, Турк, мөн цөөн тоогоор Хонконг, Сингапурт албадан хөдөлмөр эрхлүүлж байна. Монгол хөвгүүд Хятад улсын хилийн боомт дээр хурдан морь унаач болон циркийн жүжигчнээр тодорхойгүй

⁴⁹ Хүн худалдаалах асуудлаархи төлөв байдлын 2019 оны тайлангаас...

⁵⁰ Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хохирогч төвтэй аргачлалыг хэрэглэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж болон сургалтын гарын авлагыг харьцуулах, албан хаагчдын чадавхыг үнэлэх судалгааны тайлан. УБ., 2017. 27 дахь тал

⁵¹ Мөн тэнд

⁵² “Хүн худалдаалах гэмт хэргийн шийдвэрлэлт” судалгааны тайлан. УБ., 2009. 13 дахь тал

хугацаагаар ажиллаж, 6 сар тутам хүн дагуулж гэрт нь очуулах гэсэн нөхцөлтэйгөөр ажиллуулдаг нь хүчээр хөдөлмөр эрхлүүлэх, бэлгийн мөлжлөгт өртөх өндөр эрсдэлд хүргэж байна. Ийнхүү олон давтамжтай хилийн дээс алхуулж нүүлгэх нь тэднийг хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг байна. Монгол эмэгтэйчүүдийг Хятад эрчүүд, мөн сүүлийн үед давтамж нь буурсан ч Өмнөд Солонгосын эрчүүдэд арилжааны зорилготой зуучлалаар гэр бүл болгосны дараа гэртээ зарцлах, эсвэл хүчээр биеийг нь үнэлүүлж байна. Сүүлийн үед Хятад компаниуд монгол эрчүүдийг хөдөө аж ахуйн чиглэлээр хөдөлмөрийн хөлснөөс хэт доогуур цалин, тодорхой бус цагаачлал, харьяатын статустайгаар ажиллуулж байгаа нь тэднийг хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэлд оруулж байна. Зарим бичил зээл олгодог Хятад байгууллагууд Монголчуудын паспортыг барьцаанд авдаг нь тэднийг цагаачлал, харьяатын статустай холбоотой албадлагад өртөхөд хүргэдэг байна. Монгол Улсад барилга, үйлдвэрлэл, газар тариалан, ой мод, загас, ан агнуур, бөөний болон жижиглэнгийн худалдаа, автомашины засвар, уул уурхайн салбарт гэрээгээр ажиллаж буй Хойд Солонгос болон Хятад ажилчид хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх магадлалтай байна. Тэдний заримыг хилээр орж ирмэгц гэрээг нь өөрчилж, цагаачлал, харьяатын албаны хууль дүрмийг зөрчсөн нэрийдлээр албадан эрхшээлдээ оруулах эрсдэл байна. Хойд Солонгосын ажилчид хүнд, хэцүү нөхцөлд ажиллаж амьдардаг ба чөлөөтэй зорчих, ажлын байраа сонгох эрхгүйн дээр цалин хөлснийхөө өчүүхэн хэсгийг гар дээрээ авдаг байна. Энэ бүхэн бол хүний эрхийг зөрчиж байгаа ноцтой зөрчил юм.⁵³

Гэмт хэргийн статистик мэдээнээс үзэхэд, Монгол Улсад энэ төрлийн гэмт хэргийн гаралт өсөх, нийгмийн хор аюул нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, цагдаагийн байгууллагад 2006-2018 онд бүртгэгдсэн уг төрлийн гэмт хэргийн байдлаас үзэхэд, 2003-2009 онд хүн худалдаалах гэмт хэрэг 30-42 бүртгэгдэж өссөн бол сүүлийн 3 жил тогтворжих хандлагатай байгаа боловч энэ нь эрх зүйн орчин боловсронгуй бус, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах албан хаагчид энэ төрлийн гэмт хэргийн талаар нэг мөр ойлголцгүй, хохирогч гэрчийг хамгаалах тогтолцоо бүрдээгүй зэргээс шалтгаалан хүн худалдаалах гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгдэхгүй, бүртгэгдсэн ч шүүхээр хянан шийдвэрлэгдэхгүй, улмаар хэрэгсэхгүй болох, шүүхээс хэргийн зүйлчлэлийг өөрчлөх тохиолдол цөөнгүй байна.⁵⁴

Учир нь хүн худалдаалах хэргүүдээс үзэхэд, эмэгтэйчүүдийн биеийг нь үнэлүүлэх болон бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөгт ашигласан байдаг учраас практикт энэ төрлийн гэмт хэргийг бэлгийн мөлжлөг гэмт хэргээс ялган зүйлчлэхэд хүндрэл гардаг.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхийн тулд хамгийн эхэнд авах арга хэмжээний нэг нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлын хамгаалах, хохирлыг нөхөн төлүүлэх, энэхүү хууль бус үйл ажиллагаанаас ашиг хүртэгчдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх явдал юм.

Хүн худалдаалах гэмт хэрэгт зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн оролцооны талаар бодит баримтад суурилсан судалгаа, найдвартай мэдээлэл маш бага байдаг. Учир нь эдгээр үзэгдлүүд дэх хүмүүсийн оролцоо маш далд явагддаг учир шаардлага хангахуйц мэдээлэл цуглуулах бэрхшээлтэй байдагтай холбоотой. Практикт суурилсан, мэдээлэлгүй бол хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг үр дүнтэй арга хэмжээ авах боломжгүй.

Шүүхээр шийдвэрлэгдсэн хүн худалдаалах гэмт хэргүүдээс үзэхэд, сэтгэл санааны хохирол нэхэмжилсэн хохирогч цөөнгүй байсан боловч үүнийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад барагдуулаагүй байна. Энэ мэтээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын эрх, ашиг сонирхол зөрчигдсөөр байна.

Дээрхээс гадна хүн худалдаалахын хохирогчид нь ихэнхи тохиолдолд өөрийн холбогдож байгаа эрүүгийн хэрэгт гэрч болох шаардлагатай болдог нь хохирогч-гэрчийг хамтад нь авч үзэж, хамгаалахыг зүй ёсоор шаардаж байна. УИХ-аас 2013 онд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай баталсан хэдий ч энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийг хамгаалахад учир дутагдалтай байна. Түүнчлэн, Монгол Улсаас гадаадын оронд суугаа Элчин сайдын яамдууд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод тусалцаа үзүүлэх санхүүгийн нөөцгүй байгаа нь харамсалтай.

Ийнхүү хүн худалдаалах гэмт хэрэг улам бүр нарийн зохион байгуулалттай нууц, далд хэлбэрээр үйлдэгдэх болж тэр хирээр хохирогчдын эрх зөрчигдөх байдал улам бүр даамжирч,

⁵³ Сургагч багшийн гарын авлага. УБ., 2018., 15 дахь тал

⁵⁴ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2017. УБ., 2018. 257 дахь тал

түүнийг хамгаалах хамгаалалтын механизмыг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх талаар төр хүлээсэн үүргээ биелүүлж, төрийн бус байгууллагууд идэвхтэй үйл ажиллагаа явуулж, үндэсний хөтөлбөрийг гурван үе шаттай хэрэгжүүлж, Эрүүгийн хуульд тодорхой нэмэлт, өөрчлөлт оруулж, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх бие даасан хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль батлан гаргасан зэрэг ахиц байгаа хэдий ч эрх зүйн зохицуулалтыг цаашид улам бүр боловсронгуй болгох шаардлагатай байна.

Монгол Улсад биеэ үнэлэх, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг, зөрчил нэмэгдэх хандлагатай байна. Биеэ үнэлэгчдийн тоо нэмэгдэж, биеэ үнэлэгчдээс хохирогч элслүүлэх замаар хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэх хандлага нэмэгдэж байна. Ийм байдлаар хүн худалдаалах гэмт хэргийн хүрээ улам тэлж, суурь шалтгаан нөхцөл арилаагүй, хууль сахиулах байгууллагын тогтолцоо, харилцан ажиллагаа, хүн, хүч дутмаг, олон улсын хамтын ажиллагаанаас шалтгаалан тэмцэл төдийлөн үр дүнд хүрэхгүй байна. Энэ бол манай улсын үндэсний аюулгүй байдлын хэмжээнд нөлөөлж буй аюул, эрсдэл мөн.

Энэ төрлийн гэмт хэрэг нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай үйлдэгдэж арга хэлбэрээ байнга өөрчилж, нууц далд, зохион байгуулалтад орж байна. Тухайлбал, бэлгийн аялал жуулчлал голлох нөлөө үзүүлж байгаа бөгөөд хүүхдийн биеийг үнэлүүлэх явдал гарч байна. Түүнчлэн, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин, нийгмийн сүлжээнд (facebook, messenger, skype гэх мэт) тавих хяналт сул, түүний хэрэглээ, хүрээ улам бүр нэмэгдэхийн хирээр хохирогч хамгааллын цогц үйлчилгээг бий болгох, шинээр боловсруулж буй хуулийн төслүүдэд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх зохицуулалтыг оновчтой тусгаж өгөх шаардлагатай.

Энэ төрлийн гэмт хэргийн хохирогч, гэрчийг хамгаалах эрх зүйн орчин төгс бүрдээгүй байна. Тухайлбал, Монголд хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогч нь хэргийг хянан шалгах ажиллагаанд эхлээд хохирогч байж байгаад гэмт хэрэгтний ятгалаг, айлган сүрдүүлэлтийн улмаас мэдүүлгээсээ буцаж, улмаар өөрсдөө хуурамч мэдүүлэг өгсөн хэмээн буруутгагдаж гэмт хэрэгтэн болсон гашуун сургамж байдаг. Мөн энэхүү гэмт хэргийн хохирогч сэтгэл санааны асар их хохирол амссан байдаг бөгөөд энэ хохирлыг тооцох тогтолцоо, эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Ашигласан материал

1. С.Гантулга. “Хүн худалдаалах гэмт хэрэг”. /нэмж засварласан 2 дахь хэвлэл/. УБ., 2013
2. “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2018”. УБ., 2019
3. Шүүхээр шийдвэрлэсэн байдлын судалгааны тайлан. Нийслэлийн шүүх, Хүний аюулгүй байдлын судалгааны төв. УБ., 2018
4. “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: Албан хаагчдыг чадавхжуулах нь” /сургагч багшийн гарын авлага/. УБ., 2018
5. Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн зураглал. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хүйсийн тэгш эрхийн төв, Хүний аюулгүй байдлын судалгааны төв. УБ., 2012
6. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх шууд тусламжийн гарын авлага. Олон улсын шилжин суурьшлын байгууллага. УБ., 2015
7. 2019 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан

ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР ХӨРӨНГӨЖИХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРҮҮГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

О.Билэгжаргал

*ДХИС-ийн Цэргийн албаны зохион байгуулалт, бэлэн байдлын газрын
зэвсэг, хангалт хариуцсан ахлах офицер, цагдаагийн ахлах дэслэгч*

Товч агуулга. Авлигын гэмт хэрэг, ялангуяа үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн эрүүгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, энэ төрлийн гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулах, прокурорын хяналт, шүүхээс хэргийг хянан шийдвэрлэхэд тулгамдсан асуудлыг тодорхойлсон.

Түлхүүр үг. Авлига, хөрөнгө, гэмт хэрэг, гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил.

НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутеррес олон улсад авлигын гэмт хэргийн улмаас жилд 3.6 их наяд ам.долларын хохирол учирч байгаа бөгөөд энэ нь ихэвчлэн сул институт бүхий хөгжил бага, ажилгүйдлийн түвшин өндөр орнуудад түгээмэл байгаа тухай мэдэгдсэн. Харин манай улсад энэ төрлийн гэмт хэргийн улмаас жилд дунджаар 663.2 тэрбум гаруй төгрөгийн хохирол учирсан нь тухайн онд батлагдсан 7.7 их наяд төгрөгийн улсын төсвийн 8.6 хувьтай тэнцэж байна. Авилга, албан тушаалын гэмт хэргийн хувьд жилд үйлдэгдсэн гэмт хэргийн 0.4 хувийг эзлэх боловч хохирлын хувьд мөнгөн дүнгээр эзлэх жин өндөр байдаг.

ХБНГУ-ын Берлин хотод төвтэй “Транспаренси Интернэшнл” олон улсын байгууллагаас жил бүр тухайн улсын төрийн алба дахь авлигын талаар шинжээч, бизнес эрхлэгчдийн төсөөлөлд үндэслэн Авлигын төсөөллийн индексийн 2020 оны үр дүнг зарласан. Авлигын төсөөллийн индексийн дүнгээр Монгол Улс 2020 онд 35 оноо авч, 180 улс орноос 111 дүгээр байрт эрэмбэлэгдсэн байна. Энэ нь өмнөх оныхтой ижил оноотой боловч 5 байраар ухарсан үзүүлэлт болж байна.

Монгол Улс 2019 онд 106 дугаар байранд, 2018 онд 93 дугаар байр буюу 37 оноотой үнэлэгдсэн, 2012 онд 36 оноо (94 дүгээр байр), 2013 онд 38 оноо (83 дугаар байр), 2014 онд 39 оноо (80 дугаар байр), 2015 онд 39 оноо (72 дугаар байр), 2016 онд 38 оноо (87 дугаар байр), 2017 онд 36 оноо (103 дугаар байр)-ыг тус тус эзэлж байсныг дурдах нь зүйтэй байх.⁵⁵

Монгол Улсын үнэлгээнд ашигласан эх сурвалж, оноор

Д/д	Байгууллага-судалгаа	2017	2018	2019	2020	20 – 21 Өөрчлөлт
1	"Пи Ар Эс" групп - Эрсдэлийн үнэлгээ 2020	32	32	35	41	6↑
2	"Ай Эм Ди"-Дэлхийн өрсөлдөх чадварын эмхэтгэл Үзэл бодлын судалгаа 2020	33	30	28	32	4↑
3	Ардчиллын олон талт байдлын төсөл /V-Dem/ 2020	35	33	31	34	3↑
4	Дэлхийн эдийн засгийн форум - Үзэл бодлын судалгаа 2019	30	31	28	28	→
5	"Бертелсман" сан - Шилжилтийн индекс 2020	41	41	37	37	→
6	Дэлхийн банк - Улс орны бодлого, институцийн үнэлгээ 2019	43	43	35	35	→
7	Эдийн засгийн мэдээллийн нэгж - Улс орнуудын эрсдэлийн үнэлгээ 2020	37	37	37	37	→
8	Дэлхийн эрх зүйн төсөл- Хууль дээдлэх ёсны индекс 2019	36	36	36	33	3↓
9	"Глобал инсайт" байгууллага - Улс орнуудын эрсдэлийн түвшин 2019	35	47	47	35	12↓
Дундаж оноо		36	37	35	35	→

⁵⁵ "Транспаренси Интернэшнл Монгол" 2020 оны тайлан

“Транспаренси Интернэшнл” олон улсын байгууллагаас Монгол Улс боломжит 100 оноо авахаас 35 оноо авсан нь үндсэн шалтгаан нь төрийн албан хаагчид эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах байдал нэмэгдснээс хамаарсан байж болох судалгааны дүн гарсан.⁵⁶

Авлига нийгэмд газар авч эхэлдэг бөгөөд ужгирвал түүний хор нөлөөнөөс ангид үлдэх нийгмийн салбар байдаггүй онцлогтой. Улс төр, эдийн засаг, оюун санааны бүх хүрээнд үүрлэж, тогтолцооны шинжтэй болсон авлига тухайн улсын үндэсний аюулгүй байдлын баталгааг алдуулах аюултай. Авлига улс төрийн хүрээнд үүрлэх нь улсын хөгжлийн бодлогыг алдагдуулж түүнээс үүдсэн бусад олон талын таагүй үр дагаврыг үүсгэдэг.⁵⁷

Авлигын хор хөнөөл нийгмийн оюун санааг хүчтэй хордуулж шударга ёсыг ганхуулдаг нь нэн хортой бөгөөд эргэж эрүүлжүүлэн сэргээхэд маш урт хугацаа, хүчин чармайлт шаарддаг. Нийгэмд авлига газар авч сэргэлэн, ухаантай хүүхэд сургуульд сурч чадахгүй, эрдэм чадалтай хүн түүнийхээ ид хавыг үзүүлэх албан тушаалд томилогдох найдваргүй, ердийн амьжиргаандаа шаардагдах аливаа зөвшөөрөл, шийдвэрийг танил тал, хээл хахуульгүйгээр хөөцөлдөөд нэмэргүй, өөрөөр хэлбэл алхам тутамд нь авлига шаарддаг болсон бол нийгмийн гишүүд эхлээд цочирлон бухимдаж байснаа сүүлдээ энэ байдал даамжрахын хэрээр цөхөрч дасан зохицохоос өөр аргагүй байдалд хүрнэ.

Энэхүү дасан зохицох шатанд сайн муугийн тухай нийгмийн ёс суртахууны үнэлэмж өөрчлөгдөж, авлигадаж ажил бүтээхийг ердийн зүйлд тооцох, авлигачдыг нийгэмдээ сайн зохицон амьдарч чадаж байгаа сэргэлэн хүмүүс гэж даган дуурайх, шударга хүнийг тохуурхан гадуурхах зэрэг нь авлига хавтгайрсаны хожуу үеийн шинж тэмдэг юм.

Авлигын бүх хэлбэрт эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь авлигатай тэмцэх ажлын нэг гол бүрэлдэхүүн бөгөөд шүүх тогтолцооны тусламжтайгаар шударга бус явдлыг таслан зогсоож, зөрчигдсөн эрхийг сэргээж, авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явдал юм. Харин шүүгчийн, өргөн утгаараа шүүхийн алдаатай үйл ажиллагаа нь авлига авах хөрс суурийг бэлтгэж өгдөг учир ийм орчинд хамгийн сайн хууль ч ач холбогдлоо алддаг.

Авлига нь дэлхийн олон оронд шүүх тогтолцоог сулруулж, хохирогч, яллагдагчийн шударга, тэгш эрхтэйгээр шүүхээр үйлчлүүлэх үндсэн эрхээ эдлэх боломжийг хязгаарлаж байгаа учир авлигад автагдсан шүүх тогтолцооны нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөг нарийн тогтоох амаргүй байдаг. Ийм шүүх тогтолцоо нь үндэстэн дамнасан гэмт хэрэг болон терроризм, мөнгө угаах гэмт хэрэгтэй хийх олон улсын хамтын ажиллагааг сулруулж, худалдаа, эдийн засгийн өсөлт болон хүний хөгжлийг удаашруулж ялангуяа иргэд хоорондын болон иргэн, төрийн байгууллага хооронд үүссэн маргааныг эрх тэгш байдлаар шийдвэрлэх ажиллагаанд хүндрэл учруулдаг.


Эцэстээ шударга бус харьцаа бүхий авлигад автсан шүүх нь нийгэмд хагарал үүсгэдэг, шүүхийн тогтолцоонд авлига, хээл хахууль газар авснаар төр, засагт итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулаад зогсохгүй төрийн үйл ажиллагааны бүх салбарт авлига газар авах нөхцөлийг эрчимжүүлдэг.

Авлига, албан тушаалын гэмт хэрэгт авилгатай тэмцэх газраас хэрэг, бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан байдал:

⁵⁶ “Транспаренси Интернэшнл Монгол” 2020 оны тайлан


⁵⁷ Авлигын гэмт явдал. Хууль зүйн үндэсний хүрээлэн. УБ., 2010. 9 дэх тал

1.Авлигатай тэмцэх газрын хүлээн авсан гомдол, мэдээлэл /2015-2020 он/



2020 онд 1020 гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шалган шийдвэрлэж, 281 гомдол, мэдээллийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу харьяалах байгууллагад нь шилжүүлсэн. Хянан шийдвэрлэсэн гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл өмнөх оны мөн үеэс 126 нэгжээр буюу 14.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


2.Авлигатай тэмцэх газраас шалгасан эрүүгийн хэрэг /2015-2020 он/⁵⁸



Авлигатай тэмцэх газраас 2015-2020 онд нийт хуульд заасан харьяаллын 6684, 2824 холбогдогчтой, 4669 үйлдэлтэй эрүүгийн хэргийг шалгасан.

⁵⁸ Авилгатай тэмцэх газрын 2015-2020 оны үйл ажиллагааны тайлан


3.Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлт /2015-2020 он/



2015-2020 онд мөрдөн байцаалт явуулсан эрүүгийн хэргээс 844 яллах дүгнэлт үйлдүүлэхээр, 1525 хэрэгсэхгүй болгох саналтайгаар, 3397 харъяаллын дагуу шилжүүлж, 159 өөр эрүүгийн хэрэгт нэгтгэж, 39 түдгэлзүүлж шийдвэрлэсэн статистик мэдээ гарчээ.

4.Эрүүгийн хэрэгт холбогдогчдын албан тушаалын ангилал /2015-2020 он/


Гэмт хэрэгт холбогдсон этгээдийн албан тушаалын онцлогийг доорх байдлаар үзүүлэв.⁵⁹



60

⁵⁹ Авилгатай тэмцэх газрын 2015-2020 оны үйл ажиллагааны тайлан

5.Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийг Эрүүгийн хуулийн зүйл, хэсгээр үзүүлбэл /2015-2020 он/



Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйл /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг/ -2306 буюу 52.1 хувь;

Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйл /Хахууль авах/-807 буюу 13.5 хувь;

Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйл /Хахууль өгөх/-691 буюу 7.0 хувь;

Эрүүгийн хуулийн 22.8 дугаар зүйл /Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/-127 буюу 1.5 хувь;

Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйл /Үндэслэлгүйгээр хөрөнгөжих/-156 буюу 2.7 хувь;

Эрүүгийн хуулийн 22.12 дугаар зүйл /Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах/-112 буюу 1.4 хувь.

Авлига, албан тушаалын гэмт хэргээс бидний сонирхон судалж байгаа 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270 дугаар зүйлд заасан Хууль бусаар хөрөнгөжих, 2015 оны Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргээр зүйлчилж, 2015-2020 онд Авилгатай тэмцэх газраас 156 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна.

Авлига, албан тушаалын гэмт хэргийг шүүхээс хянан шийдвэрлэсэн байдал:

Монгол Улсын хэмжээнд 2015-2020 онд 2002 оны Эрүүгийн хуулийн 28 дугаар бүлэг “Албан тушаалын гэмт хэрэг”, 2015 оны Эрүүгийн хуулийн 20 дугаар бүлэг “Авлигын гэмт хэрэг”-т 1339 хүнд холбогдох 508 хэргийг хүлээн авснаас 251 гэмт хэрэгт холбогдсон 501 хүнд ял оногдуулсан байна.

⁶⁰ Авилгатай тэмцэх газрын 2015-2020 оны үйл ажиллагааны тайлан

График 1.1.Хянан шийдвэрлэлтийг өмнөх онуудтай харьцуулсан байдал



2018 онд авлигын гэмт хэрэг 55.6 хувиар өссөн ч ял шийтгүүлэгчид 20.8 хувиар буурсан дүнтэй байгаа бол 2019 онд гэмт хэрэг 67.8 хувиар, ял шийтгүүлэгчид 2.5 дахин тус тус өссөн байна. Харин 2020 оны бүтэн жилийн байдлаар хянан шийдвэрлэсэн хэргийн тоо өмнөх оноос 2.5 дахин, гэм буруутайд тооцож ял, албадлагын арга хэмжээ авагдсан хүний тоо 2.1 дахин тус тус өссөн дүнтэй гарсан байна.⁶¹

Хүснэгт 1.2.Ял шийтгүүлэгчид зарим бүлгээр

№		2015	2016	2017	2018	2019	2020
1	Урьд ял шийтгүүлсэн	1	2	2	0	0	22
2	Бүлэглэж үйлдсэн	3	1	7	2	2	8
3	Эмэгтэй	11	7	15	5	24	47

Оногдуулсан ял, түүний төрөл: Авлигын гэмт хэрэгт оногдуулсан ялын төрлөөр нь нарийвчлан авч үзвэл, 2015 онд ял шийтгүүлэгчдийн 61.8 хувьд нь, 2016 онд ял шийтгүүлэгчдийн 83.9 хувьд нь, 2017 онд ял шийтгүүлэгчдийн 92.5 хувьд нь, 2018 онд ял шийтгүүлэгчдийн 7.1 хувьд нь, 2019 онд ял шийтгүүлэгчдийн 14.0 хувьд нь хорих ял тус тус оногдуулжээ. 2017 онд 92.5 хувьд нь хорих ял оногдуулж шийдвэрлэж байсан бол 2018 онд 7.1 хувьд нь хорих ял оногдуулж шийдвэрлэжээ. 2015 оны Эрүүгийн хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш буюу 2018 онд ял шийтгүүлэгчийн 66.7 хувь, 2019 онд 65.4 хувьд тус тус торгох ял оногдуулсан байна. Харин 2020 онд ял шийтгүүлэгчдийн 67 хувьд нь торгох ял оногдуулж, 6.4 хувьд нь хорих ял оногдуулсан байна.

Хүснэгт 1.3.Оногдуулсан ял, хариуцлагын төрөл

№	Ялын төрөл	Өсөлт, бууралт					2020
		2015	2016	2017	2018	2019	
1	Торгох	13	5	4	28	70	157
3	Баривчлах	0	0	0	-	-	-
5	Нийтэд тустай ажил хийлгэх	0	0	0		0	0

⁶¹ Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020 оны тайлан

7	Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх	0	0	0	10	20	34
8	Эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн	0	0	0	1	2	2
4	Хорих	21	25	49	3	15	41

Хянан шийдвэрлэсэн хэргийг 2015-2017 оны байдлаар зүйлээр харуулбал:

Огноо	2015		2016		2017	
2002 оны Эрүүгийн хуулийн зүйл	Хэрэг	Хүн	Хэрэг	Хүн	Хэрэг	Хүн
263 дугаар зүйл. Төрийн тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах	5	8	4	4	1	3
264 дүгээр зүйл. Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх	1	0	0	0	1	0
265 дугаар зүйл Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах	0	0	1	1	0	0
266 дугаар зүйл. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх	2	1	0	0	1	1
267 дугаар зүйл. Албан тушаалтны нэр барих	0	2				
268 дугаар зүйл. Хээл хахууль авах	8	10	14	20	11	19
269 дүгээр зүйл. Хээл хахууль өгөх	1	7	1	4	0	27
270 дугаар зүйл. Хээл хахууль зуучлах	0	2	0	1	1	2
271 дүгээр зүйл. Албан тушаалтан хуурамч баримт бичиг үйлдэх	1	0	0	0	1	1
272 дугаар зүйл. Албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандах	4	4	2	1	2	0

Хянан шийдвэрлэсэн хэргийг 2018-2020 оны байдлаар зүйлээр харуулбал:

2015 оны Эрүүгийн хуулийн зүйлээр	2018 он		2019 он		2020 он	
	Хэрэг	Хүн	Хэрэг	Хүн	хэрэг	Хүн
22.1 дүгээр зүйл. Эрх мэдэл албан тушаалын байдлаа урвуулан ашиглах	7	9	17	24	61	95
22.3 дугаар зүйл. Гадаад улсын төрийн байгууллага, ОУ-н байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах	0	0	1	1	1	1
22.4 дүгээр зүйл. Хахууль авах	15	22	23	28	26	41
22.5 дугаар зүйл. Хахууль өгөх	5	15	2	51	21	87
22.8 дугаар зүйл. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах	0	0	1	1	5	7
22.10 дугаар зүйл. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих	0	0	0	1	1	1
22.12 дугаар зүйл. Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах	0	0	2	1	1	2

2002 оны Эрүүгийн хуулийн 270 дугаар зүйлд заасан “Хууль бусаар хөрөнгөжих” гэмт хэргээр зүйлчилж, ял оногдуулсан тохиолдол байхгүй бөгөөд 2015 оны Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэргээр 2019 онд 1 хүн, 2020 онд 1 хүнд тус тус ял оногдуулсан байна.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг

2017-2019 онд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргээр 42 хэрэг нээж шалгасан байх бөгөөд нийт гэмт хэргийн хохирлын хэмжээ 603 тэрбум төгрөгт хүрчээ. Нэг хэрэгт учирсан хохирлыг тооцож үзвэл дунджаар 14.3 тэрбум төгрөгийн хохирол учирсан тооцоо судалгаа байна.

2017-2020 онд дээрх гэмт хэргээр нийт 4 яллах дүгнэлт, 2 шүүхийн шийтгэх тогтоол үйлдсэн байв.



Улсын хэмжээнд анхан шатны шүүхээр 2016, 2017 онд 2002 оны Эрүүгийн хуулийн 270¹, 2015 оны Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлээр яллах дүгнэлт үйлдэж прокуророос ирүүлсэн 4 хэргийг шүүхээс таслан шийдвэрлэсэн байдлыг авч үзэхэд, анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгдэгчийг цагаатгасан шийдвэрийг хяналтын шатны шүүхээс хүчингүй болгож дахин хэлэлцүүлэхээр буцаасан 1, анхан болон давж заалдах шатны шүүхээс хэргийг хянан шийдвэрлэсэн хэргийн зүйлчлэлийг хяналтын шатны шүүх хуралдаанаар өөрчилж тогтоосон 1, анхан болон давж заалдах шатны шүүхээс хэргийг хөөн хэлэлцэх хугацаагаар хэрэгсэхгүй болгож хяналтын шатны шүүх шийдвэрийг хэвээр үлдээсэн шийдвэр 1 буюу эцсийн байдлаар прокурорын яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэгт ял шийтгүүлсэн тохиолдол 1 тус тус байна.

Монгол Улс авлига, албан тушаалын гэмт хэрэг тэр дундаа “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэргийг анх олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх үүднээс Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 20 дугаар зүйлийг хэрэгжүүлж, 2002 онд Эрүүгийн хуулийн 270 дугаар зүйлд, дараа нь 2015 оны Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэдэг томъёоллоор гэмт хэрэгт тооцсон.

Тухайн гэмт хэрэгт яллагдсан этгээдийг анхан болон давж заалдах шатны шүүхээс цагаатгах, гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгох, эсхүл анхан болон давж заалдах шатны шүүхээс шүүгдэгчийг үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэрэгт гэм буруутайд тооцсоныг хяналтын шатны шүүхээс албан тушаалын эсрэг өөр гэмт хэргээр зүйлчлэлийг өөрчлөх байдлаар шийдвэрлэх тохиолдолд цөөнгүй байна.

Анхан болон давж заалдах шатны шүүхийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болгосноос бусад шийдвэрүүдийн хувьд “үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа 2002, 2015 оны Эрүүгийн болон Эрүүгийн процессын хуульд заасан гэмт хэргийн бүх шинжийг нотлох, хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоохын тулд хуульд заасан бүх арга хэмжээг авах, шүүгдэгчээс гэм буруугүй болохыг өөрөөр нь нотлуулахаар шаардахгүй байх, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар албадахыг хориглох, шүүгдэгчид сонсгосон ялыг нотлох үүргийг прокурор хүлээх зарчмуудад нийцээгүй талаар онцлон зааж хэргийн талаар нотолбол зохих асуудлууд бүрэн шалгагдаж тогтоогоогүй болохыг Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 482 дугаар шийтгэх тогтоол тэмдэглэн шүүгдэгчийн процессын эрхүүд зөрчигдсөн болохыг дурдаж, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож, шүүгдэгчийг цагаатгасан тохиолдол зонхилж байна. Цөөн хэргийг шүүх эцэслэн шийдвэрлэж шүүгдэгчид ял оногдуулсан боловч хэргийн зүйлчлэлийг өөрчилснөөр “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэгт ял шийтгүүлсэн тохиолдол нэгээс хэтрэхгүй гарсан гэж үзэхээр байна.

Эндээс үзэхэд, “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэргийн мөн чанар, шинж нь гэмт хэргийн сонгодог тодорхойлолтоос ялгаатай, түүнийг нотлох ажиллагааг эрүүгийн процессын

нийтлэг зарчмаас өөр хандлагад тулгуурлан явуулдгаас мөрдөн шалгах ажиллагааг хийж гүйцэтгэдэг болон түүнд хяналт тавьдаг, улмаар хянан хэргийг шийдвэрлэдэг байгууллагуудын хооронд (шүүх хооронд мөн хамаарна) ажлын арга зүй, хууль хэрэглээний зөрүү үүссэн, тухайн гэмт хэргийн шинж, бүрэлдэхүүний болон нотлох ажиллагааны стандартын талаар нэгдмэл ойлголт тогтоогүй, ажилтан албан хаагчдын эрх зүйн хэвшмэл сэтгэлгээ нь энэ төрлийн хэргийн шүүн таслах ажиллагаанд ахиц гарахгүй байгаа шалтгаан байж болзошгүй байна.

Дүгнэлт

Мөрдөгч, өмгөөлөгч, прокурор, шүүгч нарын дунд үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэрэг, түүнийг илрүүлэх, шалгах, тогтоох, хянан шийдвэрлэх талаар нэгдсэн ойлголт бий болохгүйгээр түүнийг бусад төсөөтэй гэмт хэрэг, зөрчлөөс ялгаж оновчтой зөв зүйлчлэх, шүүгдэгчийн процессын эрхийн баталгааг бий болгох, гэм бурууг бодитой тогтоох, шударга шийтгэлийг оногдуулах, бусад оролцогчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хохироохгүй ажиллах нөхцөл орчин бүрдэхгүй нь ойлгомжтой байна.⁶²

Яллах болон шүүн таслах ажиллагааны статистикаас харахад, үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн яллах болон шүүн таслах ажиллагааны шийдвэрлэлт төдийлэн сайнгүй сүүлийн 5 жилийн байдлаар үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагааны тоо өсөж, ахиц дэвшил гарч байгаа ч яллах болон шүүн таслах ажиллагааны хувьд төдийлэн өөрчлөлт гараагүй дээрх шалтгаантай салшгүй холбоотой гэж үзэж байна.

Авлигатай тэмцэх газар авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх суурь нөхцлийг бүрдүүлэх зорилгоор хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг албан тушаалтнуудаас авдаг тогтолцоонд шилжээд нилээдгүй хугацаа өнгөрсөн ч үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах, шүүхээр шийдвэрлэх практик туршлага жигдрээгүй, төрийн өндөр албан тушаалтнууд, эрх бүхий байгууллагууд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх улс төрийн өндөр хүсэл зориггүй байна.

Иймд тус гэмт хэргийн хохирлын хэмжээ мөн тус гэмт хэргийг үйлдэж буй субьектэд хууль бус орлогынхоо эх үүсвэрийг нуун дарагдуулах шаардлага бусад гэмт хэрэг үйлдсэн субьектээс илүүтэйгээр үүсч байгаа зэргийг харгалзан үзэж “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэргийг мөнгө угаах гэмт хэргийн өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргүүдийн нэг хэмээн үнэлдэг.⁶³

Ашигласан материал

Нэг. Хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль. //Төрийн мэдээлэл. 1992. №1
- Авлигын эсрэг хууль. //Төрийн мэдээлэл. 2006. №35
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2012. №8
- Эрүүгийн хууль. //Төрийн мэдээлэл. 2002. №5
- Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/. //Төрийн мэдээлэл. 2016. №7
- Авлигын эсрэг НҮБ-ын конвенц

Хоёр. Ном сурах бичиг, гарын авлага, өгүүлэл

- Авлигын гэмт явдал. Хууль зүйн үндэсний хүрээлэн. УБ., 2010
- Транспаренси Интернэшнл Монгол 2020 оны тайлан
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020 оны тайлан
- Авилгатай тэмцэх газрын 2015-2020 оны үйл ажиллагааны тайлан
- “Шударга ёс” сэтгүүл. №18
- “Шүүх эрх мэдэл” сэтгүүл. 2020. №4

⁶² “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг ба авлигын эсрэг олон улсын конвенциуд дахь түүний агуулга”. Монгол Улсын Дээд шүүхийн шүүгч Ч.Хосбаяр. “Шударга ёс” сэтгүүл. №18

⁶³ “Шүүх эрх мэдэл” сэтгүүл. 2020. №4

АЛБАНЫ НУУЦЛАЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

*Д.Золзаяа
Шихихутаг хууль зүйн их
сургуулийн магистрант*

Товч агуулга. Төрийн болон албаны нууцын онцлог, тэдгээрийн эрх зүйн зохицуулалтын уламжлал, шинэчлэл, хууль тогтоомжийн хэрэгжилтийн зарим тулгамдсан асуудлыг шийдвэрлэх гарцыг тодорхойлохыг зорьсон болно.

Түлхүүр үг. Төрийн нууц, албаны нууц, нууц, эрх зүйн зохицуулалт, уламжлал, шинэчлэл.

Монгол Улсад Төрийн нууцын тухай хууль⁶⁴ 1995 онд, Төрийн нууцын жагсаалт батлах хууль⁶⁵-шинэчилсэн найруулга 2004 онд тус тус батлагдан 2016 оны Төрийн болон албаны нууцын тухай хууль⁶⁶ 2017 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөх хүртэл төрийн нууцыг тогтоох, хамгаалах, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулж байсан байна.

Монгол Улсын Үндсэн хуульд “байгууллагын нууц”, түүнийг хуулиар тогтоохоор заасан нь 1995 оны Байгууллагын нууцын тухай хууль⁶⁷-ийг батлан гаргах эрх зүйн үндэс болсон билээ.

2017 оны 09 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл Монгол Улсад бизнесийн болон албаны нууцыг “төрийн нууц”, “байгууллагын нууц” гэдэг ойлголтод багтаан, түүнийг хамгаалахтай холбогдсон харилцааг тусгай хуулиар зохицуулж ирсэн байна.

Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтаар хүний эрх, нэр төр, алдар хүнд тухайн байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор холбогдох хуулиар нууц гэж тогтоосон мэдээ, баримт, бичиг, биет зүйлийг байгууллагын нууц гэж хэлнэ” гэж тодорхойлсон нь албаны нууцад хамаарах ойлголт юм.

Мөн хуулийн 4 дүгээр зүйлд “Хуульд өөрөөр заагаагүй бол байгууллагын албан үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шудрага өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор байгууллага өөрөө нууцалж хамгаалалтаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг байгууллагын нууцад хамааруулж болно” гэж зааж, үүнд хамаарах мэдээллийг байгууллага өөрөө тогтоохоор заасан нь бизнесийн нууцын агуулгыг илэрхийлдэг байна.

Байгууллагын нууц нь хуулиар тухайн байгууллагын хамгаалалтад байх бөгөөд нууцаа хамгаалах журмыг холбогдох хууль тогтоомжид шийцүүлэн өөрөө тогтоож мөрдөнө.

Аливаа байгууллага дараах мэдээллийг нууцлахыг хориглоно. Үүнд:

- тухайн байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл;
- тухайн байгууллагын мэдэлд байгаа бөгөөд хадгалалт, хамгаалалтын горим нь зөрчигдсөн тохиолдолд хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цацраг идэвхт бодисын хор хөнөөлийг тодорхойлсон мэдээлэл;
- гэмт хэргийн тухай болон нийтэд мэдээлэхээр хуульд заасан бусад мэдээлэл.

Түүнчлэн төрийн нууцтай салшгүй холбоотой төрийн байгууллагын албаны нууцыг бизнесийн байгууллагын нууцтай хамтатган Байгууллагын нууцын тухай хуулиар зохицуулж, албаны нууцыг тогтоох, хамгаалах асуудлыг байгууллага өөрөө буюу “үзэмжээрээ” шийдвэрлэхээр орхисон.

Монгол Улсад албаны нууцын тухай ойлголт бүдгэрч, түүнийг хамгаалах төрийн байгууллага, албан тушаалтны үүрэг, хариуцлага суларч энэ хугацаанд албаны нууцыг

⁶⁴ Төрийн мэдээлэл сэтгүүлийн 1995 оны №7 дугаарт нийтлэгдсэн бөгөөд уг хуульд таван удаа нэмэлт, өөрчлөлт орсон ч зарчмын шинжтэй өөрчлөлт ороогүй байна.

⁶⁵ Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2004 оны №4 дугаарт нийтлэгдсэн.

⁶⁶ Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2017 оны №11 дугаарт нийтлэгдсэн.

⁶⁷ Төрийн мэдээлэл сэтгүүлийн 1995 оны №7 дугаарт нийтлэгдсэн.

хамгаалах үйл ажиллагааны мэргэжлийн удирдлага, зохицуулалт, хяналтыг хангах механизм Монгол Улсад үгүйлэгдэж байсан.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал⁶⁸-ын 3.6.3.2-т “төрийн мэдээллийн ангилал, нууцын зэрэглэлийг оновчтой болгож, нууц хамгаалалтыг шинэ түвшинд гаргах эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно”, Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 266.3-д “Төрийн нууцыг хамгаалах тухай хуулийн төслийг шинээр боловсруулж, холбогдох эрх зүйн актуудыг боловсронгуй болгох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ” гэж заасан.

Иймд тагнуулын байгууллагаас өнөөгийн бодит хэрэгцээ, шаардлага, гадаад орнуудын нийтлэг жишиг, туршлага, өөрийн орны онцлогт нийцүүлэн төрийн болон албаны нууцыг хамгаалах эрх зүй, удирдлага, зохион байгуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Төрийн болон албаны нууцын тухай хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлснээр Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн хуралдаанаар баталсан.

Энэхүү хуульд задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалтад байх мэдээллийг албаны нууцад хамааруулан “албаны нууцын тухай” хууль зүйн нэр томъёоны тодорхойлолт өгсөн.

Гэхдээ албаны нууц нь төрийн нууцын нэг хэсэг ч биш, байгууллагын нууцын бүрэлдэхүүн хэсэгт хамаарах төрийн байгууллагын албаны нууц болно.

Ийнхүү төрийн болон албаны нууцыг нэг хуулиар зохицуулсан нь эдгээр нууцад хамаарах мэдээллийг өөрчлөх, эзэмших, ашиглах хамгаалах субъект нь зөвхөн төр болдог, тэдгээрийг хамгаалах арга, хэлбэр нь зарчмын хувьд адил байдаг зэрэг шинжийг харгалзан үзсэнтэй холбоотой байна.

Улсын хэмжээнд тагнуулын байгууллага нь төрийн болон албаны нууцыг хадгалах, хамгаалах, ашиглах үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах хуулийн зохицуулалттай болсон билээ.

Гэвч Төрийн болон албаны нууцын тухай хуулиар төрийн болон албаны нууцын 2 харилцааг зохицуулж эхэлснээс хойш хэрэгжилтийн зарим бэрхшээлүүд үүссэнийг судлаачид тэмдэглэж байна.

Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа олон хууль, журамд “төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах, хамгаалах” ойлголт хууль зүйн техникийн хувьд хуучин хэвээр тусгагдсныг Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан үзэл баримтлалын хүрээнд “төрийн болон албаны нууц, байгууллага, хувь хүний нууц” өөрчлөх нь иргэн, албан тушаалтнуудад албаны нууцын тухай ойлголтыг өөрчилөх улмаар түгээн сурталчилах нөхцөл болно.

Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдлвэрлэх тухай хууль⁶⁹д 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтөөр Төрийн болон албаны нууцын тухай хуулийн үзэл баримтлалын дагуу хууль зүйн нэр томъёоны өөрчлөлт тусгагдсан байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 24.5 дугаар зүйл.

Мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах

1.Мөрдөгч **байгууллага, хувь хүний нууцтай** холбоотой эрүүгийн хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл, баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтан, хүнээс прокурорын зөвшөөрлөөр гаргуулан авна.

1.Мөрдөгч **төрийн нууц**, хувь хүний эрүүл мэнд, захидал харилцааны нууцтай холбоотой эрүүгийн хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл, баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтан, хүнээс прокурорын зөвшөөрлөөр гаргуулан авна.

/Энэ хэсгийг 2020.01.10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

2.Мөрдөгч энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад мэдээлэл, баримт бичгийг байгууллага, албан тушаалтан, хүнээс **прокурорын зөвшөөрлөөр** гаргуулан авч болно. */Энэ хэсэгт 2020.01.10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

Энэ нэмэлт, өөрчлөлтөөр мөрдөгч нь төрийн нууцтай холбоотой мэдээллийг гаргуулан авахад прокурорын зөвшөөрлөөр харин албаны нууц, байгууллагын нууцтай холбоотой

⁶⁸ www.Legalinfo.mn/law/details/6163?lawid=6163

⁶⁹ Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2017 оны №23-д нийтлэгдсэн.

мэдээлэл, баримт гаргуулан авахад прокурорын зөвшөөрөл шаардахгүй бөгөөд албаны болон байгууллагын нууцын жагсаалтад орсон мэдээлэл, баримт бичгийг байгууллага, албан тушаалтан, хүнээс гаргуулан авч болно.

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг “Задруулах, үрэгдүүлэх тохиолдолд Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, ашиг сонирхол, байгууллага, иргэнд учруулах аюул, занал, хохирлын хэмжээнээс хамаарч төрийн болон албаны нууцад хамаарах мэдээлэл ... зэрэглэлтэй байна” гэж заасан нь албаны нууцад хамаарах мэдээлэл иргэд, олон нийтэд хаалттай байх эрх зүйн зохицуулалт байна.

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлд Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийг хуульчилан тогтоохын зэрэгцээ Засгийн газрын 247 дугаар тогтоолоор Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг баталсан.

Харин албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг үйл ажиллагааны онцлогоосоо шалтгаалан Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийн дагуу тухайн байгууллага ажлын хэсэг гарган боловсруулж тагнуулын байгууллагын саналыг авсаны үндсэн дээр асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн эсхүл байгууллагын дарга баталдаг байна.

Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах үе шат:

- Байгууллага, албан тушаалтны боловсруулсан, хүлээн авсан мэдээлэл төрийн болон албаны нууцын жагсаалтад ороогүй байх;
- нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад оруулах үндэслэл бүхий саналаа нэн даруй удирдлагадаа танилцуулах;
- удирдах албан тушаалтан ажлын хэсэг байгуулан 3 хүртэлх сарын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах;
- Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад оруулах мэдээллийг нууцлах арга хэмжээг авах;
- албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулахаар бол үндэслэл бүхий саналаа эрх бүхий байгууллага, албан тушаалтанд танилцуулна;
- Албаны нууцын жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах эсхүл татгалзах шийдвэр гаргах;
- нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад орсон мэдээллийг нууцлах арга хэмжээг авах.

Түүнчлэн төрийн нууцад болон албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад ороогүй боловч нууцлах шаардлагатай тохиолдолд тухайн байгууллага, албан тушаалтан мэдээллийг нууцлах арга хэмжээ авч, нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад оруулах саналаа нэн даруй удирдлагадаа танилцуулах бөгөөд Засгийн газрын 246 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-д заасны дагуу шийдвэрлэхээр байна.

Тодорхой байгууллагын албаны нууцад хамаарах мэдээллээс дараах мэдээллийг нийтлэг байдлаар нууцын жагсаалтад оруулсан байна. Үүнд:

- Албаны нууцад хамаарах асуудал хэлэлцсэн хурлын тэмдэглэл;
- Албаны нууцад хамаарах асуудлаар төрийн байгууллага, бусад хуулийн этгээдтэй харилцсан албан бичиг;
- Байгууллагын хэмжээнд төрийн болон албаны нууцын хяналт, шалгалт, үзлэг тооллого хийсэн мэдээлэл;
- Онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөө;
- Дайчилгааны төлөвлөгөө;
- Сүлжээний аюулгүй байдалд хамаарах бүтэц, зохион байгуулалт болон тэдгээрийн зураг /схем/ өгөгдөл, шийдэл, тохиргоо;
- Төрийн болон албаны нууцад хамаарах баримт бичиг, нууц тээгчийг хүлээлцсэн шилжүүлсэн нотломж;
- Төрийн болон албаны нууц баримт бичгийн бүх төрлийн бүртгэлийн дэвтэр гэх мэт.

Үүнээс гадна тухайн байгууллагын холбогдох хуульд заасан чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогоос шалтгаалсан мэдээлэл нь албаны нууцад хамаарч болно. Тухайлбал, Эрүүл мэндийн салбарын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад Хувь хүний нууцын тухай хуультай холбоотойгоор өвчтөний өвчний түүхийн мэдээлэл, Гадаадын иргэн

харьяатын газрын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад Виз олголттой холбоотой асуудал гэх мэт.

Мөн ихэнх нөхцөлд байгууллагын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад “Сүлжээний аюулгүй байдалд хамаарах бүтэц, зохион байгуулалт болон тэдгээрийн зураг /схем/ өгөгдөл, шийдэл, тохиргоо гэх хэт ерөнхий мэдээллийг тусгасан байдаг.

Энэ нь хэт ерөнхий байхын зэрэгцээ сүлжээний аюулгүй байдалд ямар нэгэн осол, гэмтэл гарах түүнийг хэвийн үйл ажиллагаанд оруулах эсвэл тухайн сүлжээг хөгжүүлэх гэх мэт ажлыг хийж гүйцэтгэх үед тухайн сүлжээ албаны нууцад хамаарах тул хууль тогтоомжийн хүрээнд хаалттай байдаг нь байгууллага хэвийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхэд хүндрэл гардаг. Түүнчлэн, сүлжээтэй холбоотой асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх боломжгүй байдаг байна.

Дүгнэлт, санал

Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалтыг батлах тухай хуулиуд Монгол Улсын төрийн нууцыг тогтоох, хамгаалах, ашиглахтай холбоотой харилцаанд түүхэн үүрэг гүйцэтгэсэн боловч өнөөгийн нийгэм, эдийн засаг, эрх зүйн тогтолцоо, үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчинд явагдаж буй өөрчлөлт, шинэчлэлтийн үед уг хуулиудын хэрэгжилтийн хүндрэл бэрхшээлүүдийг шийдвэрлэх улмаар гадаад орнуудын төрийн нууцыг хамгаалах нийтлэг жишигтэй нийцүүлэх шаардлага нь судалгаа, шинжилгээ, практикаас нэгэнт дүгнэгдсэн нь 2016 оны Төрийн болон албаны нууцын тухай хууль батлагдах хөрс суурийг бүрдүүлсэн байна.

Төрийн болон албаны нууцын тухай хууль өмнөх Төрийн нууцын тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай, Байгууллагын нууцын тухай хууль болон бусад олон хууль тогтоомжоор зохицуулж байсан төрийн болон албаны нууцтай холбоотой харилцааг нэг хуулиар зарчмын онцлогтой хэм хэмжээнүүдийг тусгаж зохицуулснаараа онцлог болсон юм.

Төрийн болон албаны нууцын тухай хууль 2017 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш уг хуулийг улсын хэмжээнд сурталчилах, төрийн болон албаны нууцын хадгалалт хамгаалалтын чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд тогтмол мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж, зааварчилга өгөгдөх ажил хийгдсээр байна.

Аливаа мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулан нууцлахдаа хуульд нийцсэн, үндэслэлтэй, цаг үеэ олсон байх зарчим албаны нууц гэх хуульд заасан үндсэн тодорхойлолт болон НҮБ-ын Хүний эрхийн байгууллагын “Мэдээлэлтэй байх эрхийг хязгаарлахад баримтлах шалгуур”-ыг баримтална.

Гэтэл тухайн байгууллагын ажлын хэсэг ямар бүрэлдэхүүнтэй байх, ажлын хэсэг тухайн мэдээлэлд хэрхэн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, тагнуулын байгууллага санал өгөхөд ямар шалгуур баримтлах талаар хууль болон Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-д тусгаагүй байна.

Үүний улмаас нууцлах шаардлагагүй мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулсан нь иргэдийг мэдээлэлтэй байх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, нууцад хамаарах мэдээлэл гэх үндэслэлээр тухайн байгууллага, албан тушаалтны хууль бус, зохисгүй үйл ажиллагааны мэдээллийг нуун далдлах нь төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтийг өргөжүүлэн эрсдлийг бий болгож байна.

Иймд Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан албаны нууцад хамаарах мэдээллийг нууцлах, хамгаалахдаа дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг санал болгож байна. Үүнд:

- Мэдээллийг албаны нууцын жагсаалтад оруулах тодорхой шалгуур үзүүлэлтийг олон улсын жишиг, Монгол улсын эрх зүйн зохицуулалтын онцлогт нийцүүлэн хуулиудын уялдаа холбоо хангах зорилгоор холбогдох, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг үе шаттай авч хэрэгжүүлэн иргэдийн мэдээлэл авах, ил тод нээлттэй байдлыг хангах;

- Байгууллагын нууцын тухай хуульд “нууцлахыг хориглосон мэдээлэл”-ийн хязгаарлалтыг чанд сахин мөрдөх талаар сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт тусган төрийн байгууллага, албан тушаалтнуудыг чадавхижуулах;

- Албаны нууцтай холбоотойгоор, иргэн, албан тушаалтнаас төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан гомдол, мэдээллийн нэгдсэн санг бий болгон түүнд судалгаа дүн шинжилгээ хийх.

ХАРЬЦУУЛСАН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ГАДААД ОРНУУДЫН УУЧЛАЛ ҮЗҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ОНЦЛОГ

Г.Гантөмөр

*ДХИС-ийн Гэмт явдал судлалын профессорын судалгааны багийн
тэргүүлэх профессор, доктор (Ph.D), профессор*

Товч агуулга. Уучлал үзүүлж ялаас чөлөөлөх асуудлыг гадаад орнуудын Үндсэн хууль болон эрүүгийн хууль тогтоомжид хуульчилсан байдлыг харьцуулсан эрх зүйн хүрээнд судлах, тэдний эрх зүйн зохицуулалтын онцлог, ололттой талыг нээн харуулж, сайн туршлагыг үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгоход авч хэрэгжүүлэх боломжийн талаар дурдсан.

Түлхүүр үг: Уучлал, Ерөнхийлөгч, уучлал үзүүлэх, уучлалын хэлбэр, уучлал үзүүлж ялаас чөлөөлөх.

Удиртгал

Эрүүгийн хуульд заасан ялаас чөлөөлөх нэг үндэслэл нь уучлал үзүүлж ялаас чөлөөлөх явдал юм.

Уучлал үзүүлэх нь эрүүгийн эрх зүйн энэрэнгүй зарчмын нэг илрэл бөгөөд төр гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн, амьдралдаа алдаа, эндэгдэл гаргасан иргэндээ төрийн энэрэл, итгэлийг хүлээлгэж, түүнийг шүүхээс оногдуулсан ялыг биечлэн эдлэх, эсвэл эдлээгүй үлдсэн ялаас чөлөөлөх, эсвэл эдэлж байгаа ялын хугацаанаас хасах, оногдуулсан болон эдэлж байгаа ялыг өөр төрлийн ялаар солих, ял эдэлсэн этгээдийг ялгүйд тооцох зэрэг хэлбэрээр хэрэгжиж, түүний эрх зүйн байдлыг дээрдүүлж буй шийдвэр, үйл ажиллагаа мөн.

Манай улсын уучлал үзүүлэх үндэсний эрх зүйн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан журмын хүрээнд хуульчлагдсан ба түүнийг төгс төгөлдөр зохицуулалт гэж үзэх боломжгүй, тэдгээр нь хоорондоо зөрчилдөх, уучлал үзүүлэх журам, уучлалын хэлбэрийг хуульчлаагүй байгаа нь хууль цаазат төрийн мөн чанар, зарчимд нийцэхгүй, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай болохыг тодорхойлж байна.⁷⁰

Уучлал үзүүлэх талаарх олон улсын эрх зүйн хэм хэмжээ, гадаад орнуудын Үндсэн хууль, эрүүгийн хууль тогтоомжийг судлах нь уучлалын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход ач холбогдолтой. Иймээс харьцуулсан эрх зүйн үүднээс уучлал үзүүлэх тухай олон улсын хэм хэмжээ, гадаад орнуудын Үндсэн хууль болон Эрүүгийн хуулиудад уучлалын талаар хуульчилсан байдал, онцлогийг харьцуулан судалсан болно.

Үндсэн хэсэг

а.Уучлал үзүүлэх талаар олон улсын эрх зүйн хэм хэмжээнд тусгасан байдал:

Даяарчлагдаж буй өнөөгийн дэлхий ертөнцөд уучлал үзүүлэх нь зөвхөн тодорхой улс орны үндэсний эрүүгийн хууль тогтоомжийн хүрээний асуудал бус олон улсын эрүүгийн эрх зүйн асуудал болоод байна.

Уучлал үзүүлэх талаарх олон улсын хэм хэмжээг судлан үзэхэд тэдгээр нь:

Нэгдүгээрт: Цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдэд уучлал үзүүлэх тухай хэм хэмжээ байна. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын III хэсгийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "...Цаазаар авах ял шийтгүүлсэн хүн ял хэлтрүүлэх буюу ялыг хөнгөрүүлж өгөх хүсэлт гаргах эрхтэй. Бүх тохиолдолд ял хэлтрүүлж өршөөл, уучлал үзүүлж, цаазаар авах ялыг өөрчилж болно."⁷¹ гэж заасан байна.

⁷⁰ Г.Гантөмөр, Г.Лхагваа. Уучлалын эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. УБ. 2009 он. 66-75 дахь талаас үзнэ үү.

⁷¹ Олон Улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл. Эрүүгийн эрх зүй, эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. //эмхэтгэсэн Д.Баярсайхан, Т.Золбоо, УБ.2012 он. 14 дэх тал

Мөн Олон улсын эрх зүйн хэмжээнд цаазаар авах ял шийтгүүлсэн хүний уучлал хүсэх эрх нь НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 1984 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 1984/50 дугаар тогтоолоор баталсан “Цаазаар авах ял шийтгүүлсэн хүмүүсийн эрхийн хамгаалалтыг баталгаажуулах арга хэмжээнүүд” гэсэн баримт бичигт тусгалаа олжээ. Уг тогтоолын 7 дахь заалтад “Цаазаар авах ял шийтгүүлсэн хүн бүр уучлал хүсэх, таслан шийтгэх тогтоолыг өөрчлөх хүсэлт гаргах эрхтэй бөгөөд уг ялыг оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол гарсан бүх тохиолдолд уучлал үзүүлэх буюу таслан шийтгэх тогтоолыг өөрчилж болно.”⁷² гэж уг эрхийг баталгаажуулжээ.

Хоёрдугаарт: Хүн төрөлхтөний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд уучлал үзүүлж болохгүй талаар заасан хэм хэмжээ байна. Олон Улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн 110 дугаар зүйлийн 1-д “Хүн төрөлхтөний эсрэг гэмт хэрэг, төрлөөр устгах гэмт хэрэг, цэргийн гэмт хэрэг, түрэмгийллийн гэмт хэрэг үйлдсэн хүний хэргийг тус шүүхээр шийдвэрлэн ял оногдуулсан бол таслан шийтгэх тогтоолыг биелүүлж буй улс тогтоолд заасан хугацаа дуусахаас өмнө тухай этгээдийг чөлөөлж болохгүй.”, мөн зүйлийн 2-д “Зөвхөн тус Шүүх энэ хугацааг багасгах тухай шийдвэр гарах эрх эдлэх ба тухайн этгээдийн хүсэлтийг сонссоны үндсэн дээр энэ асуудлаар тогтоол гаргана.”⁷³ гэжээ. Энэ тохиолдолд аливаа улсын төрийн тэргүүний уучлал үзүүлэх эрх хязгаарлагдана.

б.Уучлал үзүүлэх талаар гадаад орнуудын Үндсэн хуульд хуульчилсан байдал:

Уучлал үзүүлэх асуудал нь юуны өмнө Үндсэн хуулийн эрх зүйн институт мөн. Энэ нь Үндсэн хуульд заасан төрийн тэргүүний эрх зүйн байдалтай шууд холбоотой байдгаар тайлбарлагдана.

Төрийн байгууламж, засаглалын хэлбэрийн хувьд онцлогтой, эрх зүйн тогтолцооны хувьд ялгаатай, өөр өөр эрх зүйн бүлд хамаарах 30 гаруй орноор төлөөлүүлэн тэдгээр улсуудын Үндсэн хуульд уучлал үзүүлэх талаарх хэм хэмжээг судлахад уучлалын эрх зохицуулалт дараах байдалтай байна.

Холбооны улс дахь уучлалын эрх зүйн зохицуулалт

Төрийн байгууламжийн хувьд холбооны улсуудад уучлал үзүүлэх асуудал холбооны улс болон муж улсуудын эрх мэдлийн хуваарилалт, тэдгээрийг Үндсэн хуульдаа хэрхэн хуульчилснаас хамааран өөрийн гэсэн онцлогтой. Энэ нь:

Нэгдүгээрт: Зарим холбооны улсад Холбооны Ерөнхийлөгч, Муж улсуудын Ерөнхийлөгч уучлал үзүүлэх эрхтэй ба уучлал үзүүлэх эрх, уучлал үзүүлэх хэргүүд нь өөр өөр байгаа нь судалгааны үр дүнд тогтоогдож байна.

ХБНГУ-ын 1949 оны Үндсэн хуулийн III хэсгийн 60 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Холбооны Ерөнхийлөгч тодорхой этгээдэд Холбооны Улсын нэрийн өмнөөс уучлал үзүүлэх эрх эдлэнэ.”⁷⁴ гэж хуульчилжээ.

ХБНГУ-ын 16 муж улсын нэг болох Бавари муж улсын 1946 оны Үндсэн хуулийн IV бүлгийн 47 дугаар зүйлийн 4 дэх заалтад Муж улсын Ерөнхий сайд тодорхой этгээдэд уучлал үзүүлэх эрхтэй байхаар заажээ.⁷⁵

Холбооны Ерөнхийлөгч Холбооны Дээд шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэгт, уг хэрэгт ял шийтгэгдсэн этгээдэд уучлал үзүүлдэг бол Муж улсуудын Засгийн газрын тэргүүн - Ерөнхий сайд муж улсын шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэгт уучлал үзүүлэх эрх эдэлнэ.⁷⁶ Дийлэнх уучлал хүссэн хүсэлт Муж улсын Ерөнхий сайдад хаяглагдах ба уучлал үзүүлэх процесс Муж улсуудын засаг захиргаанаас баталсан уучлал үзүүлэх журмын дагуу явагдана.⁷⁷

АНУ-д уучлал үзүүлэх асуудал Холбооны болон муж улсуудын Үндсэн хуулийн хүрээнд хэрэгждэг. АНУ-ын Үндсэн хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Холбооны Ерөнхийлөгч өндөр албан тушаалтнуудад итгэл үл үзүүлэх /импичмент/-ээс бусад тохиолдолд

⁷² Мөн тэнд. 331 дэх тал

⁷³ Олон Улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрэм. ХЭҮК. УБ 2002 он. 128 дахь тал

⁷⁴ Конституции зарубежных стран //Составитель В.Н.Дубровин. М.изд Юрлитинформ. 2006. стр 144, Ч.Энхбаатар. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын төрийн эрх зүй. УБ. 2009 он. 107 дахь тал

⁷⁵ Конституции зарубежных стран //Составитель В.Н.Дубровин. М.изд Юрлитинформ. 2006. стр181

⁷⁶ Д.В.Беллинг. О помиловании в немецком праве //ж.LEX RUSSIA. М. 2019. № 3. стр 118

⁷⁷ Д.В.Беллинг. Мөн тэнд.стр 118

АНУ-ын эсрэг үйлдсэн хэрэгт уучлал үзүүлж ялаас чөлөөлөх, ялыг хөнгөрүүлэх, ял эдлэхийг хойшлуулах эрх эдэлнэ.” гэж заасан.⁷⁸ Муж улсын хуулийг зөрчсөн үйлдэл нь АНУ-ын эсрэг гэмт хэрэг болохгүй бөгөөд ийм хэрэгт Холбооны Ерөнхийлөгч уучлал үзүүлэхгүй, уучлал үзүүлэх эрх АНУ-ын 50 муж улсын Захирагчид /губернаторт/ хадгалагдана.

Муж улсын Захирагч муж улсын хууль тогтоомжийн дагуу цаазаар авах ял шийтгүүлсэн ялтанг цагаатгаж суллах, цаазаар авах ялыг бүх насаар хорих ялаар солих, эсвэл хугацааны өмнө суллагдах эрхгүйгээр, эсвэл эрхтэйгээр 35 жилийн ялыг эдэлсний дараа суллахаар солих, цаазаар авах ялыг биелүүлэхийг 15 жилийн хугацаагаар хойшлуулах гэсэн хэлбэрээр уучлал үзүүлдэг байна.⁷⁹ Тухайлбал, АНУ-ын Калифорни муж улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт “Муж улсын Захирагч /губернатор/ муж улсын хууль тогтоомжид заасан журмын дагуу муж улсын өндөр албан тушаалтнуудад импичмент зарласнаас бусад уучлал үзүүлж ялаас хэлтрүүлэх, ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих, ял хойшлуулах эрхтэй.”⁸⁰ гэж заажээ. Вайоминг муж улсын Эрүүгийн хуульд зааснаар цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийг зөвхөн тус муж улсын Захирагч уучлах эрх эдэлнэ.⁸¹

Мөн ийм зохицуулалт Азийн анхны ардчилсан улс болох **Энэтхэг** улсад бий. 1949 оны Энэтхэг улсын Үндсэн хуулиар улсын Ерөнхийлөгч болон Муж улсын Захирагч /губернатор/ уучлал үзүүлэх эрхтэй. Тус улсын Үндсэн хуульд Ерөнхийлөгчөөс уучлал үзүүлэх асуудлыг өмнө авч үзсэн улсуудтай харьцуулахад илүү нарийвчлан хуульчилсан нь анхаарал татаж байна.

Энэтхэг улсын Үндсэн хуулийн 77 дугаар зүйлд зааснаар тус улсын Ерөнхийлөгч

а/Цэргийн шүүхээс ял шийтгэгдсэн,

б/Холбооны хууль тогтоомж зөрчсөн гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн,

в/Цаазаар авах ял шийтгүүлсэн гэмт хэрэгтэнд уучлал үзүүлж ялаас уучлан хэлтрүүлэх, ялын хэмжээг багасгах, өөр төрлийн хөнгөн ялаар солих, ял эдлүүлэх хугацааг хойшлуулах, ял эдлүүлэх ажиллагааг зогсоох гэсэн уучлалын харьцангуй олон хэлбэрээр уучлал үзүүлдэг.

Мөн тус улсын Үндсэн хуулийн 161 дүгээр зүйлд “Муж улсын Захирагч муж улсын хууль тогтоомжид заасан тохиолдолд ялаас уучлан хэлтрүүлэх, ялын хэмжээг багасгах, өөр төрлийн хөнгөн ялаар солих, ял эдлүүлэх хугацааг хойшлуулах, ял эдлүүлэх ажиллагааг зогсоож болно.”⁸² гэж хуульчилсан байна. .

Хоёрдугаарт: Зарим холбооны улсад уучлал үзүүлэх эрх зөвхөн Холбооны Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хамаарч байна. Ийм орны тоонд Бразили, ОХУ багтана.

Бразилийн Холбооны улсын Үндсэн хуулийн “Гүйцэтгэх засаглал” гэсэн II бүлгийн “Ерөнхийлөгчийн бүрэн эрх” 2 дугаар хэсгийн 84 дүгээр зүйлийн 12-т зааснаар “Уучлал үзүүлж ялаас хэлтрүүлэх, ялыг хөнгөрүүлэх эрхтэй.”⁸³

ОХУ: Хагас Ерөнхийлөгчийн засаглалтай гэгддэг манай хойд хөрш ОХУ-д бусад улсаас ялгагдах уучлал үзүүлэх өвөрмөц эрх зүйн зохицуулалт, хэрэгжих журам /процедур/ үйлчилдэг.

ОХУ-ын 1993 оны Үндсэн хуулийн 89 дүгээр зүйлийн “в” заалтад Ерөнхийлөгчийн уучлал үзүүлэх эрхийг хуульчилсан хэдий ч ямар хэлбэрээр уучлал үзүүлэх талаар нарийн зохицуулалт байхгүй байна.⁸⁴

ОХУ-ын бүрэлдэхүүнд багтдаг холбооны 83 субъект болох 21 Бүгд найрамдах улсуудын Ерөнхийлөгч, 46 муж, 9 хязгаар, 4 автономит тойрог, 1 автономит муж, холбооны хэмжээний 2 хотын Захирагч /губернатор, мэр/ уучлал үзүүлэх эрх эдэлдэггүй. Гэхдээ тэд уучлал үзүүлэх ажиллагаанд оролцдог.

⁷⁸ The Declaration of Independence and the Constitution of the United States of America. Washington, D.C. 2004. Cato institute. p. 30

⁷⁹ Д.О.Стрелков. Правовое регулирование помилования в РФ и США// журнал Уголовно- исполнительное право. 2011. № 2. стр 13

⁸⁰ Конституции зарубежных стран // Составитель В.Н.Дубровин. М.изд Юрлитинформ. 2006. стр 276

⁸¹ Wyoming Criminal Law: An Overview. URL //https://resoures.lawinfo.com-defense/wyoming/

⁸² https://legalns.com/правовая-библиотека/конституции-стран-мира/конституция-индии

⁸³ Конституции зарубежных стран // Составитель В.Н.Дубровин. М.изд Юрлитинформ. 2006. стр 332

⁸⁴ Конституция Российской Федерации. М. Изд Проспект.2020

2001 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “ОХУ-ын холбооны субъектүүдийн нутаг дэвсгэр дэх уучлал үзүүлэх асуудлаарх тусгай комиссын тухай” ОХУ-ын Ерөнхийлөгчийн 1500 дугаартай зарлигаар дээрх 83 субъектүүдэд уучлал үзүүлэх асуудлыг хариуцсан комисс байгуулагдан ажиллаж байна. Уг зарлигаар уучлал үзүүлэх нэг талаас хүн сурталтай, олон үе шаттай гэмээр, нөгөө талаас Холбооны байгууламжтай, холбооны олон тооны субъектээс тогтдог, 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар 872 хорих ангид нийт 486000 хоригдол ял эдэлж байгаа том улсын хувьд ийм журам байхаас аргагүй гэж бодогдож байна.

Энэхүү журмын дагуу ялтан уучлал хүссэн өргөдлөө ОХУ-ын Ерөнхийлөгчид хандан хоригдож буй хорих ангийн захиргаагаар дамжуулан гаргана. Хорих ангийн захиргаа уг хүсэлтийг хүлээн авч 20 хоногийн дотор холбогдох материалыг бүрдүүлэн нутаг дэвсгэрийн Хууль зүйн яамны харьяа Ерөнхий газарт шилжүүлнэ.⁸⁵ Нутаг дэвсгэрийн Хууль зүйн яамны харьяа Ерөнхий газар 7 хоногийн дотор уг хүсэлтийг хянаж, Холбооны субъектүүдийн нутаг дэвсгэр дэх уучлал үзүүлэх асуудлаарх тусгай комисст хүргүүлнэ. Уг комисс хүсэлтийг 30 хоногийн дотор хянаж, хэрэв уучлал үзүүлэх нь зүйтэй гэж үзвэл ялтанд уучлал үзүүлэх тухай дүгнэлтээ тухай Бүгд найрамдах улсуудын Ерөнхийлөгч, муж, хязгаар, автономит тойрог, автономит мужийн Захирагч /губернатор/-д ирүүлэх ба тэд 15 хоногийн дотор уучлал үзүүлэх өөрсдийн саналыг комиссын дүгнэлтийн хамт ОХУ-ын Ерөнхийлөгчийн хэрэг эрхлэх газарт хүргүүлж, Ерөнхийлөгчийн зарлиг гарснаар уучлалыг эцэслэн үзүүлдэг байна.⁸⁶

Гуравдугаарт: Холбооны байгууламжтай зарим улсад уучлал үзүүлэх эрхийг Холбооны парламент эдэлдэг онцлог зохицуулалттай улсууд бий. Тухайлбал, **Швейцарийн** Холбооны Улсын Үндсэн хуулийн “Холбооны хурлын бүрэн эрх” гэсэн V бүлгийн III хэсгийн 173 дугаар зүйлийн “к” заалтад Холбооны хурал нь уучлал үзүүлэхийг хүссэн хүсэлтийг шийдвэрлэх, өршөөл үзүүлэх хууль гаргах эрхтэй байхаар заасан байдаг.⁸⁷

Парламентын болон Ерөнхийлөгчийн засаглалтай Бүгд найрамдах улсуудын уучлалын эрх зохицуулалт

Бүгд найрамдах Франц улсын 1958 оны Үндсэн хуулийн II хэсгийн 17 дугаар зүйлд “Франц Улсын Ерөнхийлөгч уучлал үзүүлэх эрх эдэлнэ.”⁸⁸ гэж уучлал үзүүлэх талаар нийтлэг байдлаар хуульчилсан боловч Ерөнхийлөгчөөс үзүүлэх уучлалын хэлбэрийг зааж өгөөгүй байна.

Итали улсын Үндсэн хуулийн “Улсын Ерөнхийлөгч” гэсэн II бүлгийн 87 дугаар зүйлд Итали Улсын Ерөнхийлөгч уучлал үзүүлэх, ялыг хөнгөрүүлэх эрх эдлэхээр хуульчилжээ.⁸⁹

Унгар улсын Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн “к”-д зааснаар Унгар Улсын Ерөнхийлөгч гэмт хэрэг үйлдсэн хувь хүнд уучлал үзүүлэх эрхтэй.⁹⁰

Манай урд хөрш **БНХАУ**-д уучлал үзүүлэх эрхийг дараах хоёр субъект хэрэгжүүлнэ. БНХАУ-ын Үндсэн хуулийн 67 дугаар зүйлд Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Хурлын Байнгын Хорооны бүрэн эрхэд уучлал үзүүлэх шийдвэр гаргах эрхийг хамааруулсан бол II хэсгийн 80 дугаар зүйлд “БНХАУ-ын дарга уучлал үзүүлэх зарлиг гаргах эрхтэй.” гэж хуульчилсан байдаг.⁹¹

БНАСАУ-ын Үндсэн хуулийн VI бүлгийн 2 дугаар хэсгийн 107 дугаар зүйлд зааснаар “БНАСАУ-ын Ерөнхийлөгч уучлал үзүүлэх эрх эдэлнэ.”⁹²

Арабын Бүгд Найрамдах **Египет** улсын Үндсэн хуулийн 149 дүгээр зүйлд Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг ялаас хэлтрүүлэх, ялыг хөнгөрүүлэх эрх хамаарахаар заажээ.⁹³

⁸⁵ ОХУ-д шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага /хорих байгууллага/ нь Хууль зүйн яамны харьяанд байдаг. Г.Г.

⁸⁶ А.Я.Гришко. Амнистия и помилование. Монография. Рязань. 2006. стр 106-017

⁸⁷ Конституции зарубежных стран // Составитель В.Н.Дубровин. М.изд Юрлитинформ. 2006. стр 123

⁸⁸ Мөн тэнд. стр 52

⁸⁹ Мөн тэнд. стр 81

⁹⁰ Мөн тэнд. стр 391

⁹¹ Мөн тэнд. стр 418,420

⁹² <https://worldconstitutions.ru/> Азия / Конституция КНДР (Северная Корея)

⁹³ М.А.Сапронова. Государственный строй и конституции арабских республик. М.МГИМО. 2003.стр 184

Алжир улсын Үндсэн хуулийн 77 дугаар зүйлийн 7-д заасны дагуу тус улсын Ерөнхийлөгч уучлал үзүүлж, ялаас чөлөөлөх, ялыг хөнгөрүүлэх, хойшлуулах эрхтэй.⁹⁴

Энд нэг зүйлийг онцлоход Мусульманы шашинт зарим орнууд /Саудын Араб, Арабын Нэгдсэн Эмират, Иран, Пакистан, Нигери г.м/-ын хувьд шашны үзэл номлол улс орны амьдралд хүчтэй нөлөөтэй, нийгмийн амьдралыг бүхий харилцааг зохицуулдаг, шашинжсан төртэй. Тухайлбал, Саудын Араб улсад Мусульман шашны ариун судар - Коран нь Үндсэн хуулийн болон Эрүүгийн хуулийн үүрэг гүйцэтгэдэг.⁹⁵

Коран судар нь Мусульман шашныг үндэслэгч зөнч Мухаммедын амьд ахуйдаа дагалдагчид, шавь нартаа айлдсан номлол, сургааль, мусульман шашинтны дагаж мөрдөх зам мөр, зан үйлийг заасан шашны судар, эрх зүйн шинжтэй хэм хэмжээг агуулсан эрх зүйн акт юм. Энэ утгаараа Коран судар мусульман шашинт орнуудын эрх зүйн, түүний дотор эрүүгийн эрх зүйн гол эх сурвалжид тооцогдоно.

Коран сударт Шариатын хуулиар хамгаалагддаг үнэт зүйл болох хүний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгө, төрийн эрх ашиг, мусульман шашинтны итгэл үнэмшил (сүсэг бишрэл), нэр хүндэд халдсан гэмт хэргүүд /Хүнийг алах, хүний эрүүл мэндэд хохирол учруулах, хулгайлах, дээрэмдэх, төрийн эсрэг бослого тэмцэл гаргах, үймээн дэгдээх, мусульманы шашнаас урвах, мусульманы шашныг доромжлох, хүнийг гүтгэх, архи уух, гэр бүлээс гадуур бэлгийн харьцаанд орох г.м/-ийг төдийгүй тэдгээрт оногдуулахыг ялыг зааж өгсөн ба Коран сударт заасан ялыг төрийн тэргүүн - Ерөнхийлөгч, Шейх, Эмир, Султан хэн боловч өөрчлөх, хөнгөрүүлэх, уучлал үзүүлэх эрхгүй юм. Энэ нь Коран судрыг хэн ч халдашгүй, ариун судар болохыг илэрхийлдэг байна. Ийм учраас Мусульманы эрүүгийн эрх зүйд уучлал үзүүлж болох гэмт хэрэг, уучлал үзүүлж болохгүй гэмт хэрэг гэсэн ойлголт байдаг.

Хаант засаглалтай орнуудын Үндсэн хуульд уучлал үзүүлэх асуудлыг хуульчилсан байдал

Хаант засаглалтай орнуудын хувьд уучлал үзүүлэх эрхийг төрийн тэргүүн – Эзэн /хатан/ хаан, Ван, Шейх эдэлнэ.

Их Британи: Их Британи ба Умард Ирландын Нэгдсэн Вант улс нь Үндсэн хуульт хаант улс /монархи/ бөгөөд нэгтгэн баталж, хэвлэсэн Үндсэн хуульгүй цөөхөн орны нэг. Үндсэн хуулийн үүргийг үндсэн хуулийн шинжтэй актууд гүйцэтгэнэ. Тэдгээрт зааснаар Хатан хаан нь жил бүрийн парламентын хуралдааныг нээх, парламентыг тараах, парламентаар хэлэлцсэн хуулийг баталж ёсчлох, Ерөнхий сайд, сайд нарыг томилох, дайн зарлах, зэвсэгт хүчнийг удирдах, **ялтныг уучлах**, иргэдэд тусгай хэргэм цол олгох, иргэний бичиг баримт /паспорт/ олгох гэсэн 9 онцгой эрх эдэлнэ.⁹⁶

Испанийн Вант улсын Үндсэн хуулийн “Ван” гэсэн II хэсгийн 62 дугаар зүйлд Испанийн ван бүх нийтийн өршөөл үзүүлэх хуульд зааснаас бусад тохиолдолд уучлал үзүүлэх эрхтэй гэж заасан ба Парламент буюу Конгресс, Сенат нь бүх нийтийн өршөөл үзүүлэх хууль гаргахаар хуульчилсан байна.⁹⁷

Бельгийн Вант улсын Үндсэн хуулийн 110 дугаар зүйлд холбооны сайд, мужийн /region/ Засгийн газрын гишүүнээс бусад гэмт хэрэг үйлдсэн хүмүүст уучлал үзүүлж, ялаас чөлөөлөх, ялыг хөнгөрүүлэх эрхтэй. Харин Үндсэн хуулийн 111 дүгээр зүйлд зааснаар Холбооны сайд, мужийн Засгийн газрын гишүүнийг давж заалдах шатны шүүхээр ял шийтгүүлсний дараа Төлөөлөгчдийн танхим болон Мужийн Зөвлөлөөс санал болгосноор уучлал үзүүлж болно.⁹⁸

Япон улс бол Үндсэн хуульт Эзэн хаант улс юм. Тус улсын Үндсэн хуулийн Ү бүлгийн 73 дугаар зүйлд Гүйцэтгэх засаглалын байгууллага - Сайд нарын кабинетын бүрэн эрхэд бүх нийтийн болон хэсэгчилсэн өршөөл үзүүлэх, ялыг хөнгөрүүлэх, ял хойшлуулах, эрхийг сэргээх

⁹⁴ Мөн тэнд, стр 132

⁹⁵ Сандра Мавед. Уголовно-правовые системы исламских государств: к вопросу их классификации // журнал. Юридический вестник. Минск. 2015 № 2. 249

⁹⁶ А.И.Черкасова. Глава государства и правительства в странах современного мира. М.Изд Экзамен. 2006. стр 28

⁹⁷ Конституции зарубежных стран // Составитель В.Н.Дубровин. М.Изд Юрлитинформ. 2006. стр 213

⁹⁸ <https://legalins.com/правовая-библиотека/конституции-стран-мира/конституция-бельгии>

шийдвэр гаргах эрхийг хамааруулсан бол Үндсэн хуулийн 7 дугаар зүйлд Японы Эзэн Хаан бүх нийтийн болон хэсэгчилсэн өршөөл үзүүлэх, уучлал үзүүлэх, ялыг хөнгөрүүлэх, ялын хугацааг хойшлуулах, эрхийг сэргээх эрхтэй байхаар хуульчилжээ.⁹⁹

Тайланд улсын 2007 оны Үндсэн хуулийн 191 дүгээр зүйлд заасны дагуу тус улсын Эзэн хаан уучлал үзүүлэх онцгой эрх эдэлнэ.¹⁰⁰

в.Гадаадын зарим орны Эрүүгийн хуульд уучлал үзүүлэх талаар тусгасан байдал

Уучлал үзүүлэх институтын нэг онцлог нь салбар дундын институт бөгөөд уучлал үзүүлэх эрх зүйн зохицуулалт зөвхөн Үндсэн хуульд төдийгүй Эрүүгийн хууль тогтоомжид хуульчлагдсан байдаг.

Гадаад орнуудын Эрүүгийн хуулийг судлахад уучлал үзүүлж ялаас чөлөөлөх, ялтны ялыг хөнгөрүүлэх, ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих, бусад байдлаар ялтны эрх зүйн байдлыг дээрдүүлэх хэм хэмжээ бидний судалгаанд хамрагдсан 30 гаруй орноос 20 гаруй орны Эрүүгийн хуульд хуульчлагдсан байна.

Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан, одоо ТТУХН-ийн гишүүн орнуудын Эрүүгийн хуульд уучлал үзүүлэх нь ерөнхий ангид “Ялаас чөлөөлөх” эсвэл “Өршөөл, уучлал” гэсэн бүлэгт хуульчлагджээ.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн “Өршөөл, уучлал, ялтай байдал” гэсэн 13 дугаар бүлгийн “Уучлал” гэсэн бие даасан 85 дугаар зүйлд уучлал үзүүлэх талаар заасан байна. Уг зүйлийн 1 дэх хэсэгт “Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч нь тодорхой нэр бүхий хувь хүнд уучлал үзүүлнэ.” гэж заасан төдийгүй мөн зүйлийн 2 дахь хэсэгт уучлал үзүүлж ялтныг эдэлж байгаа ялаас нь чөлөөлөх, эдлээгүй үлдсэн ялын хугацаанаас хасах, эсвэл эдлээгүй үлдсэн ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих, ялаа эдэлж дуусан этгээдийг ялгүйд тооцох гэсэн уучлалын хэлбэрүүдийг тодорхой зааж өгсөн хуульчилсан¹⁰¹ нь оновчтой зохицуулалт болсон гэж үзэх бүрэн үндэстэй.

Мөн ОХУ-ын Эрүүгийн хуулийн 59 дүгээр зүйлд цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдэд уучлал үзүүлсэн тохиолдолд уг ялыг бүх насаар хорих ялаар эсхүл 25 жил хорих ялаар солих тухай заалт байдаг.

Азербайджан, Белорусь, Гүрж, Кыргыз, Молдав, Таджикстан, Украин зэрэг улсын Эрүүгийн хуульд уучлал үзүүлэх институт ОХУ-ын Эрүүгийн хуультай ижил төстэй байдлаар хуульчлагджээ. ОХУ-ын Эрүүгийн хууль дахь уучлалын эрх зүйн зохицуулалтаас ялгагдах онцлог гэвэл Молдав улсын Эрүүгийн хуулийн 108 дугаар зүйлд уучлал үзүүлж, үндсэн ялаас чөлөөлөх ба нэмэгдэл ялаас нь чөлөөлөхгүй байх, Кыргыз улсын Эрүүгийн хуулийн 75 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт ял эдэлж байгаа этгээд шүүхээс оногдуулсан ялын хоёрны нэгийг эдэлсний дараа уучлал үзүүлэх тухай хүсэлт гаргах эрхтэй байх, Беларусь улсын Эрүүгийн хуулийн 96 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт уучлал үзүүлж, ялаас чөлөөлөгдсөн этгээд шинээр санаатай гэмт хэрэг эсвэл хорих ял оногдуулах болгоомжгүй гэмт хэрэг үйлдсэн бол уг хуулийн 73 дугаар зүйлд заасан хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах журмаар ял оногдуулах, Кыргыз улсын Эрүүгийн хуулийн 75 дугаар зүйлд уучлалын хэлбэрт уучлал үзүүлж ялгүйд тооцох явдлыг зааж өгөөгүй зэрэг заалтууд болно.

Казахстан, Туркменистан, Узбекистан зэрэг орны Эрүүгийн хуульд уучлал үзүүлэх нь бие даасан зүйлд бус, “Өршөөл, уучлал үзүүлж, ялаас чөлөөлөх” гэсэн нэг зүйлд хуульчлагдсан байдаг онцлогтой. Мөн Узбекистан, Туркменистан улсын Эрүүгийн хуульд уучлал үзүүлж ялгүйд тооцох талаар заалт байхгүйг эс тооцвол бусад байдлаар үндсэндээ ижил байна.

Франц Улсын Эрүүгийн хуулийн “Уучлалын тухай” гэсэн 133 дугаар зүйлд “...уучлал үзүүлж зөвхөн ялтныг эдлээгүй үлдсэн ялаас чөлөөлнө, уучлал үзүүлэх ялтныг гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх, гэм хорыг арилгах үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.”¹⁰² гэж заасан бол эсрэгээрээ **Аргентин** Улсын Эрүүгийн хуулийн 68 дугаар зүйлд

⁹⁹ Ч.Энхбаатар. Япон улсын төрийн байгуулал, улс төрийн тогтолцоо. УБ. 2012 он. 48 дахь тал

¹⁰⁰ https://worldconstitutions.ru/Азия/Конституция_Тайланда

¹⁰¹ Уголовный кодекс Российской Федерации. М. Изд. Проспект. 2017. стр 64

¹⁰² Уголовный кодекс Франции./ Научное редактирование проф Л.В.Головки, перевод с французского Н.Е.Крыловой. СПб. Изд. «Юридический центр Пресс». 2002. стр 160

“Уучлал нь гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөхөөс ял эдлэхээс болон гэмт хэргийн бусад үр дагавараас чөлөөлж болно.”¹⁰³ гэж заасан онцлогтой.

Болгар Улсын Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйлд “Ерөнхийлөгч уучлал үзүүлж ялтныг оногдуулсан ялыг эдлэхээс бүрмөсөн буюу хэсэгчлэн чөлөөлөх, цаазаар авах ялыг өөр төрлийн ялаар солих эрхтэй.”¹⁰⁴ гэж заасан. **Латви, Сан-Марино** зэрэг улсад уучлал үзүүлж, ял эдлэхээс бүрмөсөн чөлөөлөх, оногдуулсан болон эдлээгүй үлдсэн ялыг өөр төрлийн ялаар солих зохицуулалт хуульчлагджээ.¹⁰⁵

Харин **АНУ, ХБНГУ, Израль, Дани, Швейцарь, Турк, Бельги, БНХАУ, Өмнөд Солонгос, Япон** зэрэг улсын Эрүүгийн хуульд уучлал үзүүлэх талаарх хэм хэмжээ байхгүй байгаа нь уучлал үзүүлэх асуудал огт байхгүй гэсэн хэрэг биш бөгөөд уг асуудал Үндсэн хуулийн хүрээнд хуульчлагдснаас гадна түүнд нийцүүлэн гаргасан тусгай эрх зүйн актуудаар зохицуулагддагтай холбон үзэж болно.

Дүгнэлт

1.Уучлал үзүүлэх нь тодорхой улс орны дотоод асуудал, тухайн орны Төрийн тэргүүний бүрэн эрхэд хамаарах хэдий ч уучлал үзүүлэх үндэсний эрх зүйн зохицуулалтад тодорхой хэмжээнд нөлөөлөхүйц олон улсын эрх зүйн хэм хэмжээ нэгэнт бий болжээ.

2.Судалгаанд хамрагдсан 30 гаруй улсын Үндсэн хууль дахь уучлалын эрх зүйн зохицуулалт нь тэдгээр орны төрийн байгууламж, засаглалын хэлбэр, төрийн тэргүүний институтын онцлогоос хамааран уучлал үзүүлэх субъект, уучлал үзүүлэх гэмт хэрэг, уучлалын хэлбэр нь өөр өөр байдлаар хуульчлагдсан байна.

3.Гадаад орнуудын уучлал үзүүлэх талаарх Эрүүгийн хуулийн зохицуулалт нь тухайн улсын хууль тогтоох ажиллагааны онцлог, эрх зүйн уламжлал, эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны хөгжил, Эрүүгийн хуулийн боловсруулалтын түвшин зэргээс хамааран өөр өөрийн онцлогтой. Ихэнх орнуудад уучлал үзүүлэх нь ялаас чөлөөлөх төрөл болгон Эрүүгийн хуульдаа хуульчилсан нийтлэг байдал байгаа хэдий ч уучлалын хэлбэр нь харилцан адилгүй байгаа нь харагдаж байна.

4.Монгол Улс дахь уучлал үзүүлэх эрх зүйн зохицуулалт нь гадаад орнуудын Үндсэн хуулийн жишигт, тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгчид Үндсэн хуулиар олгогдсон уучлал үзүүлэх эрх нь парламентын засаглалтай бүгд найрамдах улсын Ерөнхийлөгчийн эрх мэдлийн жишигт нийцэж байна.

--oOo--

¹⁰³Уголовный кодекс Аргентины // Научное редактирование проф. Ю.А.Голика. СПб. Изд. «Юридический центр Пресс», 2003. стр 73

¹⁰⁴Уголовный кодекс Республики Болгария // Научное редактирование проф.А.И.Лукашова, перевод с болгарского И.И.Айдарова. СПб. Изд. Юридический центр Пресс. 2001. стр 69

¹⁰⁵ Уголовный кодекс Сан-Марино // Научное редактирование проф.С.В.Максимрва. СПб. Изд. «Юридический центр Пресс», 2002. стр 59, Уголовный кодекс Сан-Марино // Научное редактирование проф.Э.А.Саркисовой. СПб. Изд. «Юридический центр Пресс», 2001. стр 97

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ТӨСВИЙН ХӨРӨНГИЙГ ЗОРИУЛАЛТЫН БУСААР ЗАРЦУУЛАХ ГЭМТ ХЭРГИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ШИНЖ, ЗҮЙЛЧЛЭЛИЙН АСУУДАЛ

Д.Энхнасан

ДХИС-ийн магистрант, цагдаагийн хошууч

Товч агуулга. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэргийн ойлголт, нийгмийн хор аюул, бүрэлдэхүүний шинжийг тодорхойлж, төсөөтэй зарим гэмт хэрэг, зөрчлөөс ялган зүйлчлэхэд анхаарах асуудлын талаар дурдсан.

Түлхүүр үг. Төсөв, төсвийн хөрөнгө, төсвийн захирагч, гэмт хэрэг, хохирол.

Монгол Улсад 1990 оноос Ардчилсан хувьсгал өрнөж нийгэм, эдийн засаг, улс төрийн тогтолцоо үндсээрээ өөрчлөгдөж, эрх зүйт төр, иргэний нийгмийг төлөвшүүлэх үйл явц эхэлсэн. Үүний үр дүнд 1992 онд ардчилсан Үндсэн хуулиа баталж, түүний үзэл баримтлалд нийцүүлэн 2002 онд Монгол Улсын Эрүүгийн хуулийг баталсан.

Тус Эрүүгийн хуулийн “Албан тушаалын гэмт хэрэг” гэсэн 28 дугаар бүлгийн 273 дугаар зүйлд “Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах” гэмт хэргийг шинээр хуульчилж байсан бол 2015 оны Эрүүгийн хуулийн “Авлигын гэмт хэрэг” гэсэн 22 дугаар бүлгийн 22.8 дугаар зүйлд “Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах” гэмт хэргийг үндсэн болон хүндрүүлэх шинжтэйгээр хуульчилж, 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Төрөөс төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зорилгын хүрээнд Төсвийн тогтвортой байдлын тухай, Төсвийн хуулийг баталсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, хэмнэх, зөвхөн үр ашигтай зүйлд зарцуулах ёстой.

Иймд төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэргийн ойлголт, нийгмийн хор аюул, бүрэлдэхүүний шинж, төсөөтэй гэмт хэрэг, зөрчлөөс ялгаж зүйлчлэхэд анхаарах асуудлыг тодохойлох, ялын бодлогын үр нөлөөг дээшлүүлэх асуудал тулгамдаж байна.

Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэрэг нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журам, улсын эдийн засгийн аюулгүй байдалд халддаг нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл юм.

Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэргийн объект нь төсвийн хөрөнгийг зарцуулах талаар хуулиар тогтоосон журам, халдлагын зүйл нь төсвийн хөрөнгө¹⁰⁶ байна.

Хөгжиж буй улс орнуудын эдийн засагт төсөв нь маш чухал бөгөөд тухайн улс орны оршин тогтнох эдийн засгийн үндсийг бүрдүүлж, төрөөс нийгэм болон ард иргэдэд зарцуулагдах хөрөнгийн эх үүсвэр болдог. Монгол Улсын эдийн засаг өргөжин тэлж буй өнөө үед төсвийн орлогийг нэмэгдүүлснээр эдийн засагт таатай орчинг бүрдүүлэх боломжтой.

Эдийн засаг өргөжин тэлэхэд улсын төсвийн орлого томоохон үүрэг гүйцэтгэдэг. Монгол Улсын хувьд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого тогтвортой өсч байгаа хэдий ч төсвийн төлөвлөлтийг алдаатай төлөвлөснөөс үүдэн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалтай гарч байгаа билээ. 2019 онд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын нийт хэмжээ 9 их наяд 676.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 27.4 хувь, нэгдсэн төсвийн зарлагын нийт хэмжээ 11 их наяд 589.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 32.8 хувь, нэгдсэн төсвийн нийт алдагдал 1 их наяд 913.3 тэрбум төгрөг буюу 5.4 хувь хүрч төсвийн үзүүлэлтүүд сайжирсан байна. Манай улсын төсвийн орлогын дийлэнх хэсгийг зөвхөн шууд татвар бүрдүүлж байна. Хэдийгээр аливаа Засгийн газрын орлогын гол эх үүсвэр нь татвар мөн ч гэлээ нийт орлого дахь татварын орлогын эзлэх

¹⁰⁶ С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй: тусгай анги. УБ., 2020. 340 дэх тал

хувь хэт өндөр буюу орлогын бусад эх үүсвэрүүдийн оролцоо бага байх нь төсвийн орлогыг тогтворгүй, эдийн засгийн мөчлөгүүдэд хэт мэдрэмжтэй болгодог.

Монгол Улсын төсвийн орлогын 90.3 хувь буюу 8,585.8 тэрбум төгрөгийг татварын орлого, 9.7 хувь буюу 1,090.7 тэрбум төгрөгийг татварын бус орлого бүрдүүлж байна. Үүнд:

- Татварын орлого 8,585.8 тэрбум төгрөг;
- Уул уурхайн салбарын орлого 3,000 тэрбум төгрөг;
- Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар 210.3 тэрбум төгрөг;
- Тамхи, согтууруулах ундааны онцгой албан татвар 394.5 тэрбум төгрөг;
- Импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвар 1,047.8 тэрбум төгрөг;
- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 1,265.0 тэрбум төгрөг;
- Газрын төлбөрийн орлого 75.8 тэрбум төгрөг;
- Агаарын бохирдлын төлбөрийн орлого 2.0 тэрбум төгрөг;
- Навигацийн орлого 156.0 тэрбум төгрөг;
- Татварын бус орлого 1,090.7 тэрбум төгрөг байна.¹⁰⁷

Төсвийн орлогын гол эх үүсвэр дутагдах үед цаасан мөнгө гүйлгээнд нэмж гаргах замаар төсөвт орлого оруулах арга байдаг. Гэвч энэ нь бараа, үйлчилгээний ямар ч баталгаа байхгүй учраас эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг алдагдуулж, инфляцийг бий болгодог сөрөг үр дагавартай.

Монгол Улсын хувьд татварын хууль тогтоомж, татварын хэмжээ, татвар төлөлтийг илүү боловсронгуй болгосноор эдийн засгийн цар хүрээг тэлсээр байна. 2015 оноос хойш манай улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн нийт дүн тогтвортой өсч, 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 7,942.4 тэрбум төгрөг болсон ч зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ нь орлогоос давамгай буюу 9,091.9 их наяд төгрөг болсноор улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1,149.4 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан. Харин өмнөх оныхоос улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 630.8 тэрбум төгрөгөөр өсөхөд орлого 17,1 хувь буюу 1,575.7 тэрбум төгрөгөөр, зарлага 23.9 хувь буюу 2,206.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж төсвийн зарлагын өсөлт орлогын өсөлтөөс 6.8 хувиар өндөр болсон нь алдагдал өсөхөд нөлөөлжээ.

Улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн хэмжээ 2015 онтой харьцуулахад 4110.7 тэрбум төгрөг буюу 107.3 хувиар өссөн байна¹⁰⁸. Гэвч 2016 онд төсвийн тэнцэл 3499.8 тэрбум төгрөг буюу хамгийн их алдагдалтай гарсан нь Монгол Улсын төсвийн орлогод уул уурхайн салбарын эзлэх хувь 13.1 хувьтай тэнцэж, 14.9 пунктээр буурсан нь зэсийн баяжмал, нүүрс, цайрын баяжмал, төмрийн хүдэр, жонш зэрэг эрдэс бүтээгдэхүүний үнийн бууралтаас шалтгаалсан байна. Мөн 2016 онд улсын төсөвт 2 удаа тодотгол хийж, төсвийн нийт орлогыг анх баталснаас 1,593.2 тэрбум төгрөгөөр бууруулж тодотгон баталснаас төсвийн тэнцэл алдагдалтай гарахад нөлөөлжээ. Харин өмнөх оны төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл хамгийн бага алдагдалтай гарсан нь татварын орлого бүх нэр төрлөөр давж биелсэнтэй холбоотой бөгөөд 2018 онд төлөвлөснөөс нийт 41.6 хувиар буюу 1,595.6 тэрбум төгрөгөөр, өмнөх оноос 1,443.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь экспорт өмнөх оноос 13.1 хувиар, импорт 35.5 хувиар өсөж, ААНОАТ-ын орлого 84.7 хувиар, НӨАТ-ын орлого 44.7 хувиар тус тус давж биелсэнтэй холбоотой байна.

Манай улс эдийн засгийн хараат байдлаа бууруулахаар хөрш орнуудтай зах зээлээ өргөжүүлж, ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг эхлүүлснээр валютын нөөцийг нэмэгдүүлж, эдийн засгийн идэвхжилт сэргэж, бодит эдийн засаг өссөн байна. Үүнтэй адилаар Монгол Улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэхийн тулд өндөр хөгжилтэй улс орны төсвийн бүтцийн бодлогыг хэрэгжүүлэх хэрэгтэй. Тухайлбал, АНУ, Скандинавын орнуудын төсвийн орлогын эх үүсвэр нь хүн амын орлогын албан татвар байдаг. Хүн амын орлогын албан татвар нь төсөв дотроо эзэлж байгаа хувийн жин өндөр байснаар төсвийг тогтвортой байлгах үндэс болдог. Харин манай улсад “Хувь хүний орлогын албан татвар”-ын тухай хуулийн 21.1-д цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн тодорхойлсон орлогын 10 хувиар татвар ногдуулна гэсэн байдаг. Гэвч хувь хүний орлогод 10 хувийн адил хэмжээтэй татвар хэрэглэж байгаа нь:

¹⁰⁷ Г.Урансанаа. Төсвийн орлого. УБ., 2020. 32 дахь тал

¹⁰⁸ Г.Урансанаа. Төсвийн орлого. УБ., 2020. 32 дахь тал

- Өндөр хэмжээний татвар нь хүний хөдөлмөрлөх сонирхлыг бууруулж чөлөөтэй байхыг эрхэмлэх зан авирт нөлөөлдөг.

- Орлогын бүх төрөлд (цалин хөлс, үйл ажиллагаа, хөрөнгийн орлого гэх мэт) 10 хувийн адил хэмжээний татвар үйлчилж байгаа нь өндөр татвартай орлогоос бага татвартай орлогын нэр төрлийн хооронд орлогоо шилжүүлж, татвараас зугатах явдал бий болох татварын систем үйлчилж байна хэмээн үзэж болохоор байна.

Төсөв гэдэг нь төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогцыг хэлнэ.¹⁰⁹ Тэгвэл улсын төсөв гэдэг нь Улсын Их Хурлаас баталсан, Засгийн газар болон улсын төсөвт харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг хэлнэ.¹¹⁰

Төрийн оршин тогтнох үндэс суурийг ганцхан татвараар бүрдүүлж байсан ба түүхэн аль ч үед татваргүйгээр оршин тогтнож байсан удаагүй билээ. Татварын үүргийн тогтолцооны талаар эрдэмтэн, судлаачид олон ургалч үзлийг баримталдаг хэдий ч төрийн санхүүг удирдах, зохицуулах үүргийг гүйцэтгэдэг болох тухайд санал бодлын хувьд нэгдмэл байдаг. Татварын шинэчлэл хийх асуудал нь маш адармаатай асуудал бөгөөд зарим тохиолдолд санамсаргүй, муу үр дагавар авчрах нь ч байдаг. Тухайлбал, XIX зууны эхэн үед Пруссид жижиглэнгийн худалдаачдыг дэмжихээр том худалдаачдын татварыг нэмсэн боловч зорилгодоо хүрч чадаагүй. Ажилгүйдэлтэй тэмцэх, хэт баян хоосны ялгааг арилгах зорилгод татварыг ашиглах замаар тансаг хэрэглээний зүйлд татвар ногдуулснаар баячуудын хэрэгцээг багасгаж, улмаар уг үйл ажиллагаа эрхлэгч эзэд ажиллагсадыг олноор ажлаас халж, харин ч ажилгүйдлийн тоог улам нэмэгдүүлсэн зэрэг гашуун туршлагауд түүхэнд тэмдэглэгдсэн байдаг.

Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэргийн объектив тал нь төсөв захирагч төрийн өмч, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан, зах зээлийн дунджаас дээгүүр үнээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан, нөөцлөх нэрээр хэрэгцээнээс илүү хэмжээгээр бараа, бүтээгдэхүүн худалдан авч, мөнгөний эргэлтийг саатуулсан, зохиомол хомдол бий болгох замаар бараа, бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх үнийг зориудаар өсгөсөн, төрийн өмчийн, төсөвт байгууллагын эд хөрөнгийг зах зээлийн дунджаас доогуур үнээр борлуулсан, улсын төсвийн, өөрийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралтад шаардлага хангаагүй бараа, бүтээгдэхүүн ашиглах замаар төсөвт өртгийг бүрдүүлж, хөрөнгө завшсан идэвхитэй үйлдэл байна. Дээрх үйлдлийн аль нэгийг хийж, хохирол учирснаар гэмт хэрэг төгсөхөөр, гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын шинжийг дэлгэрэнгүй байдлаар хуульчилсан нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилтэй холбоотойгоор гэмт хэргийн үйлдлийн арга улам нарийсч төрийн албан хаагчид албан тушаалын байдлаа ашиглан гэмт хэрэг үйлдэх явдал ихэссэнтэй холбоотой.

Гэмт этгээд иргэдийн татварын мөнгөөр бүрдсэн төсвийн хөрөнгийг явцуу хувийн ашиг сонирхлоор зориулалтын бусаар зарцуулах, иргэдэд хүрэх төрийн үйлчилгээг тасалдуулах нь нийгмийн зүгээс төрийн үйл ажиллагаанд итгэх итгэл үнэмшлийг сулруулж, төрийн албаны нэр хүндийг унагах хор хөнөөлтэй.

Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэдэг нь зээл олгох, авах, зээлийн төлбөр гүйцэтгэх, зээл хувиргах, мөнгөн хөрөнгө нэгдсэн зориулалтаас гадуур банкинд данс нээх, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлүүлэх үүрэг авах, хуульд заасныг зөрчин төсвөөс гадуур зардал гаргах, үндсэн хөрөнгө борлуулсны орлогын урсгал зардлыг санхүүжүүлэхэд ашиглах зэрэг хориглосон үйл ажиллагаа явуулахыг, зах зээлийн дунджаас дээгүүр үнээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан гэдэгт зах зээлийн эрэлт нийлүүлэлээр тогсоноос их үнэ ханшаар бараа, ажил, үйлчилгээг худалдаж авсныг ойлгох ба ингэхдээ бараа ажил, үйлчилгээг зах зээлийн үнээр авсан болгож хуурамч баримт бүрдүүлсэн байж болох¹¹¹ ба энэ үйлдэл нь дээрх агуулгад багтаж хуульчлагдсан байна.

¹⁰⁹ Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь хэсэг

¹¹⁰ Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь хэсэг

¹¹¹ С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй: тусгай анги. УБ., 2020. 340 дэх тал

Харин бараа гэж эдийн засгийн ач холбогдол, үнэ бүхий худалдаж, солилцож болох зүйл болон тухайн барааг нийлүүлэхэд шаардагдах ажлыг¹¹², ажил гэж барилга байгууламжийн ажил, барилгын тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгын ажил, түүнчлэн, тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бараа нийлүүлэлтийг,¹¹³ үйлчилгээ гэж зөвлөх үйлчилгээ болон бусад үйлчилгээг¹¹⁴ тус тус ойлгоно.

Нөөцлөх нэрээр хэрэгцээнээс илүү хэмжээгээр бараа, бүтээгдэхүүн худалдан авч, мөнгөний эргэлтийг саатуулсан гэдэгт төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа шаардлагатай хэрэгцээнээс их хэмжээгээр авсан байхыг ойлгоно.¹¹⁵

Зохиомол хомсдол бий болгох замаар бараа, бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх үнийг зориудаар өсгөсөн гэж зах зээлд хэвийн хэмжээнд худалдаалагдаж буй бараа, ажил үйлчилгээг тасалдуулах, хориглолт тогтоох зэргээр нийлүүлэлтийг бууруулах, хомсдол үүссэн мэтээр зохиомол байдал бий болгож үнийг өсгөж авсныг ойлгоно.¹¹⁶

Төрийн өмчийн, төсөвт байгууллагын эд хөрөнгийг зах зээлийн дунджаас доогуур үнээр борлуулсан гэдэг нь зах зээлийн эрэлт, нийлүүлэлтээр тогтсоноос бага үнээр төрийн өмчийн, төсөвт байгууллагын эд хөрөнгийг худалдсныг ойлгоно.¹¹⁷

Шаардлага хангаагүй гэж улсын төсвийн, өөрийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралтын ажлыг заавал дагаж мөрдвөл зохих хууль тогтоомж болон олон улсын буюу үндэсний стандартаар тодорхойлсон болзол, шалгуур үзүүлэлтэд нийцүүлээгүй байхыг ойлгоно.¹¹⁸

Төсөвт өртгийг бүрдүүлж, хөрөнгө завшсан гэж зориулалтын бусаар зарцуулсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан мэтээр хуурамч баримт бичиг, санхүүгийн тайлан, баримт бүрдүүлж өөрт авч ашигласан байхыг ойлгохоор¹¹⁹ нарийвчлан хуульчилсан байна.

Дээрх гэмт үйлдлийн улмаас төсөвт бага хэмжээнээс дээш буюу гурван зуун мянган төгрөгний хохирол учирсан байх ёстой.

Харин төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэргийн субъект нь төсвийн захирагч байхаар хуульчилсан.

Төсвийн захирагч гэдэг нь төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчийг ойлгох юм. Төсвийн ерөнхийлөн захирагч гэдэг нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээд байхаар, төсвийн төвлөрүүлэн захирагч гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээд, төсвийн шууд захирагч гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээд байна.

Энэ гэмт хэргийн субъектив тал нь гэм буруугийн санаатай хэлбэрээр, шунахайн сэдэлтэй үйлдэгдэнэ.

Харин энэ гэмт хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол хүндрүүлэхээр хуульчилсан.

Энэ гэмт хэргийг төсвийн захирагч өөрийн санаачлагаар дангаараа буюу бусадтай хамтран үйлддэгээрээ хахууль авах гэмт хэргээс ялгаатай ба төсвийн захирагч нь хахууль

¹¹² Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.10

¹¹³ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.11

¹¹⁴ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.14

¹¹⁵ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Төрийн мэдээлэл., УБ.2005 №48

¹¹⁶ С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй: тусгай анги. УБ., 2020. 341 дэх тал

¹¹⁷ С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүй: ерөнхий, тусгай анги. УБ., 2012. 654 дахь тал

¹¹⁸ С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүй: ерөнхий ба тусгай анги. УБ., 2012. 654 дахь тал

¹¹⁹ С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй: тусгай анги. УБ., 2020. 341 дэх тал

өгөгчийн ашиг сонирхлын үүднээс эрх мэдлээ урвуулан ашиглаж төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан бол хахууль авах гэмт хэргээр зүйлчилнэ. Харин төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэрэг нь төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэргээс халдлагын зүйл, гэмт хэрэг үйлдсэн хүнээрээ ялгаатай.¹²⁰

Ашигласан материал

Нэг.Хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 1992. №1
- Монгол Улсын Эрүүгийн хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 2002. №5
- Монгол Улсын Эрүүгийн хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 2016. №7
- Монгол Улсын төсвийн тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 2012. №3
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 2005. №48
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 2010. №30

Хоёр.Ном сурах бичиг, гарын авлага

- С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүй: ерөнхий ба тусгай анги. УБ., 2012
- С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй: тусгай анги /нэмж засварласан 2 дахь хэвлэл/. УБ., 2020
- Г.Урансанаа. Төсвийн орлого. УБ., 2020
- Х.Ганболд. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж. УБ., 2013
- www.esan.mn
- www.criminology.mn

¹²⁰ С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй: тусгай анги. УБ., 2020. 343 дахь тал

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬД БАРИВЧЛАХ, ТАСЛАН ЗОГСООХ ХЭР ХЭМЖЭЭГ ХЭТРҮҮЛЖ ХҮНИЙГ АЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ХУУЛЬЧИЛЖ ИРСЭН БАЙДАЛ

Ч.Баярхүү
ДХИС-ийн магистрант, ЦЕГ-ын Тусгай ажиллагааны
газрын бүлгийн ахлах, цагдаагийн хошууч

Товч агуулга. Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж хүнийг алах гэмт хэргийг 1926 оноос хойшхи Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжид хуульчилсан байдал, түүнийг онцлогийг тодорхойлсон.

Түлхүүр үг. Баривчлах, таслах зогсоох, хэр хэмжээ, хүнийг алах, гэмт хэрэг, түүхэн уламжлал, харьцуулсан судалгаа.

Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн үүсэл хөгжил нь Хүннүгийн үеэс уламжлалтай гэж үздэг ч бид Монголын эртний бүхий л хууль цаазуудад уг гэмт хэргийн талаар хэрхэн зохицуулж байсныг судлахыг зориогүй ба гагцхүү шинэ үеийн төрөлжсөн хууль болох 1926, 1929, 1934 оны Шүүх цаазны бичиг, 1942, 1961, 1986, 2002, 2015 оны Эрүүгийн хуульд баривчлах, таслан зогсоох хэр хэмжээ хэтрүүлж хүнийг алах гэмт хэргийг хуульчилсан байдлыг авч үзсэн болно.

БНМАУ-ийн 1926 оны Шүүх цаазын бичгийн III бүлгийн (ял үл хэлэлцэх) 22 дугаар зүйлд “Өөрийн буюу бусдын амь биеийг буюу эрх чөлөөг хамгаалахын тулд үйлдсэн хэрэг нь хэр хэмжээнээс хэтрээгүй бол ял үл хэлэлцэнэ”¹²¹ гэжээ. Энэ нь төрийн түшмэдийн гаргасан тушаал биелүүлэх явцдаа гэмт этгээдэд хохирол учруулсан нь хэр хэмжээнээс хэтрээгүй бол гэмт хэрэгт тооцохгүй болохыг илэрхийлсэн байна.

1929 оны Шүүх цаазын бичгийн 23 дугаар зүйлд “Өөрийн буюу бусдын амь бие, эрх чөлөөг хамгаалах, мөн төрчлэн эдүгээгийн улс төрийн амгалан байдал дор холбогдох аливаа зүйлүүдийг хамгаалахын тулд үйлдсэн хэрэг нь хэр хэмжээнээс хэтрээгүй бөгөөс ял үл хэлэлцмөй”¹²², 1934 оны Шүүх цаазын бичгийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан ял шийтгэж болохгүй учруудад “Ардын хувьсгалт засагт халдахаар завдсан ба эсвэл өөрийн ба бусдын амь бие, эд хөрөнгө, эрх чөлөөнд халдсаныг эрх биш хамгаалахаар үйлдсэн хэрэг нь хэр хэмжээнээс хэтрээгүй бол ял үл хэлэлцмөй”¹²³, 1934 оны Улсын цагдан сэргийлэх газрын дүрмийн 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт оргосон хоригдол, этгээдүүдийг хөөцөлдөн барьсан ямар тохиолдолд олон нийтийн болон бусдын эд хөрөнгийг ашиглах талаар, 1942 оны Эрүүгийн хуулийн 12 дугаар зүйлд “Эрүүгийн хуульд заасан гэмт хэргүүдийг үйлдсэн боловч хэрэв тийнхүү үйлдсэн хэрэг нь ардын хувьсгалт засаг төрд халдахыг завдсан буюу эсвэл өөрийн буюу бусдын амь бие, эрх чөлөөнд халдсан явдлаас аргагүй хамгаалахын тулд үйлдсэн хэрэг нь хир хэмжээнээс хэтрээгүй гэж шүүх таслах газраас үзвэл ял үл хэлэлцэнэ”¹²⁴, 1961 оны Эрүүгийн хуулийн 9 дүгээр зүйлийн Б хэсэгт “Хохирогч буюу бусад хүмүүсээс гэмт хэрэг нэгэнт үйлдсэн этгээдийг засаг төрийн зохих байгууллагад хүргэж өгөх зорилгоор хориглон тогтоохын тул хүч хэрэглэсэн үйлдэл нь уг хэрэгтнийг хориглон тогтоох аргагүй шаардлагатай байсан ба уул гэмт хэргийн хор аюул, тухайн нөхцөл байдалд тохирч байгаа бол аргагүй хамгаалалттай адилтгаж үзнэ”¹²⁵ гэж тус тус заажээ.

1929, 1934 оны Шүүх цаазын бичиг, 1942, 1961 оны Эрүүгийн хуулийн онцлог нь баривчлах, таслан зогсоох ажиллагааг аргагүй хамгаалалтын зохицуулалттай адилтган үздэг байсан учир хэр хэмжээ хэтрүүлсэн бол мөн адил гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэж байжээ.

1961 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 72 дугаар зүйлд “Болгоомжгүйгээс буюу аргагүй хамгаалалтын хир хэмжээг хэтрүүлж бусдыг албал таван жил хүртэл хугацаагаар

¹²¹ И.Дашням, Д.Далайбаяр. БНМАУ-ын Шүүх цаазын бичгүүдийн эмхэтгэл. УБ., 1996. Цуврал №1. 8 дахь тал

¹²² Д.Адъяабазар. Монгол Улсын 1921 оноос хойшхи эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ., 1998 он. 41 дэх тал

¹²³ Д.Адъяабазар. Монгол Улсын 1921 оноос хойшхи эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн хөгжилт. УБ., 1998. 71 дэх тал

¹²⁴ Дурдсан бүтээл. 106 дахь тал

¹²⁵ Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ., 420 дахь тал

хорьж шийтгэнэ", 74 дүгээр зүйлд "Болгоомжгүйгээс буюу аргагүй хамгаалалтын хир хэмжээг хэтрүүлсний улмаас бусдын бие махбодид хүнд гэмтэл учруулбал хоёр жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэнэ" гэж тус тус заажээ. Хэр хэмжээ хэтрүүлсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр анх удаа бие даасан гэмт хэрэг болгож хуульчилснаас гадна гэм буруугийн болгоомжгүй хэлбэрээр гэмт хэрэг үйлдсэн гэж үздэг байжээ.

1986 оны Эрүүгийн хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт гэм буруутай этгээдийг саатуулахын тулд хохирогч буюу бусад хүнээс энэ хуулийн тусгай ангид заасан үйлдлийг хийсэн бол аргагүй хамгаалалттай адилтгаж үзнэ¹²⁶ гэж заасан нь аргагүй хамгаалалттай адилтган үзэх талаар тусгайлан зүйл болгож оруулжээ. 1986 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 89 дүгээр зүйлд "Аргагүй хамгаалалтын хэр хэмжээг хэтрүүлж бусдыг алсан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ", 93 дугаар зүйлд "Аргагүй хамгаалалтын хэр хэмжээг хэтрүүлж бусдын бие махбодид хүнд гэмтэл учруулсан бол нэг жил хүртэл хугацаагаар хорих буюу зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ", 97 дугаар зүйлд "Аргагүй хамгаалалтын хэр хэмжээ хэтрүүлж бусдын бие махбодид хүндэвтэр гэмтэл учруулсан бол нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу олон нийтийн өмнө буруушаах ял шийтгэнэ"¹²⁷ гэж тус тус заажээ.

1961 оны Эрүүгийн хуульд аргагүй хамгаалалтын хэр хэмжээг хэтрүүлж хүнийг болгоомжгүй алсан, болгоомжгүйгээр хүнд гэмтэл учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэж байсан ч 1986 оны Эрүүгийн хуулиар хүндэвтэр гэмтэл учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр өргөжүүлэн дээрх 3 гэмт хэрэгт гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдсэн байхыг шаардах болжээ.

2002 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангид баривчлах, таслан зогсоох ажиллагааг хэрэгжүүлэх явцад хэр хэмжээнээс хэтрүүлсэн бол гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан боловч Эрүүгийн хуулийн тусгай ангид бие даасан гэмт хэргийг хуульчлаагүй.

УИХ-аас 2015 онд баталсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.3 дугаар зүйлд "Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж хүнийг алах" гэмт хэргийг анх удаа хуульчилсан. Тухайлбал, "Гэмт хэрэг үйлдсэн хүн, оргосон ялтныг баривчлах, эрх бүхий байгууллагад хүргэх, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох зорилгоор халдахдаа тухайн хүний үйлдсэн гэмт үйлдлийн шинж чанар, хэр хэмжээнд илт тохирохгүй үйлдэл хийж; тухайн хүнд зайлшгүй хохирол учруулж саатуулах шаардлагатай нөхцөл байдал үүсээгүй байхад халдаж алсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ" гэж заажээ.

Төрийн тусгай албан хаагч хуулиар хүлээсэн албан үүргээ гүйцэтгэх үедээ хэр хэмжээ хэтрүүлж хүнийг алсан бол тусгайлан авч үзэхээр заасан нь нэгдүгээрт: хүнийг алах гэмт хэргээс нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ бага учир тусгайлан зүйлчилж, хөнгөн ял оногдуулах, хоёрдугаарт: төрийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, албан хаагчдын эрх ашигт нийцүүлэн ялгавартай хандах, гуравдугаарт: тусгай албан хаагчийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх, төрийн эрх хэмжээгээр далайлгах, хэтрүүлэх, мэдлэг, чадвар, хандлагаа дээшлүүлэх, хууль, тогтоомж, ёс зүйг чанд сахин мөрдөх, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх явдлыг эрхэмлэх шаардлагыг зүй ёсоор тавих боллоо.

2015 оны Эрүүгийн хууль Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх явдлыг зорилгоо болгосон нь 2002 оны Эрүүгийн хууль тогтоомжоос онцлогтой болжээ. Өөрөөр хэлбэл, төрийн тусгай чиг үүрэг бүхий албан хаагч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх явцдаа хүний эрх, эрх чөлөөг нэн тэргүүнд дээдлэхийг гол зорилгоо болгох ёстой.

Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээ хэтрүүлж хүнийг алах гэмт хэрэг түүхэн хөгжлийн явцад Эрүүгийн хуулийн тусгай ангид бие даасан гэмт хэрэг болон хуульчлагдаж улам баяжиж байгаа нь Монгол Улсын эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны хөгжил нь олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлага, олон улсын гэрээ, конвенц, хүний эрхийн үзэл баримтлалд нийцэж буйг илтгэж байна.

¹²⁶ Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ., 2009. 510 дахь тал

¹²⁷ Дурдсан бүтээл. 523 дахь тал

Ашигласан материал

Нэг.Хууль тогтоомж

- 1926 оны Шүүх цаазын бичиг
- 1929 оны Шүүх цаазын бичиг
- 1934 оны Шүүх цаазын бичиг
- 1942 оны Эрүүгийн хууль
- 1961 оны Эрүүгийн хууль
- 1986 оны Эрүүгийн хууль
- 2002 оны Эрүүгийн хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 2002. №5
- 2015 оны Эрүүгийн хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 2016. №7

Хоёр.Ном, сурах бичиг, гарын авлага

- Д.Адъяабазар. Монгол Улсын 1921 оноос хойшхи эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ., 1998
- Б.Батцэрэн нар. Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/. Сургагч багшийн гарын авлага. Хууль зүй, дотоод хэргийн яам. УБ., 2017
- Г.Гантөмөр, С.Гантулга, Б.Энхболд, Л.Бат-Очир, Ж.Төгс-Очир. Эрүүгийн эрх зүй: ерөнхий анги. УБ., 2020
- С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй: тусгай анги. УБ., 2018
- И.Дашням, Д.Далайбаяр. БНМАУ-ын Шүүх цаазын бичгүүдийн эмхэтгэл. УБ., 1996
- С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол /Гэмт хэргийн тухай сургааль/. УБ., 2009

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ӨӨРӨӨ ӨӨРИЙНХӨӨ ЭСРЭГ МЭДҮҮЛЭГ ӨГӨХГҮЙ БАЙХ ЭРХИЙН АСУУДАЛД

Ц.Хонгорзул

Орхон их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал, магистр

Т.Мөнхбадрах

Орхон их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, магистр

Товч агуулга. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлд хүний халдашгүй байдал болон өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх үндсэн эрхийг баталгаажуулсан. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хувь хүн сэжигтнээр тооцогдох хүртэл эрх бүхий албан тушаалтанд гэмт хэргийн талаар тайлбар өгөх буюу мэдүүлэг өгөх үүрэгтэй болсон нь өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх хуулиар хамгаалагдаж чадаагүй гэж үзэж болохоор байна. Энэхүү өгүүлэлд өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг хангах үндэсний болон гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалж, дүгнэлт боловсруулсан.

Түлхүүр үг: Хүний эрх, сэжигтэн, гэрч, мэдүүлэг, өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх, төрөл, садан, хууль ёсны төлөөлөгч.

Удиртгал

Хүний эрх, эрх чөлөөний асуудал нь хүн төрөлхтөнтэй нэггэн зэрэг үүсэн хөгжсөн эртний Энэтхэг, Грек, Ромоос эхтэй нэн өргөн хүрээтэй ойлголт юм. Эртний сэтгэгчид болох Сэдэдраднаа, Нагаржуна, Зонхоба, шинэ үеийн Ж.Локк, Г.Гроций, В. Гегель, Ж. Боден, Ж.Руссо, Ш.Л.Монтескье, И.Кант, Т.Жефферсон, Ж.Милль зэрэг сэтгэгчид нь хүний амьд явах, аюулгүй орчинд амьдрах, эрх чөлөөтэй байх, өмчлөх, мөлжлөгийг эсэргүүцэх зэрэг жам ёсны салшгүй ариун эрхийг үндэслэжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 16.13-д “Монгол Улсын иргэн халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно.” мөн зүйлийн 16.14-д “...Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно”¹²⁸ гэж Монгол Улсад хувь хүний эрхийг гагцхүү хуулиар хязгаарлах эрх зүйт ёсны үзэл баримтлалыг баталгаажуулсан.

Хүнийг нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлах ажиллагаа нь зөвхөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн дээр л явагддаг онцлогтой.

Үндсэн асуудал

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 16.13-д “Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй”. мөн зүйлийн 16.14-д “...Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно” гэж өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн журмыг хуульчилсан байна.

Мөн хуулийн 16.13-д “...баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ”¹²⁹ гэсэн процедурыг хуульчилсан нь өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, хууль зүйн туслалцаа авах эрхээ хувь хүн эдлэх эсэхээ өөрөө шийдэх эрхийг шууд зөрчсөн зохицуулалт гэж үзэх үндэслэлтэй юм. Учир нь Монгол Улсын Үндсэн хууль хувь хүнд аливаа гэмт хэрэгт өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх буюу өөрийгөө буруутан гэж эрх бүхий албан тушаалтанд хэлэхгүй байх /дуугүй байх/, өөрөө хүсвэл хэдийд ч хууль зүйн туслалцаа авах буюу өмгөөлөгч хүсэх боломжийг олгосон билээ.

¹²⁸ Монгол Улсын Үндсэн хууль. УБ. 1992

¹²⁹ Монгол Улсын Үндсэн хууль. УБ. 1992

Өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийн хамгаалалт нь *nemo tenetur seipsumprodure* буюу “Хэнийг ч өөрийнх нь эсрэг буруутгахгүй” гэсэн эртний хэллэгээс үүсэлтэй¹³⁰ бөгөөд өөрийнх нь эсрэг мэдүүлэг шударгаар аваагүй бол хэнд ч аюултай асуултад хариулахыг албадаж болохгүй гэсэн утгатай.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлд гэрчийн эрх зүйн байдлын талаар заасан. Энэхүү хуулийн 9.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг гэрч гэнэ”¹³¹. Гэрч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан, эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд Зөрчлийн тухай хууль, эсхүл Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Гэрч өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй. Гэрч өөрийнх нь эсрэг, түүнийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай байдлаар мэдүүлэг авч байна гэж үзвэл энэ тухай тэмдэглэлд тусгуулан мэдүүлэг өгөхөөс татгалзаж, өмгөөлөгчтэй мэдүүлэг өгөх эрхтэй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.1 дүгээр зүйлд гэрчээс мэдүүлэг авах тухай зааж, мөрдөгч нь мэдүүлэг өгөх гэж байгаа хүнд өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэйг нь тайлбарлах ба санаатай худал мэдүүлэг өгвөл Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай сануулна¹³² гэж заасан байна.

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлд гэр бүл, гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн гэсэн хууль зүйн нэр томъёог тайлбарласан. Уг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д “гэр бүлийн гишүүн” гэж гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүнийг; 3.1.5-д “төрлийн хүн” гэж гэрлэгчийн эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охин, тэдгээрийн хүүхдийг; 3.1.6-д “садангийн хүн” гэж гэрлэгчийн төрсөн ах, эгч, дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхдийг¹³³ гэж заажээ.

Мөн гэрчийн өөрөө, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан. Уг хуулийн 3.6 дугаар зүйлийн 3-т “Гэрч өөрийн болон гэр бүлийн гишүүн, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй”¹³⁴ гэж заажээ.

Монгол Улсын Дээд Шүүхийн 2017 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн №1 зөвлөмжид “Нотлох баримтыг бүрдүүлэх хүсэлтийг хангавал, тухайн нотлох баримтыг хэрхэн бүрдүүлэх талаар хуульд заасан журмыг мөрдөнө. Жишээ нь, гэрч асуулгах бол уг ажиллагаанд зохигчдыг оролцуулах, гэрчид үнэн зөв мэдүүлэг өгөх талаар хууль сануулах, гэр бүлийн гишүүд бол Үндсэн хуульд заасан гэр бүлийн гишүүдийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг тайлбарлана. Гэрчийг асуухдаа зохигчдын тэгш эрхийг хангана”¹³⁵ гэсэн байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд гэрч нь өөрийнхөө эсрэг болон төрөл, садны эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг хуульчилсан явдал нь гэрчийн халдашгүй эрхтэй холбоотой. Өөрөөр хэлбэл, өөрийгөө болон гэр бүл төрөл, саднаа буруутгахгүй гэсэн үг юм. Төрөл, садангийнхаа эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах гэрчийн эрх нь гэр бүлийн холбоо, ухамсар, ёс суртахуунтай холбоотой.

Бүр 1992 онд ОХУ-д Эрүүгийн хуулийн зориуд худал мэдүүлэг өгөх гэмт хэрэгт шүүхээс ял оногдуулсан байдлыг судалж үзэхэд, ял шийтгүүлсэн хүмүүсийн 71% нь яллагдагчийн гэр бүлтэй холбоотой байна¹³⁶ гэсэн судалгааны дүн гарчээ. ОХУ-ын судлаач Т.Н.Москалкова хэлэхдээ: Ихэнх тохиолдолд яллагдагчийн төрөл, садан мэдүүлэг өгөхдөө “өөрийн хүн”-ийг халхлах гэсэн оролдлого хийдэг гэсэн байна.

Гэрлэлтээ бүртгүүлээгүй ч гэсэн удаан хугацаагаар амьдарч байгаа хүмүүсийн харилцааг гэж мөрдөгч, шүүгч нь нотлох баримт байгаа тохиолдолд гэр бүл гэж үзэж болох юм.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн процессын хуульд

- Яллагдагчтай сүй тавьсан;

¹³⁰ Malkolm M.Feeley, Samuel Krislov, Constitutional Law, second edition, 1996.

¹³¹ Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ. 2017

¹³² Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ. 2017

¹³³ Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль. УБ. 1999

¹³⁴ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль УБ. 2017

¹³⁵ Монгол Улсын Дээд Шүүхийн зөвлөмж 2017 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн №1 “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах зарчим, иргэний хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаа, цаашид анхаарах асуудал”

¹³⁶ Москалькова Т.Н. Честь и достоинство: как защитить? (Уголовно-процессуальный аспект) : пособие для слушателей народ. ун-тов/ Т.Н. Москалькова. — М. : Знание, 1992. — 126 с.

- Гэрлэлтээ цуцалсан яллагдагчийн эхнэр, нөхөр байсан хүмүүс;
- Гэр бүлийн харилцаанд хамт амьдарч байгаа хүнийг гэр бүлийн гишүүнтэй адилтган авч үзсэн байдаг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд гэрч нь хууль ёсны төлөөлөгчийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийн асуудал нь эрх зүйн зохицуулалтгүй байна.

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 9.5 дугаар зүйлд хууль ёсны төлөөлөгчийн тухай заасан.

Мөрдөгч, прокурор дараах хүнийг хууль ёсны төлөөлөгчөөр тогтооно:

- Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, арван найман насанд хүрээгүй хохирогчийн төрсөн, үрчилж авсан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг;
- Хохирогч, хуулийн этгээдийг төлөөлөх албан тушаалтан, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчийг;
- Хохирогч нас барсан, эсхүл сэтгэцийн, эрүүл мэндийн шалтгаанаар өөрийн хүсэл сонирхлоо илэрхийлж чадахгүй тохиолдолд түүний төрсөн, үрчилж авсан эцэг, эх, эхнэр, нөхөр, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг.

Арван найман насанд хүрээгүй хүний хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогдвол зохих хүн байхгүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоож болно.

Сэжигтэн, яллагдагч, гэрч нь асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон асрамжид байгаа насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчийн харьяалагддаг байгууллага, төлөөлөгчийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг хуульчлах шаардлагатай.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлд хүний халдашгүй байдал болон өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх үндсэн эрхийг баталгаажуулсан байдаг. Гэтэл өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд сэжигтнээр тооцох, сэжигтнээс мэдүүлэг авах ажиллагаа зохицуулагдаагүй бөгөөд хэрэгт сэрдэгдэж буй хүнээс гэрчийн мэдүүлэг авах нь түүний үндсэн эрхийг ноцтой зөрчиж буй үйлдэл болж байна.¹³⁷

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13-д “баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ” гэсэн үзэл баримтлалыг одоогийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль шууд агуулсан байна. Эндээс үзвэл, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх сэжигтнээр тооцсон тогтоол гарах хүртэл эрхийн хамгаалалтгүй болсон байна гэж үзэж болох юм.

Сэжигтнийг саатуулах үед тухайн этгээд эрүүгийн процессын ажиллагааны объект болж түүнд эрхийг тайлбарлаж өгдөг. Тухайн этгээд мэдээж мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй. Эрүүгийн хэрэг үүсгэсэн тохиолдолд хэрэгт сэжиглэгдэж буй этгээдэд мэдүүлэг нь чухал зүйл юм. Сэжигтэн мэдүүлэг өгөхөөс өмнө тайлбар өгөхдөө яллах нотлох баримтыг эсэргүүцэх, өөрийгөө хамгаалуулах нотолгоо гаргах зэрэг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд эрхээ эдлэх боломжгүй байна. Сэжигтэн мэдүүлэг өгөөгүй бол юунд сэжиглэж буйг болон гэмт хэргийн нөхцөл байдлыг хэн ч тайлбарлаж мэдээлэхгүй. Энэ тохиолдолд сэжигтэн этгээд нь сэжиглэж буй зүйлийн талаар мэдээлэл тайлбар өгөх боломжгүй. Иймээс сэжигтэн эрх, ашиг, сонирхлоо үр дүнтэй хамгаалж чадахгүй юм.

ОХУ-ын эрдэмтэн А.К.Аверченко “Сэжигтэн субъектив эрхээ хэрэгжүүлэх эзэлхүүн бага байх тусам эрүүгийн мөрдөн байцаах байгууллагууд хууль зөрчиж сэжигтнүүдийн эрхийг зөрчиж байна”¹³⁸ гэж үзсэн байдаг.

2018 онд Монгол Улсын хэмжээнд иргэн хуулийн этгээдээс 198.130 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 70.167 буюу 35.4% нь гэмт хэргийн шинжтэй, 127.963 буюу 64.6% нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна.¹³⁹

2020 онд 16667 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 2.6%-иар буурсан байна.¹⁴⁰

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хувь хүн сэжигтнээр тооцогдох хүртэл цагдаагийн ажилтанд гэмт хэргийн талаар тайлбар өгөх буюу мэдүүлэг

¹³⁷ Б.Өнөрмаа. Хуулийн тодорхой бус зохицуулалтаас шалтгаалж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үүсч буй бэрхшээл. <https://www.mglbar.mn/news/2490>

¹³⁸ Аверченко А.К. Подозреваемый и реализация его прав в уголовном процессе., Томск., 2001г.с.21

¹³⁹ Монгол улс дахь гэмт хэргийн цагаан ном. УБ. 2019. 17-18 дахь тал

¹⁴⁰ <http://police.gov.mn/a/5330>

өгөх үүрэгтэй болсон нь өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх хуулиар хамгаалагдаж чадаагүй байна гэж үзэхээр байна.

Хэрэгт сэрдэгдсэн үеэс эхлэн мэдүүлэг тайлбар өгөх нь тухайн хэрэгт сэрдэгдэж байгаа этгээдийн эрх юм. Харин үүрэг биш.

Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хойшлуулшгүй болон түүнээс бусад тохиолдолд сэжигтнээр тооцох, сэжигтнээс мэдүүлэг авах ажиллагааг хуульчлах шаардлагатай байна.

Эрх бүхий албан тушаалтан аливаа гэмт хэрэгт холбогдсон буюу сэрдэгдсэн этгээдтэй анх харилцахдаа асуулт асуух буюу мэдүүлэг авахын өмнө, баривчлах үед өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй, хэрэв өмгөөлөгч авах боломжгүй бол төрөөс өмгөөлөгч томилуулах эрхтэй"-г заавал сануулах шаардлагатай. Ингэхдээ энэхүү сануулгыг энгийн иргэд ойлгох, ухамсарлах боломжтой байдлаар бичих хэрэгтэй. Тухайлбал, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг хэргийн талаар тайлбар өгөхгүй байх буюу дуугүй байх, хууль зүйн туслалцаа авах эрхийг өмгөөлөгч авах буюу өмгөөлөгч томилуулах зэргээр хэрэг шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагын үйл ажиллагаанд хэвшүүлэх нь зүйтэй юм.

Түүнчлэн, хууль зүйн туслалцаа авах эрхийг хязгаарласан хугацааны зохицуулалтыг өөрчилж, сэжигтэнд өмгөөлөгчдөө болон гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүндээ өөрөө мэдэгдэх боломжоор хангах эсхүл өөрийнх нь хүссэний дагуу өмгөөлөгчөөр нэн даруй хангах зохицуулалтыг хангах шаардлагатай байна.

Дүгнэлт, санал

1. Судалгаагаар гэмт хэргийн гомдол, мэдээлэл төдийлөн буурахгүй байна.
2. Гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээдээс гэрчийн мэдүүлэг авч, гэм буруутай эсэхийг тогтоох нь хүнлэг бус явдал юм.
3. Сэжигтний эрх зүйн хамгаалалт эмзэг, сэжигтнээр тооцогдох хугацаа богино байдаг онцлогтой.
4. Мэдүүлэгт тулгуурласан хэлбэрээс аль болох татгалзах, мөрдөлтийг идэвхжүүлэх, нотлох баримтыг цогцоор нь авч үздэг байх шаардлагатай байна.
5. Хууль ёсны төлөөлөгчийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг хуульчлах нь зүйтэй.

Ашигласан материал:

Нэг. Хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль. УБ. 1992
- Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ. 2017
- Монгол Улсын гэр бүлийн тухай хууль. УБ. 1999
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль УБ. 2017
- Монгол Улсын Дээд Шүүхийн зөвлөмж 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн №1 “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах зарчим, иргэний хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаа, цаашид анхаарах асуудал”
- Комментарий к Уголовно процессуальному кодексу Российской Федерации. Юристы. 2003г

Хоёр. Ном сурах бичиг, гарын авлага

- Т.Н.Москалькова. Честь и достоинство: как защитить? (Уголовно-процессуальный аспект) : пособие для слушателей народ. ун-тов / Т.Н. Москалькова. — М. : Знание, 1992
- А.К.Аверченко. Подозреваемый и реализация его прав в уголовном процессе., Томск.,2001г
- Malkolm M.Feeley, Samuel Krislov, Constitutional Law, second edition, 1996
- Б.Өнөрмаа. Хуулийн тодорхой бус зохицуулалтаас шалтгаалж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үүсч буй бэрхшээл. <https://www.mglbar.mn/news/2490>
- Т.Мөнхбадрах. Гэмт хэрэгт сэжиглэгдэгчийн эрхийн асуудал., УБ. 2013
- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2018. УБ. 2019

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

“ЦАГДААГИЙН ХЭСГИЙН БАЙЦААГЧ” АЛБАН ТУШААЛЫН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН УЛАМЖЛАЛ

Б.Баянмөнх

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн дэд профессор,
доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга. “Цагдаагийн хэсгийн байцаагч” албан тушаалын үүсэл, хөгжил, тухайн албан тушаалтай адилтгах алба хаагчийн үүслийг тодорхойлох шинж болон хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын уламжлалыг дотоодын хууль тогтоомжийн хүрээнд авч үзсэн болно.

Түлхүүр үг: Хэсгийн байцаагч, арван тавны цагдаа

Үндсэн хэсэг

Монголын цагдаагийн байгууллагын түүх, тэр дундаа бидний судлан буй цагдаагийн хэсгийн байцаагч, түүнтэй адилтган үзэж болохуйц албан тушаал бий болсон үүсэл, хөгжлийг судлах нь тодорхой нутаг дэвсгэрт төрийн цагдаагийн үйлчилгээг хэрхэн үзүүлж байсныг тодорхойлох ач холбогдолтой.

Судлаач О.Одбаяр “Ар Монголд Улиастайн цагдаа, Их Хүрээний цагдаа, Орон нутгийн цагдаа гэж 3 үндсэн том цагдаагийн алба байснаас гадна Богд хан уул, Хан Хэнтий уулын ойн цагдаа, Авын цагдаа, Харчин өртөөний цагдаа зэрэг цагдаагийн алба байжээ”¹⁴¹ гэж дурдсан байна.

Түүхч Б.Буянчуулган 1634 онд туурвисан “Манжаас Монголыг эзэрхсэн үеийг илэрхийлсэн хэрэглэгдэхүүн” хэмээх зохиолд “Халх, Дөрвөд аймгуудын доторх олон хошуу шавийн хооронд хуваарилагдсан нутгийн өөр өөрийн хил хязгаарыг харгалзсан цагдаагийн алба байв”.¹⁴² Түүхч Ц.Содномдагва 1961 онд туурвисан “Манжийн захиргаанд байсан үеийн Ар Монголын засаг захиргааны зохион байгуулалт /1691-1911/” хэмээх бүтээлд “Аймаг хошууд нь тусгайлан заасан хил хязгаар бүхий газар нутагтай ба харгалзах цагдаа харуултай байсан”.¹⁴³ Түүхч Л.Гомбо 1960 онд туурвисан “Манжийн үеийн алба гувчуур /1750-1911/” хэмээх зохиолд “Олон хошуудын хилийг харгалзсан харуулуудыг цагдаа буюу тайгам гэж нэрлэж байсан бөгөөд хилийн цагдаа харуул нь ихэвчлэн Монгол Улсын хойд талаар байрлаж байв”¹⁴⁴ гэжээ. Орон нутгийн эдгээр цагдаа нь аймаг, хошуудын хил дагуу байрлаж, аймаг, хошуу дамжсан нүүдэл, айл, малын хөдөлгөөнд хяналт тавих гол үүрэгтэй байжээ.

1727 онд Манж, Орос хоёр гүрэн “Буурын” хэлэлцээр байгуулсан ба энэ хэлэлцээрээр Халх Монгол ба Оросын хилийг нарийвчлан тогтоожээ. Хил тогтоосны дараа Монгол Улсын хилийн дагуу “Хилийн цагдаа” (Суман харуул, гэр харуул) байгуулсан нь одоогийнхоор бол гааль, цагдаагийн болон хил хамгаалах үүрэг гүйцэтгэж байжээ. 1732 онд Улиастайд Манжийн жанжин суурин суух болж, 200 цэрэг байлдадаг байсны хариуцсан үүргийн нэлээд нь цагдаагийн ажил байв. 1788 онд Хилийн цагдаагийн зэрэгцээ “Дотуур цагдаа” ажиллах болсон нь цагдаагийн үүргийг голчлон гүйцэтгэж байжээ.¹⁴⁵

¹⁴¹ О.Одбаяр. “Манжийн үеийн Монголын “Цагдаа”-ийн алба ба “Арван тавны цагдаа” орчин үеийн Монголын цагдаагийн байгууллагын эх үндэс мөн үү”. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үүсэл, хөгжил. /Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл/. УБ., 2011. 68-69 дэх тал

¹⁴² Б.Буянчуулган. Манжаас Монголыг эзэрхсэн үеийг илэрхийлсэн хэрэглэгдэхүүн. /1634 онд туурвисан/ Худам монгол бичгээс крилл бичигт буулгасан: Хэрээд Ж.Урангуа, Боржигон Дориг З.Энхтайван. УБ., 2010. 69 дэх тал.

¹⁴³ Ц.Содномдагва. Манжийн захиргаанд байсан үеийн Ар Монголын засаг захиргааны зохион байгуулалт /1691-1911/. УБ., 1961.

¹⁴⁴ Л.Гомбо. Манжийн үеийн алба гувчуур. /1750-1911/. УБ., 1960.

¹⁴⁵ Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрмийн эмхтгэл. УБ., 2016. 3 дахь тал. Доктор Б.Пүрэвийн бичсэн өмнөтгөл үгнээс хэсэгчилэн авав.

Цагдаагийн түүх судлаач А.Думбурай Халхын хойд хязгаарт Оросын эсрэг байгуулсан Алтайн суман ба орос зүгийн гэр харуулуудыг Манж дайчин улсын харуул, орос-хятадын худалдаачдыг цагдах, хошуудын хилийг зохицуулах харуулуудыг орон нутгийн цагдаа харуул¹⁴⁶ гэж үзжээ.

Гэхдээ эдгээр олон төрөл цагдааг нэгтгэн удирдах цагдаагийн байгууллага байгаагүй, тухайн аймаг хошууны болон манжийн ноёд, түшмэл, цэргийн жанжны удирдлаган дор ажилладаг байсан нь тухайн цаг үеийг цагдаагийн алба үүссэн гэж үзэхэд учир дутагдалтай байна.

XIX зууны II хагасаас Их Хүрээнд хашаа байшин, сүм дуган олноор баригдаж, худалдаа арилжаа өргөжин тэлж эхэлсэн байна. Орон нутгаас хэрмэл цагаачин, ядуу хүмүүс “Их хүрээ”-нд ирэх нь олширч, хулгай, дээрэм мэт хэрэг, зөрчил нэмэгдсэн учир Богд хааны зарлигийн дагуу цагдаагийн алба байгуулжээ.

Бүрэн засагчийн тавдугаар он¹⁴⁷ есөн сарын хорин нэгнээ Жавзандамба хутагтын Эрдэнэ Шанздуб Цэдэндорж, сангийн хамаг хэргийг байцаан захирах засгийн тэргүүн зэрэг тайж Эриндорж, Да лам Лувсан-Иш нарын явуулсан бичигт¹⁴⁸ Түшээт хан, Сэцэн хан хоёр аймаг, Шавь гурван газраас зохих хүнийг томилон “Хүрээний ойр тойрон арван таван газрыг хэмжээлэн гурван анги хуваахад Хүрээний төв дундыг бодож Шар хүрээний¹⁴⁹ өмнөх хаалганы өмнө этгээд ойрхон газар, цаг улирлын тооны хорин дөрвөн зүгт зүг чиг үзэх толь¹⁵⁰ тавьж түүнээс хөөн гурван газрын хариуцах газрыг тогтоож, үүсгэврийг Хүрээний гадуур эргэх замаас үүсгэн, гурван зуун жаран алдыг нэгэн газар, гучин зургаан алдыг нэгэн хувь болгон хувааж, гурван зүгийн хэмжээний нэгэн газар тутам нэгжгээд тэмдэг мод хатгаж, гагцхүү арван таван газрын тэмдэг овооны модонд үсэг бичиж, бусад хорин нэгэн зүгийг мөн гадуур эргэх замаас үүсгэн хэмжиж арван таван газрын эцэст тус бүр модоо овоо тэмдэг...” босгосон тухайгаа илтгэжээ.

Гурван газрын түшмэд хамтран явж газрыг хэмжин товлож, аль хэсгийг хаанах хариуцахыг тохироод: “Эевэрэг хар хоёр зүгийн газрыг Хүрээний баруун этгээдэд худалдаалах иргэдийн¹⁵¹ хамтаар Түшээт хан аймаг цагдан байцаамуй. Хар хөхөгчин хоёр зүгийн хоорон дахь захаас дотогш хуваарийн овооны доторх газрыг хүрээний зүүн этгээдэд худалдаалах иргэдийн хамтаар Шавь цагдан байцаамуй. Хөхөгчнөөс эевэрэг хоёр зүгийн захаас дотогш хуваарийн овооны доторх газрыг Хүрээний зүүн этгээд арван газрын эцэст суугаа иргэдийн хамтаар Сэцэн хан аймаг цагдан байцаамуй. Жич: эдгээр газрын дотор бүхий Их хүрээ, Гандантэгчилэн, Шажныг бадруулагч сүм¹⁵², Буян ерөөлт сүм¹⁵³, Даяны хүрээний¹⁵⁴ олон дацан, суурлын лам нарын дотор тэдний ураг удам хэмээх, жич, таних, танихгүй энгийн учир оршин суух лам хар, эр, эм ардыг уул дүрэм хэмжээний ёсоор язгуурын байгуулсан дарга, нэмэн гаргасан хэвэй¹⁵⁵ дуганч нар цагдан байцаамуй” гэж шийджээ.

Бичгийн утгаас үзвэл, хүрээг тойрон 15 газрыг хэмжээлэн хувааж аль этгээд, аль газрыг цагдан байцаалгахыг тодорхойлон гаргаж хариу ирүүлэх тухай бичиг үүнээс жилийн өмнө ирсэн бололтой, түүнд: “Уулын цагдаад ... эрхгүй сайн чадалтай, хэвийг сахих ардыг сонгон томилж суулгаад ... хэрэв хойч өдөр эдгээр газруудад хулгай худлын зэрэг хэрэг гарваас уулын цагдаагийн харьяат хошуунд тулгаж шийтгүүлсүгэй. Басхүү харьяат хоёр аймаг, Шавь гурван газрын хуваан авсан газар, жич, Зарлигаар дархалсан Хан-Уулыг сайхан санаа

¹⁴⁶ А.Думбурай. Монгол төрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжилт. I дэвтэр. УБ., 1999. 42 дахь тал

¹⁴⁷ Бүрэн засагчийн анхдугаар он 1862 онд байсан тул тавдугаар он - 1867 болно.

¹⁴⁸ УАГ. М-1. Т-1. ХН 5007. Өргөх бичиг хэмээх нугалбар № 2.

¹⁴⁹ Шар ордныг хэлж байна. Одоогийн, “Хүүхдийн урлан бүтээх төв” байгаа, төрийн хэрэг хөтлөдөг байсан шар хэрэмтэй ордныг Шар ордон, Шар хүрээ гэж нэрлэдэг байжээ.

¹⁵⁰ Дөрвөн зүг, найман зовхисийг хорин дөрвөн зурвас болгон хөлөлд оруулдаг аргыг хэлж байна.

¹⁵¹ Энэ үеийн бичигт Хятад хүнийг иргэн, Монгол хүнийг ард буюу зохих цолоор нэрлэсэн байна.

¹⁵² Улаанбаатар хотын музейд буй “Хүрээний сүм хийдийн схем”-ээс үзвэл одоогийн Дамбадаржаагийн хийдийг ингэж нэрлэдэг байжээ.

¹⁵³ Буян Ерөөлт сүм – мөн схемээс харвал, Дамбадаржаагийн хийдээс баруун хойд зүг, Сэлбэ голын зүүн этгээдэд байсан сүм.

¹⁵⁴ Даяны хүрээ – мөн схемээс харвал, Шажныг бадруулагч сүмээс баруун хойш, голын баруун талдаа, уулын ард байсан хүрээ.

¹⁵⁵ Зөвлөх гэсэн Манж үг. De-, CoiUjixsoroet. Moekgo& oa Hegocia biciet SoreeO biciet. Foxegeebegedo*. 1974 oa. 135 dekiA De& t

агуулан цаггүй цагдан байцаалгаж урьд удаагийн тушаасан ёсоор газар орныг чанга ариун болгох явдлыг өөр өөрийн цагдан байцаах түшмэд, зайсан, цэргүүд, уулын цагдаа, ардад нийтээр ухуулан тушааж дагаж явуулахыг хамтаар тушаан явуулсугай. Иймийн тул харьяат гурван этгээдээс гаргасан түшмэд зайсан нар гурван этгээдийн цагдваас зохих газрыг гүйцэд хэмжин, чиг зүгийг тодорхойлон овоо тэмдэг, байгуулсан газрын нэр, жич, гурван ангийг тус тус хамтаар цагдаа байцаалгах явдлыг ялган салгаж урд хожид мэдүүлэн ирсэн зүйлүүдийг хэвээр сийрүүлэн нэгэн хувь цэс үйлдэж, үйлдвээс сайд, сайд Сэцэн хан танаа өргөн мэдүүлж хүргүүлээд байцаахад бэлтгүүлсүгэй” гэж заасан байсныг хариу бичигт өгүүлсэн байна.

Таван сарын шинийн дөрвөнөө илгээсэн нугалбарт “Ноднин жил сайдууд таны газраас... ирүүлсэн бичгийн хариуд...” гэсэн нь энэ талаар өмнө нь бичгээр үүрэг өгч байсныг баталж байна. Энэ мэтчилэн арван тавны цагдаа тодорхой газар нутгийг хариуцан ажиллаж байсныг түүхийн олон баримт бичиг баталж байна. А.Думбурай “Арван тавны цагдаа нь хуваарьт газраа сэргийлэн хамгаалах, хэрмэл цагаачин хүмүүсийг орон нутагт нь буцаах, хулгай дээрэм зэрэг гэмт хэрэг өдүүлэгчдийг илрүүлэн эрхлэх газарт нь хүргэх үүргийг биелүүлж байв”¹⁵⁶, доктор Ж.Долгорсүрэн “...Их хүрээний нутаг дэвсгэрт хэрмэл тэнүүлчин хүнийг суулгахгүй орон нутагт нь буцаах, нийтийн хэв журам, ариун цэврийг сахиулах, хулгай дээрэм зэрэг хэрэг өдүүлэгчдийг олж илрүүлэн, шийдвэрлэх газарт нь хүргэх зэргээр ажиллаж, тэдгээрийн морь уналгыг аймаг бүрээс нь хангуулсаар иржээ”¹⁵⁷ гэж дурдсан байна.

Бадаргуулт төрийн II он буюу 1877 оны 12-р сарын 30-нд Хүрээн дэх Сэцэн хан аймгийн жасаанд суугаа туслагч тайж Гомбожавын бичиг¹⁵⁸, Бадаргуулт төрийн IV он буюу 1879 оны 5-р сарын 1-нд Эрдэнэ Шанздубын яамнаас Хүрээ сайдын яаманд илгээсэн бичиг¹⁵⁹ зэргээс үзвэл арван тавны цагдаа нар нь Их хүрээний ойр орчмын эргэн тойрон газрыг цаг ямагт цагдан манаж, ард олны амар тайван байдлыг хангах үүрэг бүхий алба байсан төдийгүй эргүүл хийх, харуулд гарах явцад ёс бус үйлдэл гаргасан, амгалан тайван байдал эвдсэн этгээдүүдийг баривчилж харьяат газартаа тушаах эрх бүхий алба байсан байна.¹⁶⁰

Нэгэн жишээ дурдвал Бадаргуулт төрийн V он буюу 1880 оны 3-р сарын 30-нд Хүрээн дэх Сэцэн хан аймгийн жасаанд суугаа захирагч Балжираас Хүрээ сайдын газарт илгээсэн бичгийн дотор “...Тушаасныг дагаж харьяат аймгаас гаргасан арван тавны газрын дотор цагдах дарга хуягуудад тушааж бусад гурван газраас гаргасан занги, шархач¹⁶¹, хаалгач, банзач, манаач нарын хамтаар явж хүрээний ойр тойрон газарт илэрхий архины пүүс нээх ба дууч эмсийг дагуулан архи дарс уух, зоос наадах зэрэг самуун ард байгаа үгүйг чандлан цагдан байцааваас хааяа архи худалдах, зоос наадахыг нь даруй барьж өөр өөрийн газар тушааж залхаан цээрлүүлэхээс гадна энэ нэгэн сард энэ мэт муу самуун ард үгүй хэмээн батлан мэдүүлэв”¹⁶² хэмээн өгүүлсэн байна.

Арван тавны цагдаа нь морьт ба явган гэсэн хоёр төрөлтэй, морьтой цагдаа нь хүрээний орчим эргүүл хийх, оргодол, нуугдмал хэрэгтнийг эрэн сурвалжлах, аймаг, хошуу руу явж үүрэг гүйцэтгэж, харин явган цагдаа нь харуул, жижүүр, хуягийн ажил хийх, хэв журам сахиулах, хэрэг зөрчлийн газар дээр ажиллаж байжээ.

Арван тавны цагдаа нар цалин хөлс авч байсан талаар манай эрдэмтэн судлаачдын бүтээлүүдэд дурджээ. А.Думбурай “...1896-1904 он хүртэл өрх гэрээрээ нүүн ирж ажиллаж байсан бөгөөд тэдний зардал хөлсийг манжийн хууль цаазын дагуу халх дөрвөн аймгаас тэгшитгэн гаргаж байсан”¹⁶³, доктор С.Бадарчи “1894 онд Их хүрээнд зун 10, өвөл 20 хүн, морьтой монгол цагдаа 30 хүн хүрээний дотуур гадуур тогтмол цагдан байв. Хожим нь цагдааг

¹⁵⁶ А.Думбурай. Монгол төрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжилт. I дэвтэр. УБ., 1999. 48 дахь тал

¹⁵⁷ Ж.Долгорсүрэн. Монгол Улсын Цагдаагийн эрх зүйн курс. УБ., 2014. 49-50 дахь тал

¹⁵⁸ МУУТА. ФТ-1, Д-1, Х.Н-5606, Б-39

¹⁵⁹ МУУТА. ФТ-1, Д-1, Х.Н-5278, Б-1

¹⁶⁰ О.Одбаяр. “Манжийн үеийн Монголын “цагдаа”-ийн алба ба “Арван тавны цагдаа” орчин үеийн Монголын цагдаагийн байгууллагын эх үндэс мөн үү”. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үүсэл, хөгжил. /Эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл/. УБ., 2011. 69 дэх тал

¹⁶¹ Шархач гэдэг нь Арван тавны цагдаа нарын бүрэлдэхүүнд явж цогцсонд үзлэг хийдэг албаны хүн.

¹⁶² МУУТА. ФТ-1, Д-1, Х.Н-5789, Б-:

¹⁶³ А.Думбурай. Монгол төрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжилт. I дэвтэр. УБ., 1999. 49 дэх тал

110 болгож, сар бүр 4 цэн, 5 лангийн цалинтай болгожээ”¹⁶⁴, судлаач Ч.Ганболд “Явган цагдаа-цэргийг 40 хүнээр нэмэгдүүлж, жилд нэг удаа солих дүрэмт хувцас, сард 4 лан¹⁶⁵, 5 цэн¹⁶⁶-гийн цалин тавьж, гурван жилд нэг удаа шинэчлэх илд, дэгээ зэрэг зэвсэг олгосноос гадна найман зүйлийн дүрэмтэй байв¹⁶⁷ гэж дурджээ.

Дээрх баримтууд нь арван тавны цагдаа нар хариуцсан нутаг дэвсгэр дээрээ хэв журам сахиулахдаа тухайн цаг үеийн ханшаар тодорхой хэмжээний цалин хөлс авдаг байсныг илтгэж байна.

Улаанбаатарын цагдаагийн байгууллагын түүхийн баримт бичигт “Харьяат цагдаа цэргүүдийг захирах таван газрын түшмэд, морьт цагдаа цэргүүд шар өнгийн хүрэм, ханжаар (ханцуйгүй, цээжээр өмсөх хантааз), явган цагдаа цэргүүд улаан өнгийн ханжаар бүхий өмнөд, хойд талд нь шар, улаанаар хавсран үйлдсэн дөрвөлжин дэвсгэр дээр соёмбо ба Монгол үсгээр “Арван тавны цагдаа” гэсэн бичиг бүхий албаны дүрэмт хувцастай байсан, Америк, Орос, Хятад улсад үйлдвэрлэгдсэн буу зэвсэг, мөн уналгын морьдтой байсан¹⁶⁸ талаар дурджээ.

А.Думбурай “Арван тавны цагдаа нар нь морьтой явганаараа ялгагдсан тэмдэгтэй байсан бөгөөд морьт цагдаа нь “цагдан сэргийлэх морьт цагдаа”, явган цагдаа нь “цагдан сэргийлэх явган цагдаа” гэсэн монгол бичгээр бичсэн үгтэй шар хантааз өмсч, галт зэвсэг хэрэглэж байсан бөгөөд гол хэрэглэж байсан буу нь “Усан бамлий” гэдэг буу байжээ”¹⁶⁹ хэмээн бичсэн байна.

Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэх яамны Олноо өргөгдсөний 3-р он, 10 сарын 19-ны бичигт “...цагдаа цэргүүдийн ханжаарт “Монгол Улсын нийслэл хүрээг хамгаалан байцаах морьт ангийн цагдаа цэрэг” хэмээн үг бичигтүн”¹⁷⁰ хэмээн дурдсан байна. Тиймээс арван тавны цагдаа нарын албан үүрэг гүйцэтгэхдээ өмсөж байсан нэг ижил загварын ялгах тэмдэг бүхий шар хантаазтай монгол дээлийг дүрэмт хувцас гэж үзэх үндэстэй байна.

Арван тавны цагдаа үүсэн бий болсон XIX зууны дунд үе нь Монголын хаадын үед баримталж ирсэн “Их засаг” хууль хоригдож, халхын Түшээт хан ноёдын зохиосон халхын гурван хошууны дүрэм, 1709 онд халхын хоёр аймгийн ноёдын зохиосон “Халх журам” хууль хэрэглэхээ больсон үе байжээ. 1817 онд Манж Чин улсаас “Гадаад Монголын хууль зүйлийн бичиг” гэдэг 713 зүйлтэй, 63 дэвтэр хууль бий болгон мөрдөж, хэв журам сахиулж, гэмт хэрэгтэй тэмцэж ирсэн байна.¹⁷¹ Энэхүү хууль нь арван тавны цагдаа нарын үйл ажиллагаандаа мөрдөж байсан эрх зүйн баримт бичиг гэж үзэж болох боловч чуулган дарга, дэд дарга, аймгийн засаг дарга нараас өгсөн шийдвэрүүд нь үйл ажиллагааны эрх зүйн гол үндэс болж байжээ.

Арван тавны цагдаа нь төрийн цагдаагийн байгууллагын шинжүүдийг бүрэн агуулсан, манай улсын цагдаагийн анхны байгууллага мөн гэж үзэж байна. Тухайлбал, “Арван тавны цагдаа” нь:

- Тодорхой нутаг дэвсгэр хариуцаж байсан.
- Хариуцсан нутаг дэвсгэртээ гэмт хэрэгтэй тэмцэж, хэв журам сахиулж байсан.
- Алба хаагчид нь цалин хөлс авч, дүрэмт хувцас, зэвсэг хэрэгсэлтэй байсан.
- Үйл ажиллагаа нь тодорхой хууль тогтоомжоор тус тус зохицуулагддаг байсан.

¹⁶⁴ С.Бадарчи. Монголын эзэнт гүрний үед цагдаагийн чиг үүрэг, эрх дархыг хэрэгжүүлж байсан түүхэн уламжлал. Монгол Улсын цагдаагийн байгууллагын түүхэн замнал, шинэтгэл. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүдийн эмхтгэл. Уб., 2006. 12 дахь тал

¹⁶⁵ Дундад зууны Манж Чин улсын үед Монгол, Хятадад хэрэглэж байсан хүндийн хэмжүүр. Ойролцоогоор нэг лан 37.301 грамм жинг илэрхийлдэг, ланг мөнгөний нэгж болгон хэрэглэж байв.

¹⁶⁶ Цэн – 3.701 грамм.

¹⁶⁷ Ч.Ганболд, Ч.Болдбаатар, Д.Ядамдорж. Police: Дэлхийн цагдаа, Монгол цагдаагийн он дарааллын түүхчилсэн хураангуй. Уб., 2016. 115 дахь тал

¹⁶⁸ Улаанбаатарын цагдаа. Уб., 2016. 16 дахь тал

¹⁶⁹ А.Думбурай. Монгол төрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжилт. I дэвтэр. Уб., 1999. 56 дахь тал

¹⁷⁰ Т.Гомбодаш. Монголын төрийн цагдаагийн түүхийн лавлагаа, тодотгол, судалгааны эх бичгүүдийн хураангуй. /1865-1961/. Уб., 2006. 16 дахь тал.

¹⁷¹ Мөн бүтээл. 50 дахь тал

Хүн амын 1918 оны тооллогоор монголчууд 542.5 мянга, хятадууд 100 мянга, оросууд 5000 гэж тооцож, нийт хүн амын тоо 647.5 мянга байсан бөгөөд 1911-1918 оны хооронд 4.2 мянган хүнээр буюу жилд дунджаар 0.09 хувиар өсч байсан¹⁷² байна.

Хүрээний цагдан сэргийлэх албаны газрын “Нийслэл хүрээний тойрон газрыг цагдан сэргийлэх дүрэм хэмжээ тогтоохуй нь” нэртэй 27 зүйлтэй дүрэм¹⁷³, 1918 онд “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйн бичиг”¹⁷⁴ хуулийг боловсруулан батлуулсан нь хэв журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны эрх зүйн гол эх сурвалж болсон байна. Үүний зэрэгцээ 1919 онд Хятад улс цэргийн хүчээр нийслэл хүрээг эзэлсний дараа 1920 оны 6 дугаар сард “Хүрээний цагдан цээрлүүлэх хороо”-г байгуулж, “Хүрээний цагдан цээрлүүлэх хорооны зохиосон хууль”-ийг зохион мөрдүүлж эхэлсэн боловч удаан үйлчлээгүй байна.¹⁷⁵

Олноо өргөгдсөний 6 дугаар он буюу 1916 оны 12 дугаар сарын 30-нд “Нийслэл хүрээний цагдан сэргийлэх хорооны дүрэм, хэмжээ”¹⁷⁶ батлагдаж, 1923 он хүртэл үйлчилсэн байна. Түүнчлэн энэ үеийн арван тавны цагдаа нь улс орны дотоод аюулгүй байдлыг хангах зарлиг, тушаал, шийдвэрийг хэрэгжүүлж байжээ. Тухайлбал, “Хар тамхи худалдах, татах, тарихыг цаазлан хориглосон” (1912), “Нийслэл хүрээнд ирэх малыг зам тосч аваад дамлан худалдахыг зогсоох” (1917), “Аливаа хулгай худлын зэрэг хэрэгт зарлигийг дагаж явуулах цааз хууль арван зүйл” (1918), “Аливаа лам нар хороо харчуудын газраа хольцолдон муу самуун явахыг цагдан цээрлүүлэх учраа тогтоосон гучин хоёр зүйлийн дүрэм” (1918)¹⁷⁷ зэргийг дурдаж болно.

1916 оны “Нийслэл хүрээний цагдан сэргийлэх хорооны дүрэм, хэмжээ”-д цагдан сэргийлэгчийн гүйцэтгэх үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Их ёслол, Богд хаан, их дагина залрах, ном бурхан залах, цэрэг жагсах зэрэг нийтийг хамарсан арга хэмжээний үеэр дэг журам сахиулах;
- олон нийтийн газар тайван байдлыг хангах, тогтоосон хууль, цааз ба дүрэм хэмжээг сахиулах, суртал ухуулга явуулах;
- нийслэлийн аливаа газруудад ариун цэвэр сахиулах;
- гудамж талбай, зах зээл, холбооны газар зэрэг чухал газруудад хяналт тавих;
- гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд зарлан мэдээлэх, усан хөөргийг авч хамтран унтраах, эд хөрөнгийг хамгаалах;
- нийслэл хүрээний буудал, будаа идэх, цай уух зэрэг үйлчилгээний газруудад зөрчилдөх, хэрэлдэн шуугилдах, мөрийцөн наадах, архи уух, хар тамхи татах, ёс бус үг хэлэлцэх зэрэгт хяналт тавих, зөрчигдсөн тохиолдолд ятган ухуулах, таслан зогсоох;
- харьяалах нутаг дэвсгэрт хүн үхсэн байвал нягтлан шалгах, сэжиг байвал илрүүлэх, үгүй бол холбогдох газарт хүргүүлэх;
- асран хамгаалагчгүй гээгдэл хүүхэд олбол эцэг эхийг олж тогтоох, олдохгүй бол харьяат газар луу шилжүүлэх;
- харьяат газарт их дуу чимээ гаргах, хэрүүл зодоон гарахаас урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд ятган ухуулж зогсоох, үгүй бол харьяат газар хүргүүлж шалгах;
- гэмт хэрэг үйлдэн оргон зайлсан этгээдийг эрэн сурвалжилж, саатуулан баривчлах;
- иргэд бүлэглэн зэвсэг барьж үймээн гаргавал хүч хавсран таслан зогсоож, дайчлан баривчлах;
- цагдан сэргийлэгчид өөр өөрсдийн эрхлэх газрын дотор байгууллага, хүний судалгааг хийж, хяналт тавих;

¹⁷² <http://burtgel.gov.mn/index.php/component/content/article?id=80:civil>

¹⁷³ Т.Хүрэлбаатар., А.Дулаанжаргал., Г.Отгонбаатар. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрмийн эмхтгэл. Уб., 2016. 9-72 дахь тал

¹⁷⁴ Т.Гомбодаш. Монгол төрийн цагдаагийн түүхийн лавлагаа, тодотгол, судалгааны эх бичгүүдийн хураангуй /1865-1961/. Уб., 2006. 13-14 дахь тал

¹⁷⁵ Монгол Улсад шинэ үеийн цагдаагийн байгууллага үүссэн он цаг, үечлэл. Судалгааны тайлан. Уб., 2019. 26 дахь тал

¹⁷⁶ Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрмийн эмхтгэл. Уб., 2016. 12-22 дахь тал

¹⁷⁷ Мөн бүтээл. 24 дэх тал

- гадаадын иргэн хэрэг, зөрчил гаргавал дагуулан явж шалгах, эс бөгөөс гадаад яаманд хүргүүлж үргэлжлүүлэн шалгах¹⁷⁸ зэрэг үүргүүдийг гүйцэтгэж байжээ.

1921 онд Монгол Улсад Ардын хувьсгал ялсны дараа Төв хороо, Түр Засгийн газрын 3-р сарын 24-ны өдрийн хамтарсан хуралдаанаар Засгийн газрын зохион байгуулалтын асуудал хэлэлцэж, Дотоод, Цэрэг, Сангийн яамдыг байгуулж, Цэргийн яамны бүрэлдэхүүнд шинэ тулгар тогтсон хувьсгалт хэв журам, энх амгалан байдлыг сахиулах, ард түмний амь бие, эд хөрөнгөнд халдагсадтай тэмцэх “Сэргийлэх цэрэг”-ийг байгуулжээ.¹⁷⁹

Нийслэлийн цагдан сэргийлэх хороонд 1922 онд 134¹⁸⁰ цагдаа, бага дарга нар ажиллаж байсан бөгөөд 1923 онд Улаанбаатар хот засаг захиргааны хувьд 27 хороотой¹⁸¹ байсан нь нэг хороонд дунджаар тав орчим цагдаа ногдож байсан байна.

Ардын Засгийн газрын 1923 оны 6-р сарын 15-ны 397-р тогтоолоор “Хотын захиргаа байгуулах тухай хэлэлцсэн бичиг”¹⁸²-ийг баталж, зохион байгуулалтын арга хэмжээ авсан бөгөөд 1923 оны 6-р сарын 26-ны 18-р хурлаар ардын цагдан сэргийлэхийн анхны дүрэм болох “Нийслэл хүрээний цагдан сэргийлэх хорооны дүрэм, хэмжээ”, “Цагдан цээрлүүлснийг зөрчигсдийг яллах хууль”¹⁸³ батлан мөрдүүлсэн нь цагдаагийн үйл ажиллагааны эрх зүйн үндэс болсон байна.

1923 оны “Засгийн газраас цагдан сэргийлэх хорооны дүрэм, хэмжээ”-д заасан цагдан сэргийлэгчийн хүлээсэн үүрэгт 1916 оны “Нийслэл хүрээний цагдан сэргийлэх хорооны дүрэм, хэмжээ”-нээс доорх нэмэлт өөрчлөлт орсон байна. Үүнд:

Хүснэгт №1

1923 оны “Засгийн газраас цагдан сэргийлэх хорооны дүрэм, хэмжээ”	
Нэмэгдсэн	Хасагдсан
- алдуул мал, гээгдэл эд зүйл олсон тохиолдолд эзнийг нь тогтоож өгөх, олдохгүй бол харьяат хорооны газарт хүргэж өгөх; - элчин сайд, консулын түшмэдийн нааш цааш явахад хамгаалах; - олон нийтийн газар өвдсөн, гэмтсэн хүн болон ядуу хүн байвал тусламж үзүүлэх, эмнэлэгт хүргэх; - олон хүн нэвтрэн явах замд тэрэг, морь, тэмээ саад болж байвал ятган зайлуулах; - зам, гүүр эвдэрсэн буюу ялзарсан байвал зохих газарт нь мэдэгдэх; - галзуу нохой тааралдвал устгаж, аюулгүй болгох; - сэжиг бүхий эд зүйл авч яваа тохиолдолд нягтлан шалгаж, хянан байцаах; - зөвшөөрөлгүй орон хашаа барих аваас таслан зогсоож, зохих газарт мэдэгдэх; - цуу үг тарааж, олны сэтгэлийг үймүүлэхийг таслан зогсоож саатуулан шалгах; - цахилгааны утас болон гэрлийн багана мод, утас зүйлийг харж цагдах.	- Их ёслол, Богд хаан, их дагина залрах, ном бурхан залах, цэрэг жагсах зэрэг нийтийг хамарсан арга хэмжээний үеэр дэг журам сахиулах; - асран хамгаалагчгүй гээгдэл хүүхэд олбол эцэг эхийг олж тогтоох, олдохгүй бол харьяат газар луу шилжүүлэх; - гэмт хэрэг үйлдэн оргон зайлсан этгээдийг эрэн сурвалжилж, саатуулан баривчлах; - иргэд бүлэглэн зэвсэг барьж үймээн гаргавал хүч хавсран таслан зогсоож, дайчлан баривчлах; - тогтоосон хууль, цааз ба дүрэм хэмжээг сахиулах, суртал ухуулга явуулах.

Монгол Улсын Анхдугаар Үндсэн хууль 1924 онд батлагдаж, Цагдан сэргийлэх байгууллагын гүйцэтгэх үүрэг улам өргөжиж, Нийслэлийн цагдан сэргийлэх хороонд 148 цагдаа үүрэг гүйцэтгэж байжээ.

¹⁷⁸ Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрмийн эмхтгэл. УБ., 2016. 12-22 дахь тал

¹⁷⁹ Ч.Ганболд., К.Нямдаваа., Ж.Баясгалан. Улаанбаатарын цагдаа. УБ., 2016. 20 дахь тал

¹⁸⁰ Ж.Долгорсүрэн. Ардын хувьсгал, хөрөнгөтний бус хөгжлийн болон социализм байгуулахаар замнасан үеийн Монголын цагдан сэргийлэх байгууллагын эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалтын бүтцийн онцлог. /1921-1990 он/. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын түүхэн замнал, шинэтгэл. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүдийн эмхтгэл. УБ., 2006. 25 дахь тал

¹⁸¹ <http://www.ubstat.mn/m/News=70b5c1dc-1e9c-11e3-a522-001fc60e81da>

¹⁸² Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын түүхэнд холбогдох баримтын эмхтгэл. УБ., 2018. 219 дэх тал.

¹⁸³ Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. Хоёрдугаар боть. (1911-1926.V сар). УБ., 2010. 414-418 дахь тал

Улаанбаатар хот засаг захиргааны хувьд 1923 онд 27 хороотой байсныг 1924 оны 5 дугаар сард хороодын тоог цөөтгөж 13 хороо, 1925 онд 15 хороо, 1926 онд 9 хороо, 1928 онд хороодын тоог дахин цөөрүүлж 6 хороотой¹⁸⁴ болгосон бөгөөд энэ үед 3629 өрх айл амьдарч байжээ. 1926, 1927 оны үед хотын нийт оршин суугчдын тоо 30-аад мянга байсан бөгөөд Монголчуудын хувийн хашаа 2368, гадаад улсын харьяат нарын хашаа 1019 байжээ.

Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1926 оны 5-р сарын 14-ны өдрийн 9-р тогтоолоор Улаанбаатар хотын захиргааны харьяалал дор Нийслэлийн Цагдан сэргийлэх газрыг 51 хүний орон тоотойгоор байгуулжээ.¹⁸⁵

1924-1940 онд Цагдан сэргийлэх байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан дүрэм 3 удаа өөрчлөгдөн шинэчлэгдэж, цагдаагийн ажилтны гүйцэтгэх үүргийг тодорхойлж байсан байна. Тухайлбал, УБХ-ын Тэргүүлэгчдийн 1926 оны 1-р сарын 15-ны өдрийн 1-р хурлаар “БНМАУ-ын Цагдан сэргийлэх газрын дүрэм”, 1928 оны 1-р сарын 06-ны хурлаар “Цагдан сэргийлэх газрын дагаж мөрдөх дүрэм”, 1934 оны 7-р хурлаар “БНМАУ-ын Цагдан сэргийлэхийн тухай дүрэм”¹⁸⁶-ийг тус тус баталж мөрдүүлсэн байна.

1926 оны дүрэмд Засгийн газрын зөвшөөрлөөр Цагдан сэргийлэх ерөнхий газрын салбар хороодыг байгуулах зохицуулалтыг оруулсны зэрэгцээ Нийслэл хүрээнд үүрэг гүйцэтгэх цагдаа цэргүүд албаны тэмдэгт хувцас өмсөх, харин бусад хошуудын цагдаа нар тэмдэгт хувцас өмсөхгүй байхаар тусгажээ.

Түүнчлэн хүрээний салбар хороо тутам ерөнхий, бэлтгэл, эрүүгийн хэрэг эрхлэх гэсэн гурван салбар байгуулахаас гадна бусад доод зэргийн албан хаагчдыг харьяат хорооноос эхлэн гүйцэтгүүлэхээр зохицуулсан байна. Өөрөөр хэлбэл хороонд үүрэг гүйцэтгэх цагдан сэргийлэхийн алба хаагчийг цагдан сэргийлэх байгууллагад анхлан орж байгаа алба хаагч хорооноос эрхлэн үүрэг гүйцэтгэнэ гэсэн үг юм.

Хороодод үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид хөнгөн ялимгүй хэргийг өөрөө зохицуулан шийдвэрлэх, харин хүнд хэргийг хот болон аймгийн яаманд шилжүүлэн шийдвэрлэхээр тусгасан нь тухайн үеийн хороо хариуцсан алба хаагчийн үйл ажиллагааг зохицуулсан заалт болжээ.

1936 онд Цагдаагийн сэргийлэн хамгаалах албыг өргөтгөн хоёр хувааж хот хамгаалах тасаг (сэргийлэн хамгаалах байцаагч, морьт, явган эргүүл, улсын чухал объектуудыг хариуцсан), гэрээт харуулын тасаг гэсэн хоёр тасагтай болсон байна.¹⁸⁷

Сайд нарын зөвлөлийн 1936 оны 12 дугаар сарын 48 дугаар тогтоолоор “Цагдан сэргийлэх байгууллагаас аливаа торгуулийг ногдуулах ба хураах тухай дүрэм”¹⁸⁸-ийг батлан мөрдүүлсэн нь тухайн үеийн байцаагч нарын баримталж ажиллах эрх зүйн нэг сурвалж болжээ.

Энэ хугацаанд гурван удаагийн дүрмээр доорх өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

Хүснэгт №2

1926 оны “БНМАУ-ын Цагдан сэргийлэх газрын дүрэм”	
Нэмэгдсэн	Хасагдсан
- аливаа хүн ба айлын нэр, зам биеийг асуувал нарийн тодорхой зааж өгөх; - аливаа хүний гэр байшин, эд зүйлийг нэгжихдээ гэрчтэй байцааж, байцаалгасан хүнээр гарын үсэг зуруулах; - аливаа хүнийг барих, нэгжихдээ зохих газраас олгосон бичиг үзүүлж байх; - аливаа хүн хог буртаг, үхсэн мал, жич хүн, нохойн үхдэл зэргийг үл зохилдох газарт хаяхыг сайтар харгалзан сахиж, тусгай газар зааж хаяулах, зөрчигдсөн тохиолдолд шийтгэл хүлээлгэх.	- хасагдсан үүрэг байхгүй.
1928 оны “Цагдан сэргийлэх газрын дагаж мөрдөх дүрэм”	
- Ардын засгийн газар ба олон яамдын зэрэг газруудаас заасан, тушаасан аливаа хэрэг зүйлийг хууль дүрмийн	- аливаа хүн хог буртаг, үхсэн мал, жич хүн, нохойн үхдэл зэргийг үл

¹⁸⁴ <http://www.ubstat.mn/m/News=70b5c1dc-1e9c-11e3-a522-001fc60e81da>

¹⁸⁵ З.Батсүх. Нийслэлийн цагдаагийн түүхийн хураангуй. Уб., 2001. 5-8 дахь тал

¹⁸⁶ Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрмийн эмхтгэл. Уб., 2016. 141-191 дэх тал

¹⁸⁷ З.Батсүх. Нийслэлийн цагдаагийн түүхийн хураангуй. Уб., 2001. 17-18 дахь тал

¹⁸⁸ А.Думбурай. Монгол төрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжилт. I дэвтэр. Уб., 1999. 126 дахь тал

дагуу гүйцэтгэх;	зохилдох газарт хаяхыг сайтар харгалзан сахиж, тусгай газар зааж хаяулах, зөрчигдсөн тохиолдолд шийтгэл хүлээлгэх;
1934 оны “БНМАУ-ын Цагдан сэргийлэхийн тухай дүрэм”	
- улсын болон олон нийтийн хөрөнгийг хамгаалах; - ардын малыг хулгайлах, хөөн авчрахтай тэмцэх; - ардуудыг жин хэмжүүрээр мэхэлж хохируулахгүй байлгахад хяналт тавих; - төв ба орон нутгийн засаг захиргааны газруудаас гаргасан тогтоол ба тушаалуудын хэрэгжилтэд хяналт тавих, зөрчигдсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх; - эрх бүхий албан тушаалын хүмүүсээс албан үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; - гудамж ба айлууд, яармаг, наадмын газар амгалан байдлыг хянан харгалзах; - хотын доторх явах, зорчих журам сахиулах ба хашаа, гудамж, чөлөөнүүдийн ариун цэврийг харгалзах; - орон байшин ба зам гүүрийн зэрэг барилгуудыг гүйцэтгэхэд аюулыг хамгаалах тухай гарсан дүрэм ёсоор гүйцэтгүүлэх явдлыг хянан харгалзах; - гэнэтийн шуурга, үер, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, ардын мал, хөрөнгийг хамгаалах; - олон нийтийн дунд халдварт өвчин тархсан үед иргэдэд анхны тусламж үзүүлэх, холбогдох газарт мэдэгдэж, тэмцэх арга хэмжээнд туслах; - алга болсон хүүхэд, хүмүүсийг эрэх; - гээгдэл эд зүйлийг хүлээн авч эзэн нь олдтол хадгалах; - гэмт хэргээс урьдчилан сэргийлэх; - эрүүгийн гэмт хэргүүдийг илрүүлэх, мөрдөн байцааж шүүхэд шилжүүлэх; - шүүх, мөрдөн байцаалтаас оргосон этгээдийг эрж олох.	- аливаа хүн ба айлын нэр, зам биеийг асуувал нарийн тодорхой зааж өгөх; - аливаа хүний гэр байшин, эд зүйлийг нэгжихдээ гэрчтэй байцааж, байцаалгасан хүнээр гарын үсэг зуруулах; - аливаа хүнийг барих, нэгжихдээ зохих газраас олгосон бичиг үзүүлж байх.
1936 оны “Монгол Ард Улсын Дотоод явдлын яамны харьяа Улсын Цагдан сэргийлэх газрын дүрэм”	
- цэргийн алба хаагч болон насанд хүрсэн иргэн, хөсөг хэрэглэлийн зүйлүүдийг бүртгэх; - хар тамхи татах, мөрийтэй тоглоом үйлдэхтэй тэмцэх;	- орон байшин ба зам гүүрийн зэрэг барилгуудыг гүйцэтгэхэд аюулыг хамгаалах тухай гарсан дүрэм ёсоор гүйцэтгүүлэх явдлыг хянан харгалзах;

БНМАУ-ын 1940 оны Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу улс орны тухайн үеийн нөхцөл байдалтай уялдан Цагдан сэргийлэх байгууллагын дүрмийг гурван удаа буюу 1942, 1949, 1955 онуудад шинэчлэн үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээ, эрх үүргийг тусгайлан заасан байна.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1942 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 14 дүгээр хурлын тогтоолын 6 дугаар зүйлээр¹⁸⁹ Цагдан сэргийлэх байгууллагын 1936 оны дүрмийг шинэчилж, гурван бүлэг 22 зүйлтэй “БНМАУ-ын ДЯЯ-ны харьяа Улсын цагдан сэргийлэх газрын дүрэм”¹⁹⁰-ийг батлан мөрдүүлжээ.

1949 онд БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчид, Сайд нарын Зөвлөлийн хамтарсан хурлаар “БНМАУ-ын Цагдан сэргийлэх газрын дүрэм”-ийг батлан мөрдүүлсэн байна.

1950 онд Улаанбаатар хотын гудамж, орон сууцны хороодыг хариуцсан Цагдан сэргийлэх ангиудыг байгуулахаар Намын төв хороо, Сайд нарын зөвлөлийн хавсарсан 108/22 тоот тогтоол гарчээ. Энэ тогтоолыг үндэслэн ДЯЯ-ны сайдын 1952 оны 3-р сарын 14-ны 170 тоот тушаалаар Нийслэл хотын арван хороог хариуцсан Цагдан сэргийлэхийн таван анги, нэг хэсэг байгуулжээ¹⁹¹.

¹⁸⁹ Т.Хүрэлбаатар., А.Дулаанжаргал., Г.Отгонбаатар. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрмийн эмхтгэл. Уб., 2016. 296 дахь тал

¹⁹⁰ А.Думбурай. БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын зарим эрхийн актууд. Эмхтгэл. Уб., 1988. 49-52, 58-60 дахь тал

¹⁹¹ Ч.Ганболд, К.Нямдаваа, Ж.Баясгалан. Улаанбаатарын цагдаа. /Зурагт түүх/. Уб., 2016. 34-35 дахь тал

Сайд нарын зөвлөлийн 1955 оны 3 дугаар сарын 29-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор “БНМАУ-ын Дотоод явдлын яамны харьяа Улсын цагдан сэргийлэх газрын дүрэм”-ийг баталжээ.

Сэргийлэн хамгаалах хэлтсийн харьяанд сэргийлэн хамгаалах байцаагч нь орон сууцны гудамж, хороог давхар хариуцан Цагдан сэргийлэх байгууллагын 1940-1960 оны хооронд батлагдсан гурван удаагийн дүрмийг дагаж мөрдсөн байна.

Сэргийлэн хамгаалах байцаагчийн хүлээж байсан үүргүүдийг дээрх гурван дүрэмд хэрхэн тусгаж, нэмэлт өөрчлөлт оруулж байсныг авч үзвэл:

Хүснэгт №3

1942 оны “Дотоод явдлын яамны харьяа Улсын Цагдан сэргийлэх газрын дүрэм”	
Нэмэгдсэн	Хасагдсан
- олон нийтийн хэв журам ба амгалан тайван байдлыг алдагдуулах, зөрчих явдлыг таслан зогсоох, гэмт хэрэг өдүүлэгчийг дайчлан баривчлах, нэгжих, мөнгөөр торгох зэргээр багцлан оруулсан.	- хасагдсан үүрэг байхгүй;
1949 оны “БНМАУ-ын Цагдан сэргийлэх газрын дүрэм”	
- улсын ба олон нийтийн үйлдвэр, байгууллага, барилгын газруудад нийтийн амгалан тайван байдлыг сахих зааврыг биелүүлэх явдлыг хянан шалгаж сахиулах; - гэнэтийн аюул тохиолдсон үед нийтэд зарлан мэдэгдэх; - олноор цугларах газарт хэв журмыг сахиулах; - ард түмний хувийн өмч хөрөнгө, эрх чөлөөг хамгаалах; - ард ба байгууллагуудаас гарган ирүүлсэн гомдлуудыг хүлээн авч шалган барагдуулах; - сууж байсан газраас нь хөөн зайлуулахаар ял заасан шүүхийн тогтоолыг гүйцэтгэх ба хөөгдсөн бүртгэлийг эрхлэх, хяналт тавих; - буу зэвсэг, галт хэрэглэлүүдийг журам бусаар хэрэглэх, дамлан худалдах явдалд хяналт тавих, шалгалт хийх; - цэргийн насны хүмүүсийн бүртгэлийг явуулахад туслалцаа үзүүлэх; - заавал нийлүүлэх агт морьд ба зардлын хийгээд авто техникийн бүртгэлийг явуулахад туслалцаа үзүүлэх.	- хасагдсан үүрэг байхгүй;
1955 оны “БНМАУ-ын Дотоод явдлын яамны харьяа Улсын цагдан сэргийлэх газрын дүрэм”	
- яам, олон нийтийн байгууллагуудаас жагсаал ба бусад арга хэмжээг зохиож байгаа үед журам сахиулах; - гудамж, олон нийтийн газраас асрамжлагдаагүй хүүхдийг татан авч, зохих байгууллагад шилжүүлэх, эцэг эхэд нь хүлээлгэн өгөх; - гэмт хэрэг, цаг бусын аюулд өртсөн хүмүүст тусламж үзүүлэх; - гудамж талбай, нийтийн хэрэглээний газруудын ариун цэвэр, бүрэн бүтэн байлгахад хяналт тавих; - цагдан сэргийлэхийн эрхлэх асуудлуудын талаар засаг төрийн байгууллагуудаас гаргасан хууль, тогтоол, шийдвэр, захирамжуудыг албан тушаалтан ба ард иргэдээс хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих; - дэлбэрэх материал, хүчтэй хор ба хордуулах бодис буу сумыг худалдаж авах, тээвэрлэх, хадгалах эрхийг үйлдвэрийн газруудад олгох, буу сумыг эдлэх, хадгалах зөвшөөрлийг ард иргэдэд олгох, хэрэгжилтэд нь хяналт тавих; - худалдааны газруудад зөв ажиллагаатай жин хэмжүүр ба бусад хэмжих багаж хэрэгслийг хэрэглэж байгаа эсэхийг хянах; - паспорт бүртгүүлэх, хасуулах дүрэм, журмыг байрны захиргаа, байшингийн эзэн болон оршин суугчдаас хэрхэн биелүүлж байгааг хянаж шалгах.	- сууж байсан газраас нь хөөн зайлуулахаар ял заасан шүүхийн тогтоолыг гүйцэтгэх ба хөөгдсөн бүртгэлийг эрхлэх, хяналт тавих; - заавал нийлүүлэх агт морьд ба зардлын хийгээд авто техникийн бүртгэлийг явуулахад туслалцаа үзүүлэх.

1960 онд УЦСЕГ-ын Сэргийлэн хамгаалах хэлтсийг татан буулгаж, оронд нь Нийслэлийн цагдан сэргийлэх газрын Сэргийлэн хамгаалах хэлтсийг байгуулжээ. Тус хэлтэс нь 1960-1965 онд хот, хөдөөгийн хэмжээгээр хэв журам хамгаалах ажлыг хариуцаж, нийслэлийн 13 хороо, аймгийн сэргийлэн хамгаалах байцаагч нарыг харьяалж байжээ. 1965 оноос нийслэлийн хороо бүр хэв журам сахиулах сэргийлэгчтэй болсон байна.¹⁹²

1975 оны дундуур Нийслэлийн районы цагдан сэргийлэх хэлтэст сэргийлэн хамгаалах ахлах болон орон сууц, гудамжны хороод хариуцсан хэсгийн байцаагч бий болгож, 50 гаруй байцаагч, 100 гаруй сэргийлэгч ажиллуулж, хөдөөд засаг захиргааны 3-5 нэгж (сум) хариуцсан хэсгийн төлөөлөгчийг өөрчлөн, 1970-аад оны сүүлчээр сум бүрт хэсгийн төлөөлөгчтэй болжээ.¹⁹³

Тухайн үед нийслэлийн хүн ам жил ирэх тутам өсөж, ажилгүй иргэд болон хараа хяналтгүй хүүхэд, архидаан согтуурагч, танхайрагчид ихсэж байсантай холбоотой бөгөөд энэ нь цагдаагийн хэсгийн байцаагчийн хариуцсан нутаг дэвсгэр, гүйцэтгэх үүрэг буюу эрх хэмжээ, цагдаагийн байгууллагын бүтцэд хэсгийн байцаагчийн албан тушаал зүгширч тогтсон үе бөгөөд түүнээс хойш онцын өөрчлөлтгүй өнөөг хүрчээ.

Энэхүү 30 гаруй жилийн хугацаанд Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм хоёр удаа шинэчлэгджээ. Тухайлбал БНМАУ-ын СнЗ-ийн 1963 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 499 дүгээр тогтоолоор “БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм”¹⁹⁴, БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1985 оны 3 дугаар сарын 29-ны өдрийн 96-р зарлигаар “БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын үндсэн үүрэг, эрхийн тухай”¹⁹⁵ дүрэм батлагджээ.

1980-аад оны Улаанбаатар хот төвдөө 5000 га талбай бүхий нутаг дэвсгэртэй, 430 гаруй мянган хүн амтай, 5 район, ОСГ-ны 102 хороо, 73 мянган өрх, 1000 гаруй албан байгууллага, 1270 гаруй гудамж, талбайтай байжээ.¹⁹⁶

Дээрх дүрмүүдээр сэргийлэн хамгаалах байцаагч, 1975 оноос хорооны хэсгийн байцаагчийн үйл ажиллагаа зохион байгуулагдаж байснаас гадна танхайрагчид, нийгмийн хэв журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг чангатгах тухай АИХ-ын Тэргүүлэгчдийн 1974 оны 111-р зарлиг, архидаан согтуурах явдалтай хийх тэмцлийг хүчтэй болгох тухай 120-р зарлигууд¹⁹⁷ нь үйл ажиллагааны эрх зүйн үндэс болж байжээ. Түүнээс гадна орон нутгийн АДХ-ын Гүйцэтгэх захиргааны заавал биелүүлэх шийдвэр, Сайд нарын Зөвлөлийн тогтоол зэргээр тухайн үед шинэ үүргүүд бий болж хэрэгжиж байсан байна.¹⁹⁸

1963, 1985 оны дүрмүүдэд заасан сэргийлэн хамгаалах болон хэсгийн байцаагч нарт хамаарах үүргүүдийн нэмэлт өөрчлөлтийг авч үзвэл:

Хүснэгт №4

1963 оны “БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм” ¹⁹⁹	
Нэмэгдсэн	Хасагдсан
Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр: - хуулийн бусад байгууллагатай хамтарч, гэмт хэргийн үүсэн гарч байгаа шалтгаан, нөхцөл байдлыг судлан илрүүлж, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх; - олон нийтийн хэв журам зөрчигчдийг албадан ирүүлэх ба гэмт хэргийн сэжигтэй хүмүүсийг албадан саатуулж шалгах; - эрэн сурвалжлах /хүүхдэдээ хууль ёсоор тэтгэвэр төлөх явдлаас зайлсхийн нуугдсан хүнийг/ Олон нийтийн хэв журам сахиулах чиглэлээр: - нам, улс, олон нийтийн байгууллагаас эрхлэн зохиож байгаа	- гудамж талбай, нийтийн хэрэглээний газруудын ариун цэвэр, бүрэн бүтэн байлгахад хяналт тавих; - худалдааны газруудад зөв ажиллагаатай жин хэмжүүр ба бусад хэмжих багаж хэрэгслийг хэрэглэж байгаа эсэхийг хянах; - паспорт бүртгүүлэх, хасуулах

¹⁹² Ж.Содмандах. Нийгмийн хэв журам хамгаалах албаны түүхэн замнал. Уб., 2011. 14 дэх тал

¹⁹³ Ж.Долгорсүрэн. Ардын хувьсгал, хөрөнгөтний бус хөгжлийн болон социализм байгуулахаар замнасан үеийн Монголын цагдан сэргийлэх байгууллагын эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалтын бүтцийн онцлог. /1921-1990 он/. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын түүхэн замнал, шинэтгэл. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүдийн эмхтгэл. Уб., 2006. 32 дахь тал

¹⁹⁴ Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрмийн эмхтгэл. Уб., 2016. 337-348 дахь тал

¹⁹⁵ Мөн бүтээл. 352-382 дахь тал

¹⁹⁶ Ч.Ганболд, К.Нямдаваа, Ж.Баясгалан. Улаанбаатарын цагдаа. /Зурагт түүх/. Уб., 2016. 73 дахь тал

¹⁹⁷ А.Думбурай. Монгол төрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжилт. II дэвтэр. Уб., 1999. 119 дэх тал

¹⁹⁸ Мөн бүтээл. 242 дахь тал

¹⁹⁹ Мөн бүтээл. 337-348 дахь тал

нийтийн зугаалга, биеийн тамирын тэмцээний үед хэв журам сахиулах; - хот, суурин газарт ариун цэврийн зохистой байдлыг хангах талаар орон нутгийн засаг захиргаа, эрүүлийг хамгаалах байгууллагад дэмжлэг үзүүлж, мөн тарьсан мод, зүлэг, түүхийн дурсгалт зүйлийг бүрэн бүтэн байлгах талаар хяналт тавих; Галын аюулаас хамгаалах чиглэлээр: - улс, олон нийтийн байгууллага, ард иргэдийн өмчийг гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг улсын хяналтын дүрмийн дагуу гүйцэтгэх; Бусад үүрэг: - улсын аюулаас хамгаалах байгууллагад шаардлагатай туслалцаа үзүүлэх; - БНМАУ-ын Засгийн газрын шийдвэрээр даалгасан бусад үүргийг гүйцэтгэх.	дүрэм, журмыг байрны захиргаа, байшингийн эзэн болон оршин суугчдаас хэрхэн биелүүлж байгааг хянаж шалгах.
1985 оны “БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын үндсэн үүрэг, эрхийн тухай”²⁰⁰ дүрэм	
- төмөр зам, нисэх онгоцны буудал, үзвэр үйлчилгээний газарт нийгмийн хэв журам хамгаалах; - социалист өмч, иргэд, үйлдвэр, албан газар, байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг гэмт халдлага, нийгэмд харш бусад үйлдлээс хамгаалах; - нийгмийн тустай хөдөлмөрөөс зайлсхийж байгаа болон бусдын хүчийг сорон амьдарч байгаа хүмүүсийг илрүүлж тэдэнд хууль тогтоомжид заасан арга хэмжээ авах; - хүүхдийг хараа хяналтгүй байлгах явдлаас урьдчилан сэргийлэх, насанд хүрээгүй хүмүүсээс гэмт хэрэг үйлдэх, эрх зүйн бусад зөрчил гаргах явдалтай тэмцэх ажлыг улс, хоршоолол, олон нийтийн байгууллагатай хамтран зохиох; - нутаг заах, уг нутгаас зайлуулах, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял оногдуулсан болон ялтныг хөдөлмөрт заавал татан оруулахаар хорих ялыг тэнссэн шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэх, түүнчлэн нутаг заах, уг нутгаас зайлуулах ял эдэлж байгаа болон хөдөлмөрт заавал татан оруулахаар хорих ял нь тэнсэгдсэн буюу ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдсан хүмүүст хяналт тавих; - хорих ял оногдуулсан таслан шийдвэрлэх тогтоолыг хойшлуулсан насанд хүрээгүй хүмүүст орон нутгийн АДХГЗ-ны дэргэдэх Насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисстой хамтран хяналт тавих; - хорих газраас суллагдсан хүмүүст зохих журмын дагуу захиргааны хяналт тогтоон хэрэгжүүлж, нийгмийн тустай хөдөлмөр эрхлэх, амьдралаа зохиоход нь туслалцаа үзүүлэх.	- улс, олон нийтийн байгууллага, ард иргэдийн өмчийг гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг улсын хяналтын дүрмийн дагуу гүйцэтгэх; - хот, суурин газарт ариун цэврийн зохистой байдлыг хангах талаар орон нутгийн засаг захиргаа, эрүүлийг хамгаалах байгууллагад дэмжлэг үзүүлж, мөн тарьсан мод, зүлэг, түүхийн дурсгалт зүйлийг бүрэн бүтэн байлгах талаар хяналт тавих; - улсын аюулаас хамгаалах байгууллагад шаардлагатай туслалцаа үзүүлэх.

1963 оны БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм²⁰¹-д цагдан сэргийлэх байгууллагын хүлээх үүргийг дотор нь бүлэглэн а) гэмт хэрэгтэй тэмцэх талаар найм, б) олон нийтийн хэв журам сахиулах талаар 11, в) хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар 10, г) галын аюулаас хамгаалах талаар гурав, д) паспортын дүрмийг биелүүлэх талаар тав, е) иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх талаар хоёр, ё) бусад үүргийг биелүүлэх талаар дөрөв, нийт 43 үүрэг гүйцэтгэхээр заажээ.

Харин сэргийлэн хамгаалах байцаагчид хамаарах 19 үүрэг байгаа бөгөөд 1955 оны дүрэмд заасан үүргүүд дээр шинээр найман үүрэг шинээр нэмэгдэж, гурван үүрэг хасагдсан байв.

1985 оны “БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын үндсэн үүрэг, эрхийн тухай” дүрэмд хорооны хэсгийн байцаагчид хамаарах үүргүүд дээр өмнөх дүрэм дээр шинээр долоон

²⁰⁰ А.Думбурай. Монгол төрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжилт. II дэвтэр. Уб., 1999. 352-382 дахь тал

²⁰¹ Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрмийн эмхтгэл. Уб., 2016. 141-154 дэх тал

үүрэг нэмэгдэж /захиргааны хяналт тавих гурван үүрэг нь агуулгын хувьд нэг/ гурван үүрэг хасагдсан байна.

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1990 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 95 дугаар зарлигаар БНМАУ-ын Нийгмийг аюулаас хамгаалах яамыг татан буулгаж, Улсын цагдан сэргийлэх ерөнхий газар, Улсын аюулгүй байдлыг хангах ерөнхий газар байгуулахыг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлд даалгажээ. “Цагдан сэргийлэх байгууллагын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай” БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1990 оны 4 дүгээр сарын 19-ны өдрийн 192 дугаар тогтоолоор НАХЯ-ны Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрыг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Улсын цагдан сэргийлэх ерөнхий газар болгон өөрчлөн зохион байгуулжээ.²⁰²

Монгол Улсын шинэ Үндсэн хууль 1992 онд батлагдаж, үүнтэй холбоотойгоор 1993 оны 12-р сарын 13-нд УИХ-аас “Цагдаагийн байгууллагын тухай хууль” батлагдан хэрэгжиж эхэлснээс хойш Засгийн газрын тогтоолоор батлан гаргасан цагдаагийн байгууллагын дотоод албаны, цагдаагийн алба хаагчийн сахилгын, цагдаагийн эргүүл харуулын, цагдаагийн хүрээний болон цагдаагийн туслах ажилтны дүрмүүд зэрэг нь хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн үндэс болжээ.

Шинэ Үндсэн хууль болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу 1992 оны 9-р сард Нийслэл Улаанбаатар хотын засаг захиргааны зохион байгуулалтыг өөрчилж, 12 дүүрэг²⁰³, 119 хороотой байгуулжээ.²⁰⁴

Хүснэгт №5

1993 оны “Цагдаагийн байгууллагын тухай хууль” ²⁰⁵	
Нэмэгдсэн	Хасагдсан
Нийгмийн хэв журам хамгаалах: - Цагдаагийн байгууллага нь хуулиар харьяалуулсан захиргааны зөрчлийг шалгаж шийдвэрлэх; - олон нийтийн газар согтуугаар хэвийн бус яваа хүнийг тусгай байранд эрүүлжүүлэх, эсхүл хамгаалах хүнд хүлээлгэн өгөх; - тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийх, ашиглах журмын биелэлтэд хяналт тавих; - каратэ, самбо зэрэг зэвсэггүйгээр тулалдах арга/мэх/-ын байлдааны хувилбарыг цэргийн ба цагдаагийн алба хаагч бус хүмүүст зохион байгуулалттайгаар зааж сургахад хяналт тавих; - мөрийтэй тоглоом тоглуулах журмын биелэлтэд хяналт тавих; - Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ашиглаж байгаа өнгөт хувилагчийг бүртгэж, тэдгээрийн ашиглалтад хяналт тавих.	- нийгмийн тустай хөдөлмөрөөс зайлсхийж байгаа болон бусдын хүчийг сорон амьдарч байгаа хүмүүсийг илрүүлж тэдэнд хууль тогтоомжид заасан арга хэмжээ авах; - нутаг заах, уг нутгаас зайлуулах, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял оногдуулсан болон ялтныг хөдөлмөрт заавал татан оруулахаар хорих ялыг тэнссэн шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэх, суллагдсан хүмүүст хяналт тавих.

Цагдаагийн хэсгийн байцаагч нь 1975 онд албан ёсоор засаг захиргааны анхан шатны нэгж хороо хариуцан ажиллаж эхэлснээс хойш анх удаа ЦЕГ-ын даргын 2003 оны 229-р тушаалаар батлагдсан “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-тай болжээ.

Монгол Улсын хууль зүйн салбарт 2012 оноос эхлэн эрх зүйн шинэчлэл эрчимтэй явагдаж Цагдаагийн байгууллагын тухай хуулийг шинэчлэн боловсруулж 2013, 2017 онуудад “Цагдаагийн албаны тухай хууль”²⁰⁶ батлагдаж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт шинэчлэгдсэн. Үүнд үндэслэн Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байсан бүх журам, заавруудыг шинэчлэн боловсруулж системчлэн “Цагдаагийн

²⁰² Б.Пүрэв. Монгол Улсын Засгийн газрын дэргэдэх цагдаагийн байгууллага. Уб., 2016. 12 дахь тал

²⁰³ Ч.Болдбаатар., Ю.Дуламрагчаа., Э.Нансалмаа. Нийслэл Улаанбаатар. Он дарааллын бичиг. Уб., 2014. 209 дэх тал. УИХ-ын 1992 оны 8 сарын 18-ны өдрийн “Улаанбаатар хотын район, хороог татан буулгах, шинээр байгуулах тухай” 18 тогтоол гарч, шинээр Хан-Уул, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Сонгинохайрхан, Налайх, Багануур, Багахангай, Туул, Жаргалант, Гачуурт дүүргийг шинээр байгуулсан байна.

²⁰⁴ З.Батсүх. Нийслэлийн цагдаагийн түүхийн хураангуй. Уб., 2001. 45 дахь тал

²⁰⁵ Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрмийн эмхтгэл. Уб., 2016. 337-348 дахь тал

²⁰⁶ Төрийн мэдээлэл. 2017. № 8. Цагдаагийн албаны тухай хууль

байгууллагын үйл ажиллагааны журам"-ыг гаргасан нь хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн орчин бүрдэх нэг үндсэн нөхцөл болжээ.

Дүгнэлт

Цагдаагийн хэсгийн байцаагчийн үүсэл хөгжлийг арван тавны цагдаагаас үүсэлтэй гэдгийг а) тодорхой нутаг дэвсгэр хариуцаж байсан, б) хариуцсан нутаг дэвсгэртээ гэмт хэрэгтэй тэмцэж, хэв журам сахиулж байсан, в) цагдаа нар цалин хөлс авч, дүрэмт хувцас, зэвсэг хэрэгсэлтэй байсан, г) үйл ажиллагаа нь хууль тогтоомжоор зохицуулагддаг байсан шинжүүдээр нотлогдож байна.

Нийслэлийн засаг захиргааны нэгж болох хороон дээр 1965 оноос сэргийлэгч ажиллаж эхэлсэн бөгөөд 1975 оноос хэсгийн байцаагч хариуцаж цагдаагийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлж ирсэн байна. 1916-1994 онд Цагдаагийн байгууллагын тухай 11 дүрэм, нэг хууль батлагдаж, эдгээр нь цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт болж ирсэн байна. Цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааг дагнан журамласан эрх зүйн зохицуулалт-заавар 2003 онд батлагджээ.

ОРГАНИЗАЦИЯ ПРОФИЛАКТИКА ПРЕСТУПЛЕНИЙ УСЛОВНО ОСУЖДЕННЫХ ОРГАНАМИ ПОЛИЦИИ МОНГОЛИИ

А.Баасанцэрэн

Старшие преподаватель кафедры полицейское права, полковник полиции

Аннотация: В статье рассматриваются вопросы осуществления Организация профилактика преступлений условно-осужденных в Монголии. Автор раскрывает главная роль в предупреждении преступности, деятельность органов полиции при осуществлении контроля за поведением условно осужденных. Обеспечение общественного порядка среди условно осужденных и их близких играет важную роль в борьбе с рассматриваемым преступлением.

Ключевые слова: Профилактика преступлений, контроль участковые инспектор, условно осужденных, патрульное служба, функции контроль, осуществлении контроля.

Профилактика преступлений – многоуровневая система целенаправленных и общественных мер по выявлению, устранению, ослаблению и нейтрализации причин и условий преступности, отдельных видов преступлений и конкретных преступлений, а также удержанию от перехода или возраста на преступный путь людей, условия жизни и поведение которых указывают на такую возможность²⁰⁷.

Таким образом предупреждение преступлений условно осужденных можно определить, как систему государственных и общественных мер, направленных на выявление, устранение, ослабление или нейтрализацию причин и условий, способствующих совершению преступлений условно осужденными, а также на удержание их от совершения повторных преступлений.

Главная роль в предупреждении преступности условно осужденных принадлежит органам полиции. Органы полиции, по сравнению с другими правоохранительными органами, имеют больше возможностей, сил и средств, а также полномочий в профилактике рецидивной преступности со стороны условно осужденных. Так, по законодательству Монголии контроль за поведением условно осужденных в течение испытательного срока осуществляется полицейскими органами по месту их жительства.

Органов Полиции выполняют большой объем работы по специально-криминологической профилактике. Их особая роль в этом деле определяется разнообразием и широкой компетенции, обширным спектром полномочий по осуществлению оперативно-розыскной, административно-юрисдикционной, уголовно-процессуальной и иных видов деятельности по борьбе с правонарушениями и основной массой преступлений, наличием в структуре разных служб и подразделений, включая такие, которые специализируются на криминологической профилактике.

О направленности, содержании и масштабах многогранной деятельности органов полиции по профилактике преступлений и других правонарушений можно судить по следующим показателям. За 2015 г. Проведено 35 комплексных профилактических мероприятий, (Торговля людьми, Гостиница, Проститука, Сауна массаж, РС, Бар, Пьянство, Наркотических средство, Контроль за насилие, Кража, Белое мясо, Раскрытия и Побег-2015, Открыто-закрыто, Авто запчасти, Дачи, Реки, Оружия-2015, Общественные транспорт, Административный надзор) и другие. Среди тех, с кем проводилась индивидуально-профилактическая работа, По 2015 году 3866 человека осуждены условно, 2047 человека освобожденных из местах лишения свободы состоящих под административным надзором²⁰⁸.

В настоящее время в Монголии сложилась парадоксальная ситуация, поскольку контроль за поведением условно осужденных осуществляют участковые инспектора местных органов полиции. Безусловно, из-за загруженности многофункциональной работой по осуществлению общественного правопорядка сотрудники местной полиции не могут в должной мере проводить профилактическую работу среди условно осужденных с целью предупреждения преступности (посещать семьи, в которых проживают условно осужденные; встречаться с трудовыми коллегами в работе; вести профилактическую работу с

²⁰⁷ Большая юридическая энциклопедия. М., 2010. Т. 2. С. 446.

²⁰⁸ Отчет по организация профилактике преступлений Главная Управления Полиции Монголии. 2015 г.

неформальной группой, в которую входят условно осужденные). Следует обратить внимание еще на проблемы, возникающие в Монголии в связи с возложением обязанностей по контролю за условно осужденными на органы полиции. Так, мировой практикой исполнения наказаний без изоляции от общества установлена оптимальная, нагрузка на одного сотрудника 50 осужденных. В Монголии 2014 году 8178 осужденных 3396 (41,5%) условно, 2441 (29,8%) лишения свободы, 2341 (28,7%) другие виды наказания, общие осужденных 71,3%²⁰⁹, и за году освобождение от местах лишения свободы 1800 человека органов полиции за осуществлений контроль. В среднем на одного сотрудника полиции число осужденных составляет 75 в Монголии. В ряде мест нагрузка значительно выше. Хронометраж рабочего дня сотрудника полиции с учетом выполнения основных служебных обязанностей свидетельствует о том, что для живого общения с конкретным поднадзорным остается минимум времени. В такой ситуации о каком-либо системном профилактическом влиянии говорить не приходится.

Нормативно-правовый акты в соответствии с законодательством Монголии Закон О Профилактике Преступлений Монголии от 05 декабря 1997 г. Органы полиции в процессе исполнения условного осуждения возлагаются следующие обязанности:

- ведение учета условно осужденных;
- контроль за поведением условно осужденных по месту работы, учебы и жительства, а также исполнением ими обязанностей и соблюдением запретов, возложенных судом;
- проведение первоначальных мероприятий по розыску условно осужденных, местонахождение которых неизвестно;
- внесение в суды в установленном порядке представлений по вопросам отмены условного осуждения;
- выявление причин и условий, способствующих совершению условно осужденными повторных преступлений, нарушений общественного порядка, и принятие мер по их устранению.

При этом органы полиции наделяются следующими правами:

- вызывать осужденных для разъяснения порядка и условий отбывания условного осуждения, проведения профилактических бесед, выяснения вопросов, возникающих в процессе отбывания условного осуждения, и причин допущенных нарушений порядка и условий отбывания условного осуждения;
- посещать осужденных по месту их нахождения, включая место жительства и работы, с целью контроля за поведением, соблюдением ими установленных обязанностей и запретов;
- выносить в установленном порядке постановления о приводе условно осужденных, состоящих на учете в инспекции и не являющихся по вызову в инспекцию без уважительных причин;
- запрашивать от администрации организаций, в которых работают условно осужденные, документы о проведенной работе с осужденными, их поведении, отношении к труду, принятых к ним мерах поощрения и взыскания;
- обращаться в органы местного самоуправления и прокуратуры, суды и организации для решения вопросов, связанных с исполнением условного осуждения.

Инструкцией по организации Профилактика Преступлений утвержденной приказом Главное Управление Полиции Монголии от 29 сентября 2010 г, № 502 (ДСП код 226), и иными нормативными правовыми актами.

Предупредительная деятельность органов исполнение судебных решение и органов полиции в отношении условно осужденных преследует цель недопущения преступлений с их стороны, а также их исправления. В определенной степени эффективность реализации условного осуждения зависит от того, насколько четко и согласованно осуществляется в отношении указанной категории осужденных воспитательно-профилактическое воздействие со стороны контролирующих органов.

- персональный учет условно осужденных в течение испытательного срока;
- контроль инспектор участие других служб райорганов полиции за соблюдением осужденными общественного порядка и исполнением ими возложенных судом обязанностей;

²⁰⁹ По статистическим данным Центра статистики и информации Верховного Суда Монголии в 2014 г.

- проведение первоначальных розыскных мероприятий;
- проведение иных мероприятий, предусмотренных действующим законодательством.

Криминальная полиция обеспечивает проведение оперативно-розыскных мероприятий по контролю за лицами, состоящими под административным надзором полиции, а также условно осужденными к наказаниям, не связанным с лишением свободы, с целью предупреждения с их стороны повторных преступлений²¹⁰.

Полиция охраняет общественный порядок практически вся она так или иначе связана с предупреждением преступности. В поле их зрения подростки, освобожденные из мест лишения свободы, условно осужденные, вернувшиеся из специальных учебно-воспитательных учреждений, употребляющие наркотики, пьянствующие, совершающие правонарушения непроступного характера, и другие категории несовершеннолетних, от которых, судя по их противоправному поведению, можно ожидать совершения повторно преступлений.

Обеспечение общественного порядка среди условно осужденных и их близких играет важную роль в борьбе с рассматриваемым преступлением.

Почти все исследователи справедливо отмечают в этой связи важность предупреждения пьянства и наркомании, поскольку состояния алкогольного и наркотического опьянения можно считать внутренними условиями, способствующими совершению преступлений.

Профилактика алкоголизма и наркомании условно осужденных, зависит от деятельности участковых инспекторов полиции, на которых ложится обязанность контроля за поведением условно осужденного. Это также обусловлено тем, что они постоянно находятся среди людей, проживающих или работающих на их участках, поддерживают контакты с должностными лицами и представителями общественных организаций и т.

Участковые инспекторы полиции как должностные лица органов полиции ближе всего стоящие к населению, осуществляют на закрепленных участках практически все функции профилактики органов полиции.

Участковые проводят ежемесячно анализ оперативной обстановки на обслуживаемых участках, вносят руководству райотдела полиции предложения по повышению эффективности профилактической работы на закреплении территории. Осуществляют контроль за условно осужденными, освобожденными из мест лишения свободы, употребляющими наркотические средства, психотропных средств, и алкоголь, обеспечивают своевременное принятие к ним мер, установленных законодательством, постановку таких лиц на профилактический учет в целях последующего контроля за поведением.

Участковые инспекторы обязаны владеть оперативной обстановкой на своей территории. Они должны выявлять проституток, наркоманов, алкоголиков, с которыми держит контакт условно осужденный. Также участковые инспекторы полиции обязаны знать неблагополучные семьи, места сбора лиц с криминогенной направленностью, выявлять условия, способствующие их совершению правонарушений, разрабатывать и принимать меры к их устранению.

Важным моментом борьбы с преступностью условно осужденных также является предупреждение безнравственного образа жизни определенных категорий людей из близкого окружения условно осужденного, чаще всего тех, которые организуют разного рода группы, вечеринки с целью пьянства, употребления наркотиков. Полицейские органы совместно с общественностью должны выявлять лиц, ведущих и вовлекающих других в антиобщественный образ жизни. Применение к таким лицам воспитательных, а при наличии на то оснований мер уголовно-правового и административно-правового характера, способствовало бы ликвидации одного из важных условий, содействующих совершению преступления со стороны условно осужденных.

Непременным условием эффективности профилактической деятельности является комплексное планирование, обеспечивающее организацию и координацию совместных усилий по выявлению и устранению обстоятельств, порождающих преступность, предпринимаемых

²¹⁰ Алексеев А.И., Герасимов С.И., Сухарев А.Я. Криминологическая профилактика: теория, опыт, проблемы. М.: Норма-М., 2001. С. 275.

местными органами полиции, другими правоохранительными органами, органами местного самоуправления, службами занятости населения, администрациями организаций в которых работают условно осужденные, общественности и средств массовой информации.

Патрульная служба органов полиции обеспечивающая общественный порядок на улицах и в других общественных местах. На профилактика преступлений, сотрудник патрульной службы связанных пресекают случай распития спиртных напитков в общественных местах, появления в них в пьяном виде, оскорбляющем человеческое достоинство и общественную нравственность, мелкое хулиганство, другие административные правонарушения, которые могут перерасти в преступления. Осуществляют контроль за поведением условно осужденных, освобожденные из мест лишения свободы, они выявляют места возможного совершения новых преступлений,

Основным методом работы по профилактике правонарушений является убеждение, которое следует осуществлять в строго индивидуальном порядке, с учетом характерных признаков того или иного типа профилируемых осужденных, условий их жизнедеятельности.

Для повышения эффективности работы по предупреждению рецидивной преступности условно осужденных и своевременного реагирования на негативные изменения оперативной обстановки органами полиции рекомендуется:

1.Разработать и внедрить в практику систему анализа и информационного обеспечения деятельности, исходя из местных условий.

2.Обеспечить организацию взаимодействия с другими органами полиции на базе совместного планирования профилактической деятельности, проведения коллегий, оперативных совещаний, совещаний семинаров, проверок, рейдов и спецопераций, изучения приказов, указаний, рекомендаций, взаимного обмена информацией о поведении, образе жизни осужденных и примененных к ним мерах воздействия.

3.Выявить осужденных, склонных к совершению новых преступлений, организовать постоянный контроль за их поведением и образом жизни. В целях оперативного прикрытия этих лиц направлять соответствующую информацию в криминальную полицию и полицию общественной безопасности.

4.Оказывать условно осужденным всестороннюю помощь и поддержку в решении трудовых, семейно-бытовых и других проблем.

5.Своевременно рассматривать вопросы о представлении осужденных, доказавших свое исправление, к условно-досрочному освобождению, сокращению испытательного срока, обязанностей и запретов, отмене условного осуждения.

6.Грамотно и качественно осуществлять подготовку материалов в суды в отношении осужденных, злостно уклоняющихся от отбывания наказания и не выполняющих требования решений судов и законодательства.

7.Оперативно проводить первоначальные розыскные мероприятия в отношении осужденных, скрывшихся с места жительства, и своевременно направлять в суды материалы для принятия к ним соответствующих мер.

8.Ежеквартально анализировать практику применения судами наказаний без изоляции от общества, обращения к исполнению приговоров, рассмотрения представлений о замене исправительных работ лишением свободы, возложении, дополнении, сокращении обязанностей, испытательного срока, отмене условного осуждения и отсрочки отбывания наказания. О результатах информировать председателей судов и прокуроров.

9.Регулярно информировать органы исполнительной власти, местного самоуправления, прокуратуры, внутренних дел, суды, администрацию организаций о состоянии правопорядка среди осужденных и вносить предложения по устранению причин, способствующих порождению рецидивной преступности.

10.Шире привлекать к воспитательной работе администрацию организаций, в которых работают осужденные, трудовые коллективы, шефские формирования, профсоюзные и другие общественные организации, родственников и членов семей осужденных, а также других лиц, оказывающих на них положительное влияние;

11.Выступать в трудовых коллективах и средствах массовой информации (печать, радио, телевидение) по вопросам исполнения наказаний без изоляции от общества и состояния борьбы с рецидивной преступностью.

Проведенный автором анализ практики применения условного осуждения на современном этапе в Монголии позволил сделать вывод, что повышение эффективности предупредительных мер может быть достигнуто только на основе комплексного программно-целевого подхода к реализации социально-экономических, организационно-правовых, культурно-досуговых и психолого-педагогических мер.

Для повышения эффективности профилактических мер в отношении условно осужденных необходимы:

1. Передается Судебное исполнительных органов осуществляют контроль за поведением условно осужденного и освобождения от мест лишения свободы.

2. Если остаются органов полиции необходимо создать в территориальных органах полиции подразделения, специализированные на осуществлении контроля за поведением условно осужденных и освобождения от мест лишения свободы.

3. Специализация сотрудник органов Полиции по индивидуальное профилактическую работу и осуществляют контроль за поведением условно осужденного и освобождения от мест лишения свободы.

4. Патрульное служба органов полиции обеспечивающая общественный порядок на улицах применением современно технических средств осуществления контроля за поведением условно осужденных

5. Одним из важнейших направлений борьбы с рецидивной преступностью условно осужденных является обеспечение социальной обеспеченности в сфере труда, семейной, бытовой и досуговой сфере. Поэтому необходимо совершенствовать мероприятия социального характера и их правовое обеспечение: принятие подзаконных актов, определяющих организационные, финансовые и технические предпосылки для реализации мероприятий по предупреждению рецидивной преступности.

Литература

1. Алексеев А.И., Герасимов С.И., Сухарев А.Я. Криминологическая профилактика: теория, опыт, проблемы. М.: Норма-М., 2001. С. 25.
2. Батжав Л. Преступность, причины и условия > преступности, проблемы предупреждения преступности. Улан-Батор, 2002. С. 232 (на монгольском языке).
3. Батхуу С. Полиция Монголии. Улан-Батор. 1998. С. 28 (на монгольском языке).
4. Доклад пятого Конгресса ООН по предотвращению преступности и обращению с правонарушителями //Сборник стандартов и норм ООН в области предупреждения преступности и уголовного правосудия . Нью-Йорк, 1976. С.37.
5. Жанцан С. Борьба с рецидивной преступностью в Монголии (уголовно-правовые, криминологические и пенитенциарные проблемы): Дис. ... д-ра юрид. наук. М., 1992. С. 347.
6. Жанцан Н. Криминология. Учебное пособие. Улан-Батор: Монгольский гос. ун-т, 2004. С. 105 (на монгольском языке).
7. Фильченков Г.И. Обеспечение контроля за поведением несовершеннолетних, осужденных условно и к лишению свободы с отсрочкой исполнения приговора. М., 1995. С.58.
8. Большая юридическая энциклопедия. М., 2010. Т. 2. С. 446.
9. Отчет по организация профилактике преступлений Главная Управления Полиции Монголии. 2015 г.
10. По статистическим данным Центра статистики и информации Верховного Суда Монголии в 2014 г.

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧ РЕЗИНЭН БОЛОН ХУВАНЦАР СУМТАЙ БУУ ХЭРЭГЛЭХ АРГАЧЛАЛ, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Ш.Чулуун

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Дотоодын цэргийн
тэнхимийн дэд профессор, цагдаагийн дэд хурандаа

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээ биелүүлэхдээ хуульд заасан үндэслэл, журмын дагуу резинэн болон хуванцар сумтай буу хэрэглэх эрхтэй.

Нэг хүнд нөлөөлөх хэрэгслийг нэг бүрийн тусгай хэрэгсэл гэнэ. Нэг бүрийн тусгай хэрэгсэлд дараах хэрэгсэл хамаарна.²¹¹ Үүнд:

- Гав;
- Хүлэг, ороох цамц, хөдөлгөөн хязгаарлах бусад хэрэгсэл;
- Бороохой;
- Цахилгаан гүйдлээр цохигч;
- Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр;
- **Резинэн ба хуванцар сумтай буу;**
- Нэг бүрийн бусад тусгай хэрэгсэл;

Цагдаагийн алба хаагч дараах тохиолдолд нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэнэ.²¹² Үүнд:

- Өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд учирч болзошгүй халдлагыг таслан зогсоох;
- Гэмт хэрэг, зөрчлийн үйлдлийг таслан зогсоох, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг баривчлах;
- Зэвсэглэсэн болон зэвсэг хэрэглэн эсэргүүцэж болзошгүй хүнийг баривчлах;
- Баривчлагдсан хүнийг эрүүл мэндийн болон холбогдох байгууллагад албадан хүргэх, яллагдагч, ялтныг хуяглан хүргэх;
- Хяналтад байгаа хүн амиа хорлох, өөрийн бие махбодид гэмтэл учруулах, оргон зайлахаас урьдчилан сэргийлэх;
- Сэтгэцийн эмгэг, сэтгэл санаа хүчтэй цочрон давчидсаны улмаас өөрийгөө удирдах чадваргүй, түүнчлэн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүн догшин, хэрцгий авирлаж бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх;
- Албаны болон бусдын орон байрыг эзлэн авсан, гудамж, замын хөдөлгөөнийг бүслэн хаасныг чөлөөлөх;
- Олон нийтийн арга хэмжээний үед нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тавьсан цагдаагийн алба хаагчийн шаардлагыг биелүүлээгүй;
- Нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчих, эсхүл нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, хууль бус жагсаал, цуглааныг албадан тараах;
- Тээврийн хэрэгслийг зогсоох эрх бүхий албан тушаалтны шаардлагыг үл биелүүлэн зугтаасан;
- Энэ хуульд галт зэвсэг хэрэглэхээр заасан үндэслэл бүхий бүх тохиолдолд²¹³

Мөн “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-т резинэн болон хуванцар сумтай буу хэрэглэхэд дараах зүйлийг анхаарахаар тодотгож өгсөн байна.²¹⁴ Үүнд:

- Цагдаагийн алба хаагч резинэн, хуванцар сумтай бууг хэрэглэх зорилгоо

²¹¹Цагдаагийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх заалт

²¹²Цагдаагийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх заалт

²¹³Цагдаагийн албаны тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх заалт

²¹⁴ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий Прокурорын хамтран баталсан 2017.09.06-ны өдрийн А-126/А-102 дугаар тушаалын Нэгдүгээр хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-ын 3.16 дахь хэсэг

- тодорхойлж тухайн бууг хэрэглэхдээ үйлдвэрлэгчийн зааврыг баримтлах;
- Алба хаагч бууг гал хамгаалагчийг нь түгжиж биедээ авч явна. Алба хаагч үүрэг гүйцэтгэхийн өмнө резинэн, хуванцар сумтай бууны хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг шалгаж, тавьж олгосон сумаар цэнэглэгдсэн эсэхийг шалгах;
- Цагдаагийн албаны болон мэргэжлийн сургалтад хамрагдсан алба хаагчид резинэн, хуванцар сумтай буу хэрэглэх.

Цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэрээр гадаадын цэрэг, цагдаагийн байгууллагын албанд ашигладаг зарим нэр төрлийн загварын резинэн болон хуванцар сумтай бууг үзэж судлан улмаар албажуулан бүртгэлд тусган алба, ажиллагаанд хуульд заасан үндэслэл, журмыг баримтлан хууль тогтоомжийн хүрээнд хэрэглэж байна.

Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн тусгай хэрэгслийн бүртгэл судалгаанд БНХАУ-д үйлдвэрлэсэн 18.4 мм-ийн YJ-12-1 'Police' загварын буу ихэвчлэн нэгдсэн хангалтаар олгогдсон байх бөгөөд тус бууг албаны үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Иймд тус бууны зориулалт, бүтэц зохион байгуулалт, ажиллах зарчим, эд ангиудын гүйцэтгэх үүрэг, сумны төрөл онцлог, хагас задаргаа, эвлүүлгээ хийх аргачлал, анхаарах зүйлийн талаар дэлгэрүүлэн авч үзье.



Бууны зориулалт: 18.4 мм-ийн YJ-12-1 "Police" загварын буу олон улсад аминд халгүй зэвсэг /non lethal weapon/ гэж нэрлэдэг, цагдаагийн болон харуул хамгаалалтын албанд ашигладаг. Англи нэр нь 'Riot shotgun' буюу бянтгүй гол төмөртэй, хагас автомат төрлийн буу юм.


18.4 мм-ийн YJ-12-1 "Police" загварын буу нь ойрын зайд /35-100 метр хүртэл/ довтолсон, зугтсан этгээдийн хүчийг сааруулах, номхотгох, унагах, айлгах зорилгоор олон үрэлт болон нэг үрэлтэй резинэн, нулимс асгаруулагч, хатуу тугалган үрлэн, будган гэсэн 5 төрлийн модель 97 загварын 18.4 мм-ийн сумаар буудах зориулалттай хийгджээ.

Буу сумны техникийн өгөгдөхүүн: 18.4 мм-ийн YJ-12-1 "Police" загварын буу нь хатуу хайлшаар хийгдсэн, өндөр температуртай галд тэсвэргүй, нэгийн галаар буудлага үйлдэгддэг, хагас автомат ажиллагаатай, буудлагын үед тийрэлт өгдөггүй онцлогтой, гол төмөр нь зөвхөн 18.4 мм-ийн зориулалтын сумаар буудахад зориулагдаж хийгдсэн, ашигтай тусгал нь төрөл бүрийн зориулалтын сумнаас хамаарч 100 метр хүртэл, ашигтай тусгалын зайд хүний толгой хэсэг рүү буудахад амь насанд аюултай, бууг өрөө тасалгаа, ил талбай хаана ч ашиглаж болдог онцлогтой юм. Бууны сумны хүхээ нь 5 ш сумны багтаамжтай.²¹⁵

Бууны эд анги нь:


- Эвхэгддэг мөрлөгч
- Овоо, гох, замгийн эд анги бүхий их бие
- Хийн даралтын суваг, хараа бүхий гол төмөр
- Оосор гэсэн үндсэн хэсгээс бүрдэнэ.

²¹⁵18.4 мм-ийн YJ-12-1 загварын бууны зааар УБ хот, 2008 он 19 дэх тал



Бууг ашиглах явцад гол төмрийг нь байнга цэвэр байлгах шаардлагатай, гол төмөр, хүхээ, цэнэглэх механизм зэрэгт ус чийг, шороо зэрэг бохир зүйл оруулахыг хориглоно.


18.4 мм-ийн YJ-12-1 "Police" загварын буу нь үндсэн 5 төрлийн сумаар буудлага үйлдэх бөгөөд сум тус бүрийн гүйцэтгэх үүрэг, онцлогийн талаар алба хаагч нь тодорхой онолын мэдлэгтэй зайлшгүй хэрэглэх тохиолдол бий болсон үед тухайн нөхцөл байдалд тохируулан сумаа сонгох чадвартай байх шаардлагатай.²¹⁶



18.4 мм-ийн нэг бүрийн резинэн үрэлтэй сум

Нэг резинэн 1.2 см диаметртэй үрэлтэй сум нь хар хонгиотой, сумны хонгионы урд үзүүр буюу сум задрах хэсэгт резинэн үрэл нь ил харагддаг, хонгион дээрээ 18.4 мм гэсэн тоо ба ханз бичигтэй байдаг.

Энэ сумны урт 62мм, хүндийн жин 18.7 грамм, 35-100 метр хүртэлх зайд буудна. Энэ нь сумаар 35 метрээс дотогш буудсан тохиолдолд хүний биеийн 1см² талбайд 120 джоулийн хүчтэй үйлчлэл үзүүлнэ. Томъёолол: $Ez \times Ey < 0.3 \times 0.4 \text{ m}$



18.4 мм-ийн олон резинэн үрэлтэй сум:

Олон резинэн үрэлтэй 10.8 см-ийн диаметртэй. 1ш үрэл нь 0.85 грамм жинтэй, 8-9ш сум нь хар хонгиотой, сумны хонгионы урд үзүүр буюу сум задрах хэсгийг "Цагаан" өнгийн "=" тэмдэгтэй хуванцараар бөглөсөн, хонгион дээрээ 18.4 мм гэсэн тоо ба ханз бичигтэй байдаг.

Энэ сумны урт 62мм, хүндийн жин 24 грамм, 35-100 метр хүртэлх зайд буудна. Энэ сумаар 35 метрээс дотогш буудсан тохиолдолд хүний биеийн 1см² талбайд 35 джоулийн хүчтэй үйлчлэл үзүүлнэ.

²¹⁶Чулуун.Ш., "Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл", УБ хот., 2019 он., 118 дахь тал



18.4 мм-ийн нулимс асгаруулагчсум:

Нулимс асгаруулагч сум нь цэнхэр хонгиотой, сумны хонгионы урд үзүүр буюу сум задрах хэсгийг “Цагаан” өнгийн төмөрлөгөөр бөглөсөн /энэ нь баллонтой нулимс асгаруулагч болно/ хонгион дээрээ 18.4 мм гэсэн тоо ба ханз бичигтэй байдаг.

Энэ сумны урт 65 мм, хүндийн жин 21.7грамм, 20м² талбайд идэвхтэй нөлөөлнө. Үйлчлэх хугацаа 2 секунд, барилгын хана таазны битүүмжлэлийг нэвтлэх чадвартай. 50м² талбайд тархах бололцоотой.



18.4 мм-ийн тугалган үрэлтэй сум:

Хатуу тугалган үрлэн сум нь “улаан” өнгийн хонгиотой 122ш 0.6мм-ийн диаметртэй, 1ш тугалган үрэл нь 1.2 грамм \Сумны хонгионы урд үзүүр буюу сум задрах хэсгийг “цагаан” өнгийн хуванцараар бөглөж “-” тэмдэг тавьсан, хонгио дээрээ 18.4 мм гэсэн тоо ба ханз бичигтэй байдаг.

Энэ сумны урт 65мм, хүндийн жин 43 грамм, 50 метрээс дотор зайд устгах чадвартай, хүний амь насанд аюултай, энэ сумаар хүний толгойноос доош хэсэгт 50-100 метр хүртэлх зайд буудаж болно.

Аюулгүй арга хэмжээ:

Энэ бууны зохион бүтэц нь санамсар, болгоомжгүй байдлаар буудлага үйлдэгдэхээс хамгаалагдсан, аюулгүйн арга хэмжээг сайтар хангасан буу юм. Бууны гал хамгаалагчийн түгжээ нь /safely/ гохны гэр дотор, гох татах чиглэлийн хэсэгт хөндлөн хөдөлдөг, дугуй хэлбэртэй, хоёр талдаа 'on', 'off' гэсэн бичигтэй байрладаг. Бууны гал хамгаалагч нь нээлттэй үед гал хамгаалагчийн түгжээний “улаан бүслүүр” ил харагдана.²¹⁷





Бууг сумлахаас өмнө дараах ажиллагааг заавал хийсэн байна.

- Бууны амыг аюулгүй чиглэлд 45 градусаас дээш өнцөгт барина.
- Гал хамгаалагчийн түгжээ түгжигдсэн эсэхийг шалгана. Энэ үед гал хамгаалагчийн түгжээний улаан бүслүүр ил харагдахгүй байх ёстойг анхаарах шаардлагатай.
- Зүүн гараар бууны цэнэглэгч хэсгээс барьж замгийг хойш татна.
- Замгийг урагш түлэхгүйгээр баруун гарын долоовор хурууны үзүүрээр гох чөлөөлөгчийг дарж, гох чөлөөлөгчийг дарсан хэвээр замгийг 2-3 удаа хойш, урагш

²¹⁷18.4 мм-ийн YJ-12-1 загварын бууны заавар УБ хот, 2008 он 24 дэх тал

татаж үзнэ. Гох чөлөөлөгч нь гохны гэрний урд хэсэгт бэхлэгч жижиг хадаасны ойролцоо үзүүр хэсэг нь цухуйсан байдалтай байрласан нимгэн төмөр болно.



Тус бууны сумлах ажиллагаа нь доор дурдсан байдлаар хийгдэнэ.²¹⁸

- Бууны замгийг урагш тултал нь түлхэж, гал хамгаалагчийн түгжээг түгжинэ. Энэ үед замгийг урагш гүйцэд түлхээгүй бол сум замгийн рам руу багтаж орохгүй бөгөөд хүчээр сумыг түлхэж болохгүй.

²¹⁸Чулуун.Ш., "Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл", УБ хот., 2019 он., 120 дахь тал



- Бууны амыг дээш харуулж сумлах хэсгийг нүдэнд ил харагдах байдлаар бууг барьж сумны үзүүр хэсгээр дайзны дотор харагдах шар түлхэгчийг цааш түлхэж дайзанд угсарна. Дайз 5 ширхэг сум орох багтаамжтай.
- Дайзанд сум угсарсны дараа замгийг зориулалтын бариулаас барьж нэг л удаа хойш нь татаж урагш болгоход сум бууны гол төмрийн хойд хэсэгт байрлах сумны байранд шууд орж буудлага үйлдэхэд бэлэн болно.
- Энэ үед гох дарвал шууд буудах аюултайг онцгой анхаарч гол төмрийн хойд хэсэгт байрлах сумны байранд сум орсон бол эхний ээлжинд гал хамгаалагчийг заавал түгжинэ.

Буудлага үйлдэх ажиллагаа нь дараах дэс дараалалтай явагдана. Үүнд:

- Буудлага үйлдэхээс өмнө гал хамгаалагчийн түгжээг нээнэ. Гал хамгаалагчийн түгжээ нээгдсэн бол түгжээний улаан бүслүүр ил гарна.
- Буудах чиглэл рүү бууны амыг чиглүүлж овоо, харааг нэг түвшинд байхаар шагайж гохыг дарна. Буунд ямарч тийрэлт байхгүй тул нарийвчлан мөрлөх шаардлагагүй.



- Дахин буудах шаардлагатай бол замгийг хойш татаж, урагш болгоход буудагдсан хонгио унаж, дараагийн сум бууны сумны байранд орно.
- Буудлага үйлдэж дууссаны дараа бууг шалгахдаа бууны гох чөлөөлөгчийг баруун гарын долоовор хуруугаар дарж, зүүн гараар замгийг 2-3 удаа хойш, урагш татна. Энэ үед бууны хоолойд болон дайзанд сум үлдсэн эсэхийг хонгио хаягчийн хэсгээр ажиглаж харж байх шаардлагатай.

Бууг сумтай эсэхийг шалгах, буунаас сумыг буцааж авах, бууны хоолойд орсон сумыг гаргаж авахын тулд дараах ажиллагааг хийнэ.²¹⁹ Үүнд:

- Гал хамгаалагчийг түгжинэ
- Гох чөлөөлөгчийг баруун гарын долоовор хуруугаар дарж, зүүн гараар замгийг олон удаа татаж урагш болгоно. Энэ үед бууны хоолойд болон дайзанд сум үлдсэн эсэхийг хонгио хаягчийн хэсгээр ажиглаж, харж байх шаардлагатай.

Буунаас гарсан сумыг хаана унахыг харж хянаж бууны гал хамгаалагч хаалттай эсэхийг дахин шалгана. Сумыг авч бялт нь цохигдсон эсэхийг шалгаж хүлээлгэж өгөх эсвэл зориулалтын гэр /дайз/-т хийж хадгална.

Алба хаагч нь бууг дараах байдлаар авч явбал зохино.

- Босоо үедээ бууны амыг 45 градусаас дээш нь эсвэл доош нь чиглүүлж бууны оосорыг хүзүү, зүүн гарын мөр, тохойд угалж баруун гараар гох дарах хэсгийн бариулаас барьж зогсоно.




- Суугаа үедээ бууны оосорыг хүзүүндээ угалж бууны амыг зөвхөн дээш нь харуулна.
- Бууг ашиглах үедээ оосорыг хүзүүнээс салгахыг хориглоно.

Алба хаагч буугаар буудлага үйдсэн, буу гацсан, буу удаан хугацаанд хадгалалтанд байсан үед арчиж цэвэрлэх зорилгоор эсхүл хичээл, сургалт, бэлтгэлд хамрагдаж байгаа үед бууны хагас задаргаа, эвлүүлгээ хийнэ. Харин бууны бүтэн задаргааг зөвхөн зориулалтын газар зэвсгийн мастер хийхийг зөвшөөрсөн байдаг.

Буунд хагас задаргаа нь дараах дэс дараалалаар хийгдэнэ.


- Бууны замгийг хойш нь тултал татаж байрлуулна.
- Бууны амыг дээш харуулж замгийн урд хэсэгт байрладаг оосор зүүх зориулалттай эргэдэг тагийг эргэж авна. "Оосорыг тайлахгүйгээр"
- Бууны гол төмрийг эгц чигээр нь зөөлөн дээш нь татаж сугална. Үүнээс өөр ямар нэг эд ангийг нь задлахыг хориглоно.

²¹⁹18.4 мм-ийн YJ-12-1 загварын бууны заавар УБ хот, 2008 он 29 дэх тал



Бууны эвлүүлгээ хийх ажиллагаа хагас задаргааны эсрэг дэс дараалалаар хийгдэнэ.

- Замгийг хойш нь тултал татаж байрлуулсан байранд нь байлгана.
- Гол төмрийг эгц дээрээс нь замгийн дээд хэсэгт углаж, сумны байранд гол төмөр суурилагаар зөөлөн суурилуулна. Энэ үед ямар нэг хүч хэрэглэж болохгүйг анхаарах.
- Гол төмрийг байранд нь суурилуулсны дараа оосор бүхий эргэдэг тагийг эргэдэж байрлуулна.



Бууг хадгалах

Бууг буу хадгалах зориулалттай, төмөрлөсөн шүүгээнд зөвхөн босоо байдлаар хадгална. Ашиглах, хадгалах, данс бүртгэл хөтлөх ажиллагааг Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2017 оны “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”²²⁰ аар зохион байгуулна.

Бууны гол төмөр, ил харагдах хэсгийг хуурай алчуураар сайтар цэвэрлэж, ямар нэг шороо тоос орохоос хамгаалж байх шаардлагатай.

Бууны гохыг хоосон дарж болохгүй, хоосон гох дарах нь бууны цохигч төмөр буюу шөвөг төмрийг амархан хугалдаг тул Та бууг шалгахдаа гох чөлөөлөгчийг дараад замгийг хойш урагш татаж шалгаад гох даралгүйгээр гал хамгаалагчийг хааж байх хэрэгтэй.

Өөрөөр хэлбэл тус буу материалын хувьд төдийлөн сайн биш хайлшин материаллаар хийгдсэн учир гохыг хоосон дарахад шөвөг төмөр хий ажиллаж үзүүр нь мохох цаашлаад хугарах аюултай юм. Ийм учраас тус бууг үйлдвэрлэхдээ бууны аюулгүй байдлыг шалгах процессын ажиллагааг гох дарж шалгахгүй байдлаар зохицуулалт хийж өгчээ.

Алба хаагч үүрэг гүйцэтгэхийн өмнө резинэн, хуванцар сумтай бууны хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг шалгаж, тавьж олгосон сумаар цэнэглэгдсэн эсэхийг сайтар шалгасан байвал зохино.

Мөн тус буугаар буудлага үйлдэх алба хаагч нь орчноо сайтар үнэлсэн байх шаардлагатай гардаг. Жишээ нь: Өрөө тасалгаанд буудлага үйлдэхэд сум хананд ойж бусдад хүнд гэмтэл учруулах гэх мэт.

Түүнчлэн олон хүн цугласан үйлчилгээний газар, наадмын талбай, ойр орчиндоо хатуу ханатай газар резинэн болон хуванцар сумтай бууг гэмт этгээд, зөрчил гаргасан хүнд хэрэглэхдээ сум байнаасаа ойж гэмгүй ард иргэдийг хохироож болзошгүйг юуны түрүүнд анхаарвал зохино.

Хэт ойр зайнаас буюу 10 метрээс дотогш зайд хэрэглэвэл хүний биеийн ясыг хугалах, бэртээх, хүнд гэмтэл учруулах цаашлаад амь насанд аюул учруулах магадлал өндөр байна. Иймд тус буугаар буудлага үйлдэхдээ холбогдох хууль тогтоомж, заавар, журмыг баримтлан ажиллах зайлшгүй шаардлагатай билээ.

Дүгнэлт

Цагдаагийн алба хаагч нь хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримтлан түүнд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулах нь учирч болох аливаа сөрөг үйлдэл, үр дагавраас урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ болох юм.

Мөн өөрт тавьж олгогдсон албаны тусгай хэрэгслийг хэрэглэхдээ хууль эрх зүйн үндэс, ашиглах арга зүй, тухайн тусгай хэрэгслийн онцлог, анхаарах зүйл болон холбогдох аюулгүй ажиллагааны заавар, журмыг сайтар судлан нарийн чанд сахиж албанд мөрдлөг болгон ажиллах шаардлагатай. Ингэснээр нэг талаас өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангах, нөгөө талаас хүний эрхийг дээдлэх үндсэн нөхцлийг бий болгоно.

Ашигласан материал

Нэг.Хууль тогтоомж:

- Цагдаагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017.02.09
- Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий Прокурорын хамтарсан 2017 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн А-224/А-102 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код-236/ “Тусгай хэрэгслийг хадгалах, хамгаалах, бүртгэх, тавьж олгох журам” 2017.02.28

Хоёр.Сурах бичиг, гарын авлага

- Ш.Чулуун. Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл. УБ., 2019
- 18.4 мм-ийн YJ-12-1 загварын бууны заавар. УБ., 2008

²²⁰2017 оны 2 дугаар сарын 28-ны өдөр баталсан ЦБҮАЖ-ын код-236 “Тусгай хэрэгслийг хадгалах, хамгаалах, бүртгэх, тавьж олгох журам”

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

БИЧИХ ХЭРЭГСЛИЙН МӨРИЙГ ДҮРС ӨСГӨХ АРГААР СУДАЛСАН НЬ

М.Түмэннаст

ШШҮХ-ийн Криминалистикийн шинжилгээний газрын

Бичиг баримтын шинжилгээний лабораторийн шинжээч, цагдаагийн ахмад

Товч агуулга: Энэхүү судалгаагаар аливаа бичиг баримт дээр буюу цаасан дээр үзэг, тосон бал, үзгэн бал, эсгий үзүүртэй бал, гелэн бал, харандаа зэрэг бичих хэрэгслээр зурсан туршилтын мөрүүдийг лабораторийн нөхцөлд оношилж, улмаар үүссэн онцлог шинж тэмдгүүдэд үндэслэн бичих хэрэгслийн төрлийг тодорхойлох боломжтой болохыг тогтоосон.

Гарын үсэг зурсан бичих хэрэгслийн төрлийг тодорхойлсноор бичих хэрэгслийн шинж тэмдгийг тодорхойлж, шинжилгээний харьцуулах загварыг зөв оновчтой авах, хэрэг шалгах хүрээг хумих, хэрэгт ач холбогдолтой нөхцөл байдлыг зөв тодорхойлох боломжийг хууль сахиулах ажилтнуудад олгох практик ач холбогдолтой бөгөөд мөн бичих хэрэгслүүдийн онцлог шинж тэмдгүүд үүсэх зүй тогтлыг тодорхойлж, өөр хооронд нь ялгах нэршлүүдийг томъёолсон нь шинжлэн магадлахуйн ухаанд онолын ач холбогдолтой.

Түлхүүр үг: Бичих хэрэгсэл, шинж тэмдэг, бэхний зурлага, бичих хэрэгслийн хошуу.

Удиртгал

Гарын үсэг, гар бичмэлийн бүх төрлийн шинжилгээг зөвхөн шүүхийн шинжилгээний байгууллага дээр хийж, тухайн байгууллагаас гаргасан шинжээчийн дүгнэлтийг үнэлэх, эс үнэлэх тухай асуудал шүүх дээр яригддаг.

Гэвч шүүхийн шинжилгээний байгууллага дээр хийгдсэн гарын үсгийн шинжилгээний тоон үзүүлэлтээс²²¹ харахад гарын үсгийн оношлогооны шинжилгээ тэр дундаа бичих хэрэгслийн төрөл тодорхойлох шинжилгээ огт хийгдээгүй байна.

Криминалистикийн адилтгал чухал ач холбогдолтой хэдий ч нотолгооны зарим асуудал, мөн чанарыг тодорхойлоход оношлогоогоор тогтоодог. Мөн оношлогооны шинжилгээгээр мөр нь зүй тогтлын дагуу, эсвэл гаж тогтлоор үүссэн эсэхийг тогтоох боломжтой.

Оношлогооны шинжилгээгээр үзэгдэл, үйл явдал, баримт, объектын мөн чанарыг тогтоох, эсвэл бүлгийн харъяаллыг тодорхойлох²²² бөгөөд явцуу утгаараа оношлогдож буй объектоос хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл гаргаж, тодорхой нөхцөл байдлыг тогтоодог²²³.

Иймд шинжлэх гарын үсгээс хэрэгт ач холбогдолтой мэдээлэл гарган авахын тулд бичих хэрэгслийн төрөл тодорхойлох оношлогооны шинжилгээ хийлгэх нь хэрэг шалгах хүрээг хумих, хэрэгт ач холбогдолтой нөхцөл байдлыг зөв тодорхойлох боломжийг хууль сахиулах ажилтнуудад олгох ач холбогдолтой юм.

Мөн бичих хэрэгслийн мөрүүдийг шинжлэн судалсанаар онцлог шинж тэмдгүүдийн үүсэх зүй тогтлыг тодорхойлж, өөр хооронд нь ялган нэршлүүдийг томъёолох нь шинжлэн магадлахуйн ухаанд онолын ач холбогдолтой.

Бид энэхүү судалгаагаар аливаа бичиг баримт дээр буюу цаасан дээр зурсан гарын үсгийн бичих хэрэгслийн мөрийг оношилж, улмаар онцлог шинж тэмдгүүдэд үндэслэн бичих хэрэгслийн төрлийг тодорхойлох боломжтой эсэхийг тогтоох зорилгоор үзэг, тосон бал, үзгэн бал, эсгий үзүүртэй бал, гелэн бал, харандаа зэрэг хэрэгслүүдийг сонгон авч, туршилтын мөрүүд үүсгэн лабораторийн судалгаа хийж, үр дүнг нэгтгэлээ. Мөн анатоми, физиологи,

²²¹ 2018 онд гарын үсгийн 480, бичиг судлалын 191; 2019 онд гарын үсгийн 507, бичиг судлалын 180; 2020 онд гарын үсгийн 360, бичиг судлалын 98 шинжилгээ хийгдсэн. /Байгууллагын дэлгэрэнгүй бүртгэлийн архив/

²²² Бат-Эрдэнэ, Б. (2003). Криминалистик, 24.

²²³ Лхагвасүрэн, Б. (2008). Гэмт үйлдлийн мөр, 68.

сэтгэцийн хувьд эрүүл хүний зурсан гарын үсгийн адилтгалын шинж чанарт нөлөөлдөг зарим хүчин зүйлсийн талаар авч үзэх бөгөөд шинжээч нь гарын үсгийн шинжилгээ хийхдээ эдгээр хүчин зүйлсийг харгалзаж адилтгалын болон оношлолын дүгнэлтийнхээ үндэслэлийг магадлах хэрэгтэй.

Үндсэн хэсэг

Америкийн бичиг баримт судлалын шинжээчдийн нийгэмлэгийн 9 дэх ерөнхийлөгч Жек Харрис 1949 онд тус нийгэмлэгээс жил бүр зохион байгуулдаг “Адилтгалын зарчим” сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд хэлэлцүүлсэн “Жинхэнэ гарын үсгийн адилтгалын зарчим” илтгэлдээ: “Гарын үсэг нь жинхэнэ байхын тулд жинхэнэ гарын үсгийн онцлог шинж чанарыг бүгдийг нь агуулсан байх ёстой бөгөөд адилтгалын зөрүүгүй байх ёстой” гэж тайлбарласан ба дараа нь уг судалгаандаа тэрээр “Жинхэнэ гарын үсэгт ч хүртэл юу ч тохиолдож болно²²⁴” гэж сануулжээ.

Учир нь бичих хэрэгсэл, гарын үсэг үйлдэгчийн байрлал, бичих гадаргуу, бичих хэрэгслийн суурь бодис болон хязгаарлагдмал орон зай нь гарын үсэг зурахад нөлөөлж, нэг удаагийн үйл явдлын улмаас хүний гарын үсэгт хэзээ ч дахин давтагдахгүй зөрүүг үүсгэж болзошгүй юм.

Бичих хэрэгсэл

Бичих хэрэгсэл нь гарын үсэг зурахад маш чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд зарим нь гарын үсгийн нарийн, төвөгтэй үйлдэцтэй хэсгүүдийг далдалж, улмаар тухайн шинж тэмдгүүдийн адилтгалын болон оношлолын ач холбогдлыг алдагдуулдаг.

1969 онд Швейцарийн Лозаннагийн Их сургуулийн Хууль зүйн факультетийн Цагдаа, криминологийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн судлаач Жакес Матьер төрөл бүрийн бичих хэрэгслийн мөрийг судалсны үндсэн дээр бичих хэрэгслийн нөлөө гарын үсэг зурахад чухал биш гэж дүгнэсэн ч шинжилж буй гарын үсэгтэй ижил төрлийн бичих хэрэгслээр зурсан харьцуулах загвар ашиглахыг зөвлөжээ.²²⁵ Харин 1984 онд бичиг баримт судлалын шинжилгээний мэргэжлийн болон сэтгүүл зүйн нийтлэлүүдээрээ нэрд гарсан эксперт Ордвэй Хилтон²²⁶ судалгаа хийж, зарим бичих хэрэгслийн үндсэн шинж чанарууд нь бичгийн зарим нарийн шинж тэмдгүүдийг далдалж чаддаг болохыг тогтоосон.²²⁷

Объект №1. Үзэг

Үзэг нь бэхэнд дүрэх болон дотор нь бэх соруулж, бичих, зурахад хэрэглэх үзүүр бүхий бичгийн хэрэгслийг²²⁸ хэлнэ. Өнөө үед үзгээр гарын үсэг зурах сонирхол дэлхий даяар улам нэмэгдэж байгаатай уялдан үзгээр зурсан гарын үсэгт шинжилгээ хийх тохиолдлууд нэмэгдэж байна.

Үзэгний хошууны мөрийн шинж тэмдгүүдийг оношилж чадаагүйн улмаас хуурамч шинж тэмдэг мэтээр буруу тайлбарлан шинжээч ноцтой алдаа гаргаж болзошгүй. Тиймээс үзэгний хошууны шинж чанар, бэх, цаас болон бусад хүчин зүйлс нь гарын үсэгт ямар нөлөө үзүүлдэг болохыг үзгээр үүсгэсэн туршилтын мөрүүдээс тогтоож, улмаар үүссэн шинж тэмдгүүдийн нэршлийг томъёоллоо. Үүнд:



²²⁴ Linton, A. (2019). Forensic examination of signatures, 97.

²²⁵ Mathyer, J. (1969). The influence of writing instruments on handwriting and signatures. The Journal of Criminal Law, Criminology and Police Science, 60(1), 102–112.

²²⁶ Чикаго хотын цагдаагийн газрын гэмт хэрэгтэй тэмцэх лабораторийн анхны бичиг баримтын шинжээч

²²⁷ Hilton, O. (1984a). Effects of writing instruments on handwriting details. Journal of Forensic Sciences, 29, 80–86., Hilton, O. (1984b). Characteristics of erasable ball point pens. Forensic Science International, 26, 269–275.

²²⁸ <https://mongoltoli.mn/dictionary/detail/99675>

Шинж тэмдэг №1: Үзэгний хошуунаас үүсэх зурлагын өргөн

Үзэгнээс үүссэн бэхэн зурлагын нэг гадна хүрээнээс нөгөө хүрээ хүртэлх зайг “зурлагын өргөн” гэнэ.

Үзгийг дэлхийн улс орнуудад өргөнөөр үйлдвэрлэдэг тул тухайн загвар бүрээс цуглуулан туршилт судалгаа хийх нь бидний хувьд боломжгүй тул үзэгнээс үүсэх зурлагын өргөнийг хэмжих талаар бичсэн судлаачийн бүтээлийг иш татан ашигласан болно.

Үзэг нь маш нарийн (XF), нарийн (F), дунд (M), өргөн (B), маш өргөн (BB) гэсэн хэд хэдэн төрлийн хошуутай байдаг бөгөөд өөр өөр үйлдвэрлэгчийн хийсэн дунд хэмжээтэй хошуутай үзгүүд нь ижил өргөнтэй зурлага үүсгэхгүй байж болно. Учир нь Европ хошуунуудын ихэнх нь ижил өргөнтэй хэдий ч яг ижил хэмжээтэй байдаггүй. Харин Азид үйлдвэрлэсэн дунд хэмжээтэй хошуу нь ерөнхийдөө Европын нарийн хошууны өргөнтэй тэнцүү байдаг. Тиймээс бэхний зурлагыг шинжлэхдээ өргөний хэмжээн дээр үндэслэн ашигласан үзэгний үзүүрийн хэмжээг тодорхой тогтоох боломжтой гэж үзэх нь тийм ч оновчтой санаа биш юм./Зураг№2/


Зурлаганы өргөнд үзэгний хошууны чийглэг болон хуурай байдал нөлөөлөхөөс үзэгний хошууны бохирдол, бэхний төрөл, цаасны гадаргуугаас үүссэн хог хаягдал, хошууны ховил, уян хатан чанар, бэхний бортогоны төрөл болон эдгээр хүчин зүйлсийн хослолоос ихээхэн шалтгаалдаг²²⁹.



Зураг№2. Хоёр өөр төрлийн үзгээр үүсгэсэн зурлагын өргөний хэмжээг харуулав.

Шинж тэмдэг №2: Бэхний тархалт

Үзгээр зурсан туршилтын зурлагуудын зарим хэсгүүд дээр илүү их хэмжээний бэх ажиглагдаж байна. Энэ шинж тэмдэг нь үзэгний хошуу цаасны гадаргуутай харьцах үед цаасны гадаргуун чанараас хамааран бэх цаасан дээр хүрэхэд цаасны хялгасан судас шиг бүтэц нь бэхийг зурлаганы төв цэгээс сорж, зурлагын аль нэг хэсэгт бэхний илүү агууламж үүсгэснээр бий болдог бөгөөд үүнийг “бэхний тархалт”-ын шинж тэмдэг хэмээн томъёолж байна. /Зураг №3/ Бэх нь цаасан дээр нэвт шингэж, тухайн хуудасны ар тал, тэр ч байтугай дараагийн хуудсанд хүртэл толбо үлдээж болдог.



Зураг №2. Бэхний тархалтын шинж тэмдгийг харуулав.

Бэхний тархалт үүсэх хэд хэдэн шалтгаан байна. Үүнд:

- Цаасны гадаргуун чанар бөгөөд мэдрэгч нь цаасны шүд байдаг. Цаасны шүд²³⁰ нь цаасны төрлөөс хамаардаг бөгөөд өнгөлсөн (хатуу өнгөлгөө, зөөлөн өнгөлгөө), өнгөлөөгүй, гөлгөр



²²⁹ Linton, A. (2019). Forensic examination of signatures, 98.

²³⁰ Үзэгний хошуунд эсэргүүцэл үзүүлж, чирэгдэлт үүсгэдэг цаасны гадаргуун чанар

бүтэцтэй, барзгар бүтэцтэй зэрэг нь үзэгний гүйцэтгэлд нөлөөлж байна. Цаас илүү шүдтэй байх тусам хүрэхэд барзгар мэдрэмж төрүүлдэг.

Үзэгний бэх нь маш бага шүдтэй гөлгөр цаасанд муу наалдаж, улмаар цаасны гөлгөр, толигор гадаргуу нь өргөн зурлагуудыг үүсгэж, бичих ажиллагааны хяналтыг бууруулж байхад дунд зэргийн шүднүүд нь үзэгний хяналт, хэмнэлийг сайжруулж, нарийн хийцтэй зурлагуудыг бий болгоход хангалттай чирэгдэлт үүсгэж байна. Харин хэт их шүд нь үзгээр бичихэд саад болж байна. Богино ширхэгтэй болон хатуу цаас нь илүү нарийн, жигд зурлага үүсгэж байхад урт ширхэгтэй, зөөлөн болон дахин боловсруулсан цаас нь бэхний тархалтанд илүү өртөмтгий байна.

- Цаасны төрлөөс үл хамааран зурлагыг маш удаанаар гүйцэтгэх болон зурлаганы чиглэлийг өөрчлөх үед бэхний тархалт үүсэж байна.
- Бичигчийн гарнаас үүссэн тос болон хөлсний бохирдол нь цаасанд шингэснээр бэхний тархалт үүсгэдэг.
- Үзэгний их даралтаас шалтгаалан бэхний тархалт үүсэж байна. Гэхдээ эсрэгээрээ бага даралттай, жигд хэмнэлтэй зурсан зурлага дээр бэхний тархалт үүсэхгүй байна.
- Бэхний тархалт нь газарзүйн бүсийн чийгшлийн түвшингээс мөн шалтгаалж болохыг тогтоосон туршилт хийгдсэн байна. Энэ туршилтыг явуулахдаа нэг цаасыг нь ESDA /цахилгаан статик илрүүлэх аппарат/-ын чийгшүүлэгч өрөөнд байрлуулж, нөгөө ижил цаасыг хэвийн чийгшилтэй өрөөнд(цөлд) байрлуулан ижил үзэг, ижил бэх, ижил цаасаар цаасаар хийсэн туршилтаар үзэгний бэхэн зурлага нь чийгшүүлсэн өрөөнд байх цаасан дээр тод тархалттай байх бөгөөд цаасны хуурай хэсгүүдэд тархалтгүй байсан байна.²³¹



Зураг №3. Эхний зурагт бэхний тархалтгүй, дараагийн зурагт бэхний тархалттай байгааг харуулав.

Усан суурьтай бэх ашигладаг үзгэн бал, шилэн үзүүртэй бал, хуванцар үзүүртэй бал гэх мэт бусад үзгээр зурсан зурлагуудаас үзэгний зурлагатай төстэй шинж тэмдгүүд илэрч байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Бэхний тархалтыг шинжлэхдээ чийгшил, бичигчийн гарын тос, хөлс болон цаастай харьцах үед санамсаргүй бий болсон бусад бохирдлууд, цаас болон бэх хоорондын харилцан урвал, үзэгний хүчтэй даралт, цаасны гадаргуун чанар зэрэг бусад шалтгаануудыг харгалзан үзэх шаардлагатай.

Шинж тэмдэг №3: Бэхний зурлага дээрх бараан тунадас

Үзэгний хувьсах даралтаас хамааран бэх нь цаасыг янз бүрийн хэмжээгээр норгодог бөгөөд ингэснээр нэ удаагийн хөдөлгөөнөөр зурсан үргэлжилсэн бэхний зурлагын зарим хэсэгт илүү бараан тунадас үүссэн байна. Энэ нь үзэгний хувьсах даралтаас хамааран бэх нь цаасыг янз бүрийн хэмжээгээр норгосон үед үзэг бэхний зураасны дагуу дээш, доош хөдөлж байх үед зурлагын аль нэг хэсгээс зарим бэхийг чирч дээд болон доод талын хэсгүүдэд буулгаснаар үүсэж байна. Үүнийг бэхний "Бараан тунадас" гэж томъёоллоо. /Зураг №4/

²³¹ Linton, A. (2019). Forensic examination of signatures, 101.



Зураг№4. Зурлаганы зарим хэсгүүдэд үүссэн бараан тунадасуудыг харуулав.

Бэхний өнгийн өөрчлөлт нь “цэнхэр-хар” өнгийн бэхэн дээр тод илэрч байгаа бөгөөд ялангуяа их даралттай үйлдэгдсэн зурлага дээр цэнхэр, хар өнгөний агууламж илүү ялгарч байна.

Бэхний зурлаганд буулгагдсан бэхний хэмжээний ийм өөрчлөлт нь шинжээчийг хоёр өөр төрлийн бэх хэрэглэсэн гэсэн дүгнэлт гаргахад хүргэж болзошгүй.


Шинж тэмдэг №4: Бэхний урсгал

Бэхний зурлагын зарим огтлолцсон эсхүл давхардсан хэсгүүдэд бусдаасаа ялгаатай бэхний бараан өнгийн агууламж ажиглагдаж байна. Энэ нь нэг зурлагаас нөгөө зурлага дээгүүр зурах эсвэл нэг зурлага дээр давхарлан зурах үед огтлолцсон болон давхарлагдсан хэсгүүдэд үүсдэг. Үүнийг “бэхний урсгал”-ын шинж тэмдэг гэж томъёоллоо. /Зураг №5/

Бэхний урсгалын шинжийг судлахын тулд бичиг баримтын шинжээч, доктор Линтон Мохаммед олон тооны үзэгний бэхээр туршилт хийж, “бэхний урсгал” нь үзэгний зурлагад ихэвчлэн тохиолддог болохыг олж тогтоосон бөгөөд бэхний зурлага дээгүүр бэх урсах шалтгаан нь капиллярын үйлчлэл юм гэж тайлбарласан байна.

Мөн энэ үзэгдлийн шинжээчийг төөрөгдүүлэх боломжуудын талаар хойд Америкийн бичиг баримтын шинжилгээний эцэг хэмээгддэг Альберт Шерман Осборн²³² “бэхний урсгал”-ын үзэгдэл (Зураг №5-ыг үзнэ үү) болон түүний боломжуудыг тэмдэглэж үлдээсэн бөгөөд туршлагагүй шинжээч энэхүү үзэгдэл нь зурлагыг засч янзалсаныг харуулж байна гэж дүгнэж байна” гэжээ.²³³

Гэвч өнөө үед зарим бэхний хувьд “бэхний урсгал” нь арай өөр байдаг байна. Учир нь өнөө үед целлюлозын реактив будагч бодис агуулсан үзэгний бэх элбэг бөгөөд эдгээр будгууд нь цаастай урвалд орж, хатсан үедээ ус нэвтрүүлдэггүй байна. Иймээс энэ төрлийн бэхүүд нь “бэхний урсгал”-д бага өртдөг байна.




Зураг№5. Бэхний урсгалын шинж тэмдэг

²³² Conway, James V.P. (June 1998), "A Brief History of the American Society of Questioned Document Examiners", Journal of the American Society of Questioned Document Examiners, 1, 2–3

²³³ Osborn, A. (1929). Questioned documents (2nd ed.). Chicago, IL: Boyd Printing Company.

Шинж тэмдэг №5: Бэхний хуваагдал



Энэ шинж тэмдгийг шинжлэхэд үзэг салгалтын шинж мэт харагддаг.²³⁴ Гэвч уг шинж тэмдэг нь их даралттай бичиж байхад зарим үсгүүд болон босоо шулуун элементүүдийн дээд үзүүрт үзэгний хошуу хүрэх үед хошууны үзүүрүүд салж, үзүүр бүр тус тусдаа хоорондоо зайтай бэхний агууламж үлдээснээр үүсдэг бөгөөд уг шинж тэмдгийг “бэхний хуваагдал” гэж томъёоллоо. /Зураг №6/ Хошуу нь мөрийн дээрх элементээс буцаж доошилход үзүүрүүд буцаж нийлж, зурлагыг хэвийн үйлддэг. Харин бага даралттай бичигч нь мөрийн дээрх элементийн дээд хэсэгт үзэгний хошууны үзүүрүүдийг салгахгүй байна. Мөн энэ шинж тэмдэг нь хошууны уян хатан байдлаас хамаарна.



Зураг №6. Мөрийн дээрх элементийн дээд хэсэгт үүссэн бэхний хуваагдлын шинж тэмдгийг харуулав.

Шинж тэмдэг №6: Хуваагдмал хошууны нуруу

Зарим зурлага дээр бэхний зурлаганы ирмэгтэй зэрэгцэн байрласан бэхний шугамны төв хэсэгт өргөгдсөн нуруу үүссэн байна. Энэ шинж тэмдэг нь дунд болон их даралттай бичиж байх үед үзэгний хошууны үзүүрүүд ялимгүй салж, улмаар цаасан дээр үзүүр болгоны зураасан мөр үүсэж, 2 зураасан мөрний хооронд гарч ирдэг бөгөөд үүнийг “хуваагдмал хошууны нуруу” гэж томъёоллоо./Зураг №8/



Зураг №8. Хуваагдмал хошууны нурууг харуулав.


Зурлага дахь хуваагдмал хошууны нурууны оршихуй нь үзэг хэрэглэсэн /ган хошуутай дүрлэг үзэг ч бас нуруу үүсгэдэг/ болохыг тодорхойлох найдвартай шинж тэмдэг юм. Үзэгний байрлал нь уг шинж тэмдэг харагдахуйц байх эсвэл байхгүй байх эсэхэд ихээхэн нөлөөлж байна.

Уг шинж тэмдгийг шинжлэхдээ даралт ямар байхаас үл хамааран бэхний зурлага бүхий цаасыг өөр өөр байрлалд шилжүүлэн дүрс өсгөх болон хажуугийн гэрэлтүүлгийн аргаар шинжлэх хэрэгтэй. Мөн барзгар цааснаас илүү гөлгөр цаасан дээр хуваагдмал хошууны нурууг харах нь илүү хялбар байх тул цаасны төрлийг мөн анхаарч үзэх хэрэгтэй.

²³⁴ Практик дээр хийгдсэн шинжилгээнүүд дээр ийм төрлийн шинжүүд илэрч, шинжээчдийг төөрөгдүүлдэг талаар мэргэжлийн шинжээчид ярьж байсан.

Шинж тэмдэг №7: Бэхний бичил дусал


Бэхний зурлагыг дүрс өсгөх аргаар шинжлэх үед ойр орчимд нь бэхний бичил дуслууд үүссэн байна. Эдгээр дуслууд нь үзэгний хошуу цаасны ширхгийн ирмэгийг цохиж, улмаар зурлага огцом зогсоход хүргэдэг бөгөөд хошууны үзүүр нь зогсолтоос өөрийгөө хурдан гаргахад бэхний бичил дуслууд цацагдан үүсч байна. Уг шинж тэмдгийг “бэхний бичил дусал” хэмээн томьёоллоо. /Зураг №9/



Зураг №9 Бэхний бичил дуслуудыг харуулав.

Шинж тэмдэг №8: Бэхний гэрэлтэлт

Бэхний зурлагуудыг шинжилж байх үед хэт улаан /IR/ гэрэлд усан суурьтай цэнхэр-хар өнгийн бэхний зурлагад үе үе хар болон цэнхэр бэхний гэрэлтэлттэй байхад ижил бэхний зурлагад хар бэх огт гэрэлтэхгүй байх тохиолдол ажиглагдаж байна. Энэ нь бичигчийн даралтаас хамааран цаасан дээр бэхний янз бүрийн хэмжээтэй агууламж үүссэнээс шалтгаалж байна. Учир нь даралт багатай зурсан бүдэгхэн зурлага нь цэнхэр өнгөөр гэрэлтэж байхад даралт ихтэй зурсан зурлагууд нь хар өнгөөр гэрэлтэх тохиолдол байна. Энэ шинжийг “Бэхний гэрэлтэлт” гэж томьёоллоо. /Зураг №10/




Зураг №10. Бэхний хар болон цэнхэр өнгийн гэрэлтэлтийг харуулав.

Үүнээс харахад бэхний их агууламж нь гэрэлтэлтийг унтрааж байна гэж үзэж болохоор байна. Мөн гэрэлтэлтийн шинжийг шинжлэхдээ цаасан дээрх флюоресцент гэрэлтүүлэгч бодисыг бас анхаарч үзэх хэрэгтэйг зарим баримтуудад дурдсан байна.

Шинж тэмдэг №9: Бэхэн бохирдол



Үзгээр зурсан зарим зурлагуудыг шинжлэхэд бэхний зурлагын ойр орчимд бэхээр бохирлогдсон хэсгүүд ажиглагдаж байна. Энэ нь усан суурьтай бэх хэрэглэдэг үзгээр зурсан зурлагуудтай гарын зарим хэсэг харьцах үед үүсдэг бөгөөд энэ шинж тэмдэг нь бичигч солгой гартай эсэхийг тодорхойлох чухал ач холбогдолтой юм. /Зураг №11/



Зураг №11. Бэхэн бохирдлыг харуулав.

Шинж тэмдэг №10: Бэхэн зураас

Бэхний зурлагуудыг дүрс өсгөх аргаар шинжлэхэд бэхний зурлагын зарим хэсгээс янз бүрийн хэмжээтэй шулуун болон тахир бэхэн зураасууд үүссэн байна. Энэ шинж тэмдэг нь бэхний үндсэн зурлагаас цаасны зарим ширхгийн дагуу бэхийг сорж үүсдэг бөгөөд үүнийг “бэхэн зураас” гэж томьёоллоо. /Зураг №12/



Зураг №12. Бэхэн зураасуудыг харуулав.

Объект №2. Тосон бал

Газар сайгүй байдаг тосон бал нь магадгүй өнөө үед хэрэглэж буй хамгийн алдартай бичих хэрэгсэл юм. Ласло Йозеф Бирогийн²³⁵ зохион бүтээсэн энэхүү тосон бал нь 1944 оноос хойш олон нийтэд танилцуулагдаж эхэлсэн байна.

Тосон бал нь хэрэглээнд нэвтэрснээс хойш хүмүүсийн анхаарлыг маш их татсан тул бичиг судлалын шинжээч Стэйн болон Хилтон нар Америкийн Хуульчдын Холбооны сэтгүүлд зориулан бичсэн нийтлэлдээ балны чиг үүргийн талаар тайлбар хийж, зарим нь тааруухан ажиллаж байгааг тэмдэглээд тосон балаар бичсэн гарын үсгийг хуурамчаар үйлдэхэд хялбар гэж үзэн чухал баримт бичигт гарын үсэг зурахдаа тосон бал ашиглаж болохгүй гэсэн дүгнэлт өгчээ²³⁶.

Мөн Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газраас итгэмжлэгдсэн анхны 3 бичиг судлалын шинжээчдийн нэг болох Жеймс В.П.Конвей²³⁷ “Муу ажиллагаатай тосон бал нь доголдлоор дүүрсэн жигд бус бэхний зурлагуудыг үүсгэдэг” гэж бичсэн байдаг²³⁸ ч тэр үеэс хойш балны чанар эрс сайжирсан.

²³⁵ https://en.wikipedia.org/wiki/László_Bíró/

²³⁶ Stein, E., & Hilton, O. (1948). Questions raised by examiners of signatures and documents. American Bar Association Journal, 34(5), 373–376.

²³⁷ <http://www.asqde.org/about/presidents/conway.html>


²³⁸ Conway, J. (1959). Evidential documents. Springfield, IL: Charles C. Thomas.

Тосон бал нь бэхний бортогоноос өнхөрдөг бөмбөг рүү шилжүүлэгддэг наалдамхай бэх ашиглан ажилладаг бөгөөд бөмбөг нь бэхийг бичих гадаргуу руу шилжүүлдэг. Ихэвчлэн бөмбөг нь бөмбөгний хэмжээ, бичигчийн даралтаас хамааран цаасан дээр бага зэргийн ховил бүхий мөрийг үүсгэх зарчмаар ажилладаг²³⁹.

Судлаач бидний зүгээс 5 өөр төрлийн тосон балны зурлага дээр хийсэн туршилтын үр дүнд тулгуурлан тосон балнаас үүсэх оношлогооны шинж тэмдгүүдийг томьёолохыг зорьсон. Үүнд:


Шинж тэмдэг №1: Сүүн шугам

Тосон балны зурлагыг шинжлэхэд зурлаганы үндсэн шугамнаас геометрийн хувьд ижил зайтай боловч тусдаа зэрэгцэн үйлдэгдсэн өнгөгүй цагаан шугам харагдаж байна. Энэ шинж тэмдэг нь бичигч этгээд бичихдээ бичих хэрэгслээ хурц өнцөг үүсгэн барьсан үед балны эргэлдэгч бөмбөгийг тогтоосон балны дугуйрсан туузанаас /Зураг №13, тэмдэглэгээ-1/ маш бага зайд байрлах цагираган хүрээнээс /тэмдэглэгээ-2/ үүсдэг бөгөөд уг шинж тэмдгийг “сүүн шугам” гэж томьёоллоо. /Зураг №14/



Зураг №13. Тосон балны хошуу

Тосон балны дугуйрсан тууз болон цагираган хүрээ хоорондох зай нь үйлдвэрлэгчийн онцлогоос хамааран өөр өөр байдаг бөгөөд бичигчийн балаа барьсан өнцгөөс шалтгаалан “сүүн шугам” үлдэж, эсхүл үлдэхгүй байж болно.




Зураг №14. Бэхний зурлагатай зэргэлдээ үүссэн сүүн шугамыг харуулав.

Шинж тэмдэг №2: Бэхэн хялгас

Тосон балаар зурагдсан зурлагыг бэхний хэсгийг дагасан хялгасан бэхэн шинжүүд үүссэн байна. Үүнийг “бэхэн хялгас” гэж томьёоллоо. Энэ шинж тэмдэг нь зөвхөн тосон балны бэхнээс үүсдэгээрээ онцлог байна./Зураг №15/

²³⁹ Mathyer, J. (1969). The influence of writing instruments on handwriting and signatures. The Journal of Criminal Law, Criminology and Police Science, 60(1), 102–112.



Зураг№15. Тосон балны бэхэн хялгасуудыг харуулав.

Шинж тэмдэг №3: Бэхний судал


Тосон балнаас үүссэн зурлагууд дээр цагаан өнгийн судлууд үүссэн байна. Энэ судлууд нь бөмбөгний бэхээр бүрхэгдээгүй хэсгүүдээс үүсдэг бөгөөд энэ шинж тэмдгийг “бэхний судал” хэмээн томъёоллоо. Үйлдвэрлэлийн согог эсвэл бохирдлоос шалтгаалан бэх нь бөмбөгийг жигд бүрхэхгүй байж болно.

Бэхэн судал нь оношлогооны чухал ач холбогдолтой шинж тэмдэг юм. Учир нь судлуудыг бэхний зурлагын чиглэлийг тодорхойлоход ашиглах боломжтой.

Жишээлбэл, зураг№16-д гараар зурсан зууван хэлбэртэй зурлагуудыг дүрслэв. Зүүн талын зурлагын судал нь бэхний шугамны гадна хүрээнээс дотогш чиглэж дээшилсэн байгаа нь хөдөлгөөн цагийн зүүний эсрэг байгааг илтгэнэ. Харин баруун талын зурлагын судал нь бэхний шугамны дотор хүрээнээс гадагш чиглэж дээшилсэн байгаа нь хөдөлгөөн цагийн зүүний дагуу байгааг харуулж байна.



Зураг№16.
Эргэлтийн чиглэлийг
заах бэхний
судлуудыг харуулав.





Доод (<\$ 10) болон дээд зэрэглэлийн (> \$ 10) тосон балнуудын аль нь илүү их судал үүсгэдэг болохыг тогтоох зорилгоор Висконсин муж улсын бичиг судлалын шинжээч Жэн А.Льюис судалгаа хийсэн байна. Судалгаанд янз бүрийн үйлдвэрлэгчдийн өөр өөр гарал үүсэлтэй 132 шинэ бал, хэрэглэж байсан буюу хуучин 117 бал ашигласан бөгөөд судалгааны үр дүнг нэгтгэхэд шинэ балны 22.7%, хуучин балны 80.3%, дээд зэргийн буюу үнэтэй балны 50% нь судал үүсгэж байсан байна.²⁴⁰

Мөн Калифорни муж улсын хувиараа ажилладаг бичиг судлалын шинжээч Жэмс А.Блэк нь судалны хэв маяг/үйлдэцийн онцлог/ нь бичих хэрэгслийн адилтгалд бас хэрэгтэй байж болох юм гэж үзсэн байна.²⁴¹

Шинж тэмдэг №3: Бэхэн бөмбөлөг

Тосон балны бөмбөлөгний ил байгаа хэсгийг залгаас руу буцааж оруулахад бөмбөлөг дээр үлдсэн багахан хэмжээний бэх нь залгаас руу орохгүй бол уг бэх нь залгаасны ирмэг дээр бөөгнөрч, улмаар жижиг бэхэн бөмбөлөг болон хэлбэршиж, бөмбөгний эргэлтийн чиглэлийг эсрэг тал руу нь өөрчлөх үед бичгийн гадаргуу дээр бэхний хэвийн бус том агууламж болон үлддэг. Энэ шинж тэмдгийг “бэхэн бөмбөлөг” гэж томъёоллоо. Энэ нь өнөө үеийн балны нийтлэг шинж чанар юм²⁴². Бэхэн бөмбөлөг нь мөн бөмбөлөгний бүрхүүл дэх үйлдвэрлэлийн согог, бохирдол, хог хаягдлаас болж үүсч болно²⁴³.


Бэхэн бөмбөлөг үүсэх хамгийн нийтлэг шалтгаануудын нэг бол үйлдвэрлэл согог эсвэл цагираган хүрээний элэгдэл, гэмтэл юм. Жишээлбэл, хэрэв та балаа унагаахад тэр нь цагираган хүрээний маш зөөлөн гуулин материалтай ирмэгээрээ газардчихвал энэ нь цагираган хүрээний хэсгийг эргэж буй бөмбөгний эсрэг түлхэх магадлалтай. Ийм зүйл болсон тохиолдолд бөмбөг эргэж, цагираган хүрээг үрэх бүрт бөмбөгнөөс тодорхой хэмжээний бэхийг хусаж, тэр нь цагираган хүрээний ирмэг дээр хуримтлуулна. Ингээд зөвхөн чиглэл өөрчлөхөд ч биш янз бүрийн байрлал дахь цагираган хүрээнээс бэхэн бөмбөлөг үүсэх боломжтой болно.

²⁴⁰ Lewis, J. (2003). Striation patterns in new and used ballpoint pens. Journal of the American Society of Questioned Document Examiners, 6(2), 67-71.

²⁴¹ Black, D. (1970). Identifying ball pens by the burr striations. Journal of Criminal Law, Criminology and Police Science, 61(2), 280-282.

²⁴² Ryan, R. (1966). United States patent office 3, 261,326 patented July 19, 1966. Retrieved 08/12/18.

²⁴³ Ellen, D. (1989). The scientific examination of documents: Methods and techniques. Chichester, England: Ellis Horwood Ltd.



Зураг№17. Бэхэн бөмбөлөгүүдийг харуулав.

Лондон хотын цагдаагийн газрын Шүүхийн шинжилгээний лабораторийн Баримт бичиг хариуцсан ажилтан Фрийд бэхэн бөмбөлөг нь балны зурлагын чиглэлийг тодорхойлох нэг арга гэж үзээд балны бөмбөлөг цаасан дээгүүр хөдөлж байх үед цаасны ширхэг дээрх бэхэн бөмбөлөгийг ажиглалтын микро스코поор харж, зурлагын чиглэлийг тодорхойлж болох аргачлалыг дэвшүүлсэн байна²⁴⁴. Энэхүү аргын найдвартай байдлыг тогтоохын тулд Шинжлэх ухааны редактор, доктор Андреа Девлин, бичиг баримтын шинжээч, химийн ухааны доктор Стивен Страч болон Австралийн засгийн газрын бичиг баримтын шинжээч Клэйр Грэйдон нар Австралийн засгийн газрын болон хувийн лабораторийн бичиг судлалын 16 шинжээчдийг оролцуулан судалгаа хийж, Фрийдийн судалгааны үр дүнг зөв гэж үзээд уг аргын техникийн найдвартай байдлыг 97.6% гэж баталгаажуулсан²⁴⁵ байна.

Шинж тэмдэг №4. Ором мөр/Арилгаж болох балны зурлага дээр/

Арилгаж болох балыг 1979 онд Папермате нэвтрүүлсэн бөгөөд удалгүй бусад бал үйлдвэрлэгчдийн ижил төстэй бүтээгдэхүүнүүд гарч эхэлсэн. Ердийн балны бэх болон ялангуяа хатсан арилдаг бэхний хооронд микроскопоор харахад ялгаатай шинж маш бага байдаг талаар судлаач Ордвэй Хилтон судалгаандаа дурдсан бөгөөд арилгаж болох балны арилгасан ормуудын учрыг тайлахыг оролдсон янз бүрийн арга техникүүдийг мөн тайлбарласан²⁴⁶ байдаг.

Судлаач бид уг талаар үүсгэсэн зурлагыг арилгаж, мөр үлдэх эсэхийг туршиж үзэхэд бэхний зурлага бүрэн арилсан ч үзэгний бөмбөлөгний ором мөр үлдэж байгааг тогтоосон./Зураг №18/

²⁴⁴ Fryd, C. (1957). The direction of pen motion and its effects on the written line. *Medicine, Science and the Law*, 15(3), 167-171.

²⁴⁵ Devlin, A., Graydon, C., & Strach, S. (2015). Line direction determination of ballpoint pen ink writing. *Journal of the American Society of Questioned Document Examiners*, 18(1), 29-39.

²⁴⁶ Hilton, O. (1984a). Effects of writing instruments on handwriting details. *Journal of Forensic Sciences*, 29(1), 80-86. Hilton, O. (1984b). Characteristics of erasable ball point pens. *Forensic Science International*, 26, 269-275.



Зураг №18. Арилгадаг балны ором мөрийг цагаан болон хажуугийн гэрэлд харуулав.


Объект №3. Эсгий хошуутай үзэг

Эсгий хошуутай үзэг (нийлэг үзүүр, акрилэн үзүүр, хиймэл үзүүр, зэгсэн үзэг, хулсан үзэг, шилэн үзүүр гэж бас нэрлэдэг) нь 1964 оноос ашиглагдаж эхэлсэн.


Тухайн үедээ эксперт А.Блэк үзэгний бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлж, "Ихэнхи тохиолдолд жинхэнэ эсхүл хуурамч болохыг нотлох шинжүүд нь үзэг болон тосон балны шинжүүдээс эрс ялгаатай биш" гэж дүгнэжээ.²⁴⁷

Эсгий хошуутай үзэг их тархахын хэрээр уг үзгээр зурсан гарын үсэг, гар бичмэлийн шинжилгээний тоо ихсэж байсан.

Зузаан эсгий хошуутай үзгийг чухал баримт бичигт гарын үсэг зурахад ховорхон ашигладаг ч ийм тохиолдлууд гарч байсан. Эдгээр үзэг нь ул мөрийг дарж бичихэд тохиромжтой хэрэгсэл тул энэ төрлийн үзгээр зурсан зурлагуудыг янз бүрийн гэрэлтүүлгийн техник хэрэгслээр шалгаж, суурь харандаа, бэх байгаа эсэхийг тодорхойлох хэрэгтэй. /Зураг №19/



²⁴⁷ Black, D. (1967). Fiber tipped pens. Journal of Criminal Law and Criminology, 57(4), 521-525.



Зураг №19. Эсгий үзэгний зурлага болон төгсгөлийн зурлагад үүсэж буй шинж тэмдгүүдийг харуулав.



Зураг №20. Эсгий үзэгний зурлаганы цаасны ар талд үүсгэж буй шинжийг харуулав.

Энэ үзгээр зурсан зурлагыг дүрс өсгөх аргаар шинжилж үзэхэд бэхний жигд хуваарилалттай үүссэн бөгөөд зарим тохиолдолд хэвлэсэн мэт шинжийг харуулж байна. Гэхдээ хэвлэмэл биш гэдэг нь бэхний тосны шинжээр ялгагдаж байна. Харин зурлагын бэхний нягтаршил нь бусад бичих хэрэгслээс илүү жигд харагдаж байна.

Мөн эсгий хошуутай үзэгний зурлага дээр бэхний хуваагдал, бэхэн бохирдол, бэхний судал, бэхэн бөмбөлөг зэрэг шинжүүд ажиглагдахгүй байна.


Энэ төрлийн үзэгний зурлагатай холбоотой судалгааг АНУ-ын Техас мужийн бичиг судлалын шинжээч Стюарт Жеймс Массон хийсэн байна. Тэрээр бичигч нь бичих хэрэгслийн төрлөөс үл хамааран бичих зуршлаа хадгалан үлддэг ч зарим бичигчид эсгий хошуутай үзэг хэрэглэх үедээ үсгийн ер бусын хэлбэржүүлэлт хийдэг болохыг анхааруулжээ. Тиймээс шинжилж буй гарын үсэг зурсан бичих хэрэгсэлтэй ижил төстэй бичих хэрэгслээр зурсан загварыг шинжлэн судалж, эргэлзэж буй шалтгаанаа бүрэн арилгахыг шинжээчдэд зөвлөсөн байна.²⁴⁸

Объект №4. Үзгэн бал

Үзгэн бал 1960-аад оны сүүлээр танилцуулагдсан бөгөөд баланд хэрэглэдэг наалдамхай бэхнээс өөр усан суурьтай шингэн бэх хэрэглэдэг.

Үзгэн бал нь ерөнхийдөө цаасны ширхэг рүү бага зэргийн бэх шингээх зарчмаар ажилладаг. /Зураг №21/

²⁴⁸ Masson, J. (1985). Felt tip pen writings: problems of identification. Journal of Forensic Sciences, JFSCA, 30(1), 172–177.



Зураг №21. Үзгэн балны зурлагуудыг харуулав. /Ар талын зурагт 0.5, 0.7, 1.0 хэмжээтэй хошуунаас үүссэн зурлагуудыг нарийвчилсан гэрэлзургаар харуулав/

Канадын бичиг судлалын шинжээч Бриан Линдблом үзгэн балны бүтэц, зохион байгуулалтыг судалсан²⁴⁹ байна.

Үзгэн балны зурлагыг шинжилж үзэхэд бэхний зах ирмэгүүд нь бусад бичих хэрэгслүүдээс илүү жигд, тэгшхэн байна. Мөн бэхэн бөмбөлөг, бэхний судал, бэхэн хялгас зэрэг шинжүүдийг үүсгэхгүй байна.

Үзгэн балны зурлагатай холбоотой нэгэн сонирхолтой судалгааг судлаач Мербан болон Турнэр нар хийсэн байна. Тэд сканнердсан цахим гарын үсэгт бичих хэрэгслийн шинж тэмдгийн өөрчлөлт хэр их гардаг болохыг тогтоох зорилгоор 150 гарын үсгийн онцлог шинж чанарыг судлан жинхэнэ болон сканнердсан гарын үсгийн хоорондох ялгааны хамгийн бага нь тосон балаар, хамгийн их нь үзгэн балаар зурсан гарын үсэгт илэрч²⁵⁰ байна гэж тэмдэглэжээ.

Объект №5. Гелэн үзэг

1984 онд Японд үйлдвэрлэсэн гелэн үзэг нь олон төрлийн өнгөтэй бөгөөд дэгдэмхий органик материал болон хүнд металл агуулаагүй байгаль орчинд ээлтэй гэдгээрээ нэр хүнд нь өсөж, хүмүүсийн хэрэглээнд өргөн нэвтэрсэн.²⁵¹

Гелэн үзэгний бэхний зурлагуудыг дүрс өсгөх аргаар шинжилж үзэхэд уг үзэг нь үзгэн балны бэхний зурлагатай ижил шинжтэй зурлагуудыг үүсгэж байна. /Зураг №22/. Харин гелэн бэх нь 20-30 секундын хугацаанд хатдаг бөгөөд үзгэн балны бэхийг бодвол арай удаан хатаж байна.


Зарим гелэн үзэг болон үзгэн бал нь бохирдол үүсгэж болзошгүй тул солгой гартай бичигчдэд асуудал үүсгэдэг²⁵² тухай судлаач Матранга илтгэлдээ дурдсан байна.

²⁴⁹ Lindblom B. (2006). Pens and pencils. In B. Lindblom & J. Kelly (Eds.), Scientific examination of questioned documents (pp. 147-158). (2nd ed.). Boca Raton, FL: CRC Press.

²⁵⁰ Mehrban, N., & Turner, I. (2008). A comparison of the identifying features in original and electronically scanned signatures. Journal of the American Society of Questioned Document Examiners, 11(1), 1-7.

²⁵¹ Gernandt, M., & Urlaub, J. (1996). An introduction to the gel pen. Journal of Forensic Sciences, JFSCA, 41(3), 503-504.

²⁵² Matranga, A., & Oleksow, D. (2003). The effects of gel pens on handwriting details. In Paper presented at the annual meeting of the American society of questioned document examiners, Baltimore, MD.



Зураг №22. Гелэн балны зурлагыг харуулав.


Объект №6. Харандаа

Харандааг хувийн болон бизнесийн үйл ажиллагааны тэмдэглэлд байнга ашиглагддаг боловч арилгахад хялбар тул гарын үсэг зурах нь тун ховор.

Харандааны хошууны зөөлөн эсвэл хатуулаг байдлаас шалтгаалан бичигчийн даралтын хэлбэлзлээс хамаарч нь үргэлжлүүэн зурсан зурлагуудад тод болон бүдэг шугамуудыг үүсгэж болзошгүй²⁵³ талаар судлаач Хилтон бүтээлдээ дурдсан байна. Энэ нь туршилтын үр дүнд нотлогдсон./Зураг №23/

Мөн ердийн графит үзүүртэй харандаагаас гадна шингэн тугалгыг хошуундаа ашигладаг зарим харандаанууд нь шугаман морфологитой бөгөөд тосон балны зурлагатай төстэй олон шинж тэмдгүүдийг агуулдаг гэж Сан-Диего мужийн бичиг судлалын шинжээч Бренда Н Ланнерс илтгэлдээ өгүүлсэн²⁵⁴ байна.

Харандаагаар үүсгэсэн туршилтын зурлагуудыг шинжилж үзэхэд бэхний судал, бэхэн бөмбөлөг зэрэг тосон балны шинжүүд илэрч байна.



Зураг №23. Харандааны зурлагыг харуулав.

Ингээд судлаачдын зүгээс “Бичих хэрэгслийн мөрийг дүрс өсгөх аргаар судалсан нь” сэдвийн хүрээнд хийсэн судалгааны үр дүнд үндэслэн дараах дүгнэлт, саналыг гаргаж байна.

Дүгнэлт

1. Аливаа бичиг баримт дээр буюу цаасан дээр зурсан бичих хэрэгслийн төрлийг тухайн мөрөнд үүссэн онцлог шинж тэмдэгт нь үндэслэн тодорхойлох боломжтой гэж дүгнэж байна.
2. Бичих хэрэгслээс үүссэн онцлог шинж тэмдэг бүр өөрийн үүсэх зүй тогтолтой.
3. Шинж тэмдгүүдийг онцлог шинжүүдэд нь үндэслэн нэршлүүдийг тус тусад нь том тодорхойлсон.

²⁵³ Hilton, O. (1991). Detecting and deciphering erased pencil writing. Springfield, IL: Charles Thomas.

²⁵⁴ Lanners, B. (2011). Liquid lead pencils revisited. Journal of the American Society of Questioned Document Examiners, 14(1), 51–56.

Санал

1. Шүүхийн шинжилгээний байууллага дээр бичих хэрэгслийн төрөл тодорхойлох оношлогооны шинжилгээ хийх арга зүйн болон эрх зүйн орчинг бүрдүүлэх;
2. Бичих хэрэгслээс үүссэн шинж тэмдгүүдийн нэршлийг шинжлэн магадлах ухааны эргэлтэд оруулан нэг мөр ойлголтод оруулах.

Ашигласан материал

1. Байгууллагын дэлгэрэнгүй бүртгэлийн архив
2. Бат-Эрдэнэ, Б. (2003). Криминалистик
3. Лхагвасүрэн, Б. (2008). Гэмт үйлдлийн мөр
4. Linton, A. (2019). Forensic examination of signatures
5. Mathyer, J. (1969). The influence of writing instruments on handwriting and signatures. *The Journal of Criminal Law, Criminology and Police Science*, 60(1)
6. Hilton, O. (1984a). Effects of writing instruments on handwriting details. *Journal of Forensic Sciences*
7. Hilton, O. (1984b). Characteristics of erasable ball point pens. *Forensic Science International*
8. <https://mongoltoli.mn/dictionary/detail/99675>
9. Conway, James V.P. (June 1998), "A Brief History of the American Society of Questioned Document Examiners", *Journal of the American Society of Questioned Document Examiners*, 1
10. Osborn, A. (1929). *Questioned documents* (2nd ed.)
11. https://en.wikipedia.org/wiki/László_Bíró/
12. Stein, E., & Hilton, O. (1948). Questions raised by examiners of signatures and documents. *American Bar Association Journal*, 34(5)
13. <http://www.asqde.org/about/presidents/conway.html>
14. Conway, J. (1959). *Evidential documents*. Springfield, IL: Charles C. Thomas.
15. Mathyer, J. (1969). The influence of writing instruments on handwriting and signatures. *The Journal of Criminal Law, Criminology and Police Science*, 60(1)
16. Lewis, J. (2003). Striation patterns in new and used ballpoint pens. *Journal of the American Society of Questioned Document Examiners*, 6(2)
17. Black, D. (1970). Identifying ball pens by the burr striations. *Journal of Criminal Law, Criminology and Police Science*, 61(2)
18. Ryan, R. (1966). United States patent office 3, 261,326 patented July 19, 1966. Retrieved 08/12/18.
19. Ellen, D. (1989). *The scientific examination of documents: Methods and techniques*. Chichester, England: Ellis Horwood Ltd.
20. Fryd, C. (1957). The direction of pen motion and its effects on the written line. *Medicine, Science and the Law*, 15(3)
21. Devlin, A., Graydon, C., & Strach, S. (2015). Line direction determination of ballpoint pen ink writing. *Journal of the American Society of Questioned Document Examiners*, 18(1)
22. Black, D. (1967). *Fiber tipped pens*. *Journal of Criminal Law and Criminology*, 57(4)
23. Masson, J. (1985). Felt tip pen writings: problems of identification. *Journal of Forensic Sciences*, JFSCA, 30(1)
24. Lindblom B. (2006). Pens and pencils. In B. Lindblom & J. Kelly (Eds.), *Scientific examination of questioned documents* (2nd ed.). Boca Raton, FL: CRC Press.
25. Mehrban, N., & Turner, I. (2008). A comparison of the identifying features in original and electronically scanned signatures. *Journal of the American Society of Questioned Document Examiners*, 11(1)
26. Gernandt, M., & Urlaub, J. (1996). An introduction to the gel pen. *Journal of Forensic Sciences*, JFSCA, 41(3)
27. Matranga, A., & Oleksow, D. (2003). The effects of gel pens on handwriting details. In Paper presented at the annual meeting of the American society of questioned document examiners, Baltimore, MD.
28. Hilton, O. (1991). *Detecting and deciphering erased pencil writing*. Springfield, IL: Charles Thomas

29. Lanners, B. (2011). Liquid lead pencils revisited. *Journal of the American Society of Questioned Document Examiners*, 14(1)
30. Kelly, J. (1978). An unusual writing surface and considerations. *Journal of Police Science and Administration*, 6(3)
31. Brown, C. (1985). The identification of handwriting on a convex surface. In Presented at the annual conference of the American academy of forensic sciences, Las Vegas, NV.
32. Masson, J. (1992). The effect of unusual writing position and/or surface on signatures. In Presented at the annual conference of the American academy of forensic sciences, New Orleans, LA.
33. Simsons, D., Spencer, R., & Auer, S. (2011). The effects of constraining signatures. *Journal of the American Society of Questioned Document Examiners*, 14(1)
34. Fazio, K. (2015). The effects of constraint of a signature's static and dynamic features. *Journal of the American Society of Questioned Document Examiners*, 18(1)
35. Cheng, Y. (2007). A study on the influence of wearing a glove on handwriting by Chinese in Hong Kong. *Journal of the American Society of Questioned Document Examiners*, 10(1)
